8. Хувцас загвар	11	148	0.5%	132	0.8%	-	139	9	-
9. Архитектур	12	273	1.0%	121	0.7%	5	256	12	-
10. Дизайн	13	150	0.5%	64	0.4%	1	139	10	-
11. Дижитал инноваци, контент	14	336	1.2%	85	0.5%	3	321	12	-
12. Маркетинг, зар сурталчилгаа	15	202	0.7%	91	0.5%	-	199	3	-
Холбогдох салбар мөр16= мөр(17+18+19)	16	1,477	5.3%	801	4.6%	-	1,298	171	8
А. Аялал жуулчлал	17	152	0.5%	83	0.5%	-	147	5	-
В. Спорт чөлөөт цаг	18	562	2.0%	128	0.7%	-	528	34	-
С. Соёлын боловсрол	19	763	2.7%	590	3.4%	-	623	132	8

Эх үүсвэр: БШУЯ, "Их, дээд сургууль, коллежийг төгсөгчдийн нийт тоо" 2019-2020 он, "Их, дээд сургууль, коллежийн мэргэжлийн хөтөлбөрийн тоо" 2018-2019 он
Аргачлал: UNESCO, "Соёлын статистикийн хүрээ" 2009
—Д Үндэслэн тооцоолов

График 4: Бараа, бүтээгдэхүүний гадаад худалдаа, 2020 оны байдлаар



Хүснэгт 9: СБУ-ийн гадаад худалдааны хэмжээ, 2020 оны байдлаар

Салбар	Импорт		Экспорт	
	Үнийн дүн, ам.доллар	Эзлэх хувь	Үнийн дүн, ам.доллар	Эзлэх хувь
Соёлын салбарын бараа, бүтээгдэхүүн	23,121,484.16	22.0%	70,746.25	19.5%
А. Байгалийн болон соёлын өв	12,279.93	0.0%	1,553.70	0.4%
Б. Урлагийн тоглолт, баяр наадам	19,320,391.01	18.4%	18,562.79	5.1%
В. Дүрслэх урлаг ба гар урлал	1,855,383.71	1.8%	31,771.59	8.8%
Г. Ном, хэвлэл	1,921,356.80	1.8%	18,858.17	5.2%
Е. Дизайн болон бүтээлч үйлчилгээ	12,072.70	0.0%		0.0%
ТТДМ	81,847,503.44	78.0%	291,463.51	80.5%
Б. Урлагийн тоглолт, баяр наадам	2,336,697.09	2.2%	15,255.84	4.2%
В. Дүрслэх урлаг ба гар урлал	1,364,945.89	1.3%		0.0%
Г. Ном, хэвлэл	828.00	0.0%		0.0%
Д. Аудио, дүрс бичлэг, Интерактив мэдээллийн хэрэгсэл	78,145,032.46	74.4%	276,207.68	76.3%
Нийт	104,968,987.60	100.0%	362,209.76	100.0%

Эх үүсвэр: ГЕГ, "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"
Аргачлал: UNESCO, "Соёлын статистикийн хүрээ" 2009 –д үндэслэн
HS 2007 ангиллын дагуу тооцоолов.

БҮЛЭГ 1

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ



Судалгааны арга зүй

Монгол Улсын СБҮ-ийн салбарын суурь судалгааны тайлан нь үндсэн хоёр үе шатнаас бүрдэнэ. Нэгдүгээрт Монгол Улсын СБҮ-ийн салбарын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох чанарын судалгаа. Хоёрдугаарт Монгол Улсын СБҮ-ийн салбарт хамаарах салбар, чиглэл тус бүрийн статистик тоон мэдээллийн судалгаа.

I шат

“СБҮ-ийн салбарын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох чанарын судалгаа”

Судалгааны аргачлал:
ЧАНАРЫН СУДАЛГАА

II шат

“СБҮ-ийн салбарын статистик, тоон мэдээллийн судалгаа”

Судалгааны аргачлал:

ХОЁРДОГЧ МЭДЭЭЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

1.1. ЧАНАРЫН СУДАЛГАА

1.1.1. Судалгааны зорилго

Уг судалгаагаар СБҮ-ийн салбарт хамаарах салбар чиглэлийг тодорхойлж, эдийн засгийн болон нийгмийн үр өгөөж, асуудал бэрхшээлийг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох, салбар чиглэл тус бүрийн өртгийн гинжин хэлхээ, үйл ажиллагааны процессыг зураглахыг зорилгоо.

1.1.2. Судалгааны мэдээлэл цуглуулалт

Чанарын судалгааны аргачлалын хувьд бүлгийн хэлэлцүүлэг болон ганцаарчилсан ярилцлага, цахим асуулга судалгааны аргачлал ашиглан мэдээлэл цуглуулав.

Судалгааны мэдээлэл цуглуулалт, ярилцлагыг 2021 оны гуравдугаар сарын 15 -аас 2021 оны 4-р сарын 10 -ны хооронд зохион байгуулав. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг чанарын судалгаа, ганцаарчилсан ярилцлагын аргаар гүйцэтгэв.

Ярилцлагыг нүүр тулсан ярилцлага болон цахим хэрэгслийг ашиглан хийж гүйцэтгэлээ. Нүүр тулсан ярилцлага хийхдээ компанийн “Ковид-19 цар тахлын үед баримтлах дотоод журам”, Эрүүл мэндийн яамнаас гаргасан “Аж ахуйн нэгж, байгууллагад өгөх зөвлөмж”-ийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллалаа. Цахим хэрэгслийн хувьд Zoom цахим уулзалтын платформыг ашигласан.

1.1.3 Судалгааны хамрах хүрээ, оролцогчдын тоо

СБҮ-ийн салбарын 12 салбар чиглэлийн уран бүтээлч, мэргэжилтнүүдийг нийт 16 удаагийн хэлэлцүүлэг, 205 ганцаарчилсан ярилцлага болон 50 цахим судалгаанд хамруулсан.

Соёлын яамнаас зохион байгуулсан 16 удаагийн хэлэлцүүлэгт салбарын тулгамдаж буй асуудал, боломжийг хэлэлцэхээс гадна Соёлын яамнаас баримталж буй хөгжлийн бодлогын талаар танилцуулга хийгдсэн. Тус хэлэлцүүлэгт оролцсон оролцогчдоос гадна салбар тус бүрийн голлох мэргэжилтнүүдийг хамруулан 205 удаагийн ганцаарчилсан ярилцлагыг судалгааны баг зохион байгуулсан. Ганцаарчилсан ярилцлагаар салбар тус бүрийн асуудлыг илүү гүнзгийрүүлэн судлахаас гадна процесс, өртгийн сүлжээний зураглалыг хийж, СБҮ-ийн салбарын зах зээлийг

нэмэгдүүлэх боломж, тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлов. Судалгаанд хамрагдаж чадаагүй боловч санал бодлоо илэрхийлэх хүсэлтэй уран бүтээлч, мэргэжилтнүүдийн дунд цахим хэлбэрээр санал асуулга авсан бөгөөд тус судалгаанд нийт 50 оролцогч хамрагдсан.

1.1.4. Судалгааны асуулгын бүтэц

Чанарын судалгааны асуулгыг боловсруулахад олон улсын зөвлөх Tom Fleming¹ зөвлөж ажилласан бөгөөд судалгааны зорилго, хэрэгцээ, шаардлагад үндэслэн боловсруулав.

Чанарын судалгаагаар соёлын салбарт тулгамдаж буй асуудал бэрхшээл, салбар тус бүрийн боломжийг дараах таван чиглэлээр тодорхойлов. Үүнд:

- 1) **Хүний нөөц** – Уран бүтээлч, мэргэжилтнүүдийн ур чадвар, мэдлэг туршлага, боловсрол, сургалттай холбоотой мэдээлэл;
- 2) **Эко орчин** – Салбарын хууль, эрх зүйн орчин, бодлого, зохицуулалт, салбар хоорондын харилцан хамааралтай холбоотой мэдээлэл;
- 3) **Дэд бүтэц** – Барилга, байгууламж, тоног төхөөрөмж, дэд бүтэцтэй холбоотой мэдээлэл;
- 4) **Хөрөнгө оруулалт** – Хөрөнгө оруулалт, санхүүжилттэй холбоотой мэдээлэл;
- 5) **Маркетинг, сурталчилгаа** – Эрэлтийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан таниулах, борлуулалттай холбоотой мэдээлэл тус тус багтана.

Үүнээс гадна салбар тус бүрд Ковид-19 цар тахал хэрхэн нөлөөлж байгаа талаар, мөн салбарын дижитал трендийн талаар тус тус тодруулав.

1.1.5. Судалгааны ёс зүй

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг зохион байгуулахад баримталдаг ESOMAR ёс зүйн код, олон улсын судалгааны ISO 20252:2019 стандартын дагуу судалгаанд оролцогчоос зөвшөөрөл авч ярилцлагыг сайн дурын үндсэн дээр зохион

¹ www.Tfconsultancy.co.uk

байгуулсан. Мөн судалгаанд оролцогчийн хариултыг чандлан нууцлах, олон нийтэд задруулахгүй байх, зөвхөн нэгдсэн үр дүн гаргахад ашиглах зэрэг дүрмийг баримтлан ажиллав.

Чанарын судалгааны тайлан боловсруулахад баримталсан гол зарчим нь оролцогчийн өгсөн мэдээлэлд судлаачийн хувийн өнцгөөс хандах бус бүхий л нөхцөлд төвийг сахисан байр суурийг чандлан баримталж, бүх талын санал бодлыг тусгахыг хичээж ажиллалаа.

Уг судалгааны тайлан нь хэн нэгэн уран бүтээлч, мэргэжилтний хувийн эрх ашигт хандаж бус салбарт нийтлэг тулгамдаж буй асуудлыг хөндөж, бүх нийтэд хүртээлтэй, өгөөжтэй шийдэл, зөвлөмжийг боловсруулахад чиглэсэн болно.

1.1.6. Мэдээлэл боловсруулалт

Чанарын судалгааны мэдээллийг боловсруулахдаа ярилцлага тус бүрийг Microsoft Office Word 2016 программд шивж оруулан, шивэлтийн алдааг хяналтын ажилтан хянаж, тайлан боловсруулах судалгааны менежерт хүлээлгэн өгөх процессын дагуу ажиллав. Агуулгын шинжилгээ, бүлэглэлийн шинжилгээ зэрэг чанарын судалгааны мэдээллийг нэгтгэн боловсруулах аргачлалыг ашиглан тайланг бэлтгэв.

1.2. СТАТИСТИК, ТООН МЭДЭЭЛЛИЙН СУДАЛГАА

1.2.1. Судалгааны зорилго

Уг судалгаагаар СБҮ-ийн салбарын статистик, тоон мэдээлэлд шинжилгээ хийн СБҮ-ийн салбарын өнөөгийн нөхцөл байдлыг тоон үр дүнгээр илэрхийлэх, хөгжлийн түвшнийг хэмжих гол шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, цаашдын стратеги төлөвлөгөөнд шаардлагатай тоон мэдээллийг гаргахыг зорьж ажиллав.

Судалгааны аргачлал, мэдээлэл цуглуулалт

СБҮ-ийн салбарын статистик тоон мэдээллийн судалгааны арга зүйн хувьд хоёрдогч тоон мэдээлэлд шинжилгээ хийх аргачлалын дагуу боловсруулав. Ингэхдээ холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос өгөгдлүүдийг цуглуулан нэгтгэн дүгнэлээ.

Төрийн байгууллагуудын хувьд Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Гаалийн ерөнхий газар (ГЕГ), Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ), Оюуны өмчийн газар (ОӨГ), Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Татварын ерөнхий газар (ТЕГ), Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ) зэрэг байгууллагуудаас албан ёсны статистик мэдээллийг цуглуулан боловсруулав.

Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос мэдээлэл цуглуулахад нийт 43 байгууллагад Соёлын яамнаас хандсан албан бичиг хүргүүлэн шаардлагатай тоон мэдээллийг гаргуулан авч ажилласан.

1.2.2. Статистик, тоон мэдээллийн судалгааны хамрах хүрээ

СБҮ-ийн салбарын статистик, тоон мэдээллийн судалгааны хамрах хүрээг 12 салбар чиглэл тус бүрд үндсэн таван төрлийн тоон мэдээллийг хүрээнд авч үзлээ. Үүнд:

- 1) ААНБ-ын тоо;
- 2) Ажиллагчдын тоо;
- 3) Үйл ажиллагааны борлуулалтын орлого;
- 4) Бараа бүтээгдэхүүний гадаад худалдаа;
- 5) Их, дээд сургууль, коллежийн төгсөгчдийн тоо;

ЮНЕСКО 2015 онд дэлхийн улс орнуудын тоон мэдээллийг нэгтгэн СБҮ-ийн салбарын тайланг боловсруулсан байдаг. Үүнд дурдсанаар СБҮ-ийн салбарын хөгжлийг хэмжих гол хэмжүүр нь эдийн

засагт үзүүлж буй нөлөө болон бий болгосон ажлын байрны тоо байдаг. Тус тайланд дурдсанаар СБҮ-ийн салбар дэлхийн хэмжээнд 2,250 тэрбум ам.долларын орлого олж, 29.5 сая ажлын байр бий болгосон байдаг (UNESCO, 2015).

1.2.3. Ашигласан статистик ангиллууд

Монгол Улсын СБҮ-ийн салбарын статистик, тоон мэдээллийн судалгаанд ашигласан статистик ангиллуудаас дурдвал:

- ▶ **Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал-4 (ЭЗБҮАСА-4) /Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал - International Standard Industrial Classification (ISIC 4)/**

Энэхүү ангилал нь НҮБ-ын Статистикийн комиссоос гаргасан олон улсын стандарт ангилал бөгөөд гишүүн орнууддаа өөрийн орны онцлогийг тусган, мөрдөж ажиллахыг зөвлөмж болгосон. Хуулийн этгээд, өмчийн бүх төрөлд хамаарах ААНБ, хүн амд үйлчилдэг төр, олон нийтийн байгууллага болон хувь хүний эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээг үйл ажиллагааны чиглэлээр нь бүлэглэж, судлах зорилготой боловсруулсан эдийн засгийн үйл ажиллагааны бүлэглэлт юм. Монгол Улсад ЭЗҮАСА 4 хувилбарыг ашиглаж байна. (Үндэсний Статистикийн Хороо, 2021)

- ▶ **Уялдуулсан Системийн (УС) Ангиллаар тодорхойлогддог соёлын бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсын худалдаа - Harmonised Commodity Description and Coding System 2007 (HS 2007) Өргөтгөсөн төлбөрийн тэнцэл -Extended Balance of Payments (EBOPS)**

- ▶ **Ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал - International Standard Classification of Occupations (ISCO 08) болон бусад салбарын статистик ангиллууд багтана.**

БҮЛЭГ 2

МОНГОЛ УЛСЫН СБҮ-ИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Монгол Улсын СБҮ-ийн хамрах хүрээ

Монгол Улсын СБҮ-д хамаарах үйл ажиллагаа, салбар чиглэлийг тодорхойлоход ЮНЕСКО-гийн ССХ, Монгол Улсын соёлын салбарын уран бүтээлч, мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага, судалгаанд үндэслэв. Энэхүү бүлэгт Монгол Улсын СБҮ-ийн салбарт хамаарах салбар чиглэлийг тодорхойлоход ашигласан суурь загваруудын талаар авч үзнэ.

2.1.1. ЮНЕСКО, Соёлын статистикийн хүрээ (ССХ), 2009²

Энэ хэсэгт ЮНЕСКО-гийн ССХ-г дүрслэн харууллаа. Үүнд, соёлын салбар, холбогдох салбарууд, нийтлэг хамааралтай салбарууд багтана.

СБҮ: Соёлын салбар нь соёлтой холбоотой үйлдвэрлэл, үйл ажиллагаа, практикийн нэгдэл бөгөөд дараах байдлаар бүлэглэн хувааж байна. Үүнд:

- A. Байгалийн болон соёлын өв;
 - B. Урлагийн тоглолт, баяр наадам;
 - C. Дүрслэх урлаг, гар урлал;
 - D. Ном, хэвлэл;
 - E. Аудио болон дүрс бичлэг, интерактив мэдээллийн хэрэгсэл;
 - F. Дизайн болон бүтээлч үйлчилгээ;
- Соёлын биет бус өв (нийтлэг хамааралтай салбар).

Эдгээр салбаруудыг соёлын салбарууд гэж тодорхойлсон байна. Мөн ЮНЕСКО-гийн зүгээс улс орнуудыг харьцуулах мэдээ мэдээлэл цуглуулахад дэмжиж буй салбаруудыг төлөөлөхөд авч үзнэ.

Холбогдох салбар: ССХ-ний холбогдох салбар нь дараах хоёр бүрэлдэхүүнийг багтаана. Үүнд:


- Аялал жуулчлал,
- Спорт, чөлөөт цаг.

Эдгээр салбаруудад соёлын элементүүд байдаг ч соёлын үйл ажиллагаа гэж тэр бүр авч үзлэггүй. Өөрөөр хэлбэл, үйл ажиллагаа нь соёлын шинжтэй байж болох ч тэдгээрийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд соёлын бус байдаг. Иймээс ССХ-д **холбогдох салбарууд** гэж тусгасан байна. (UNESCO Institute for Statistics, 2009)

Нийтлэг хамааралтай салбар: Соёлын үйлдвэрлэлийн дамжуулалтын үе шатанд голлох үүрэгтэй гурван өөр нийтлэг хамааралтай салбар байдаг. Тэдгээрийг нийтлэг хамааралтай салбарууд гэх учир нь соёлын болон тэдгээртэй холбоотой бүх салбарт бүгдэд нь хамаардаг явдал юм. Үүнд:

1. Соёлын биет бус өв;
2. Боловсрол, сургалт;
3. Архив, хадгалалт;
4. Тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслүүд багтана.

Схем 1: ЮНЕСКО, Соёлын статистикийн хүрээ, 2009



СБҮ-ийн салбарын статистик тоон мэдээллийг ЮНЕСКО-гийн ССХ-нд суурилан дараах схемийн дагуу бүлэглэж үзлээ. Үүнд, соёлын бүтээлч үйлдвэрлэл (СБҮ), тоног төхөөрөмж, дагалдах материал (ТТДМ), холбогдох салбар (ХС), СБҮ-ийн эдийн засаг (ЭЗ), СБҮ-ийн эдийн засгийн хамрах хүрээ (ЭЗХХ) гэсэн ойлголтууд тусгагдсан болно.

СБҮ: Тус салбарт соёлын мөчлөгийн янз бүрийн үе шатанд хамааралтай соёлын үйл ажиллагаа, бараа, үйлчилгээ багтдаг. ЮНЕСКО-ийн зүгээс соёлын салбарыг дараах байдлаар бүлэглэн хувааж үздэг. Үүнд:

1. Байгалийн болон соёлын өв (Биет бус өв-Нийтлэг хамааралтай салбар);
2. Урлагийн тоглолт ба баяр наадам;
3. Дүрслэх урлаг, гар урлал;
4. Ном, хэвлэл;
5. Аудио, дүрс бичлэг, интерактив мэдээллийн хэрэгсэл;
6. Загвар ба бүтээлч үйлчилгээ.

Монгол Улсын хувьд дээрх салбаруудыг үндсэн 12 салбарт хувааж үзсэн ба СБҮ-ийн салбар гэж нэрлэсэн. Үүнд:

1. Соёлын өв;
2. Утга зохиол, ном хэвлэл;
3. Дүрслэх урлаг, гар урлал;
4. Дуу хөгжим;
5. Тайзны урлаг;
6. Кино урлаг, дүрс бичлэг;
7. Хэвлэл мэдээлэл;
8. Хувцас загвар;
9. Архитектур;
10. Дизайн;
11. Дижитал инноваци, контент;
12. Маркетинг, зар сурталчилгаа.

Тоног төхөөрөмж, дагалдах материал /ТТДМ/: Энэхүү салбар нь “соёлын бүтээгдэхүүн болон соёлын үйл ажиллагааны хэрэгслийг” хамардаг. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь

соёлын агуулгатай хамаатай бөгөөд үүний зэрэгцээ тоног төхөөрөмж, дагалдах материал нь соёлын бүтээгдэхүүнийг **бүтээн бий болгох, түгээн тараах** (агуулгын хувьд зарим талаараа соёлын байсан ч) боломжийг бүрдүүлдэг, дэмждэг, нэмэлт үйлчилгээ үзүүлдэг тул энэ салбарт хамаарна. Энэ ангилалд мөн компьютер, мэдээллийн технологийг хамруулна (UNESCO Institute for Statistics, 2009).


СБҮ-ийн ЭЗ: СБҮ болон ТТДМ-ийг хамтад нь СБҮ-ийн ЭЗ гэж тодорхойлно.

Холбогдох салбар (ХС): Аялал жуулчлал, спорт, чөлөөт цагийн үйл ажиллагаа нь СБҮ-ийн холбогдох салбар юм. Өөрөөр хэлбэл, эдгээр салбарууд нь СБҮ-ийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг эдийн засагт дамжуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх гол чухал ач холбогдолтой салбарууд байдаг тул ЮНЕСКО-ийн ССХ-ний дагуу ХС-т хамааруулдаг байна. Тус салбарууд нь соёлын шинж чанартай үйл ажиллагаа явуулдаг ч эдгээрийг соёлын үйл ажиллагаа гэж авч үздэггүй. Учир нь эдгээр үйл ажиллагаанууд соёлын шинжтэй боловч тэдгээрийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд нь соёлын бус байдаг. (UNESCO Institute for Statistics, 2009)

СБҮ-ийн ЭЗХХ: СБҮ, ТТДМ, ХС зэргийг хамтад нь СБҮ-ийн ЭЗХХ гэж тодорхойлно.

Схем 2: СБҮ-ийн эдийн засгийн хамрах хүрээ (ЭЗХХ)

СБҮ-ийн ангилал, нэр томъёоны тайлбар



2.1.3. СБУ-ийн ерөнхий төвт тойргийн загвар

Дараах схемд СБУ-ийн ерөнхий төвт тойргийн загварыг дүрсэллээ. Энэхүү схем нь Соёлын өв, соёл урлаг, СБУ, эдийн засгийн бусад салбаруудын харилцан хамаарлыг тодорхойлно.

- **Соёлын өв** нь СБУ-ийн гол ЦӨМ бөгөөд үндэсний ялгарал үүсгэх үндэс, ундарга нь юм.
- **Соёл урлаг** нь Соёлын өв, авьяас билгээс эхтэй. Соёл урлагийн бүтээл туурвил нь уран бүтээлчийн мэдрэмж дээр үндэслэх бөгөөд нийгмийн болон эдийн засгийн үр өгөөжийг давхар өгнө. Биет бус үнэ цэн давамгайлдаг.
- **Соёлын бүтээлч үйлдвэрлэл** (СБУ) гэж соёл урлаг, Соёлын өвийн хэв шинжийг агуулсан бүтээл туурвил, бүтээлч

үйлчилгээ, бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг ойлгоно. СБУ нь орчин үеийн дэвшилтэт технологи, дижитал трендтэй хосолсноор цаашид тасралтгүй, тогтвортой хөгжих нөхцөл бүрдэнэ. СБУ нь нийгмийн болон эдийн засгийн үр өгөөжийг аль алиныг олгодог биет болон биет бус үнэ цэнийг бий болгодог.

- **Эдийн засгийн бусад салбар:** СБУ нь эдийн засгийн бусад салбарт дамболон шууд нөлөөлөх ба үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний өнгө төрх, загвар дизайн, орчны үнэ цэнийг нэмэгдүүлдэг.

СБУ-ийн гол хөдөлгөгч хүч нь **“БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭ, АВЬЯАС БИЛИГ”** байна.


Схем 5: СБУ-ийн ерөнхий төвт тойргийн загвар



2.1.4. СБУ-ийн процессын зураглал

Монгол Улсын СБУ-ийг үндсэн 12 салбар чиглэлд ангилсан. Эдгээр 12 салбар чиглэл нь процессын хувьд үндсэн 4 үе шатад хуваагдана. Үүнд, Соёлын өв, Соёл урлаг, Дизайн, Маркетинг, зар сурталчилгаа, хэвлэл мэдээлэл зэрэг процесс багтаж байна.

Схем 6: Монгол Улсын СБУ-ийн процессын зураглал



2.1.5. СБУ-ийн гарцад суурилсан загвар

СБУ-ийн сайжруулсан загвар нь СБУ-д хамаарах үйл ажиллагаануудыг Үйлчилгээ, Мэдрэмж, Эх бүтээл, Контент үйлдвэрлэл зэрэг шинж чанарыг агуулж буй байдлаар нь дөрвөн тэнхлэгт тархаан байршуулдаг.

Үйлчилгээний шинж чанар давамгайлж буй үйл ажиллагаанд Маркетинг, зар сурталчилгаа, Архитектур, Интерьер дизайн, Студи продакшны үйл ажиллагаанууд багтаж байна. Контент үйлдвэрлэл давамгайлж буй үйл ажиллагаанд Хэвлэн нийтлэх үйл ажиллагаа, Хэвлэл мэдээлэл, Телевиз радио, Кино продакшн зэрэг багтана. Үйлчилгээ болон контент үйлдвэрлэлийн хэв шинжийг зэрэг агуулж буй үйл ажиллагаанд Зар сурталчилгаа, График дизайн, Тоглоом хөгжүүлэлт, Гэрэл зураг, Номын сан зэрэг багтана. Мэдрэмжийг

олгож буй үйл ажиллагаанд Соёлын аялал жуулчлал, Амралт, соёлын төв багтана. Мэдрэмж болон үйлчилгээг зэрэг агуулж буй үйл ажиллагаанд Кино театр багтаж байна. Эх бүтээлд Соёлын өв, Дүрслэх урлаг, Гар урлал хамаарч байна. Эх бүтээл, мэдрэмж олгох үйл ажиллагаанд Музей, Түүх соёлын дурсгалт газар, Үзэсгэлэн, галерей багтана. Эх бүтээл болон контент үйлдвэрлэлийн шинж чанарыг зэрэг агуулж буй үйл ажиллагаанд Утга зохиол, ном хэвлэл, Хувцас загвар, Дуу хөгжим хамаарч байна. Эдгээр дөрвөн шинж чанарыг бүгдийг агуулж буй үйл ажиллагаанд Цирк, Тайзны урлагийн тоглолт, Дуурь, балет, Концерт, шоу тоглолт зэрэг багтана.

Тус загварт дурдсан үйл ажиллагааны чиглэлүүдүүгээр хязгаарлагдахгүй бөгөөд бусад олон төрлийн үйл ажиллагааг тус жишгээр ангилах боломжтой.

Схем 7: СБУ-ийн сайжруулсан загвар



2.1.6. СБУ-ийн эко системийн суурь загвар³

Бүтээлч үйлдвэрлэлийн экосистемийн загварын хүрээн дэх интеграцийг дотоод (дэд систем, элементүүдийн хоорондын уялдаа холбоо) болон гадаад (үндэсний инновацийн тогтолцоо, эдийн засаг, олон улсын хамтын ажиллагаа) гэсэн 2 үндсэн чиглэлээр авч үзсэн ба олон тооны нийгмийн институт, байгууллагууд оролцож байгаа тул бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан нэг салбар гэж үзэх үндсийг бүрдүүлж байгаа юм.

Уг загвар нь үндэсний инновацийн тогтолцоонд суурилсан 4 дэд систем, тогтолцооны механизмын үүрэг гүйцэтгэх хүрээ болон бүтцийн үндсэн элемент (байгууллага) зэргээс бүрдэнэ. Үүнд:


- **Судалгаа ба хөгжүүлэлтийн дэд систем:** Сургалтын байгууллага, шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд, Соёлын өвийн үндэсний төв;
- **Контент үйлдвэрлэлийн дэд систем:** соёл, урлагийн байгууллагууд, санхүүгийн компани, технологийн компани, креатив компаниуд;
- **Түгээлтийн дэд систем:** соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл, үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн зах зээл;
- **Соёлын бодлогын дэд систем:** мэдээллийн, хууль эрх зүйн, удирдлага зохион байгуулалт, мэргэжлийн, холбоод, дэд бүтэц тус тус багтана.

Уг загвар нь дэд системүүдэд тулгуурласан урлаг, шинжлэх ухаан, боловсрол, төр, бизнес, болон зах зээлийг хамрах 4 хүрээнээс бүрдэх юм. Үүнд:

- Соёлын өвийн судалгаа ба хөгжүүлэлтийн хүрээ:** Үндэсний өв, соёлыг судлах үйл ажиллагааг төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хүрээнд төсвийн санхүүжилтээр Сургалтын байгууллага, Соёлын өвийн үндэсний төв болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд хэрэгжүүлнэ.
- Соёлын контент хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн хүрээ:** үндэсний соёлыг арилжааны зорилгоор бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх, үйлдвэрлэх үйл ажиллагааг хувийн хэвшлийн үйл ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- Түгээлт, арилжааны хүрээ:** Соёлын бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд түгээлтийн системд тулгуурлан түгээх, арилжих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- Соёл урлагийн боловсролын хүрээ:** Үндэсний соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хүн амд соёл, урлагийн боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

³ Эх үүсвэр: Ж.Эрхэмтөгс, ЮНЕСКО, БУИТ, "Бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх онол, практикийн асуудал", 2019

Схем 8: Бүтээлч үйлдвэрлэлийн салбарын эко системийн суурь загвар



Эх үүсвэр: Ж. Эрхэмтөгс, ЮНЕСКО, БУИТ, "Бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх онол, практикийн асуудал", 2019

2.1.7. СБҮ-ийн хөгжлийн суурь зарчим

Монгол Улсын СБҮ-ийн хөгжлийн суурь зарчмыг Соёлын яамны хөгжлийн бодлого, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг "Алсын хараа-2050", Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт зэрэгтэй уялдуулан дараахь таван зарчмын дагуу тодорхойллоо.

- 1. Байгалиа дээдэлсэн тогтвортой хөгжлийг эрхэмлэнэ.** СБҮ-д хамаарах бүх салбар чиглэлүүд үйл ажиллагааны процесс, бодлого, төлөвлөлт, алсын хараа зэрэгт байгаль орчноо дээдэлсэн үзэл баримтлалыг эрхэмлэж ажиллана.
- 2. Тэнцвэртэй, тасралтгүй хөгжүүлэлтийг дэмжинэ.** СБҮ нь Монгол уламжлалт соёл, болон

бүтээлч сэтгэлгээ, шинэчлэлийг тэнцвэртэй, тасралтгүйгээр хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.

- 3. Авьяас билгийг дээдэлнэ.** Монгол Улсын СБҮ-ийн үндэсний авьяастнуудыг эрэл хайгуул хийж, дэмжиж хайрлан хамгаална. СБҮ-ийн хөгжлийн гол хөдөлгөх хүч нь бүтээлч авьяас билиг байна.
- 4. Тэгш оролцоог хангана.** СБҮ нь насны бүлэг, хүйсээр үл ялгаварлах, хөгжлийн бэрхшээл, нийгмийн цөөнх иргэдийн ажиллах боломж, оролцоог дэмжинэ.
- 5. Дэлхийн стандартад нийцүүлнэ.** Монгол Улсын СБҮ-ийн хөгжлийг олон улсын жишигт нийцүүлэн, технологи, дижиталчлалыг дэлхийн стандартад хүргэхийг зорьж ажиллана.

Зураг 1: Монгол Улсын СБҮ-ийн хөгжлийн суурь зарчмууд



2.2. Олон улс дахь СБҮ-ийн салбарын хөгжил

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ 2013 ОНД

2.3 ИХ НАЯД АМ. ДОЛЛАР

2015 онд дэлхийн СБҮ-ийн салбарын эдийн засагт үзүүлсэн нөлөөг ЮНЕСКО тодорхойлж байжээ. (UNESCO, 2015) Уг судалгаа нь архитектур, тайзны урлаг, дүрслэх урлаг, кино, утга зохиол, хөгжим, сонин сэтгүүл, зар сурталчилгаа, радио, телевиз, дижитал тоглоом зэрэг 11 салбар чиглэлийн хүрээнд дэлхийн 5 тивийн улс орнуудыг хамруулан судалжээ. The First Global Map of Cultural and Creative Industries, UNESCO, (EY, 2015) Тус тайланд дурдсанаар дэлхийн СБҮ-ийн эдийн засагт үзүүлсэн нөлөө 2013 оны байдлаар 2.3 их наяд ам.доллар байжээ. Энэ нь 2013 оны дэлхийн харилцаа холбооны үйлчилгээний нийт орлого (1,570 тэрбум ам.доллар), Энэтхэг улсын ДНБ (1,900 тэрбум ам.доллар)-ий хэмжээнээс давж байв. Хамгийн их орлого олж буй салбар чиглэл нь нэгдүгээрт телевизийн салбар (477 тэрбум ам.доллар), хоёрдугаарт дүрслэх урлаг (391 тэрбум ам.доллар), гуравдугаарт сонин сэтгүүлийн салбар (354 тэрбум ам.доллар) тус тус эрэмбэлэгджээ.

ДЭЛХИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ 100 ХҮН ТУТМЫН НЭГ НЬ

СБҮ-ийн САЛБАРТ АЖИЛЛАЖ БАЙНА

Дэлхийн СБҮ-ийн ажиллагчдын тоо (29.5 сая) нь дэлхийн идэвхтэй ажиллах хүчний 1 хувийг бүрдүүлж байна. Дэлхийн СБҮ-ийн салбарт хамаарч буй 11 салбар чиглэлээс хамгийн их ажлын байр бий болгож буй салбар нь нэгдүгээрт, дүрслэх урлаг (6.73 сая), хоёрдугаарт, ном, хэвлэл (3.67 сая), гуравдугаарт, хөгжмийн салбар (3.98 сая) байх ажээ (EY, 2015).

2015 оны байдлаар дэлхийн нүүрсний экспортын хэмжээ 78.4 тэрбум ам доллар байсан бол СБҮ-ийн салбарын экспортын хэмжээ 500.0 тэрбум ам доллар байжээ. Үүнээс харвал СБҮ-ийн экспортын дүн нь дэлхийн нүүрсний экспортын дүнгээс 6.4 дахин их байжээ (Workman, 2021).

Шигтгээ 1: Монгол Улсын газар зүйн байршлын давуу тал

Ази, Номхон далайн бүс нутаг нь 2013 онд дэлхийн СБҮ-ийн салбарын орлогын 33 хувь (743 тэрбум ам.доллар), ажиллах хүчний 43 хувь (12.7 сая) -ийг бүрдүүлж байна. Ази, Номхон далайн бүс нутаг нь хамгийн том хэрэглэгчийн зах зээл бөгөөд Дижитал тоглоом, Архитектур, Киноны зах зээлээр дэлхийд тэргүүлж байна (EY, 2015).

**СБҮ-ийн салбарын дэлхийн
ЭКСПОРТЫН ХЭМЖЭЭ,**
2015 оны байдлаар

**ДЭЛХИЙН НҮҮРСНИЙ
ЭКСПОРТЫН ХЭМЖЭЭНЭЭС 6.4
ДАХИН ИХ БАЙЖЭЭ.**



БҮЛЭГ 3

МОНГОЛ УЛСЫН СБҮ-Д ТУЛГАМДАЖ БУИ НИЙТЛЭГ АСУУДЛУУД

Монгол Улсын СБҮ-ийн салбарт тулгамдаж буй асуудлыг Хүний нөөц, Эко систем, Дэд бүтэц, Хөрөнгө оруулалт, Маркетинг зэрэг таван чиглэлийн хүрээнд судлав. СБҮ-ийн салбарын 12 салбар чиглэлийн хүрээнд тулгамдаж буй нийтлэг асуудал, тэдгээрийг шийдвэрлэх боломжийг нэгтгэн энэхүү бүлэгт танилцуулья.

3.1. ХҮНИЙ НӨӨЦ

Олон улсын судалгаануудад чадварлаг хүний нөөцийн ур чадвар нь СБҮ-ийн салбарыг хөгжүүлэх суурь үндэс байдаг хэмээн үзэж байна. Тухайлбал, Их Британи улсын парламентын гишүүдээс авсан судалгаанд “Боловсрол болон ур чадвар нь бүтээлч үйлдвэрлэлийн салбарыг урт хугацаанд амжилттай хөгжүүлэх гол хөдөлгөгч хүч” хэмээн нийт судалгаанд оролцогчдын 37 хувь нь үзсэн байдаг (MP Panel, 2015). Монгол Улсын хувьд СБҮ-ийн салбарын уран бүтээлчид авьяас чадвараараа Монголдоо төдийгүй дэлхийд танигдаж, Монгол Улсын нэр хүндийг олон улсад таниулж байна. Гэтэл СБҮ-ийн салбарыг хөгжүүлэх нь дан ганц авьяас чадвартай байгаад шийдэгдэх асуудал биш юм. Манай уран бүтээлчид хосгүй авьяас билигтэй боловч түүнийгээ бусдад сурталчлах, маркетинг, менежмент хийх, өөрийн уран бүтээл, эрх ашгаа хамгаалах хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгаа нь олон салбарт ажиглагдаж байна. Нэн ялангуяа, дуу хөгжим, кино урлаг, дүрслэх урлагийн салбарын уран бүтээлчид өөрсдийн оюуны өмчөө хамгаалахад Монгол Улсын СБҮ-ийн салбарын хүний нөөцийн чиглэлд дараах сайжруулалтыг хийх шаардлагатай.

3.1.1. Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх

Олон улсын судалгаанд хүний СБҮ-ийн салбарын уран бүтээлч, мэргэжилтнүүдийн нийтлэг тулгамдаж буй асуудалд уран бүтээлчдийн ур чадварыг олон улсын түвшинд хүргэх, нэн эрэлт хэрэгцээтэй мэргэжлүүдээр

гадаадад болон дотоодод сургах, багшлах хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, хууль эрхзүй, менежмент, санхүүгийн чиглэлийн мэдлэг олгох зэрэг багтана. Энэ хүрээнд:

• Гадаадад тэтгэлгээр сургах:

Нэн шаардлагатай тэргүүлэх чиглэлийн уран бүтээлч, нарийн мэргэжилтнийг гадаадад тэтгэлгээр жил бүр тогтмол сургах,

СБҮ-ийн хамгийн эрэлт хэрэгцээтэй мэргэжлүүдэд:

- Найруулагч /Бүх чиглэлд/;
- Арт менежер;
- Судлаач, шүүмжлэгч;
- Куратор;
- Зураглаач;
- Гэрлийн техникч;
- Тайзны зураач;
- Өнгө шүүлтийн мэргэжилтэн;
- Дууны мастер;
- График дизайнер;
- Материал судлаач, технологич;
- Оёдолчин, эсгүүрчин зэрэг багтана.

• Дотоодод мэргэшүүлэх сургалт зохион байгуулах:

Салбар бүрд гол ач холбогдолтой чиглэлд мэргэшүүлэх сургалтыг дотооддоо зохион байгуулах, гадаадын мэргэжилтэн урьж багшлуулах.

• Багшлах хүний нөөцийг чадавхжуулах:

Багшлах хүний нөөцийг чадавхжуулах, чадварлаг уран бүтээлчдийг ЗӨВЛӨХ БАГШААР ажиллуулах.

• Нарийн мэргэжлүүдэд зэрэглэл тогтоох:

Дизайнер, найруулагч, зохиолч нарыг зэрэгжүүлэх.

• Хууль эрхзүй, менежментийн мэдлэг олгох:

Уран бүтээлч, мэргэжилтнүүдэд оюуны өмчийн тухай хууль, бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах гэрээ гэх мэт хууль эрх зүйн мэдлэг олгох, сургалт зохион байгуулах.

• Менежмент, маркетинг, хууль эрхзүй, санхүүгийн зөвлөх үйлчилгээний кластер байгуулах:

СБҮ-ийн салбарын уран бүтээлчид өөрсдийн хосгүй бүтээлээ олон нийтэд таниулж өөрийгөө үнэлүүлэх, цаашлаад худалдан борлуулахад мэдлэг, ур чадвар дутагдаж байгаа тухай олонтоо дурдаж байна. Иймд уран бүтээлчдийг энэ чиглэлийн зөвлөх үйлчилгээг хөнгөлөлттэй үнээр авах боломжийг бүрдүүлэх хэрэгцээ их байна. Ингэснээр эх бүтээлээс хүртэх эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

3.1.2. Сургалтын хөтөлбөрийг сайжруулах, шинэчлэх

СБҮ-ийн бүх түвшний сургалтын хөтөлбөрийг сайжруулах, шинэчлэх шаардлагатай болсныг салбар чиглэл бүрээс оролцсон уран бүтээлч, мэргэжилтнүүд дурдаж байна. Ингэхдээ дараах зүйлсийг анхааралдаа авах шаардлагатай. Үүнд:

• Олон улсын стандартад нийцүүлэх:

Олон улсын стандартад нийцсэн хөтөлбөр, технологийг сургалтын программдаа нэвтрүүлэх, их дээд сургуулиудад тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, чанартай боловсрол олгох нөхцөлийг бүрдүүлэх.

3.1.3. Нийгмийн баталгаа хангах

СБҮ-ийн салбарын төрийн албан хаагчид, уран бүтээлчид, мэргэжилтнүүдийн нийгмийн асуудлыг анхааралдаа авч нийгмийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Энэ хүрээнд дараах арга замуудаас хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

• Залуус хороолоос СБҮ –ийн салбарын уран бүтээлч болон мэргэжлийн ажиллагчдад орон сууц олгох:

СБҮ–д ажиллаж буй уран бүтээлчдийг дэмжих нэг боломж нь Залуус хороолоос 1,000 байрыг хөнгөлөлттэй үнэ, зээлийн нөхцөлөөр

олгох боломжтой.

• Цалин нэмэгдүүлэх:

СБҮ-ийн нийт ажилтнуудыг үе шаттайгаар нэмэгдүүлэхийг санал болгож байна.

3.2. ЭКО СИСТЕМ

Эко системийн хүрээнд салбарын бодлого, хууль эрх зүйн орчин, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тодруулсан. Энэ хүрээнд судалгаанд оролцогчдоос дараах саналуудыг өгч байна.

3.2.1. Мэргэжлийн холбоо, хамтын удирдлагын байгууллагыг дэмжих:

СБҮ-ийн 12 салбар чиглэлд олон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээр байгууллагуудаас төрийн дэмжлэггүй ч өөрсдийн нөөцөө боломж дайчлан идэвхтэй үйл ажиллагаа явуулж Монгол Улсын соёлын салбарыг хөгжүүлэхийн төлөө олон жил зүтгэж ажиллаж буй олон байгууллагуудыг дурдаж болно. Гэсэн хэдий ч тэдгээр байгууллагын урт хугацааны тогтвортой үйл ажиллагааг хангахын тулд төр засаг тэдгээрийг анхаарч, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгааг холбогдох мэргэжилтнүүд дурдаж байв. СБҮ-ийн салбарын эко системийг хөгжүүлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг дурдвал:

• Тогтвортой байдлыг дэмжих

Хамтын удирдлагын байгууллага, мэргэжлийн холбоодыг байгуулахад дэмжлэг үзүүлэх, тэдний үйл ажиллагааг тогтвортой болгоход бодлогоор дэмжих;

• Төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх

Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг бусад мэргэжлийн холбоо, хамтын удирдлагын байгууллагуудад хариуцуулан гүйцэтгүүлэх замаар төрийн ачааллыг хөнгөлөх, мөн мэргэжлийн холбоо, хамтын удирдлагын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх боломжтой;

3.2.3. Оюуны өмчийг бодитоор хамгаалах

ОЮУНЫ ӨМЧИЙГ ХАМГААЛАХАД

ДЭМЖЛЭГ ХЭРЭГТЭЙ БАЙНА.

Оюуны өмчийг хамгаалах тухай хууль тогтоомж байгаа хэдий ч уран бүтээлчдийн бүтээлийг бодитоор хамгаалахад учир дутагдалтай байгааг судалгаанд оролцогчид онцолж байна. Тухайлбал:

- **Процессыг тодорхой, түргэн шуурхай болгох**
Оюуны өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг илүү тодорхой, хурдан шуурхай болгох;
- **Хохирлыг барагдуулдаг байх**
Уран бүтээлч, мэргэжилтнүүдийн хохирлыг барагдуулдаг байх;
- **Торгууль, шийтгэлийг чангатгах**
Мөнгөн торгуулийг чангатгах, эрүүгийн хуулиар шийдэх боломжийг судлах;
- **Санал гомдол, маргаан шийдвэрлэх байдалд дүн шинжилгээ хийх**
Оюуны өмчийн газарт уран бүтээл, соёлын үйлдвэрлэлтэй холбоотой маргаан шийдвэрлэлтийн байдалд судалгаа хийж, маргааны төрөл, бүртгэл, эзэмшил, өмчлөл, гэрээ, эрх зүйн байдалд дүн шинжилгээ хийх.

3.2.4. Татварын бодлогоор СБҮ –ийг дэмжих

СБҮ-ийн дэмжих өөр нэг хувилбар нь татварын хөнгөлөлт үзүүлэх явдал юм. Дараах саналуудаас СБҮ-д ашиглагдаж буй сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай асуудлыг хамгийн ихээр хөндөж байлаа.

- **Тоног төхөөрөмжийн гаалийн татвар**
Стратегийн ач холбогдолтой орчин үеийн тоног төхөөрөмж, түүхий эд материалыг импортын татвар, НӨАТ-аас чөлөөлөх;
- **Хөрөнгө оруулалтын татвар**
Урлаг, соёлыг ивээн тэтгэсэн ААН-ийн хөрөнгө оруулалтыг татвараас хасагдах зардалд тооцох;
- **Гадаадын экспертүүдийн орлогын татвар**
Гадаадаас урьж авчирсан хамтлаг, уран бүтээлчид, мэргэжилтнүүдийн орлогоос төлөх татварыг хөнгөлөх;
- **Татварын буцаан олголт**
Монгол Улсад кино бүтээл хийсэн тохиолдолд төлсөн татварын тодорхой хувийг буцаан олгох;
- **Кино бүтээх зардлын буцаан олголт, нөхцөл**
Монгол Улсын нутаг дэвсгэрт Монголын болон гадаадын хуулийн этгээд хамтран кино үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.2.5. Уран бүтээлчдийн эрх ашгийг хамгаалах

СБҮ-ийн салбарын уран бүтээлчид өөрсдийн бүтээлээ ААНБ-уудтай бараа бүтээгдэхүүн, контент хэлбэрээр худалдан борлуулах, олон нийтэд

түгээх гэрээ хийж ажилладаг боловч гэрээ хийсэн ААНБ-ууд борлуулалтын мэдээллийг бодитоор тайлагнахгүй байх, худалдан борлуулсан тоо хэмжээг нуун дарагдуулах, тоог багасгаж мэдэгдэх зэрэг асуудал тохиолддог байна. Иймд бизнесийн байгууллагуудтай харилцан ашигтай гэрээ байгуулах, борлуулалтын тоо хэмжээг гэрээ байгуулсан уран бүтээлч нарт шилэн байдлаар үнэн зөв тайлагнадаг байх нөхцөлийг хуулиар зохицуулж, олон улсын стандартад нийцүүлж өгөх шаардлагатай. Ингэснээр уран бүтээлчдийн орлого нэмэгдэж дахин шинэ бүтээл хийх, түүнээс эдийн засгийн үр өгөөж хүртэх боломж нэмэгдэнэ.

3.2.6. Салбар, чиглэлийн хууль эрх зүйн орчныг тодорхой болгох

Шинээр эрчимтэй хөгжиж буй салбар чиглэлийн хууль эрх зүйн орчныг сайжруулах, тодорхой болгох шаардлагатай. Үүнд:

- Цахим, дижитал орчин;
- График дизайн;
- Интерьер;
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль гэх мэт.

3.3. ДЭД БҮТЭЦ

СБҮ-ийн дэд бүтцэд СБҮ-ийн цогцолбор хороолол, дүүрэг, хотын барилга байгууламж, цахим программ, платформ, тоног төхөөрөмж зэргийг хамруулж ойлгоно. Энэ хүрээнд дараах ерөнхий саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

3.3.1. СБҮ-ийн цогцолбор байгуулах СБҮ-ийн цогцолборыг байгуулах нь дараах ач холбогдолтой

- **Нэг дор суралцах, чадавхжих боломж:**

СБҮ-ийн нэгдсэн цогцолбор байгуулснаар уран бүтээлчид нэг дор хамтран ажиллах, суралцах, өрсөлдөх боломжийг бүрдүүлнэ;

- **Хямд, тогтвортой түрээсийн байр:**
СБҮ –ийн уран бүтээлч, мэргэжилтэн, байгууллагыг хөнгөлөлттэй үнэ бүхий тогтвортой түрээсийн байраар хангана;
- **Хууль, менежмент, маркетингийн зөвлөх үйлчилгээг нэг дороос авах:**
СБҮ –ийн салбарын уран бүтээлчид хууль, менежмент, маркетингийн үйлчилгээг нэг дор авна;
- **Өндөр үнэтэй тоног төхөөрөмжийг дундаа худалдан авч ашиглах:**
Хувцас загвар, дуу хөгжим, студи продакшн өндөр үнэтэй тоног төхөөрөмжөө дундаа худалдан авч ашиглах боломжийг бүрдүүлнэ. Энэ нь эдийн засгийн бодит дэмжлэг болно;
- **Үзэсгэлэн, арга хэмжээний танхим:**
Үзэсгэлэн, арга хэмжээ, загварын шоу зохион байгуулах боломж бүхий том танхим байгуулна;
- **Кино үйлдвэр, студи продакшн:**
Олон улсын стандартад нийцсэн кино үйлдвэр, студи продакшн нэг дор төвлөрч ажиллана;
- **Шинжилгээний лаборатори:**
Судалгаа, шинжилгээний лаборатори, материалын шинжилгээний лаборатори байгуулна.

3.3.2. Цахим ХАБ байгуулах

1. СБҮ –ИЙН ЦАХИМ ХАБ

- **Уран бүтээлч, мэргэжилтний мэдээллийг бүртгэлжүүлэх:** СБҮ-ийн салбарт хэчнээн тооны уран бүтээлчид ажиллаж байгааг албан ёсоор бүртгэлжүүлж, нэгдсэн мэдээллийн санд бүртгэх;
- **Бүтээл туурвилын нэгдсэн мэдээллийн платформ хөгжүүлэх:** Дуу хөгжим, дүрслэх урлаг, ном хэвлэл, утга зохиол зэрэг СБҮ –ийн бүх салбарын уран бүтээлийн нэгдсэн мэдээллийн сан, каталог, платформыг хөгжүүлэх;

Шигтгээ 2: Зохиогчийн эрхийн зөрчил

“Бүтээлээ бүртгүүлж зохиогчийн эрх авахад шат дамжлага, цаг хугацаа их ордог. Ихэвчлэн энэ хугацаанд л зохиогчийн эрх зөрчигдөх, хууль бусаар хуулбарлах, олшруулах зэрэг зөрчлүүд гардаг. Тэдгээрийг холбогдох байгууллагад мэдүүлж гомдол гаргахад зохиогчийн эрхээ албан ёсоор аваагүй байгаа учраас хэрэгсдэггүй”

- **Одоо байгаа бүртгэл, мэдээллийн санг ашиглах:** Одоо байгаа бүртгэл, мэдээллийн сангуудыг уран бүтээлч, мэргэжилтнүүд, мэргэжлийн холбоодод нээлттэй болгох, ашиглах эрхийг олгох, эдийн засгийн эргэлтэд оруулах, хянах эрхийг Соёлын яаманд олгох;
- СБҮ-ийн нийт уран бүтээлч, мэргэжилтнүүдийг нэг системд бүртгэлжүүлэх;
 - ▶ Уран бүтээлчид, тоног төхөөрөмж, байгууллагын мэдээлэл, хаяг байршил зэргийг нэг дор бүртгэж ашиглах;
 - ▶ Уран бүтээлч, мэргэжилтнүүдийг ур чадвараар нь зэрэгжүүлэх;
 - ▶ Олон улсын уралдаан наадам, тэтгэлэгт шалгаруулахад ашиглах;
 - ▶ Хүний нөөцийн бодлого чиглэл, стратегийг тодорхойлоход ашиглах;
 - ▶ Хүний нөөцийг чадавхжуулах, мэргэшүүлэхэд ашиглах.

2. Соёлын биет болон биет бус өвийн мэдээллийн сан – glam

Соёлын биет болон биет бус өвийн нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд GLAM загвараар хамтад нь хөгжүүлэх нь үр дүнтэй. Галерей, Номын сан, Архив, Музейд байгаа зураг, мэдээлэл, түүх, археологийн олдвор, ном, архивын бичиг баримтуудыг нэг дор бүртгэж, цахим каталог үүсгэснээр хаана юу байгаа нь тодорхой болж, Монгол Улсын иргэд болон дэлхийн Монгол судлаачид судалгаа, шинжилгээ, сургалт хөгжлийн зорилгоор авч ашиглах боломж бүрдэнэ.

- Монгол Улсын соёлын өвийг хадгалах, хамгаалах;
- Үнэ цэнтэй соёлын биет өвийг сурталчлах, олон нийтэд таниулах, хэрэглээнд нэвтрүүлэх;
- Мэдээллийн сан, бүртгэлээр дамжуулан уран бүтээлийн сэдэл, санаа авах, судалгаа шинжилгээг

- үргэлжлүүлэх;
- Монгол Улсын түүх соёл, үнэ цэн, ур чадварыг дэлхийд таниулах;
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдыг татах.

АЖИЛЛАХ ЗАРЧИМ:

- Салбар, чиглэл тус бүрд мэргэжлийн холбоо, хамтын удирдлагын байгууллага хариуцан бүртгэлжүүлэх;
- Олон улсын стандартын дагуу бүртгэлийг хөтлөн явуулах;
- Салбар чиглэл тус бүрийн бүртгэлийн бүтэц нэг стандартын дагуу зохион байгуулагдах;
- Бүх салбар чиглэлийн мэдээллийн бүртгэл, нэгтгэлийг Соёлын яам удирдан хянах.

МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН КЛУБИЙГ ДЭМЖИХ:

- Гол оролцогч талуудын мэргэжлийн төлөөлөл орсон клубийг Соёлын яам дэмжих;
- Бодлогоор GLAM санг уялдаа холбоотойгоор хөгжүүлэх;
- Мэргэжилтнүүдийг хооронд нь холбох гүүр болох (Networking).

ДИЖИТАЛ САН ҮҮСГЭХ:

- GLAM-д байгаа бүх ном, архивын материал, үзмэр, зураг баримал зэрэг соёлын биет болон биет бус өвийг нэг системд нэгтгэн бүртгэлжүүлэх;
- Дэлхийн дижитал каталогид нэгтгэх.

ХЭРЭГЛЭЭ, МЭДЛЭГ БОЛГОХ:

- Соёлын биет болон биет бус өвийн мэдээллийн нэгдсэн системийг ашиглах, хэрэглэх, мэдлэг олж авах.

3.4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

СБҮ-ийн хөрөнгө оруулалттай холбоотой тулгамдаж буй асуудлуудыг тодруулахад дараах нийтлэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь ажиглагдаж байна.

1. Хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулах

- а. Олон улсын дэмжлэгтэй сан байгуулах төсөл бэлтгэх;
2. Чиглэлийг тодорхойлж, санг бүрдүүлэх, ХОМК-ийг байгуулах;
3. ХО-ын төслүүдийг санхүүжүүлэх;
4. Өгөөжийг хүлээн авч, дараагийн төслүүдэд оруулах;

3.4.1. СБҮ-ийн хөрөнгө оруулалтын сангийн зарчим:

- ЗГ - Соёлын яамны оролцоо (<20%);
- СБҮ-ийн цогцолбороор хувиа баталгаажуулах;
- Улсын төсвөөс хөрөнгө оруулах, бонд гаргах;
 - ▶ Соёл урлагийг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх – ХО-ын өгөөжөө бусад салбарт оруулах / Олон улсын хөрөнгө оруулалтын сангууд, Хувийн хэвшил, Хувь хүн/

Үйл ажиллагааны чиглэл:

- Санхүүжилт босгох, олгох;
- Зах зээлийг үүсгэх;
- Хөрөнгө оруулагчдад мэдээлэл зөвлөгөө өгөх;
- Уран бүтээлчдэд санхүү, менежментийн зөвлөгөө өгөх;

3.4.2. СБҮ-ийг НӨАТ –аас чөлөөлөх:

НӨАТ-аас чөлөөлөхөд баримталдаг 5 зарчмыг бүгдийг хангаж байна.

1. Татвар ногдуулахад хүндрэлтэй (Hard to tax)
2. Олон нийтийн ашиг сонирхол (Public interest)
3. Олон улсын хандлага (International trends)
4. Бодлоготойгоор хөгжүүлэх салбар (Target sector)

5. Түр тусгай арга хэмжээ (Temporary special measurement)

3.4.3. СБҮ-ийн ААНБ-д зээл олгох:

- Ковидын улмаас хамгийн их хохирсон салбар;
- Бүртгэлгүй, орлого нотлох боломжгүй;
- Барьцаа хөрөнгөгүй - оюуны өмч барьцаа болдоггүй;
- ЖДҮХС => ХХААХҮЯ => СБҮ-ийг хамруулдаггүй;
- Хөгжлийн банк – салбарын төсөлд хөрөнгө оруулалт хийдэггүй;

3.4.4. Зээлийн шугам нээх:

- Ажлын байрыг дэмжих (3%-ийн) зээлээс соёл, урлагийн үзвэр үйлчилгээний газруудад зориулсан зээлийн шугам нээх;
- Репо санхүүжилтийн зээлийн шугам нээх;
- ЖДҮХС болон Хөгжлийн банкны санхүүжүүлэх, төслийн хамрах хүрээнд оруулах;

3.4.5. Гадаад, дотоодын ОУУН, үзэсгэлэнд хөрөнгө оруулалт хийх:

Гадаадад ОУУН-д оролцоход дэмжих:

Тэргүүлэх ач холбогдолтой чиглэлийн уран бүтээлчид, мэргэжилтнүүдийг гадаадын ОУУН, үзэсгэлэн, арга хэмжээд оролцоход хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

Дотооддоо ОУУН зохион байгуулах:

Дотооддоо ОУУН, арга хэмжээ, фестиваль, конференц зохион байгуулахад хөрөнгө оруулах.

Шигтгээ 3: Хөрөнгө оруулалтыг дэмжих

"Хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх нь СБҮ-ийг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай"

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

3.5. МАРКЕТИНГ, БОРЛУУЛАЛТ

1. Монгол Улсыг таниулах стратегия тодорхойлох

- Монгол үндэсний хэв маяг, Соёлын өв, үнэт зүйлс, **брэндийг** олон улсад болон дотоодын хэрэглэгчдэд сурталчлан таниулах нэгдсэн бодлого стратегитай болох;

2. Аялал жуулчлалаар дамжуулан сурталчлах

- БОАЖЯ-тай хамтран СБҮ-ээр дамжуулан гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах;

3. Цахим орчин дахь мэдээлэл, сурталчилгаагаа сайжруулах

- Монгол Улсын онлайн орчин дахь харагдах байдал /online presence/-ыг сайжруулах;
- Уран бүтээл, дизайн, бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, сурталчлан таниулах, олон нийтэд түгээх онлайн каталог, платформ, мэдээллийн сан хөгжүүлэх;

4. Үндэсний соёл уламжлалаа сурталчлан таниулах кампанит ажлууд

- Бүх үйл ажиллагааг Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулж, СБҮ-ийн олон улсаас санхүүжилтийн эх үүсвэрийг татаж, дэлхий нийтийн анхаарлыг татах боломжтой.

5. Эсгий туургатны соёлын нэгдсэн арга хэмжээ

- Эсгий туургатны соёлын их наадмыг 2022 онд зохион байгуулах;
- Монгол туургатны хувцас дизайны шоу зохион байгуулах;

6. СБҮ-ийн нэгдсэн форум зохион байгуулах

- Соёлын салбарын шилдэг төслүүдийн PITCH DAY зохион байгуулж, тэргүүлэх компанийн CEO, СМО-г оролцуулах;
- Соёлын салбарын судалгаа, зохиол бүтээлүүдийн танилцуулга хийх;
- Бүтээлч үйлдвэрлэлийн салбарын нэгдсэн үзэсгэлэн зохион байгуулах;



- 2021 оныг НҮБ-ээс “Тогтвортой хөгжлийн төлөө бүтээлч эдийн засгийн олон улсын жил” болгон зарласан. Тус хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын СБҮ-ийн чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагаа, арга хэмжээ, фестивалийн талаарх мэдээллийг шууд дэлхийд сурталчлах боломжтой.



7. Олон нийтийн соёлын боловсролыг сайжруулах

- Бүх нийтийг соён гэгээрүүлэх;
- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг таниулах;
- Соёлжуулах ажлыг боловсролын хөтөлбөрт тусгах, одоогийн хөтөлбөрийг шинэчлэн хүүхэд залуучуудын сонирхлыг татах хэлбэрт шилжүүлэх;
- Дижитал платформ, тоглоомтой хослуулах, хүүхэд залуусын суралцах боломжийг хувийн болон төрийн өмчийн сургуулиудад тэгш хүртээмжтэй хуваарилах.

8. Бүх нийтийн соёл, урлагийн боловсрол олгох хөтөлбөр

Урлагийн багц 5 хичээлийг бүх түвшний боловсролын хөтөлбөрт тусган хүүхэд, залуучуудад цогцоор нь олгох үндэсний хөтөлбөр боловсруулах нь хүүхдэд урлагийн боловсролыг цогцоор нь олгох боломжийг бүрдүүлнэ. Урлагийн багц хичээлийн онцлог давуу талыг урлагийн төрөл бүрээр товч тодорхойлбол:

- 1. Хөгжим** - Стресс уур бухимдлыг арилгах, сэтгэл зүйгээ удирдах чадвар хөгжих, дуу хөгжмөөр дамжуулан бусдыг ойлгох, өөрийгөө ойлгуулах, оюун санаагаа удирдах чадвартай болох, өөртөө итгэх итгэлтэй болох, дуу хоолойны өнгөө засах, ой тогтоолтыг сайжруулах, эрүүл мэндэд эергээр нөлөөлөх, зүрх судасны өвчин багасах;

- 2. Жүжиг** - Харилцааны ур чадвараа хөгжүүлэх, багаар ажиллах, бие даан ажиллах чадвар хөгжих, асуудал шийдвэрлэх чадвар сайжрах, сэтгэн бодох, бүтээлч ур чадвар хөгжих, өөртөө итгэлтэй болох, удирдан зохион байгуулах чадвар хөгжих;

- 3. Утга зохиол** - Өөрийгөө илэрхийлэх чадвар хөгжих, аливаа асуудалд дүн шинжилгээ хийж, нухацтай хандах, шүүн тунгаах чадвартай болох, сэтгэн бодох, бүтээлчээр сэтгэх ур чадвар хөгжих, ёс зүйтэй, ёс суртахуунтай, хүмүүжилтэй болж төлөвших, өөрийгөө таньж мэдэх, бусдыг ойлгох чадвар хөгжих, асуудлыг ойлгох, шийдвэрлэх чадвар хөгжих;

- 4. Дуу хөгжим** - Стресс уур бухимдлыг арилгах, сэтгэл зүйгээ удирдах чадвар хөгжих, дуу хөгжмөөр дамжуулан бусдыг ойлгох, өөрийгөө ойлгуулах, оюун санаагаа удирдах чадвартай болох, өөртөө итгэх итгэлтэй болох, дуу хоолойны өнгөө засах, ой тогтоолтыг сайжруулах, эрүүл мэндэд эергээр нөлөөлөх, зүрх судасны өвчин багасах;

- 5. Дүрслэх урлаг** - Аливаа асуудлын цаад учир шалтгааныг ойлгох, тайлбарлах, бүтээлчээр сэтгэх, асуудлыг өөр өнцгөөс харах, асуудал шийдвэрлэх

чадвар хөгжих, өөрийгөө зургаар дамжуулан илэрхийлэх, сэтгэл зүйгээ эмчлэх, удирдах, эерэг хандлагатай болох;

9. “Уншигч үндэстэн” үндэсний хөтөлбөр

- Бүх нийтээр уншигч болоход уриалах;
- Номыг хэрэглээ болгох;
- Номоор дамжуулан хүнээ хөгжүүлэх;
- Хэзээ ч, хаанаас ч, ямар ч хэлбэрээр унших боломжийг нэмэгдүүлэх, сурталчлах;
- Бүх насны хүмүүст чиглэх.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Бүх шатны боловсролын байгууллага
- Ном хэвлэлийн салбар
- Төрийн болон төрийн бус байгууллагууд
- Иргэд, олон нийт

10. Бүх нийтийн мэдээллийн боловсролын хөтөлбөр

Бүх нийтийг соён гэгээрүүлэхдээ хэвлэл мэдээллийн боловсрол, мэдээллийн боловсрол болон цахим боловсролыг хамтад нь өгөх үндэсний хөтөлбөр боловсруулах нь зүйтэй.

- ▶ Олон ургалч үзэл бодол;
- ▶ Мэдээллийн төрөл бүрийн эх үүсвэртэй байх;
- ▶ Мэдээллийн эх үүсвэрийг шалгадаг байх;
- ▶ Зөв мэдээлэлтэй иргэнийг бэлдэх.

Мэдлэг олгох арга зам:

- ✓ Бүх шатны боловсролын байгууллагын хичээлийн хөтөлбөрт тусгах
- ✓ Их сургуулийн номын сангийн хөтөлбөр боловсруулах
- ✓ Бодлоготойгоор дэмжих

Шигтгээ 4: Урлагийн боловсрол

Урлагийн боловсролоор дамжуулан нийгмийн сэтгэл зүйг эмчлэх, оюун санааны дархлаа тогтоох, бүтээлч, өрсөлдөх чадвартай иргэн бэлтгэх боломжтой.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

3.5.1. “Ковид-19” цар тахлын нөлөө



ЮНЕСКО 2020 онд CISAC-тай хамтран “Ковид-19” цар тахлыг сөрж СБҮ, соёл урлагийн салбарыг идэвхжүүлэх олон улсын хөдөлгөөн өрнүүлжээ. Үүний адилаар бид Монгол Улсдаа соёл урлагаа дэмжиж иргэдийн сэтгэл зүйг дээшлүүлэх хэрэгтэй.

“Соёл урлаг биднийг сэтгэлийн хаттай болгодог”

<https://en.unesco.org/news/resiliart>

АСУУДАЛ	ШИЙДЭЛ
<p>УРАН БҮТЭЭЛЭЭ ТАНИЛЦУУЛАХ БОЛОМЖ БУУРСАН</p> <ul style="list-style-type: none"> • Үзэсгэлэн гаргах, гадна орчинд уран бүтээл хийх, тоглолт хийх боломжгүй болсон <p>ОРЛОГО, ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ БУУРСАН</p> <ul style="list-style-type: none"> • Уран бүтээлээ хийх санхүү, эргэлтийн хөрөнгөгүй болсон • Орлого буурсан • Түрээсийн төлбөрөө төлөх чадваргүй болсон <p>ЗАХИАЛГАТ АЖЛУУД ЦУЦЛАГДСАН</p> <ul style="list-style-type: none"> • Гэрээний ажлууд цуцлагдсан, захиалга буурсан <p>БАРАА МАТЕРИАЛ, ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ ӨСӨЖ, ХОМСДОЛД ОРСОН</p>	<p>ЦАХИМ ОРЧИНД БҮТЭЭЛЭЭ СУРТАЛЧЛАХ</p> <ul style="list-style-type: none"> • Цахим орчинд уран бүтээл, бараа бүтээгдэхүүнээ сурталчлах, LIVE хийх <p>ВИРТУАЛ ҮЗЭСГЭЛЭН ГАРГАХ, ТОГЛОЛТ ХИЙХ</p> <ul style="list-style-type: none"> • Тоглолт, шоу арга хэмжээ виртуал хувилбарт шилжиж илүү өргөн хүрээг хамруулдаг болсон <p>ХУВИЙН ХӨГЖИЛ, ХУВИЙН УРАН БҮТЭЭЛ ДЭЭР ТӨВЛӨРӨХ</p> <ul style="list-style-type: none"> • Хувийн хөгжил, уран бүтээл дээрээ төвлөрөх боломж бүрдсэн • Онлайнаар ажиллах, онлайнаар уулзах хэлбэрт шилжсэн нь цаг хугацаа, тээврийн зардал, түрээсийн зардлыг хэмнэсэн <p>TV, ONLINE STREAMING ХУРДАЙ ХӨГЖИЖ БАЙНА</p> <ul style="list-style-type: none"> • Цахим түгээлтийн суваг, Streaming хурдтай хөгжсөн • Дижитал платформын хэрэглээ нэмэгдэж, цахим орчинд ажиллах чадвар сайжирсан

Шигтгээ 5. Мэдээллийн боловсрол

“Мэдээллийн боловсрол нь дижитал ертөнцөд хүний эрх бөгөөд бүх улс оронд нийгмийн олон талын оролцоог хангах хөшүүрэг болдог. Мэдээллийг үр ашигтайгаар хайх, үнэлэх, хэрэглэх, шинээр бүтээх замаар хүн өөрийн хувийн, нийгмийн, ажил мэргэжлийн, боловсролын зорилгодоо хүрэхэд мэдээллийн боловсрол дэмжлэг болно.”

Alexandria Proclamation of 2005, UNESCO




4.1. Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ)

Монгол Улсын СБҮ-д хамаарах соёл урлагийн салбарын эдийн засгийн үзүүлэлтийг энэ бүлэгт авч үзье. ҮСХ-ны эдийн засгийн үйл ажиллагааны ангилалд соёлын салбарын ДНБ-ий хэмжээг "Урлаг үзвэр, тоглоом наадам" бүлгээр тодорхойлдог. Харин ЮНЕСКО-ийн соёлын статистикийн хүрээ (ССХ)-гээр соёлын салбарыг илүү өргөн хүрээнд авч үздэг. Энэ талаар дараах бүлгүүдэд нарийвчлан тайлбарлана.

4.1.1. Урлаг үзвэр, тоглоом наадмын ДНБ-ий хэмжээ

Монгол Улсын ҮСХ-ны тоо мэдээгээр "Урлаг, үзвэр, тоглоом наадам" гэсэн үзүүлэлтийн дотоодын нийт бүтээгдэхүүн

График 5: "Урлаг үзвэр, тоглоом наадам" үзүүлэлтийн ДНБ-ий дүн, оны үнээр, эзлэх хувь



4.1.2. СБҮ-ийн эдийн засгийн хамрах хүрээ (ЭЗХХ)-ний нэмэгдэл өртөг

СБҮ-ийн Эдийн засгийн хамрах хүрээний (СБҮ+ТТДМ+ХС) нэмэгдэл өртгийн хэмжээ 2020 онд оны үнээр 982.8 тэрбум төгрөг байсан нь Монгол Улсын ДНБ-ий 2.6%-ийг эзэлж байна.

Хүснэгт 10: СБҮ-ийн Эдийн засгийн хамрах хүрээний нэмэгдэл өртөг (үндсэн үнээр), оны үнээр, сая төгрөг

Салбар	Дэд салбар	Салбарын нэршил	2015	2016	2017	2018	2019	2020*	Хамрах хүрээ
С - БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ									
C	14	Хувцас үйлдвэрлэл	104 851.9	131 238.6	164 871.9	194 354.0	216 030.0	117 961.6	СБҮ, ТТДМ
C	15	Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	17 129.4	22 194.4	27 106.3	29 737.3	33 089.3	47 567.5	СБҮ, ТТДМ
C	18	Хэвлэх, дуу бичлэгийн хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	23 870.9	37 785.6	38 555.2	40 447.1	44 440.6	43 075.8	СБҮ
C	32	Боловсруулах бусад үйлдвэрлэл ¹	1 163.4	1 219.2	1 353.1	1 308.3	1 204.2	1 509.3	СБҮ, ТТДМ
G - БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА; МАШИН, МОТОЦИКЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ									
G	46	Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад бөөний худалдаа ²	14 049.1	17 425.2	19 226.1	20 484.3	26 855.5	25 264.5	ТТДМ
G	47	Автомашин, мотоциклийн худалдаанаас бусад барааны жижиглэн худалдаа ³	31 075.5	27 033.5	27 220.4	28 865.2	31 189.2	29 029.5	ТТДМ
J - МЭДЭЭЛЭЛ, ХОЛБОО									
J	58	Эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа	10 759.8	9 641.3	9 306.3	14 214.0	13 097.9	13 624.0	СБҮ
J	59	Кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая үйлдвэрлэх үйл ажиллагаа	7 642.2	5 953.7	8 651.8	13 816.9	14 961.9	15 562.8	СБҮ
J	60	Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа	74 116.0	77 254.5	87 673.6	104 873.0	112 285.0	116 794.4	СБҮ, ТТДМ
J	62	Компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа	34 409.4	32 587.6	35 666.0	59 983.4	76 647.2	79 725.3	СБҮ, ТТДМ
J	63	Мэдээллээр үйлчлэх үйл ажиллагаа	6 336.3	6 713.1	6 608.7	9 529.0	7 443.5	7 742.5	СБҮ, ТТДМ
M - МЭРГЭЖЛИЙН, ШИНЖЛЭХ УХААН БОЛОН ТЕХНИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА									
M	71	Архитектур болон инженерийн үйл ажиллагаа; техникийн туршилт, шинжилгээ	93 435.9	84 141.1	104 201.8	114 536.9	142 351.2	154 401.7	СБҮ, ТТДМ
M	72	Шинжлэх ухааны эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны үйл ажиллагаа	53 416.2	52 627.2	50 466.8	54 810.0	65 298.6	74 555.9	СБҮ, ТТДМ

Салбар	Дэд салбар	Салбарын нэршил	2015	2016	2017	2018	2019	2020*	Хамрах хүрээ
M	73	Зар, сурталчилгааны ажил, зах зээлийн судалгаа	15 586.7	20 443.1	16 234.2	11 008.8	15 672.9	15 790.1	СБУ
M	74	Мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн ажлын бусад үйл ажиллагаа	47 973.5	35 992.2	43 212.7	34 141.8	40 643.5	40 947.4	СБУ, ТТДМ
N - УДИРДЛАГЫН БОЛОН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА									
N	77	Түрээс, лизингийн үйл ажиллагаа ⁴	312.9	361.5	450.8	566.7	1 003.4	903.1	ТТДМ
Үйлдвэрлэл, үйл явц	3	3
Нэхмэл эдлэлийн дизайн	2	2
Хувцас үйлдвэрлэлийн технологи, загвар зохион бүтээлт	1	1

Салбар, хөтөлбөрийн чиглэлээр	Нийт төгсөгчид	Үүнээс: Эмэгтэй
9. Архитектур дизайн	273	121
Инженер	166	67
Архитектур	166	67
Урлагийн гүйцэтгэх төрлүүд	73	42
Интерьер дизайн	73	42
Хөдөө аж ахуй	34	12
Ландшафтын архитектур	34	12
10. Дизайн	150	64
Инженер	9	8
Материал судлал	9	8
Компьютерийн шинжлэх ухаан:	116	45
График дизайн	116	45
Урлагийн гүйцэтгэх төрлүүд	24	11
Үйлдвэрлэлийн дизайн	24	11
Үйлдвэрлэл, үйл явц	1	0
Мебель модон эдлэлийн дизайн	1	0
11. Дижитал инновации, контент	336	85
Компьютерын шинжлэх ухаан:	336	85
Мэдээллийн систем	73	25
Програм хангамж	258	60
Програмист	5	0
12. Маркетинг, зар сурталчилгаа	202	91
Бөөний худалдаа, маркетинг, борлуулалт, олон нийттэй харилцах, үл хөдлөх хөрөнгө	202	91
Маркетинг	202	91
А. Аялал жуулчлал	152	83
Бөөний худалдаа, маркетинг, борлуулалт, олон нийттэй харилцах, үл хөдлөх хөрөнгө	37	26
Зочлох үйлчилгээ	37	26
Хувийн үйлчилгээ	115	57
Аялал жуулчлал	115	57
В. Спорт, чөлөөт цаг	562	128
Боловсрол	562	128
Багш, биеийн тамирын боловсрол	406	106
Багш, спортын дасгалжуулагч	156	22
С. Соёлын боловсрол	763	590
Боловсрол	640	488
Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол	346	306
Багш, мэдээлэл зүйн	16	4
Багш, урлагийн боловсрол	182	109
Багш, урлагийн боловсрол /бүжгийн/	82	63
Дуу, хөгжмийн боловсрол, урлагийн боловсрол	2	1
Дүрслэх урлаг, технологийн багш	12	5
Боловсролын шинжлэх ухаан	123	102
Виртуал сургалтын систем	5	2
Хэл шинжлэл	118	100
Нийт	3,880	2,099

Эх үүсвэр: БШУЯ, "Их, дээд сургууль, коллежийн төгсөгчдийн тайлан" 2019-2020

4.9. Олон улсын хамтын ажиллагааны үзүүлэлтүүд

4.9.1. ОУ-ын хэмжээнд зохиогдсон СБҮ-ийн чиглэлийн уралдаан тэмцээнд онцгой амжилт гаргасан уран бүтээлчдийн тоо

24 УРАН БҮТЭЭЛЧ

139.0 САЯ ТӨГРӨГИЙН УРАМШУУЛАЛ

2020 онд соёл урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэнд оролцож онцгой амжилт гаргасан 24 уран бүтээлч байгаа ба тэдгээрт нийт 139.0 сая төгрөгийн урамшуулал олгожээ.

НЭГ УРАН БҮТЭЭЛЧИД НОГДОХ ШАГНАЛ

5.8 САЯ ТӨГРӨГ

2020 онд нийт олгосон урамшууллын хэмжээг уран бүтээлчийн тоонд харьцуулан үзвэл ОУ-д СБҮ-ийн чиглэлээр амжилт гаргасан нэг уран бүтээлч дунджаар 5.8 сая төгрөгийн шагнал авчээ.

2005-2020 оны хооронд хамгийн олон уран бүтээлч амжилт гаргасан жил нь 2019 он бөгөөд нийт 40 уран бүтээлч ОУ-ын уралдаан, тэмцээн, үзэсгэлэнд амжилт гарган оролцсон байна. Хамгийн цөөн уран бүтээлч амжилт гаргасан жил нь 2016 он бөгөөд 1 уран бүтээлч ОУ-д амжилт гаргажээ.

Эх үүсвэр: Соёлын яам



201 УРАН БҮТЭЭЛЧ

2.4 ТЭРБУМ ТӨГРӨГ


2005-2020 оны хооронд соёл урлагийн их наадам, уралдаан, үзэсгэлэнд оролцож онцгой амжилт гаргасан нийт 201 уран бүтээлч /давхардсан тоогоор/ байгаа ба тэдгээрт нийт 2.4 тэрбум төгрөгийн урамшуулал олгожээ. Тус хугацаанд уран бүтээлчдэд олгох нийт мөнгөн шагналын дүн хамгийн их байсан жил нь 2011 он бөгөөд нийт 332.0 сая төгрөгийг ОУ-д амжилт гаргасан 29 уран бүтээлчид олгожээ. Дунджаар нэг уран бүтээлчид олгож буй мөнгөн шагналын дүн 2013 онд хамгийн их буюу 15.3 сая төгрөг байжээ.

2005-2013 оны хооронд нэг уран бүтээлчид олгож буй мөнгөн урамшууллын дүн ерөнхийдөө өссөн буюу 2005 оны нэг уран бүтээлчид олгож буй дүнг 2013 онтой харьцуулахад 3.6 дахин өссөн байна. 2013 оноос хойш нэг уран бүтээлчид олгож буй мөнгөн шагнал буурах хандлагатай байгаа ба 2020 оны хувьд 2013 онтой харьцуулахад 2.6 дахин буурсан байна.



Эх үүсвэр: Соёлын яам

График 24: ОУ-дамжилт гаргасан уран бүтээлчдийн тоо ба тэдэнд олгосон мөнгөн урамшууллын дүн



4.9.2. ОУ-ын байгууллагын дэмжлэгээр хэрэгжүүлсэн төслүүд

7 ТӨСӨЛ


1.59 тэрбум төгрөг

2005 оноос хойш СБҮ-д ОУБ-ын дэмжлэгээр 7 төслийг хэрэгжүүлсэн ба нийт 1.59 тэрбум төгрөгийн санхүүжилттэй байжээ.

Хүснэгт 37: ОУБ-ын дэмжлэгтэй төслүүд

Байгууллага	Төслийн нэр	Он	Санхүүжилт /сая төгрөг/
Соёлын өвийн үндэсний төв; ЮНЕСКО.	"Монголын туулийн уламжлалыг хадгалж хамгаалах, сэргээн амилуулах нь" төсөл	2013-2016	250.0
Соёлын өвийн үндэсний төв; ЖАЙКА.	"Түүх, соёлын дурсгал, соёлын өвийн оношилгоо, судалгааны төхөөрөмж" төсөл	2009-2013	675.0
Соёлын өвийн үндэсний төв; БНХАУ-ын Соёлын өвийн академи	"Хэрлэн барс" цамхгийн сэргээн засварлалт төсөл	2012-2016	270.0
Соёлын өвийн үндэсний төв; ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн сан	"Монгол уртын дуу хөгжимдөх уламжлалт арга-битүү амьсгаа өвийг залуу хойч үед хуучны урын сангаар дамжуулан өвлүүлэн уламжлуулж, тогтворжуулах нь" төсөл	2019-2020	174.0
Байгаль, соёлын өвийг хамгаалах сан; ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн сан	"Уул, ус тахиx Монгол ёс заншил, зан үйлийг сэргээн тэтгэх замаар тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх нь" төсөл	2019-2020	170.0
ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс	"Дэлхийн өвийн хөдөлгөөнт сургалт" төсөл	2019-2020	51.3
Хархорум музей; Италийн Турин хот дахь Ази, Дорно дахины археологийн малтлага судалгааны төв	Эртний Хархорум хотын комикс ном, хөлөгт тоглоом хийх төсөл	2020	5.0

Эх үүсвэр: Соёлын яам



БҮЛЭГ 5

СБҮ-ИЙН САЛБАР ТУС БҮРИЙН ТАЙЛАН



СОЁЛЫН ӨВ

Cultural heritage



01

СОЁЛЫН ӨВ

Cultural heritage

Биет өвийг хамгаалах, сэргээн засварлах

- Түүх соёлын үл хөдлөх дурсгал
- Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйл (Музейн үзмэр);
- Археологийн олдвор;

Биет бус өвийг хадгалах, түгээн дэлгэрүүлэх

- Нүүдлийн соёл;
- Аман зохиол;
- Монгол судлал;
- Хэл шинжлэл, Соёл судлал;
- Антропологи;

5.1. СОЁЛЫН ӨВ

Соёлын өвийн салбар нь түүх, соёлын өвийг судлан бүртгэж, хамгаалж, олон нийтэд сурталчлан таниулах, судалгаа шинжилгээний болон эдийн засгийн эргэлтэд оруулах чиг үүргийг гүйцэтгэнэ. Энэ утгаараа уг салбарт дараах байгууллагуудын үйл ажиллагааг хамруулан авч үзнэ:

- Соёлын өвийг бүртгэх, мэдээлэх, авран хамгаалах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага болох **Соёлын өвийн үндэсний төв**;
- Энэ чиглэлд судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэж буй ШУА-ийн харьяа холбогдох хүрээлэнгүүд;
- Мөн судалгаа шинжилгээ болон сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа **их, дээд сургуулиуд**;
- Сурталчлан таниулах үүрэг бүхий музей, галлерей зэрэг соёлын байгууллага;
- Баримт өвийг хадгалж, хамгаалах үүрэг бүхий **Архивын байгууллага**.

Соёлын өвийн салбарт давхардсан тоогоор 79 байгууллагад 1,179 хүн ажиллаж байна.

Хүснэгт 38: Соёлын өвийн салбарт хамаарах байгууллага, тэдгээрийн ажиллагчдын тоо

Байгууллага	Байгууллагын тоо	Ажиллагчдын тоо
Соёлын өвийн үндэсний төв	1	30
ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд	6	247
Их, дээд сургуулиуд	32	200
Музей	39	671
Үндэсний төв архив	1	30
Бүгд	79	1,178

Тайлбар: Холбогдох мэдээллийн эх үүсвэрийг дэд бүлэг тус бүрээс харна уу.

01

5.1.1. Дэлхийн өвд бүртгүүлсэн байгалийн болон соёлын өв

Монгол Улсаас Дэлхийн байгалийн болон соёлын өвд бүртгүүлсэн өв: ЮНЕСКО-ийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах, таниулан сурталчлах, хойч үедээ үлдээх зорилгоор **1972 онд Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай конвенцыг** батлан хэрэгжүүлж эхэлсэн билээ.



2020 оны байдлаар 167 улсын нийт 1,121 байгалийн болон соёлын өв Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлээд байна. Үүнээс **869 нь соёлын, 213 нь байгалийн, 39 нь хосолмол өв** байна.⁶

Монгол Улс Дэлхийн өвийн конвенцод 1990 онд нэгдэн орж, 1996 онд анх Дэлхийн өвд бүртгүүлж болох Монголын байгалийн болон соёлын өвийн Урьдчилсан жагсаалтыг боловсруулж, Дэлхийн өвийн төвд хүргүүлж байсан.

Монголын байгалийн болон соёлын өвийг Дэлхийн өвд бүртгүүлэх, Урьдчилсан жагсаалтад оруулах, Дэлхийн өвд бүртгүүлсэн өвийн болон конвенцын тайлан илтгэлийг бичих, конвенцын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Дэлхийн өвийн үндэсний хороог 2004 онд соёлын болон байгаль хамгааллын зүтгэлтэн, мэргэжилтэн, эрдэмтдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтад оруулсан өвөөс дэлхийн өвд бүртгүүлэх боломж нээгддэг. 2015 онд шинэчилсэн байдлаар Дэлхийн өвийн урьдчилсан

жагсаалтад Монгол Улсаас нийт 12 газар байна.⁷ Үүнд:

Соёлын ангиллаар:

1. Амарбаясгалант хийд, түүнийг хүрээлсэн тахилгат, соёлын дурсгалт газар
2. Хөдөө арал дахь археологийн дурсгал, түүнийг хүрээлсэн соёлын дурсгалт газар
3. Балдан Бэрээвэн хийд, түүнтэй холбогдох тахилгат газар нутаг
4. Буган хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор
5. Хүннүгийн язгууртны оршуулгын цогцолбор
6. Монголын говь дахь хадны зургийн цогцолбор
7. Тахилгат Биндэр уул, түүнтэй холбогдох соёлын дурсгалт газар
8. Монголын тахилгат уулс
9. Монголын говь дахь Цэрдийн галавын үлэг гүрвэлийн өлгий нутаг
10. Монголын Их говийн цөл нутаг
11. Дорнод Монголын тал нутаг.

Хосолмол ангиллаар:

12. Монгол Алтайн өндөр уулс

Монгол Улсаас Дэлхийн өвийн жагсаалтад 2020 оны байдлаар дараах таван өв бүртгэгдсэн. Үүнд:

Байгалийн ангиллаар:

- Увс нуурын ай сав газар (2003 он)
- Дагуурын ландшафт (2017 он)

Соёлын ангиллаар:

- Орхоны хөндийн соёлын дурсгалт газар (2004 он)
- Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор (2011 он)
- Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг (2015 он)⁸

Монгол Улсаас дэлхийн соёлын биет бус өвд бүртгүүлсэн өв: Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцыг 2003 онд ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын

⁷ <https://whc.unesco.org/en/tentativelists/state=mn>

⁸ <https://unesco.mn/mn/soyol/delhiin-uv/>

32 дугаар чуулганаар баталж, Монгол Улс 2005 оны 6 дугаар сарын 29-нд нэгдэн орсон.⁹ 2020 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар тус конвенцод 180 орон нэгдэж орсон байна.¹⁰



Уг конвенцын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлохдоо **“Соёлын биет бус өв гэж хамт олон, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүмүүс соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, мэдлэг болон дадал, эдгээртэй холбоо бүхий багаж зэмсэг, эд зүйл, урлагийн бүтээл, соёлын орон зайг хэлнэ. Үеэс үед уламжлагдах соёлын биет бус өвийг хамт олон, бүлэг хүмүүс нь тэдгээрийг хүрээлэн буй орчин, байгаль, түүхийн харилцан шүтэлцээнээс шалтгаалан байнга шинэчилдэг бөгөөд тухайн өв нь тэдгээрт оршин тогтнох болон залгамж чанарын мэдрэмж төрүүлж, соёлын төрөл зүйл, хүний туурвилыг хүндэтгэхэд дэмжлэг үзүүлдэг. Энэхүү конвенцын зорилгод олон улсын хүний эрхийн зөвхөн одоо мөрдөж буй баримт бичиг болон хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн хоорондын харилцан хүндэтгэл, мөн тогтвортой хөгжлийн шаардлагуудад нийцсэн соёлын биет бус өвийг авч үзнэ”** гэжээ.

Үндэснийхээ соёлын биет бус өв (СББӨ)-ийг ЮНЕСКО-д бүртгүүлж баталгаажуулна гэдэг нь тухайн улс үндэстний нэр төрийн хэрэг бөгөөд дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн хүндтэй үүрэг хариуцлага юм. Тухайн өвийг орон нутаг, улс үндэстэн, олон улсын түвшинд танин мэдүүлж, хадгалж хамгаалах,

сэргээн амилуулах, түгээн дэлгэрүүлэх явдал хамгийн чухал. Иймд соёлын өвөө бүртгүүлсэн улс орон илүү их идэвх санаачилгатай ажиллах хэрэгтэй болдог.

Соёлын биет бус өвийн нэг өвөрмөц онцлог бол түүний байнга хувьсан өөрчлөгдөж, үргэлжилж байдаг чанар юм. Тухайн өв нь газарзүйн өргөн уудам нутагт оршин байж болох бөгөөд тухайн бүлэг хүмүүст тохиолдож болох олон янзын нөхцөл байдалд дасан зохицож амьдрах чадвартай байдаг аж. Энэ утгаар конвенцын дагуу бий болгосон

- **Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт** (List of Intangible Cultural Heritage in Need of Urgent Safeguarding);
- **Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалт** (Representative List of the Intangible Cultural Heritage of Humanity);
- **Хадгалалт хамгаалалтын шилдэг туршлагын бүртгэл** (Register of Good Safeguarding Practices) гэсэн гурван жагсаалтад хамтран нэрдэвшүүлэхийг оролцогч улсуудад ЮНЕСКО уриалан дэмжиж байгаа билээ.¹¹

2020 оны 12 дугаар сарын байдлаар ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцын **Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад 35 улсын 67 өв¹², Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад 128 улсын 492 өв¹³, нийт 559 өвийг бүртгээд байна.**

Монгол Улс 2008 оноос хойш Соёлын биет бус өвийн конвенцын **Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөллийн жагсаалтад:**

1. *Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг (2008)*
2. *Монгол ардын уртын дуу (2008)*
3. *Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг (2009)*
4. *Монгол тууль (2009)*

¹¹ <https://ich.unesco.org/en/purpose-of-the-lists-00807>

¹² <https://ich.unesco.org/en/00011?type=00003#tabs>

¹³ <https://ich.unesco.org/en/00011?type=00002#tabs>

5. Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг (2009)
6. Монголын уламжлалт Хөөмийн урлаг (2010)
7. Шувуучлахуй буюу Бүргэдээр анхных зан үйл (Ази, Европ, Арабын 18 улстай хамтран) (2010)
8. Монгол баяр наадам (2010)
9. Монгол лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил – битүү амьсгаа (2011)
10. Монгол уран бичлэг (2013)
11. Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл (2013)
12. Монгол шагайн харваа (2014)
13. Ботго авхуулах зан үйл (2015)
14. Ууловоо тахих Монгол зан үйл (2017)
15. Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл (2019)

гэх нийт 15 өвийг бүртгүүлээд байна.

5.1.2. Үндэсний соёлын өв

і. Соёлын өвийн үндэсний төв

1994 онд Монгол Улсын түүх, соёлын дурсгалыг хамгаалах тухай хууль (2001 онд Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон өөрчлөгдсөн) шинэчлэгдэн батлагдсанаар Монгол Улсын Засгийн газрын “Соёлын өв хамгаалах төв байгуулах тухай” 1995 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 238 дугаар тогтоол, Монгол Улсын Соёлын сайдын “Соёлын өвийн төвийг байгуулах тухай” 1996 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 07 дугаар тушаалаар Музейн үзмэр сэргээн засварлах урлангийн үйл ажиллагааг өргөжүүлэн Соёлын өвийн төв болгон өөрчлөн зохион байгуулжээ.


Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 302 дугаар тогтоол, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 47 дугаар тушаалаар Соёлын өвийн төвийн бүтэц, орон тоог нэмж, соёлын биет бус өвийг судлах, хадгалж хамгаалах, бүртгэн баримтжуулах, биет бус соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүрэг нэмэгдэн, үйл ажиллагаа нь өргөжсөн.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга 2014 онд батлагдсантай холбогдуулан 2018 онд тус байгууллагыг **Соёлын өвийн үндэсний төв** болгон өргөжүүлсэн.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д заасны дагуу Монгол Улсын соёлын өвийг бүртгэх, мэдээлэх, авран хамгаалах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага нь **Соёлын өвийн үндэсний төв** байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 11 сарын 10-ны өдрийн А/295 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар Соёлын өвийн үндэсний төвийн бүтэц зохион байгуулалтыг дараах байдлаар баталсан.

Зураг 2: Соёлын өвийн үндэсний төвийн бүтэц



Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төвийн цахим хуудас - <https://ncch.gov.mn/structure>

Тус төв нь 5 газар, 4 зөвлөл бүхий бүтэц зохион байгуулалттайгаар орон тооны 30 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Соёлын өвийн үндэсний төвөөс 2020 оны төсвийг 1.4 тэрбум төгрөг байхаар санал

оруулсан хэдий ч 50%-аар буюу **698.7 сая төгрөг**өөр баталжээ. Соёлын өвийн үндэсний төв нь 2020 онд батлагдсан төсвийн 83% буюу **581.6 сая төгрөгийг зарцуулсны** дотор **438.8 сая төгрөг буюу 83%-ийг цалин, НДШ-д зарцуулжээ.**

Хүснэгт 39: Соёлын өвийн үндэсний төвийн төсвийн мэдээлэл, сая төгрөгөөр

	Төсвийн санал	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Үүнээс: цалингийн зардал
2016	450.7	377.6	368.1	280.2
2017	550.1	414.5	413.4	277.5
2018	568.3	457.5	442.8	270.9
2019	987.9	637.3	539.6	378.8
2020	1,403.4	698.7	581.6	438.8

Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төвийн 2020 оны гүйцэтгэлийн тайлан.

Соёлын өвийн үндэсний төвөөс түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалахад 2016-2020 онд нийтдээ **173.8 сая төгрөгийг зарцуулжээ.** 2020 онд 8.9 сая төгрөгийг зарцуулсан нь 2017-2019 оныхоос 5.3-6.1 дахин буурчээ.

График 25: Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зардал, сая төгрөг



Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төвийн 2020 оны гүйцэтгэлийн тайлан.

Соёлын өвийн үндэсний төв гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2020 онд **181.8 сая төгрөгийн санхүүжилт** авчээ.


Хүснэгт 40: Соёлын өвийн үндэсний төвийн төсөл хөтөлбөрийн санхүүжилт, сая төгрөгөөр

Үе	Гадаадын төсөл хөтөлбөр /ЮНЕСКО болон бусад ОУБ/	Дотоодын төсөл хөтөлбөр /Дээд шатны байгууллага/	Дүн
2016	214.7	44.2	258.9
2017	120.7	8.1	128.7
2018	85.1	41.4	126.5
2019	187.9	29.7	217.6
2020	93.2	88.6	181.8

Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төвийн 2020 оны гүйцэтгэлийн тайлан.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасны дагуу соёлын өвийг биет ба биет бус гэж ангилах бөгөөд 4.2-д заасны дагуу соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилна.

Схем 13: Соёлын өвийн ангилал



Шигтгээ 8: Соёлын өвийг хамгаалах тухай хууль

3.1.1. "соёлын өв" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг;
3.1.2. "соёлын биет өв" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг;
3.1.5. "соёлын биет бус өв" гэж хамт олон, бүлэг, хувь хүн соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, уламжлалт мэдлэг, арга барил, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг;

ii. Түүх, соёлын үл хөдлөх дурсгал

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1-д заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/108 дугаар тушаалаар түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого улсын хэмжээнд

анх удаа 2015 онд зохион байгуулагдсан. Тооллогоор 21 аймгийн 330 сум, нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэр дэх **9,537 дурсгалт газрын 86,157 үл хөдлөх дурсгалыг** тоолж, соёлын өвийн улсын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

Зураг 3: Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2015 оны тооллогод хамрагдсан үл хөдлөх дурсгалт газар, дурсгалын тоо, төрөл зүйлийн ангиллаар

	Дурсгалт газар 9,537	Дурсгал 86,157
Булш, оршуулгын дурсгал	4,953 (52%)	67,927 (79%)
Хадны зураг, бичгийн дурсгал	981 (10%)	6,796 (8%)
Хөшөө дурсгал	1,562 (16%)	4,230 (5%)
Тахил тайлгын байгууламж	957 (10%)	4,167 (5%)
Барилга, архитектурын дурсгал	1,084 (11%)	2,820 (3%)
Чулуун зэвсгийн дурсгалт газар	131 (1%)	131 (0.15%)
Палеонтологийн дурсгалт газар	51 (0.5%)	51 (0.05%)
Үйлдвэрлэлийн үл мөр хадгалсан дурсгалт газар	35 (0.4%)	35 (0.04%)

Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл судалгааны газар

Шигтгээ 9: Соёлын өвийг хамгаалах тухай хууль

3.1.6. "соёлын өвийн дурсгалт газар" гэж соёлын биет болон биет бус өв нь байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн соёлын орон зай, газар нутгийг;
 3.1.7. "түүх, соёлын дурсгалт газар" гэж энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүхий газар, түүний хэвлийг;
 5.1. Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамааруулна:
 5.1.1. эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар;
 5.1.2. эртний хүний оршин сууж байсан үл мөрийг хадгалсан соёлт давхарга;
 5.1.3. чулуун зэвсгийн олдворт газар;
 5.1.4. хадны зураг, бичээс;
 5.1.5. булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;
 5.1.6. эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал;
 5.1.7. хөшөө дурсгал;
 5.1.8. эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;
 5.1.9. тахилгат газар;
 5.1.10. түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;
 5.1.11. бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын анхны (2015 оны) тооллогоос хойш 2017-2019 онд 3,406 дурсгалыг, 2020 онд 217 дурсгалт газар, 480 дурсгалыг нэмж бүртгэсэнээр, 2021 оны 5 дугаар сарын байдлаар Соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санд 9,754 дурсгалт газрын 90,043 түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүртгэлтэй байна.

Хүснэгт 41: Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй дурсгалт газар, дурсгалын тоо

№	Үзүүлэлт	Дурсгалт газар	Дурсгал
1	2015 оны түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын дүн	9,537	86,157
2	2017-2019 онд нэмж бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоо	-	3,406
3	2020 онд нэмж бүртгэгдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоо	217	480
Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тоо (2021 оны 5 дугаар сарын байдлаар)		9,754	90,043

Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төв

Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал: Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор "Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д **182** дурсгал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дугаар тушаалын хавсралт "Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д **607** дурсгал тус тус батлагдсан.
Сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал: Сум, дүүргийн хамгаалалтад байх 3,625 дурсгалт газрын 32,710 түүх соёлын дурсгал байна.

Хүснэгт 42: Сум, дүүргийн хамгаалалтад байх түүх соёлын дурсгалт газар, дурсгалын тоо

№	Хуулийн үндэслэл	Хамрах хүрээ	Дурсгалт газар	Дурсгал
1	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт	Архангай, Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Орхон, Төв, Увс зэрэг 7 аймгийн 92 сум	1,496	11,123
2	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	Хэнтий аймаг	234	3,675
3	Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн ИТХ-ын тогтоолоор хамгаалалтын зэрэглэл тогтоосон	Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл, Хэнтий зэрэг 13 аймгийн 172 сум, Улаанбаатар хотын 4 дүүрэг	1,895	17,912
Нийт			3,625	32,710

Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төв

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан Улсын тусгай хамгаалалтад байх дархан цаазат газар; байгалийн цогцолборт газар; байгалийн нөөц газар; дурсгал газарт нийт 4,848 үл хөдлөх дурсгал оршиж байна. Ингэснээр давхардсан тоогоор 38,347 түүх соёлын үл хөдлөх дурсгал буюу нийт түүх соёлын үл хөдлөх дурсгалын 43%-ийг аль нэг зэрэглэлээр хамгаалалтад авчээ.

Хүснэгт 43: Холбогдох хуулийн заалтын дагуу хамгаалалтад байх түүх соёлын дурсгалын тоо

№	Зэрэглэл	Хуулийн үндэслэл	Дурсгалын тоо
1	Улсын хамгаалалтад байх	Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоол	182
2	Аймаг, нийслэл хамгаалалтад байх	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/161 дугаар тушаал	607
3	Сум, дүүргийн хамгаалалтад байх	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн ИТХ-ын тогтоол,	32,710
4	Улсын тусгай хамгаалалтад байх	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	4,848
Нийт			38,347

Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төв

Засгийн газрын 12 удаагийн тогтоолоор 36 дурсгалт газрын нийт 1,5 орчим кв.км талбайд хамгаалалтын бүс тогтоожээ. Үүнээс хамгийн том нь Засгийн газрын 2006 оны 123 дугаар тогтоолоор хамгаалалтын бүсийг тогтоосон 1,219.7 кв.км талбай бүхий Дэлхийн өв – Орхоны хөндийн соёлын дурсгалт газар байна. **iii. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл** Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг 2006 оноос хойш улсын хэмжээнд 3 удаа зохион байгуулсан. 2018-2019 оны түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогод нийт 307 байгууллагын 126.8 мянган дэсийн 276.1 мянган дурсгалт зүйл тоологджээ.

Зураг 4: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогод хамрагдсан байгууллага, тоологдсон үл хөдлөх дурсгалт зүйлийн тоо, тооллого тус бүрээр

Тооллого явагдсан хугацаа	Хамрагдсан байгууллага, тоо	Дэс	Тоо ширхэг
2006-2008 оны музейн сан хөмрөгийн улсын тооллого	Улсын болон аймаг, орон нутгийн музей	35	-
	Нийт	35	206,109
2012-2014 оны музейн сан хөмрөгийн улсын тооллого	Улсын музей	16	124,810
	Аймаг, орон нутгийн музей	24	
	Сумдын орон нутаг сурталчлах төв	257	
	Сүм, хийд	3	
Нийт	300	304,196	
2018-2019 оны түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого	Улсын музей	10	126,810
	Эрдэм шинжилгээний хүрээлэн	2	
	Их, дээд сургууль	3	
	Байгууллагын дэргэдэх музей	3	
	Үндэсний номын сангийн ховор номын фонд	1	
	Аймаг, орон нутгийн музей	24	
	Сумдын орон нутаг сурталчлах төв	261	
	Сүм, хийд	3	
	Нийт	307	


Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төв

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны улсын тооллогоор **127,264 дэсийн 277,019 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тоологдохоос 126,810 дэсийн 276,077 ширхэг, 110.1 тэрбум төгрөгийн үнэ** бүхий түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тоологдсон байна.

Тооллогод 15 аймгийн 87 сумын орон нутаг сурталчлах танхим, аймаг, орон нутгийн 6 музей, улсын 4 музей, байгууллагын харьяа нэг музей, нэг сүм хийд, нийт 99 байгууллагын нийтдээ 435 дэсийн 875 ширхэг, 146.5 сая төгрөгийн үнэ бүхий хөдлөх дурсгалт зүйл “дутсан”, “хулгайд алдсан”, “солигдсон” шалтгаанаар тоологдоогүй байна.

Дүрслэх урлагийн музей, Монголын уран зургийн галерей, Богд хааны ордон музей түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн үнийн дүнгээр тэргүүлж байна. Бүртгэлийн үнээр хамгийн өндөр үнийн дүнтэй түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл бүхий 15 байгууллагад Увс, Сэлэнгэ, Баян-Өлгий, төв аймгийн музей болон тэдгээр аймгийн 72 сумын орон нутаг сурталчлах танхим багтаж байна. Эдгээр 15 байгууллагад түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн нийт үнийн дүнгийн 85% нь ногдож байна.

График 26: Бүртгэлийн үнээр хамгийн өндөр үнийн дүнтэй түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл бүхий байгууллага, тэдгээрт тоологдсон дурсгалт зүйлийн үнийн дүн, тэрбум төгрөгөөр




Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төв

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Монголбанкны Эрдэнэсийн сан, МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль, ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Улаанбаатарын их сургууль, Говьсүмбэр аймгийн Баянтал сумын ОНСТ, Шанхын Баруун хүрээ, Төвхөн хийд зэрэг 8 газар бүртгэлийн үнэ хийгдээгүй байна.

Улсын тооллогод хамрагдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн бүтцийг төрөл зүйлээр нь авч үзвэл 29% нь түүхийн холбогдолтой, 22% нь шашин шүтлэгийн холбогдолтой, 19% угсаатны зүйн, тус бүр 13% нь байгалийн түүхийн холбогдолтой болон урлаг уран сайхны дурсгалт зүйл, 7% нь археологийн олдвор байжээ.

График 27: Улсын тооллогод хамрагдсан түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн бүтэц, төрөл зүйлээр



Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төв

Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан дахь түүх, соёлын хөдлөх дурсгалын баяжилт: Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тайланд 2020 онд нийт 88 байгууллага хамрагдаж, 1,774 дэсийн 3,147 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлээр сан хөмрөгөө баяжуулжээ. Баяжилтаар

нэмэгдсэн зүйлээс 966 дэсийн 1,422 ширхэг үзмэрт зааврын дагуу “хувийн дугаар” олгож “Register” бүртгэлийн программд бүртгэж баталгаажуулсан байна (“Register” программд бүртгэгдсэн тоон дүнгээр бодит баяжилтыг тооцдог).

Зураг 5: Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан дахь түүх, соёлын хөдлөх дурсгалын баяжилтын үзүүлэлтүүд

Баяжилтаар нэмэгдсэн		Шилжилт хөдөлгөөнд хамрагдсан	
2019	1,410 дэсийн 1,672	2019	4,901 дэсийн 8,704
2020	1,774 дэсийн 3,147	2020	2,274 дэсийн 3,183
2020 онд нэмэгдсэнээс			
Register програмд оруулсан		966 дэсийн 1,422	
RCH програмд оруулсан		401 дэсийн 663	
Төрөл (2020)	Арга зам (2020)	Шилжилт хөдөлгөөний төлөв (2020)	
Байгалийн түүхийн цуглуулга	24%	Бэлэг хандиваар ирсэн	61.8%
Түүхийн цуглуулга	20%	Эрдэм шинжилгээ судалгаагаар ирсэн	20.6%
Угсаатны зүйн цуглуулга	19%	Худалдаж авсан	8.2%
Урлаг уран сайхны	14%	Шилжиж ирсэн	7.6%
Археологийн олдвор	12%	Бусад замаар ирсэн	1.6%
Шашин шүтлэгийн	11%		
		Дотоодын үзэсгэлэнд оролцсон	1,410 дэсийн 1,878
		Гадаадын үзэсгэлэнд оролцсон	19 дэсийн 20
		Судалгаа шинжилгээнд хамрагдсан	627 дэсийн 1,035
		Сэргээн засварласан	2,274 дэсийн 3,183

Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл судалгааны газар

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн 2018-2019 оны тооллогоос хойш 2019 оны баяжилтаар 1,410 дэсийн 1,672 хөдлөх дурсгал зүйлийг, 2020 он баяжилтаар 966 дэсийн 1,422 дурсгалт зүйлийг, түүнчлэн Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчлин хийд, Данзанравжаагийн музей болон Олон улсын оюун ухааны

музейн 11,754 дэсийн 57,278 дурсгалт зүйлийг нэмж бүртгэснээр, 2021 оны 5 дугаар сарын байдлаар Соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санд 140,940 дэсийн 336,449 түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл бүртгэлтэй байна.

Хүснэгт 44: Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн Register программд бүртгэгдсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн тоо

№	Үзүүлэлт	Дэс	Тоо
1	2018-2019 оны улсын тооллогын үр дүнд Register программд бүртгэгдсэн	126,810	276,077
2	2019 оны баяжилтаар Register программд нэмж бүртгэгдсэн	1,410	1,672
3	2020 оны баяжилтаар Register программд нэмж бүртгэгдсэн	966	1,422
4	Монголын Бурхны Шашинтны Төв Гандантэгчлин хийдийн Register программд бүртгэгдсэн	8,333	46,070
5	Данзанравжаагийн музейн Register программд бүртгэгдсэн (хувийн хэвшил)	258	1,461
6	Олон улсын оюун ухааны музейн Register программд бүртгэгдсэн (хувийн хэвшил)	3,163	9,747
Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн Register программд бүртгэгдсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлсийн тоо (2021 оны 5 дугаар сарын байдлаар)		140,940	336,449

Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төвийн Соёлын өвийн бүртгэл судалгааны газар

Шигтгээ 10: Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан


Соёлын өвийн үндэсний төв нь биет ба биет бус соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлж, соёлын өвийг уг санд бүртгэнэ. Соёлын өвийг бүртгэх бүртгэлийн программыг нэвтрүүлэн, соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сангийн улсын нэгдсэн сүлжээ, мэдээллийн бааз бий болгож, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх арга зүйгээр хангаж зөвлөгөө өгөх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2006 онд Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл – “RCH, Registration of Cultural Heritage” бүртгэлийн программыг музейд нэвтрүүлсэн. Музейн үзмэр эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл буюу “Register” бүртгэлийн программыг 2012-2013 оны улсын тооллогоор нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн. Түүх, соёлын хөдлөх дурсгалтын зүйлсийг бүртгэлийг холбогдох байгууллагууд Register программд бүртгэн, уг мэдээлэл нь RCH мэдээллийн санд холбогдож байна.

Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн мэдээлэл: Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 болон 8.3, 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу Засгийн газрын 18 удаагийн тогтоолоор түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг баталсны

дотор 778 дурсгалт зүйл оржээ. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн ихэнх нь түүхийн холбогдолтой дурсгалт зүйлс байгаа бөгөөд голчлон төрийн болон орон нутгийн өмчийн музейд хадгалагдаж байна.

Зураг 6: Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн тоон мэдээлэл




Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төв

iv. Соёлын биет бус өв

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/759 тоот тушаалаар “Монгол Улсын Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”, “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-ийг тус тус баталсан.

“Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”-д соёлын биет бус өвийн 7 ай савын 279 өвийн төрөл зүйл, “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д 7 ай савын 83 өвийн төрөл зүйл, нийт 362 өв хамрагдсан.


График 28: Соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний бүртгэлд хамрагдсан өвийн тоо, ай савын ангиллаар



Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төв

Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоо: Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоо 2020 онд 10,849 болж, 2019 оныхоос 385 өвлөн уламжлагчаар буюу 3.6 хувиар өсжээ.

График 29: Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоо, 2020 оны байдлаар, ай савын ангиллаар



Эх үүсвэр: Соёлын өвийн үндэсний төв

5.1.3. Түүх, соёл судлал

Түүх, соёл судлалын үйл ажиллагааг Шинжлэх ухааны академи, энэ чиглэлийн мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиудын мэдээллээр энэ хэсэгт авч үзэв.

i. Шинжлэх ухааны академи

Хүний нөөц: Шинжлэх ухааны академи (ШУА)-ийн харьяа эрдэм шинжилгээний 14 хүрээлэнд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 1,122 хүн ажиллаж байгаагаас 896 нь эрдэм шинжилгээний ажилтан байна. Үүний дотор академич 24, доктор (Sc.D) 15, доктор (Ph.D) 249 ажиллаж байгаа бөгөөд 35 хүртэлх насны залуучууд нийт эрдэм шинжилгээний ажилтны 43.7 хувь, 35-аас 50 насных 37.2 хувийг эзэлж, дундаж нас 40 байна.

Түүх, угсаатны зүйн хүрээлэнд 44 эрдэм шинжилгээний ажилтан (ЭША) ажиллаж байгаагийн 50% нь, Хэл зохиолын хүрээлэнд 47 ЭША ажиллаж байгаагийн 62% нь, Археологийн хүрээлэнд 39 ЭША ажиллаж байгаагийн 46% нь, Палеонтологийн хүрээлэнд 41 ЭША ажиллаж байгаагийн 20% нь доктор болон түүнээс дээш цолтой ЭША байна. Түүнчлэн Философийн хүрээлэнд 44 ЭША ажиллаж байгаагийн 50% нь, Олон улсын харилцааны хүрээлэнд 32 ЭША ажиллаж байгаагийн 47% нь доктор болон түүнээс дээш цолтой ЭША байна.

Эдгээр хүрээлэнд нийтдээ 283 ажилтан ажиллаж байгаагийн 247 нь ЭША байгаа бөгөөд тэдний дотор 9 академич, 11 шинжлэх ухааны доктор (Sc.D.), 93 боловсролын доктор (Ph.D.) ажиллаж байна.

Зураг 7: ШУА-ийн болон холбогдох хүрээлэнгүүдийн хүний нөөцийн тоон мэдээлэл, 2020 оны жилийн эцсийн байдлаар

	МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ	Нийт ажилтны тоо - 4,749	Эмэгтэй: 49%		ЭША - 896
	ЭША-уудын дундаж нас: 40	35 хүртэлх насны 44%	35-50 насны 37%	51-60 насны 11%	60-аас дээш насны 8%
	Доктор болон түүнээс дээш цолтой ЭША: 37%	Академич 30	Доктор (Sc.D.) 19	Доктор (Ph.D.) 249	
		Докторант 180	Магистр 360		


Холбогдох хүрээлэнгүүдэд:	Нийт	ЭША	ЭША-уудын дундаж нас	Доктороос дээш цолтой ЭША
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН	54	44	43	50%
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН	50	47	42	62%
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	45	39	42	46%
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ПАЛЕОНТОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	47	41	44	20%
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН	50	44	48	50%
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭЛЭН	37	32	46	47%

Эх үүсвэр: “Эрдэм шинжилгээ үйл ажиллагааны 2020 оны тайлан”, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, 2021 он

Санхүүжилт, гэрээт ажил, төслийн орлого: ШУА-ийн санхүүжилт 2020 онд 23.4 тэрбум төгрөгт хүрч, 2019 оныхоос 6.6 тэрбум төгрөгөөр буюу 39%-аар өссөн байна. ШУА-ийн санхүүжилтийн 79% нь 18.5 тэрбум төгрөг нь цалин, НДШ-д, 4.9 тэрбум төгрөг буюу 21% нь үйл ажиллагааны зардалд зарцуулагджээ.

ШУА-ийн хүрээлэнгүүдийн гэрээт ажил, төслийн орлого 2017-2020 оны хооронд жилд дунджаар 25%-аар нэмэгдэж, 2020 онд 7.1 тэрбум төгрөгт хүрчээ.

График 30: ШУА-ийн санхүүжилт, гэрээт ажил, төслийн орлого, сая төгрөгөөр



Эх үүсвэр: “Эрдэм шинжилгээ үйл ажиллагааны 2020 оны тайлан”, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, 2021 он

ШУА-ийн холбогдох хүрээлэнгүүд 2020 онд гэрээт ажил гүйцэтгэж, эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлж 1.8 тэрбум төгрөгийн орлого олсон нь ШУА-ийн нийт гэрээт ажил, төслийн орлогын 25%-ийг эзэлж байна. Тухайлбал, Палеонтологийн хүрээлэн 558.6 сая төгрөгийн, Хэл зохиолын хүрээлэн 469.2 сая төгрөгийн, Археологийн хүрээлэн 375.7 сая төгрөгийн, Түүх угсаатны зүйн хүрээлэн 308.0 сая төгрөгийн өртөг бүхий гэрээт ажил, эрдэм шинжилгээний төслийг хэрэгжүүлжээ.

Зураг 8: ШУА-ийн холбогдох хүрээлэнгүүдийн 2020 онд гүйцэтгэсэн гэрээт ажил, төслийн орлого, сая төгрөгөөр

Байгууллага	Гэрээт ажил, төслийн орлого, сая төгрөг
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН	308.0
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН	469.2
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	375.7
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ПАЛЕОНТОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	558.6
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН	66.2
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭЛЭН	17.0
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ	7113.3

Эх үүсвэр: “Эрдэм шинжилгээ үйл ажиллагааны 2020 оны тайлан”, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, 2021 он

Эрдэм шинжилгээний ажил: ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдэд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 247 төсөл хэрэгжиж байсны 103 нь тухайн онд дуусах төсөл байжээ. Төслүүдийн 107 нь гадаадтай хамтарсан, 65 нь суурь судалгаа, 33 нь улсын захиалгат, 13 нь Шинжлэх ухаан

технологийн сан (ШУТС)-гийн, 4 нь инновацийн төсөл байжээ. Холбогдох хүрээлэнгүүдийн дотор Археологийн хүрээлэн (38), Палеонтологийн хүрээлэн 19 төсөл хэрэгжүүлж байгаагийн дийлэнх нь гадаадтай хамтарсан төсөл байна.

Зураг 9: ШУА-ийн холбогдох хүрээлэнгүүдийн хэрэгжүүлж буй төслийн тоо, 2020 оны жилийн эцсийн байдлаар

Байгууллага	Суурь судалгааны	ШУТС-гийн	Улсын захиалгат	Инновацийн	Гадаадтай хамтарсан	ШУА-ийн грант	Төслийн тоо - бүгд
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН	6	-	1	-	2 (1)	-	9 (1)
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН	2 (1)	-	-	1 (1)	2 (1)	2 (2)	7 (5)
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	3	-	-	-	34	1 (1)	38 (1)
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ПАЛЕОНТОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	2	1 (1)	-	-	16	-	19 (1)
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН	3	-	1 (1)	-	2	1 (1)	7 (2)
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭЛЭН	3	-	1 (1)	-	2 (1)	3 (3)	9 (5)
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ	65 (19)	13 (9)	33 (28)	4 (1)	107 (21)	19 (19)	247 (103)

Эх үүсвэр: “Эрдэм шинжилгээ үйл ажиллагааны 2020 оны тайлан”, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, 2021 он

* - Тайлбар () хаалтад тухайн онд дууссан төслийн тоо.

Түүх, угсаатны судлалын хүрээлэнгийн 2020 онд гаргасан гол үр дүнгээс дурдвал “Чингис хааны өв, соёл: архивын баримтын эмхэтгэлд Монгол Улсын Үндэсний төв архивд хадгалагдаж буй Чингис хааны өв, соёлд холбогдох 110 баримтыг үндэсний монгол бичгээс кирилл үсэгт хөрвүүлэн, эрдэм шинжилгээний тайлбар хийж, уг эхийн хуулбар болон Чингис хаанаас хойших үед буюу 1830-1962 оныг хамрах хэдий ч агуулгын хувьд өргөн цар хүрээтэй, шинжлэх ухаан, танин мэдэхүйн үнэ цэнтэй сурвалжуудыг

багтаасан сонирхолтой бүтээлийг олон нийтийн хүртээл болгосон байна. Мөн “Монголын нийслэл Сарьдгийн хийд: Түүх, археологийн судалгаа” үндэсний төслийн малтлага судалгаагаар илэрсэн олдворуудаар “Археологийн судалгааны лаборатори”, угсаатны эх материалаар “Монголын биет бус соёлын өвийн судалгаан лаборатори-танхим”-ыг хүрээлэндээ нээжээ.

ШУА-ийн холбогдох хүрээлэнгүүдийн 2020 онд хэвлүүлсэн бүтээлийн тоо мэдээллийг дор харуулав.

Зураг 10: ШУА-ийн холбогдох хүрээлэнгүүдийн 2020 онд хэвлүүлсэн бүтээлийн тоо

Байгууллага	Нэг сэдэвт бүтээл	Ном товхимол	ЭШ-ний өгүүлэл		ЭШ-ний илтгэл		Аргачлал, гарын авлага	Зөвлөмж	Зураг, каталог	ШУ-ны хялбаршуулсан			Хээрийн судалгааны тайлан	
			Гадаад	Дотоод	Гадаад	Дотоод				Товхимол	Нийтлэл	Лекц		
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН	3	17	14	13	11	38	-	-	-	3	10	10	27	7
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН	9	12	12	111	17	35	-	-	-	2	16	7	-	-
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	3	16	26	60	15	16	-	-	9	5	-	-	-	25
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ПАЛЕОНТОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	-	-	6	4	8	6	1	-	-	-	8	2	-	-
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН	6	14	2	38	9	31	-	2	-	1	9	-	-	2
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ХҮРЭЭЛЭН	4	12	20	45	11	16	2	12	1	1	55	8	1	1
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ	65	123	373	565	148	296	28	31	159	25	192	123	28	41

Эх үүсвэр: “Эрдэм шинжилгээ үйл ажиллагааны 2020 оны тайлан”, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, 2021 он

Зураг 11: ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2020 онд хэвлүүлсэн бүтээлүүд



Эх үүсвэр: “Эрдэм шинжилгээ үйл ажиллагааны 2020 оны тайлан”, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, 2021 он

Зураг 12: ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн 2020 онд хэвлүүлсэн бүтээлүүд



Эх үүсвэр: “Эрдэм шинжилгээ үйл ажиллагааны 2020 оны тайлан”, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, 2021 он

Зураг 13: ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн 2020 онд хэвлүүлсэн бүтээлүүд



Эх үүсвэр: “Эрдэм шинжилгээ үйл ажиллагааны 2020 оны тайлан”, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, 2021 он

Авран хамгаалах ажил: ШУА-ийн харьяа дотор Палеонтологийн хүрээлэн 119, хүрээлэнгүүд 2019 онд 121, 2020 онд Археологийн хүрээлэн 58, Түүх, угсаатны 212 археологи, түүх соёлын өвийг авран зүйн хүрээлэн 35 авран хамгаалах ажлыг хамгаалах ажлыг хэрэгжүүлжээ. Түүний гүйцэтгэжээ.

Зураг 14: ШУА-ийн холбогдох хүрээлэнгүүдийн 2020 онд хэрэгжүүлсэн авран хамгаалах ажлын тоо

Байгууллага	Авран хамгаалах ажлын тоо
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН	35
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ АРХЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	58
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ПАЛЕОНТОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	119
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ	212 (2020) 121 (2019)

Эх үүсвэр: “Эрдэм шинжилгээ үйл ажиллагааны 2020 оны тайлан”, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, 2021 он

Археологийн хүрээлэн хөдөө орон нутгийн засаг захиргаа, ард иргэдтэй нягт хамтран ажиллаж байгаагийн хүчинд археологи, түүх соёлын олон өвийг авран хамгаалах, сүйдэх эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллажээ. Тухайлбал 2020 онд:

- Төв аймгийн Эрдэнэсант сумын Баян-Уул багийн нутагт эртний дурсгал тонож сүйтгэсэн хэргийн хүрээнд Төв аймаг дахь Цагдаагийн газрын албан хүсэлтийн дагуу шинжээч томилон дүгнэлт гаргуулж, шүүх хуралд оролцсон.
- Баян-Өлгий аймгийн Сагсай сумын 3-р багийн нутагт эртний хадны оршуулга тонож сүйтгэсэн хэргийн хүрээнд Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газрын албан хүсэлтийн дагуу шинжээч томилон дүгнэлт гаргуулж, хураагдсан олдвор эд өлгийн зүйлсийг цаг алдалгүй ирүүлж, сэргээн засварлалтын лабораторид

шаардлагатай арга хэмжээг авч ажиллажээ.

- Өмнөговь аймгийн Булган сумын ЗДТГ-ын захиалгат “Өмнөговь аймгийн Булган сумын нутаг дахь эртний түүхийн дурсгалуудыг бүртгэн баримтжуулах судалгаа” төслийн хүрээнд Булган сумын нутагт археологийн хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэж, 28 газраас нийт 380 дурсгалыг илрүүлэн баримтжуулжээ.
- Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын ЗДТГ-ын захиалгат “Баян-Өндөр сумын нутаг: түүх, археологи, угсаатны зүйн судалгаа” төслийн хүрээнд Баян-Өндөр сумын нутагт археологийн хайгуул судалгааны ажил гүйцэтгэж, нийт 500 орчим дурсгалыг бүртгэн баримтжуулсан зэрэг ажлыг орон нутгийнхантай хамтран хийжээ.¹⁴

¹⁴ “Эрдэм шинжилгээ үйл ажиллагааны 2020 оны тайлан”, Монгол Улсын Шинжлэх ухааны академи, 2021 он

в. Их дээд сургууль

Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-ны дээд боловсролын статистик мэдээллээс харахад 2020-2021 оны хичээлийн жилийн байдлаар **32 их, дээд сургуульд** Монгол хэл, уран зохиол, түүх, сэтгүүл зүй, соёл судлал, соёл, урлагийн мэргэжилтэн, багш, судлаачдыг бэлтгэж

байна. Эдгээр 32 их, дээд сургуульд тухайн чиглэлээр 200 орчим багш, судлаачид ажиллаж байна.

Эдгээр их, дээд сургуулиудаас түүх, соёл, урлаг судлал болон холбогдох мэргэжлээр сургалт, судалгааны үйл ажиллагаа явуулж байгаа зарим их, дээд сургуулийн талаарх мэдээллийг энд оруулав.

Хүснэгт 45: Түүх, соёл, урлаг судлал болон холбогдох мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа зарим их дээд сургуулийн мэдээлэл

Их дээд сургуулиуд	Бүрэлдэхүүн сургууль, холбогдох тэнхэм	Бэлтгэж буй мэргэжлийн чиглэл (дипломын)	Судалгааны хүрээлэн, төв, тэнхим, профессорын баг
Соёл урлагийн их сургууль	Дүрслэх, дизайны сургууль	Уран зураг, Зураасан зураг, Монументаль уран зураг, Хувцасны дизайн, Уран дархан, металл урлаг, Арьсан урлал, Уран баримал, Хэвлэлийн эх бэлтгэл, хяналт, Уран баримал /чимэглэх/	Хүрээлэн - 1: Соёл, урлаг судлалын хүрээлэн Судалгааны төв - 3: Театрын боловсрол, инновацийн төв; Бүжиг судлал, инновацийн төв; Соёлын үйлдвэрлэл, инновацийн төв; Тэнхим - 25, Профессорын баг - 10: Ардын урлаг, бүжиг судлалын; Соёлын онол, философийн; Өрнө, дорно дахины хөгжим судлалын; Мэргэжлийн хөгжим судлал, урлагийн боловсрол судлалын; Тайз дэлгэцийн урлаг судлалын; Монгол үндэстний урлахуй судлалын; Сэтгүүл зүйн гэх мэт.
	Бүжгийн урлагийн сургууль	Бүжгийн найруулга, бүжиглэх урлаг, бүжгэн жүжгийн, бүжгийн	
	Хөгжмийн урлагийн сургууль	Багш, урлагийн боловсрол /дуу хөгжмийн/, Дуу, хөгжмийн боловсрол, Найрал хөгжим удирдах урлаг, Хөгжимдөх урлаг /үндэсний хөгжим/, Дуулах урлаг /эстрад/, Үндэсний язгуур урлаг, Дуурийн, Монгол ардын уртын дуу, Нийтийн дуу, Нийтийн дуу, Эстрадын дуу, Монгол хөөмий, Соёл, урлагийн багш /дуу хөгжим-концертмейстерийн, Дуу хөгжим-найрал дуу удирдахуйн	
	Театрын урлагийн сургууль	Кино, драмын жүжгийн урлаг, Тайзнаас ярих урлаг, Утга зохиол судлал, Жүжгийн урлаг судлал, Тайз, дэлгэцийн бүтээлийн зураг, Жүжгийн урлаг /Кино, драмын театрын, Ярих урлаг	
	Соёлын сургууль	Соёл судлал /соёлын өв, музей судлал/, Номын сан судлал, мэдээлэл, Менежмент, Маркетинг, Аялал жуулчлал /соёлын аялал жуулчлал/, Соёл хоорондын харилцаа, Соёл судлал, Түүх /түүх-музей	
	Радио, телевиз, медиа урлагийн сургууль	Зураг авалт, График дизайн /мультимедиа/, Найруулах урлаг, Радио, Телевизийн найруулах урлаг, Сэтгүүл зүй, Кино, телевизийн, Телевиз, радиогийн, Кино, телевиз, хэвлэлийн болон гэрэл зураг авалт, Мультимедиа, Радио, телевизийн техник, технологи, Дуу чимээний технологи	
Монгол Улсын консерватори	Хөгжмийн ухаан, дуулаачийн сургууль	Хөгжмийн зохиолч, хөгжим судлаач, хөгжмийн удирдаач, дуурийн дуучин, уртын дуучин, жазз хөгжмийн чиглэлээр бакалаврын болон магистрын сургалт	Хөгжмийн ухаан, Дуулаачийн гэсэн хоёр тэнхимтэй.
	Бүжиг, циркийн мэргэжлийн сургууль	Сонгодог бүжиг, Ардын бүжиг, Цирк	Сонгодог бүжиг, Ардын бүжиг, Цирк гэсэн 3 тэнхимтэй
	Сонгодог хөгжмийн мэргэжлийн сургууль	Төгөлдөр хуур, Утсан хөгжим, Үлээвэр, цохивор хөгжим	Төгөлдөр хуурын, Утсан хөгжмийн, Үлээвэр, цохивор хөгжмийн гэсэн 3 тэнхимтэй
	Үндэсний хөгжмийн мэргэжлийн сургууль	"Хөгжимдөх урлаг"-Үндэсний хөгжмийн	Хөгжмийн тэнхим, язгуур урлагийн тэнхим, нумт-үлээвэр, товшвор хөгжмийн нэгдэлтэй

Их дээд сургуулиуд	Бүрэлдэхүүн сургууль, холбогдох тэнхэм	Бэлтгэж буй мэргэжлийн чиглэл (дипломын)	Судалгааны хүрээлэн, төв, тэнхим, профессорын баг
Монгол Улсын Их Сургууль	Шинжлэх ухааны сургууль	Багш, монгол хэл-эх бичиг судлал; Археологи; Утга зохиол судлал; Урлаг судлал; Монгол хэл, уран зохиол; Монгол хэл, эх бичиг судлал; Утга зохиол судлал, шүүмж; Түүх, археологи; Түүх /Судалгааны/; Хэл шинжлэл /Судалгааны/; Утга зохиол судлал /Судалгааны/; Нийгэм-Соёлын антропологи	Нийгмийн ухааны салбар: Антропологи, археологийн тэнхим Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхим Хүмүүнлэгийн салбар: Түүхийн тэнхим Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим Утга зохиол, урлаг судлалын тэнхим Монгол судлалын хүрээлэн Түрэг судлалын хамтарсан хүрээлэн
МУБИС	Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль	Багш, монгол хэл-уран зохиолын, Утга зохиол судлал, Сэтгүүл зүй	Сэтгүүл зүйн тэнхим Монгол хэлний тэнхим Түүхийн тэнхим Утга зохиолын тэнхим Монгол судлалын төв
	Дүрслэх урлаг, технологийн сургууль	Багш, дүрслэх урлаг-технологийн, Компьютерын график дизайн, Дүрслэх урлаг, зураг зүйн боловсрол, Дүрслэх урлаг, дизайн	
ШУТИС	Барилга, архитектурын сургууль	Архитектур, Архитектур /Хот төлөвлөлт/	Архитектурын салбар
	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	Соёл судлал	Хүмүүнлэгийн ухааны салбар дотор
	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Хувцасны дизайн, График дизайн, Үйлдвэрлэлийн дизайн, Интерьер дизайн	Дизайны салбар
Сити их сургууль	Барилга, архитектур, дизайны сургууль	Хувцасны дизайн, График дизайн, Үйлдвэрлэлийн дизайн, Интерьер дизайн, Архитектур	Архитектур, интерьер дизайны тэнхим, Компьютер, график дизайны тэнхим, Хувцас дизайны тэнхимтэй
	Урлагийн сургууль	Хөгжмийн урлаг, Дуулах урлаг, Жүжиглэх урлаг, Гоо заслын урлаг, технологи, Урлаг судлал	
Их Засаг Олон Улсын их сургууль	Дүрслэх урлаг, дизайн, технологийн сургууль	Хувцасны дизайн, Интерьер дизайн, Архитектур, Уран зураг, Урлаг судлал	Архитектурын тэнхим, Дүрслэх урлагийн тэнхим, Дизайны тэнхим
	Театр урлагийн сургууль	Зураг авалт, Жүжиглэх урлаг, Сэтгүүл зүй	
	Үндэсний инженер технологийн сургууль	Компьютерын график-дизайн	
Улаанбаатарын Их Сургууль		Утга зохиол судлал, Түүх	Монгол хэл, уран зохиол, сэтгүүл зүйн тэнхим Түүх, археологийн тэнхим

Эх үүсвэр: БШУЯ-ны дээд боловсролын статистик мэдээлэл болон тухайн их, дээд сургуулийн цахим хуудас.

5.1.4. Музей

Нэр томьёоны тодорхойлолт¹⁵

Музей: Нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэхүйц олон нийтэд зориулагдсан, байнгын үйл ажиллагаатай, ашгийн төлөө бус байгууллага бөгөөд хүний түүх, амьдрах орчны тухай баримт гэрч болох эд зүйлийг судлах, хүнийг гэгээрүүлэх оюуны хэрэгцээг нь хангах зорилгоор олж цуглуулах, хадгалах, хамгаалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлж сурталчлах ажил эрхэлдэг газар;

Хосгүй үнэт зүйлс: Түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлж чадах түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий эд зүйлсийг 3 зэрэглэлд ангилдаг бөгөөд зэрэглэлийн хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн гайхамшигт хосгүй, дахин давтагдашгүй “Дэлхийн соёлын өв” -ийн жагсаалтад орох шаардлага хангасан эд өлгийн зүйлсийг хосгүй үнэт зүйл гэнэ.

Сан хөмрөг: Сан хөмрөгт музейгээс цуглуулан бүрдүүлж, бүртгэж, хадгалж байгаа гарал үүсэл, бүтсэн эд, хийсэн арга, музейн ач холбогдол бүхий төр, нийгэм, байгалийн түүх, ард түмний эдийн болон оюуны соёлын өвийн бодит ба бодит бус дурсгалт зүйлсийн цогц бүрдэл, Монгол Улсын үндэсний эрхэм баялгийг хамааруулна.

Музейн тухай хуулиас¹⁶

4.1.1.“музей” гэж соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус соёл, эрдэм шинжилгээний байгууллагыг;

4.1.2.“музейн үзэл баримтлал” гэж музейн төрөл, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, цуглуулгын болон үзүүлэгийн бодлогыг тодорхойлсон баримт бичгийг;

4.1.3.“ерөнхий бүртгэл” гэж үзмэрийн хувийн дугаар, нэр, тоо, хэмжээ, тодорхойлолт бүхий бүртгэл, мэдээллийн баримт бичгийг;

4.1.4.“үзмэр” гэж ерөнхий бүртгэлд бүртгэгдсэн музейн өмчийн соёлын үнэт зүйлийг;

4.1.5.“цуглуулга” гэж нэг болон хэд хэдэн шинжээрээ харилцан холбоотой, тодорхой цаг үеийг төлөөлөх шинжлэх ухаан, урлаг, танин мэдэхүйн ач холбогдолтой үзмэрийн бүрдэл хэсгийг;

4.1.6.“музейн сан хөмрөг” гэж үзмэр, цуглуулга, түүний хадгалалт хамгаалалтын нөхцөлийг бүрдүүлсэн орон зайг;

4.1.7.“үзүүлэг” гэж үзмэр, цуглуулгыг шинжлэх ухааны үндэслэлтэй, уран сайхны аргаар дэглэн үзүүлсэн орон зайг.



Хүснэгт 46: Музейн нэгдсэн тоон мэдээлэл

Үзүүлэлт		МД	2018	2019	2020	
А		Б	1	2	3	
Музейн байгууллагын нийт тоо		1	46	38	39	
Үзвэр, үйлчилгээний нийт тоо		2		2,537	1,309	
Үйлчилгээний төрлөөр	Музейн үйлчилгээ	Байнгын үзүүлэг	3	217	596	
		Түр үзэсгэлэн	4	1,457	140	
	Бусад үйлчилгээ		5	863	573	
	Хүүхдэд зориулсан		6	860	581	
Зориулалтын төрлөөр	Дижитал		7	27	214	
	Тайлбартай		8	2,095	421	
	Төлбөргүй		9	761	484	
Үйлчилгээний хэлбэрээр	Үзэсгэлэнгийн танхимын үйлчилгээ		10	2,157	1,084	
	Нүүдлийн үйлчилгээ	Дотоодод	11	371	221	
		Гадаадад	12	9	4	
Нийт үйлчлүүлэгчид		13	781,409	782,071	769,136	
Хүүхэд		14	269,764	197,908	116,692	
Төлбөргүй		15		330,983	557,147	
Гадаад		16	116,869	170,565	31,951	
Тусгай бүлгийн		17		16,030	14,139	
Хөгжлийн бэрхшээлтэй		18		1,820	1,130	
Бусад		19		14,210	13,009	
Үйлчилгээний төрлөөр	Музейн үйлчилгээ	Байнгын үзүүлэг	20	479,236	179,480	
		Түр үзэсгэлэн	21	210,334	157,392	
	Бусад үйлчилгээ		22	92,501	432,264	
Тоглолтын хэлбэрээр	Үзэсгэлэнгийн танхимын үйлчилгээ		23	543,374	245,159	
	Нүүдлийн үйлчилгээ	Дотоодод	24	135,628	59,513	
		Гадаадад	25	10,568	32,200	
Нийт үзмэрийн тоо		26	289,589	244,918	246,971	
Нэмэгдсэн үзмэр		27	5,743	1,190	1,469	
Хасагдсан үзмэр		28		312	277	
Дижитал хэлбэрт оруулсан үзмэр		29		3,730	3,868	
Сэргээн засварласан		30		697	283	
Хуулбарлагдсан		31		16	4	
Дэлгэгдсэн төрлөөр	Үзүүлэлт дэглэсэн		32	46,576	53,458	
	Үзэсгэлэнд дэглэгдсэн		33	15,665	2,527	
	Сан хөмрөгт		34	182,677	190,986	
Үзмэрийн зэрэглэл/дэсээр	Түүх, соёлын хосгүй үнэт		35	781	727	
	Түүх, соёлын үнэт		36	50,122	56,058	
Баталсан орон тоо		37	732	674	684	
Нийт ажиллагчдын тоо		38	639	658	671	
Эмэгтэй		39	381	365	379	
Мэргэжлийн		40		291	320	
Төр, засгийн шагналтан		41		101	95	
Хөгжлийн бэрхшээлтэй		42		13	16	
Эмэгтэй		43		6	7	
Албан тушаалын ангиллаар	Захиргаа, аж ахуйн ажиллагчид		44		254	243
	Эмэгтэй		45		119	114
	Мэргэжлийн ажиллагчид		46	307	185	195
	Эмэгтэй		47	219	122	131
	Үйлчилгээний ажиллагчид		48		198	214
	Эмэгтэй		49		119	131
	Түр хугацаагаар ажиллагчид (гэрээт)		50		21	19
Эмэгтэй		51		5	3	

Үзүүлэлт		МД	2018	2019	2020
Насны бүлгээр	25 хүртэлх	52	44	54	45
	Эмэгтэй	53	28	26	30
	25-34	54	180	166	165
	Эмэгтэй	55	115	98	96
	35-44	56	213	205	207
	Эмэгтэй	57	141	125	131
	45-54	58	144	153	178
	Эмэгтэй	59	85	89	101
	55-59	60	42	58	47
	Эмэгтэй	61	9	23	17
60+	62	16	22	29	
Эмэгтэй	63	3	4	4	
Нийт ажиллагчдын тоо		64	639	658	671
Эмэгтэй		65	381	365	379
Боловсролын түвшнээр	Боловсролгүй	66	1	-	-
	Эмэгтэй	67	2	-	-
	Бага	68	4	5	5
	Эмэгтэй	69	2	-	-
	Суурь	70	27	22	22
	Эмэгтэй	71	8	9	7
	Бүрэн дунд	72	112	115	123
	Эмэгтэй	73	50	51	53
	Техникийн болон мэргэжлийн	74	67	61	47
	Эмэгтэй	75	28	15	17
	Тусгай мэргэжлийн дунд	76	48	41	37
	Эмэгтэй	77	21	15	15
	Дипломын болон бакалаврын дээд	78	266	291	310
	Эмэгтэй	79	184	192	202
	Магистр	80	105	109	114
	Эмэгтэй	81	80	77	78
Доктор	82	9	14	13	
Эмэгтэй	83	6	6	7	

Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик мэдээлэл

i. Музейн тоо¹⁷

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн болон бүх төрлийн музейг музейн тоонд хамруулна. Тооцох аргачлалын хувьд сум, аймаг, нийлэлд байршилтай музейн нийт дүнгээр илэрхийлэгдэнэ.

График 31: Музейн тоо, улсын хэмжээнд



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик
 Монгол Улсын хэмжээнд 2018 онд нийт 46 музей байсан бөгөөд 2019, 2020 онд 38, 39 музей тус тус бүртгэгджээ.

Музейн тоог бүсээр задлан харвал Улаанбаатар хотод хамгийн олон музей байх бөгөөд хангайн бүсэд 8, төвийн бүсэд 9 музей, зүүн бүсэд 4, баруун бүсэд 5 музей үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 47: Музейн тоо, бүс, нийслэлээр, сүүлийн гурван жилийн байдлаар

Бүс, нийслэл	2018 он	2019 он	2020 он
Баруун бүс	5	5	5
Хангайн бүс	8	9	9
Төвийн бүс	8	8	8
Зүүн бүс	4	4	4
Улаанбаатар	21	12	13
Улсын дүн	46	38	39

Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

ii. Музейн үзвэр, үйлчилгээний тоо мэдээлэл

Музейн үйлчилгээний тоон үзүүлэлтийг энэ хэсэгт авч үзье. Сүүлийн хоёр жилийн хугацаанд үзвэр, үйлчилгээний тоог тусгайлан бүртгэж эхэлсэн байдаг.

Улсын хэмжээнд 2019 онд нийт 2537, 2020 онд нийт 1309 үзвэр, үйлчилгээ бүртгэгджээ. 2019 онд зүүн бүсэд хамгийн олон буюу 1285 үзвэр, үйлчилгээ, 2020 онд хангайн бүсэд хамгийн олон буюу 495 үзвэр, үйлчилгээ үзүүлсэн байна.

Хүснэгт 48: Музейн үзвэр, үйлчилгээний тоо, бүс, нийслэлээр

Бүс, нийслэл	2019 он	2020 он
Баруун бүс	118	86
Хангайн бүс	272	495
Төвийн бүс	302	277
Зүүн бүс	1285	111
Улаанбаатар	560	340
Улсын дүн	2537	1309

Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Схем 14: Музейн үзвэр, үйлчилгээ



Хүснэгт 49: Музейн үзвэр, үйлчилгээний тоо, төрөл ангиллаар

Үзвэр, үйлчилгээний үзүүлэлтүүд	Улаанбаатар хотод		Улсын хэмжээнд	
	2019 он	2020 он	2019 он	2020 он
НИЙТ	560	340	2537	1309
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР				
Музейн үйлчилгээ	240	124	1674	736
Үүнээс: Байнгын үзүүлэг	71	78	217	596
Түр үзэсгэлэн	169	46	1457	140
Бусад үйлчилгээ	320	216	863	573
ЗОРИУЛАЛТЫН ТӨРЛӨӨР				
Хүүхдэд зориулсан	216	117	860	581
Дижитал	7	46	27	214
Тайлбартай	287	175	2095	421
Төлбөргүй	382	170	761	484
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛБЭРЭЭР				
Үзэсгэлэнгийн танхимын үйлчилгээ	431	274	2157	1084
Нүүдлийн үйлчилгээ	129	66	380	225
Үүнээс: Дотоодод	122	62	371	221
Гадаадад	7	4	9	4


Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Үйлчилгээний төрлөөр

Музейн үзвэр, үйлчилгээг үйлчилгээний төрлөөр музейн үйлчилгээ, бусад үйлчилгээ гэж ангилна. Музейн үйлчилгээ дотор байнгын үзүүлэг, түр үзэсгэлэн багтдаг.


Музейн үзвэр, үйлчилгээний тоо 2019 оны байдлаар түр үзэсгэлэн хамгийн өндөр утгатай байсан бол 2020 онд байнгын үзүүлэг болон бусад үйлчилгээний тоо өссөн байна.

График 32: Музейн үзвэр, үйлчилгээний тоо, үйлчилгээний төрлөөр, тоон утгаар



Улсын хэмжээнд 2019 оны байдлаар байнгын үзүүлэг 9 хувийг эзэлж байсан бол 2020 онд 46 хувь болж өссөн байна. Түр үзэсгэлэнгийн эзлэх хэмжээ 57 хувиас 11 хувь болж буурчээ. Бусад үйлчилгээний эзлэх хувь 34 хувиас 44 хувь болж өссөн байна.

График 33: Музейн үзвэр, үйлчилгээний тоо, үйлчилгээний төрлөөр




Зориулалтын төрлөөр

Музейн үзвэр, үйлчилгээний тоог зориулалтын төрлөөр хүүхдэд зориулсан,

дигитал, тайлбартай, төлбөргүй гэж дөрвөн үндсэн хэсэгт хуваадаг.


Дараах графикт улсын хэмжээнд үзүүлсэн музейн үзвэр, үйлчилгээний тоог зориулалтын төрлөөр харуулж байна. Улсын хэмжээнд 2019 оны байдлаар тайлбартай үйлчилгээ хамгийн өндөр утгатай байсан боловч 2020 онд 5 дахин буурч 421 -т хүрчээ. Хүүхдэд зориулсан үйлчилгээ, болон төлбөргүй үйлчилгээний тоо хэмжээ мөн адил буурсан байна. Эсрэгээрээ дигитал үйлчилгээний тоо хэмжээ 8 дахин өсжээ.

График 34: Музейн үзвэр, үйлчилгээний тоо, зориулалтын төрлөөр, тоон утгаар



Сүүлийн хоёр жилд үзүүлсэн үйлчилгээнээс хүүхдэд зориулсан үйлчилгээний эзлэх хувь 10 хувиар буурч, дигитал хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний эзлэх хувь 15 хувиар өссөн байна. Тайлбартай үйлчилгээний эзлэх хувь 50 хувиар буурчээ. Төлбөргүй үйлчилгээний эзлэх хувь 7 хувиар өссөн байна.

График 35: Музейн үзвэр, үйлчилгээний тоо, зориулалтын төрлөөр, нийт дүнд эзлэх хувиар




Үйлчилгээний хэлбэрээр

Музейн үзвэр, үйлчилгээг үйлчилгээний хэлбэрээр үзэсгэлэнгийн танхимын үйлчилгээ, нүүдлийн үйлчилгээ гэж ангилна. Нүүдлийн үйлчилгээ дотор дотоодод үзүүлсэн, гадаадад үзүүлсэн үйлчилгээ багтана.


Улсын хэмжээнд үзэсгэлэнгийн танхимаар үйлчилгээ үзүүлж буй тоо 2 дахин буурсан байх ба нүүдлийн үйлчилгээ мөн адил буурчээ.

График 36: Музейн үзвэр, үйлчилгээний тоо, үйлчилгээний хэлбэрээр, тоон утгаар



Улсын хэмжээнд нийт үзүүлсэн үзвэр, үйлчилгээний 80 гаруй хувийг үзэсгэлэнгийн танхимын үйлчилгээ эзэлж байна. Нүүдлийн үйлчилгээ нь тоо утгын хувьд багассан ч нийт үйлчилгээнд эзлэх хувь 2020 онд 2 хувиар өссөн байна. Нүүдлийн үйлчилгээний дийлэнх хувийг дотоодод үзүүлсэн үйлчилгээ эзэлж байна.

График 37: Музейн үзвэр, үйлчилгээний тоо, үйлчилгээний хэлбэрээр



iii. Музейн үзвэр үзэгчдийн тоо

мэдээлэл

Үзэгчдэд тухайн музейн өөрийнх нь танхимд ирж үзээр үзсэн хүмүүс болон нүүдлийн хэлбэрээр зохион байгуулсан үзэсгэлэн үзсэн хүмүүсийг тус тус хамааруулна. Тооцох аргачлалын хувьд нийт үзэгчдийн тоог тухайн музейн үзвэр үзсэн хүүхдийн тоо, гадаадын үзэгчдийн тоо, бусад үзэгчид (том хүн)-ийн тоон нийлбэрээр авна.


Дараах хүснэгтэд Музейн үйлчлүүлэгчдийн тоог бүс, нийслэлээр сүүлийн гурван жилийн байдлаар харууллаа. 2020 оны байдлаар 336,9 мянган музейн үйлчлүүлэгч бүртгэгдсэн ба үүнээс 163,539 буюу 49 хувийг Улаанбаатар хотын үйлчлүүлэгчид эзэлж байна.

Хүснэгт 50: Музейн үзэгчдийн тоо, бүс, нийслэлээр, сүүлийн гурван жилийн байдлаар

Бүс, нийслэл	2018 он	2019 он	2020 он
Баруун бүс	61,163	30,351	14,404
Хангайн бүс	163,650	148,976	85,178
Төвийн бүс	145,542	77,172	43,685
Зүүн бүс	39,286	68,718	30,066
Улаанбаатар	371,768	364,353	163,539
Улсын дүн	781,409	689,570	336,872

Дараах графикт музейн үзэгчдийн тоог сүүлийн 18 жилээр харуулав. Энэхүү динамик үзүүлэлтийг харвал 2013 онд музейн үзэгчдийн тоо хамгийн өндөр утгатай байжээ. Үүнээс хойш 2016 он хүртэл буурсан боловч эргэж нэмэгдэн 2020 онд 769 мянгад хүрсэн байна.

График 38: Музейн үзэгчдийн тоо, 2002-2020 оны байдлаар



Схем 15: Музейн үйлчлүүлэгчид



Хүснэгт 51: Музейн үйлчлүүлэгчид, төрлөөр, сүүлийн гурван жилийн байдлаар

Музейн үйлчлүүлэгчдийн тоон үзүүлэлтүүд	Улаанбаатар хотод			Улсын хэмжээнд			
	2018 он	2019 он	2020 он	2018 он	2019 он	2020 он	
Нийт үйлчлүүлэгчид	371,768	397,277	499,147	781,409	782,071	769,136	
Хүүхэд	136,164	102,978	49,485	269,764	197,908	116,692	
Төлбөргүй		179,495	433,181		330,983	557,147	
Гадаад	58,111	118,974	31,519	116,869	170,565	31,951	
Тусгай бүлгийн		3,432	6,587		16,030	14,139	
Үүнээс:	Хөгжлийн бэрхшээлтэй		671		1,820	1,130	
	Бусад		2,761	5,848		14,210	13,009
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР							
Музейн үйлчилгээ		364,353	163,539		689,570	336,872	
Үүнээс:	Байнгын үзүүлэг		289,843	63,378		479,236	179,480
	Түр үзэсгэлэн		74,510	100,161		210,334	157,392
Бусад үйлчилгээ		32,924	335,608		92,501	432,264	
ТОГЛОЛТЫН ХЭЛБЭРЭЭР							
Үзэсгэлэнгийн танхимын үйлчилгээ		308,604	85,818		543,374	245,159	
Нүүдлийн үйлчилгээ		55,749	77,721		146,196	91,713	
Үүнээс:	Дотоодод		51,949	45,521		135,628	59,513
	Гадаадад		3,800	32,200		10,568	32,200

Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Үйлчлүүлэгчдийн төрлөөр


Музейн үзэгчдийн тоог хүүхэд, төлбөргүй үзэгч, гадаадын үзэгч, тусгай бүлгийн үзэгч зэрэг үзүүлэлтүүдээр авч үзье. Нийт үйлчлүүлэгчид дунд хүүхдийн эзлэх хувь 2018 онд 35 хувь байсан бол сүүлийн хоёр жил дараалан буурч 2020 оны байдлаар 15 хувьд хүрсэн байна. Улаанбаатар хотын хувьд нийт үзэгчдийн дунд хүүхдийн эзлэх хувь 2018 онд 37 хувь байсан бол 2020 онд 10 хувьд хүрчээ.

Төлбөргүй үзэгчдийн эзлэх хувь 2018 онд тооцоологдоогүй байна. Улсын хэмжээнд 2019 онд төлбөргүй үзэгчийн эзлэх хувь 42 хувь байсан бол 2020 онд 72 хувь хүртэл өсжээ. Улаанбаатар хотод тус үзүүлэлт 2019 онд 45 хувь, 2020 онд 87 хувьтай буюу 2 дахин өсжээ.

Гадаад үйлчлүүлэгчийн эзлэх хувь 2018 онд нийт үйлчлүүлэгчдийн 15 хувийг, 2019 онд 22 хувийг эзэлж байсан бол 2020 онд огцом буурч 4 хувьд хүрчээ. Улаанбаатар хотын хувьд гадаад үйлчлүүлэгчдийн эзлэх хувь улсын дүнтэй харьцуулахад бага зэрэг өндөр байх бөгөөд 2018 онд 16 хувь, 2019 онд 30 хувь, 2020 онд 6 хувийг тус тус бүрдүүлж байв.

Сүүлийн хоёр жилд музейн үйлчлүүлэгчдийн статистик бүртгэлд тусгай бүлгийн үйлчлүүлэгчдийг бүртгэдэг болсон байна. Тус үзүүлэлт сүүлийн хоёр жил дараалан нийт үйлчлүүлэгчдийн 2 хувийг эзэлж байна.

График 39: Музейн үзэгчдийн тоо, үзэгчдийн төрлөөр




Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Үйлчилгээний төрлөөр

Музейн үзэгчдийн тоог үйлчилгээний төрлөөр музейн үйлчилгээ авсан, бусад төрлийн үйлчилгээ авсан гэж ангилна. Музейн үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийг байнгын үзүүлэг үзэж танилцсан, түр үзэсгэлэнгээр үйлчлүүлсэн гэж хуваадаг.


График 40: Музейн үзэгчдийн тоо, үйлчилгээний төрлөөр, тоон утгаар



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Монгол Улсын хэмжээнд музейн үйлчилгээ авсан тоо хэмжээ 2 дахин багассан ба эсрэгээрээ бусад төрлийн үйлчилгээ авсан тоо хэмжээ 5 дахин өссөн байна. Дараах графикт музейн үйлчлүүлэгчдийг үйлчилгээний төрөлд эзлэх хувиар харууллаа. Үүнээс харахад 2019 онд байнгын үзүүлэг үзсэн үйлчлүүлэгчдийн эзлэх хувь 61 хувь байсан бол 2020 онд 23 хувь хүртэл буурсан байна. Улсын хэмжээнд бусад үйлчилгээ авсан байдал 2019 онд 12 хувь байсан бол 2020 онд 56 хувь хүртэл өсжээ.

График 41: Музейн үзэгчдийн тоо, үйлчилгээний төрлөөр




Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Үйлчилгээний хэлбэрээр

Музейн үйлчилгээ авсан үзэгчдийг үйлчилгээний хэлбэрээр үзэсгэлэнгийн танхимаар үйлчилгээ авсан, нүүдлийн үйлчилгээ авсан гэж ангилна. Нүүдлийн үйлчилгээг дотоодод болон гадаадад гэж хуваана.

График 42: Музейн үйлчлүүлэгчдийн тоо, үйлчилгээний хэлбэрээр, тоон утгаар



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Дараах графикт музейн үйлчлүүлэгчдийг үйлчилгээний хэлбэрээр ангилж харуулав. Улсын хэмжээнд 2019 оны байдлаар нийт үзэгчдийн 79 хувь үзэсгэлэнгийн танхимаар үйлчлүүлсэн бол тус үзүүлэлт 2020 онд 73 хувь болж буурчээ. Дотоодын нүүдлийн үйлчилгээ авсан хувь мөн адил буурсан байна. Гадаадад нүүдлийн үйлчилгээ авсан хувь 2020 онд 8 хувиар өссөн байна. Гэвч дээр дурдсанчлан музейн үйлчилгээ авсан үзүүлэлт тоон утгаар 2 дахин буурсан байгааг санах хэрэгтэй.

График 43: Музейн үйлчлүүлэгчдийн тоо, үйлчилгээний хэлбэрээр, нийт дүнд эзлэх хувиар



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

vi. Музейн үзмэрийн тоо мэдээлэл

Үзүүлэгийн харилцан идэвхтэй үйлчлэл бөгөөд оюуны эрэлт хэрэгцээ, мэдээллийн эх сурвалж болох соёлын өвийг музейн үзмэр гэнэ. Тухайн музейн нийт үзмэрийн тоогоор илэрхийлэгддэг.

Монгол Улсын хэмжээнд музейн үзмэрийн тоог сүүлийн гурван жилээр дараах хүснэгтэд харуулж байна. 2020 оны байдлаар улсын хэмжээнд 246,971 үзмэр бүртгэгдсэнээс 60 хувь буюу 148,205 үзмэр Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. 2018 онтой харьцуулахад музейн үзмэрийн тоо 2019 онд 15 хувиар буурсан ч 2020 онд 1 хувиар өсжээ.


Хүснэгт 52: Музейн үзмэрийн тоо, бүс, нийслэлээр, сүүлийн гурван жилийн байдлаар

Бүс, нийслэл	2018 он	2019 он	2020 он
Баруун бүс	39,694	27,183	27,278
Хангайн бүс	44,884	37,282	36,295
Төвийн бүс	37,304	25,798	26,041
Зүүн бүс	13,366	8,810	9,152
Улаанбаатар	154,341	145,845	148,205
Улсын дүн	289,589	244,918	246,971

Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Дараах графикт 2002 оноос 2020 оны байдлаар улсын хэмжээнд бүртгэгдсэн болон Улаанбаатар хотод бүртгэгдсэн музейн үзмэрийг тоог харуулж байна.


График 44: Музейн үзмэрийн тоо, 2002-2020 оны байдлаар



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Музейн үзмэрийг нэмэгдсэн үзмэр, хасагдсан үзмэр, дижитал хэлбэрт оруулсан үзмэр, сэргээн засварласан, хуулбарлагдсан үзмэр зэргээр авч үзье.

Схем 16: Музейн үзмэр



Хүснэгт 53: Музейн үзмэрийн тоон үзүүлэлтүүд, сүүлийн гурван жилээр

Музейн үзмэрийн тоон үзүүлэлтүүд	Улаанбаатар хотод			Улсын хэмжээнд		
	2018	2019	2020	2018	2019	2020
НИЙТ ҮЗМЭРИЙН ТОО	154,341	145,845	148,205	289,589	244,918	246,971
Нэмэгдсэн үзмэр	986	598	731	5,743	1,190	1,469
Сэргээн засварласан		651	257		697	283
Дижитал хэлбэрт оруулсан үзмэр		3	131		3,730	3,868
Хасагдсан үзмэр		1	190		312	277
Хуулбарлагдсан		14	1		16	4
ДЭГЛЭГДСЭН ТӨРЛӨӨР						
Үзүүлэгт дэглэсэн		16,115	24,271		46,576	53,458
Үзэсгэлэнд дэглэгдсэн		13,399	1,747		15,665	2,527
Сан хөмрөгт		116,331	122,187		182,677	190,986
ҮЗМЭРИЙН ЗЭРЭГЛЭЛ ДЭСЭЭР						
Түүх, соёлын хосгүй үнэт		668	529		781	727
Түүх, соёлын үнэт		37,347	28,400		50,122	56,058

Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Нэмэгдсэн үзмэрийн тоо

Музейн сан хөмрөгийг баяжуулах иж бүрдэл болгох зорилгоор музейн бодлого, сэдэв, төрөлтэй уялдуулан, байгууллагын цуглуулгын төлөвлөгөөг үндэслэн тухайн жилд солилцоо, хандивын шугамаар ирсэн болон шинээр худалдан авсан үзмэрийг шинээр нэмсэн үзмэр гэнэ. Тооцох арга зүйн хувьд тухайн жилд шинээр нэмсэн үзмэрийн тоогоор тодорхойлно.

Монгол Улсын хэмжээнд 2018 онд 5,743 -аар нэмэгдсэн. Үүний 17 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ. Сүүлийн хоёр жилд музейн үзмэрийн тоо 1,190 болон 1,469 -өөр тус тус нэмэгдсэн ба эдгээрийн 50 хувь нь Улаанбаатар хотод нэмэгджээ.

Сэргээн засварлагдсан үзмэр

Музейн сан хөмрөг, бүртгэлд байгаа болон археологи, палеонтологийн олдвороос музейд хүлээлгэн өгсөн үзмэрийг цаг хугацаа, хадгалалт хамгаалалт, тээвэрлэлтээс шалтгаалан гарсан эвдрэл гэмтлийг мэргэжлийн сэргээн засварлагчаар бэхжүүлж, засуулан, цаашид удаан хугацаанд хадгалах боломжтой болгосон үзмэрийг сэргээн засварласан үзмэр гэнэ. Тухайн жилд сэргээн засварласан үзмэрийн тоогоор илэрхийлэгдэнэ.

Улсын хэмжээнд 2019 онд 697 үзмэр, 2020 онд 283 үзмэрийг сэргээн засварласан бөгөөд эдгээрийн дийлэнх хэсэг Улаанбаатар хотод байх ажээ.

Дижитал хэлбэрт оруулсан үзмэр

Музейн үзмэрийг дижитал хэлбэрт оруулсан байдлыг сүүлийн хоёр жилд бүртгэжээ. Улсын хэмжээнд 2019 онд 3,730 үзмэр, 2020 онд 3,868 үзмэрийг дижитал хэлбэрт оруулсан байна. Голчлон орон нутгийн музейн үзмэрийг дижитал хэлбэрт оруулж байна.

Хасагдсан болон хуулбарлагдсан үзмэр

Улсын хэмжээнд хасагдсан үзмэрийн тоог авч үзвэл 2019 онд 312, 2020 онд 277 үзмэр хасагдсан байна. Улаанбаатар хотод 2019 онд 1, 2020 онд 190 үзмэр хасагдсан байна. Үүнээс харахад 2019 онд

орон нутагт, 2020 онд Улаанбаатар хотод музейн үзмэр ихээр хасагдсан байна.

Улсын хэмжээнд хуулбарлагдсан үзмэрийн тоо 2019 онд 16, 2020 онд 4 байжээ.

Музейн үзмэр, дэглэгдсэн төрлөөр

Музейн үзмэрийн тоог дэглэгдсэн төрлөөр нь авч үзье. Дэглэгдсэн төрлөөр нь музейн үзмэрийг үзүүлэгт дэглэсэн, үзэсгэлэнд дэглэгдсэн, сан хөмрөгт гэж гурав ангилна.

Дараах графикт музейн нийт үзмэрийн тоон эзлэх хувиар дэглэгдсэн үзмэрийн төрлүүдийг харууллаа. Улсын хэмжээнд үзүүлэгт дэглэсэн болон сан хөмрөгт дэглэгдсэн үзмэрийн тоо өссөн байна. Үзэсгэлэнд дэглэгдсэн үзмэрийн тоо багассан байна.


График 45: Музейн үзмэрийн тоо, дэглэгдсэн төрлөөр, тоон утгаар



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Улсын сан хөмрөгт дэглэгдсэн тоог харвал 2019 онд нийт үзмэрийн 75 хувь, 2020 онд нийт үзмэрийн 77 хувь улсын сан хөмрөгт дэглэгдсэн байна. Үүний дараагаар үзүүлэгт дэглэгдсэн эзлэх хувь багтах ба 2019 онд нийт үзмэрийн 19 хувь, 2020 онд нийт үзмэрийн 28 хувь үзүүлэгт дэглэгдсэн байна. Үзэсгэлэнд дэглэгдсэн байдал хамгийн бага хувийг эзлэх ба 2019 онд нийт үзмэрийн 6 хувь, 2020 онд нийт үзмэрийн 5 хувь үзэсгэлэнд дэглэгджээ.

График 46: Музейн үзмэрийн тоо, дэглэгдсэн төрлөөр




Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Музейн үзмэр, үзмэрийн зэрэглэл, дэсээр

Музейн үзмэрийн тоог үзмэрийн зэрэглэл, дэсээр авч үзье. Үзмэрийн зэрэглэл дэсийн хувьд түүх, соёлын хосгүй үнэт, түүх, соёлын үнэт гэж хоёр ангилна. Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 56,058 буюу нийт үзмэрийн 23 хувийг түүх, соёлын

v. Музейн ажиллагчдын тоо мэдээлэл

Музейн ажиллагчдын батлагдсан орон тооны дүүргэлт, 2020 оны байдлаар:




Монгол Улсын хэмжээнд музейн ажиллагчдын тоо 2020 оны байдлаар 671 байсан ба энэ нь СБҮ-ийн ажиллагчдын 2 хувийг бүрдүүлж байна.

Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

үнэт үзмэр эзэлж байна. Түүх, соёлын хосгүй үнэт үзмэр 2020 оны байдлаар 727 бүртгэгдсэн ба нийт үзмэрийн 0,3 хувийг эзэлж байна.

График 47: Музейн үзмэрийн тоо, үзмэрийн зэрэглэл, дэсээр, тоон утгаар



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

График 48: Музейн ажиллагчдын тоо, 2019, 2020 оны байдлаар:






График 49: Музейн ажиллагчдын албан тушаал, нийт дүнд эзлэх хувь, 2020 оны байдлаар



График 50: Музейн ажиллагчдын дундаж нас, сүүлийн гурван жилийн байдлаар



Музейн ажиллагчдын хүйсийн харьцааг харахад нийт ажиллагчдын 56 хувийг эмэгтэй ажиллагчид бүрдүүлж байна.


График 51: Музейн ажиллагчид, боловсролын түвшнээр, 2020 оны байдлаар

Боловсролын түвшнээр:


Суурь болон бүрэн дунд



Техникийн болон тусгай мэргэжлийн дунд



Дипломын болон дээд боловсролын



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Музейн ажиллагчид, албан тушаал, насны бүлэг, боловсролын түвшин, хүйсээр:

Хүснэгт 54: Музейн ажиллагчдын тоон мэдээлэл

Музейн ажиллагчдын тоон үзүүлэлтүүд	Улаанбаатар хотод			Улсын хэмжээнд		
	2018	2019	2020	2018	2019	2020
Баталсан орон тоо	343	305	306	732	674	684
Нийт ажиллагчдын тоо	275	294	303	639	658	671
Үүнээс: Эмэгтэй	181	172	182	381	365	379
Мэргэжлийн		142	147		291	320
Төр, засгийн шагналтан		52	42		101	95
Хөгжлийн бэрхшээлтэй		6	8		13	16
Үүнээс: Эмэгтэй		3	5		6	7
АЛБАН ТУШААЛААР						
Захиргаа, аж ахуйн		94	99		254	243
Үүнээс: Эмэгтэй		55	58		119	114
Мэргэжлийн ажиллагчид	183	81	85	307	185	195
Үүнээс: Эмэгтэй	131	52	54	219	122	131
Үйлчилгээний ажиллагчид	103	108		198	214	
Үүнээс: Эмэгтэй	60	67		119	131	
Түр хугацаагаар ажиллагчид (гэрээт)		16	11		21	19
Үүнээс: Эмэгтэй		5	3		5	3
НАСНЫ БҮЛГЭЭР						
25 хүртэлх	26	38	34	44	54	45
Үүнээс: Эмэгтэй	18	19	23	28	26	30
25-34	81	79	77	180	166	165
Үүнээс: Эмэгтэй	57	48	45	115	98	96
35-44	72	68	79	213	205	207
Үүнээс: Эмэгтэй	51	46	54	141	125	131
45-54	69	68	76	144	153	178
Үүнээс: Эмэгтэй	47	40	45	85	89	101
55-59	20	27	22	42	58	47
Үүнээс: Эмэгтэй	7	17	13	9	23	17
60+	7	14	15	16	22	29
Үүнээс: Эмэгтэй	1	2	2	3	4	4
БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР						
Боловсролгүй				1		
Үүнээс: Эмэгтэй				2		
Бага				4	5	5
Үүнээс: Эмэгтэй				2		
Суурь		3	3	27	22	22
Үүнээс: Эмэгтэй		2	1	8	9	7
Бүрэн дунд	30	36	34	112	115	123
Үүнээс: Эмэгтэй	21	22	24	50	51	53
Техникийн болон мэргэжлийн	32	24	25	67	61	47
Үүнээс: Эмэгтэй	17	8	7	28	15	17
Тусгай мэргэжлийн дунд	28	17	13	48	41	37
Үүнээс: Эмэгтэй	13	6	6	21	15	15
Дипломын болон бакалаврын дээд	128	140	153	266	291	310
Үүнээс: Эмэгтэй	82	89	98	184	192	202
Магистр	48	61	63	105	109	114
Үүнээс: Эмэгтэй	42	39	39	80	77	78
Доктор	9	13	12	9	14	13
Үүнээс: Эмэгтэй	6	6	7	6	6	7

vi. Архив

Соёлын биет өвийн нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд GLAM загвараар хамтад нь хөгжүүлэх хэрэгтэй. Галерей, Номын сан, Архив, Музейд байгаа зураг, мэдээлэл, түүх, археологийн олдвор, ном, архивын

бичиг баримтуудыг нэг дор бүртгэж, цахим каталог үүсгэснээр хаана юу байгаа нь тодорхой болж, Монгол Улсын иргэд, судлаачид, уран бүтээлчид болон дэлхийн монгол судлаачид судалгаа, шинжилгээ, сургалт хөгжлийн зорилгоор авч ашиглах боломж бүрдэнэ.

Шигтгээ 11: Архивын тухай хууль

- 4.1.1. "архив" гэж архивын баримтыг хуульд заасан журмын дагуу хүлээн авах, бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, хяналт тавих, ашиглуулах үүрэг бүхий байгууллага болон байгууллагын зохион байгуулалтын нэгжийг;
- 4.1.2. "архивын баримт" гэж архивт байнга болон түр хугацаагаар хадгалагдаж байгаа бүх төрлийн баримтыг;
- 4.1.3. "архивын хадгаламжийн нэгж" гэж тодорхой шинжээр нь ангилан төрөлжүүлсэн, биет байдлаараа тус тусдаа хадгалагдаж байгаа бүртгэлийн дугаар бүхий нэг буюу хэд хэдэн баримтыг;
- 4.1.4. "архивын хөмрөг" гэж өөр хоорондоо гарал үүсэл, учир шалтгааны салшгүй холбоотой энэ шинжээрээ ангилагдан хадгалагдаж байгаа архивын баримтыг;

Зураг 15: Монгол Улсын архивын тогтолцоо, төрийн архивын тоо



Эх үүсвэр: Архивын ерөнхий газар - <http://www.archives.gov.mn/home>


Үндэсний төв архивт 2020 оны жилийн эцсийн байдлаар 1570-2019 оны цаасан болон тусгай төрлийн байнга хадгалагдах 1,311 хөмрөгийн 974,392 хадгаламжийн нэгж баримт хадгалагдаж байна. Үүнээс 519 хосгүй үнэт баримт байна.

Зураг 16: Үндэсний төв архивт байнга хадгалагдаж буй цаасан суурьтай баримтын тоо




Эх үүсвэр: Үндэсний төв архив, 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

Зураг 17: Үндэсний төв архивт байнга хадгалагдаж буй кино болон гэрэл зургийн баримтын тоо



Эх үүсвэр: Үндэсний төв архив, 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

Зураг 18: Үндэсний төв архивт байнга хадгалагдаж буй дуу авианы болон дүрс бичлэгийн баримтын тоо



Эх үүсвэр: Үндэсний төв архив, 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

Үндэсний төв архивт 519 хосгүй үнэт баримт хадгалагдаж байна. Тухайлбал, үүний дотор "Халхын Очирай бат Түшээт хааны тамга" байдаг. Энх-Амгалангийн 59 дүгээр /1720/ онд Өндөр гэгээн Занабазар өөрийн ач дүү Түшээт хан Ванжилдоржийн цолыг үе улируулан батламжлуулахаар гуйн айлтгаснаар Энх-Амгалангийн 60 дугаар /1721/ онд Манж Чин Улсын Энх-Амгалан хаан Халхын Түшээт хан Ванжилдоржид "Халхын Очирай бат Түшээт хааны тамга"-ыг олгосон.¹⁸

¹⁸ <http://www.archives.gov.mn/content/509>

Зураг 19: Халхын Очирай бат Түшээт хааны тамга. 1721 он. /Гууль/



Эх үүсвэр: Үндэсний төв архив. /ТБА. Х-М 169, Д-1, ХН-23

Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Архивын ерөнхий газрын даргын 2021 оны А/25 тушаалаар баталсан “Архивын баримтыг хүн, хуулийн этгээдэд

ашиглуулах нийтлэг журам”-д заасны дагуу эрдэмтэн судлаачид, уран бүтээлчид архивын баримтыг ашиглах боломжтой.

vii. Салбарын гадаад худалдааны үзүүлэлтүүд

Зураг 20: Соёлын өвийн салбарын гадаад худалдааны хэмжээ, мянган ам.доллар

Соёлын өвийн салбарын импортын хэмжээ 2010 онд 2,116 ам.доллар байжээ. Сүүлийн арван жилийн хугацаанд 2018 онд хамгийн өндөр буюу 15,649 ам.долларт хүрсэн байна. Нийт соёлын салбарын импортын хэмжээний 0,01 хувийг эзэлж байна.


Соёлын өвийн салбарын экспортын хэмжээ 2010 онд 4188.75 ам.доллар байжээ. Сүүлийн арван жилийн хугацаанд

2017 онд хамгийн өндөр буюу 9,385 ам.долларт хүрсэн байна. 2020 оны байдлаар 1,554 ам.доллар байх ба нийт соёлын салбарын экспортын хэмжээний 0,43 хувийг эзэлж байна. Соёлын өвийн салбарын импорт, экспортыг бүтээгдэхүүний төрлөөр харвал үнэт эдлэл 100 хувь бүрдүүлж байна.

Эх үүсвэр: ГЕГ, “Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл”

viii. Салбарын төгсөгчдийн тоо мэдээлэл

График 53: Соёлын өвийн салбарын төгсөгчдийн нийт СБҮ-ийн төгсөгчдийн тоонд эзлэх хувь



12 их, дээд сургууль

40 ХӨТӨЛБӨР

Соёлын өвийн салбарт 2019-2020 оны хичээлийн жилд 268 оюутан суралцаж төгссөн ба энэ нь нийт соёлын салбарын төгсөгчдийн 8 хувийг бүрдүүлж байна.

\$12.2 мянга


СОЁЛЫН ӨВИЙН САЛБАРЫН ИМПОРТЫН ХЭМЖЭЭ, 2020 оны байдлаар

\$0.002 мянга

СОЁЛЫН ӨВИЙН САЛБАРЫН ЭКСПОРТЫН ХЭМЖЭЭ, 2020 оны байдлаар

Соёлын өвийн салбарын бараа бүтээгдэхүүний экспорт, импортын хэмжээг сүүлийн арван жилийн байдлаар дараах графикт харуулж байна.

График 52: Соёлын өвийн салбарын экспорт, импортын хэмжээ, 2010-2020 оны байдлаар, ам.доллар



Боловсролын зэрэг






График 54: Соёлын өвийн салбарын төгсөгчид, боловсролын зэрэг, хүйсээр, 2019-2020 оны хичээлийн жилд



Эх үүсвэр: БШУЯ, “Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн тайлан”, 2019-2020

УТГА ЗОХИОЛ, НОМ ХЭВЛЭЛ

Literature and Publishing



“

Номын утга нь тэнгэр мэт агуу, дэлхий мэт өргөн, далай мэт гүн. Номыг унших нь тэнгэрт нисэж, дэлхийг тойрч, далайд ХӨВӨХ МЭТ...

Ардын уран зохиолч
Ц.Дамдинсүрэн

”

5.2. УТГА ЗОХИОЛ, НОМ ХЭВЛЭЛ

5.2.1. Утга зохиолын салбар

АНУ-д жилд дунджаар 600.000-1.000.000 ширхэг ном хэвлэгддэг ба ном хэвлэлийн салбар нь дэлхийн хэмжээнд 103 тэрбум доллар үнэлэгддэг томоохон салбаруудын нэг юм (Rosen, 2016). Хүмүүс дан ганц цаасан ном уншихаа больсон бөгөөд Америкт л гэхэд 20.5 сая “Kindle” ашиглагдаж байна (How many people read on a Kindle?, 2016). Технологийн хөгжлөө дагаад утга зохиолын салбар ч мөн хөгжиж байна. Бид яагаад өдөр тутмын амьдралдаа утга зохиолын сонирхон уншиж, номыг амьдралынхаа хэрэглээ болгох шаардлагатай вэ? Энэ нь бидэнд ямар үр өгөөжийг өгөх вэ? Цаашлаад нийгэм, эдийн засагт ямар үр нөлөөтэй вэ?

Нийгмийн үр нөлөө

Ном уншихын давуу талууд

11-р зууны үед Японы зохиолч Мирасаки Шикибүгийн бичсэн “Генжийн үлгэр” гэх 54 бүлэг номыг дэлхийн хамгийн анхны роман гэж үздэг. Хэдийгээр тэр цагаас хойш 2000 гаруй жил өнгөрсөн ч хүмүүс номыг шимтэн уншсаар л байна.

Ном унших нь таны бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндэд тустай бөгөөд эдгээр ашиг тус нь насан туршид тань үргэлжилж болно (Stanborough, 2019). Үүнд:

Унших нь таны тархины үйл ажиллагааг бэхжүүлнэ.

Сайхан амрахад тусалдаг.

Үгсийн санг нэмэгдүүлнэ.

Стрессийг багасгана.

Сэтгэлийн хямралын шинж тэмдгийг арилгахад тусалдаг.

Номын сан

Дэлхийн хамгийн анхны нэгдсэн систем, зохион байгуулалттай номын сан МЭӨ 7-р зуунд Ирак дахь Ниневед байгуулагдсан байна (Vaughan, n.d.). 2017 оны байдлаар АНУ-д 715 сая зохиол бүтээлтэй, 9045 нийтийн номын сан үйл ажиллагаа явуулж байна. Хүмүүс номын сангаар идэвхтэй үйлчлүүлснээр дараах үр өгөөжийг хүртэнэ. Үүнд:

Элдэв зүйлд сатааралгүй, төвлөрөх боломжтой.

Зохиол бүтээлийн сан бүрдүүлэх боломжтой.

Дэлхийн алдартай номын сангууд

• Конгрессын номын сан - АНУ, Вашингтон



Вашингтон ДС-ийн Конгрессын номын сан нь үндсэндээ АНУ-ын үндэсний номын сан болон тус улсын хамгийн эртний холбооны соёлын байгууллага юм. Ердөө гурван барилгаас бүрдэх боловч номын тавиур, боть хэмжээгээрээ дэлхийд хамгийн томд тооцогдох номын сан юм. Номын сангийн сан хөмрөг нь асар өргөн бөгөөд үүнд 32 сая гаруй ном, 61 сая гаруй гар бичмэл багтдаг (The best libraries in the world, 2020).

• Раза номын сан – Энэтхэг



1904 онд баригдаж дууссан бөгөөд нэгэн цагт ордны нэг хэсэг байжээ. Хааны гэр бүл 1774 оноос хойш номын санд зориулж бүтээлүүдээ цуглуулж эхэлсэн байна. Эдгээр санд 17000 ховор гар бичмэл, 205 дал модны навчин дээрх гараар бичвэр, 5000 жижиг хэмжээтэй зураг багтжээ (Harness, 2012).

Цахим ном

Электрон ном буюу цахим ном нь уран зохиол, текстэд суурилсан мэдээлэлд нэвтрэхэд хамгийн хялбар, орчин үеийн арга зам юм. 2015 оны байдлаар АНУ-д 83.4 сая цахим уншигч, хэрэглэгч байна гэж тооцоолсон бөгөөд энэ тоо нь цаашид

ч мөн өсөх хандлагатай байна (E-reader, 2015). Цахим ном унших төхөөрөмжүүдээс хамгийн олон хүнд хүрч, танигдсан төхөөрөмж бол “Киндл” юм.

Амазон компани 2007 оны 11-р сарын 19-нд 399 долларын үнээр анхныхаа Kindle-ийг гаргаж байсан ба таван цаг хагасын дотор зарагдаж дууссан байдаг. 2017 оны байдлаар “Kindle”-ийн бүтээлийн санд АНУ-д зөвшөөрөгдсөн нийт 5.9 сая цахим ном байсан байна (25 Interesting And Awesome Facts About The Amazon Kindle, 2018).

Дан ганц төхөөрөмж ч гэлтгүй ухаалаг утсандаа цахим номын аппликейшныг суулган хүссэн газраасаа, хүссэн зүйлээ, хүссэн үедээ унших боломжтой.

• Ухаалаг утасны аппликейшнууд:



Amazon Kindle



Apple Books



SCRIBD



Google Play Books



Blue fire Reader

Эдийн засгийн үр нөлөө

Дэлхийн ном хэвлэн нийтлэгчдийн зах зээл 2020 онд 87.92 тэрбум доллар байсан бол 2021 онд 92.68 тэрбум доллар болж жилийн нийлмэл өсөлтийн хурдаар (CAGR) 5.4% -иар өсөх төлөвтэй байна. Энэ өсөлтөд компаниуд үйл ажиллагаагаа шинэчилж, ковид-19-ийн нөлөөллөөс гарсантай холбоотой бөгөөд үүнээс өмнө алсын зайнаас ажиллаж, арилжааны үйл ажиллагаа нь зогсоод байсан юм. Зах зээл 2025 онд 3% -ийн CAGR-ээр 104.21 тэрбум долларт хүрэх төлөвтэй байна.



2020 онд 87.92 тэрбум доллар

5.4%↑



2021 онд 92.68 тэрбум доллар

3%↑



2025 онд 104.21 тэрбум доллар

Харин цахим ном/E-Book/-ын хувьд АНУ, Европын зах зээл дээр цахим номын худалдаа эрчимтэй өсөж байна. Цахим номууд нь АНУ, Их Британи зэрэг өндөр хөгжилтэй орнуудын зах зээл дээрээс цаасан номоос илүү их орлого олж байгаа ба дэлхийн ном хэвлэн нийтлэгчдийн нийт орлого 1.7% -иар өсөх төлөвтэй байна. Бодит ном хэвлэн нийтлэгчдийн салбар тасралтгүй хумигдаж байгаа ч цахим номын борлуулалт өсөж байна. Дижитал хувилбарыг хэрэглэгчдийн таашаал нэмэгдэж байгаа нь энэ хугацаанд зах зээлийн өсөлтөд ихээхэн нөлөөлж байна (Global Book Publishers Market Report (2021 to 2030) - COVID-19 Impact and Recovery - ResearchAndMarkets.com, 2021).

Утга зохиол, ном хэвлэлийн салбарын мэргэжлийн холбоод



Монгол Улсад “Монголын зохиолчдын эвлэл”, “Орчуулагчдын эвлэл”, “Чөлөөт зохиолчдын эвлэл”, “Хүүхдийн зохиолчдын холбоо”, “Хүүхдийн зохиолчид, зураачдын холбоо” гэх мэт 10 гаруй утга зохиол, ном хэвлэлийн мэргэжлийн холбоод байдаг. Үүнээс хамгийн том мэргэжлийн холбоо нь “Монголын зохиолчдын эвлэл” юм. 890 гишүүдтэй.

1929 оны 1-р сарын 9-ий өдөр Монголын уран зохиолын авьяастнууд хуралдан, уран зохиолын бүлгэм байгуулсан нь одоогийн “Монголын зохиолчдын эвлэл” юм (Монголын орчин үеийн уран зохиолын үйл явдлын товчоон, 2016).

“Монголын зохиолчдын эвлэл”-ээс “Болор цом” яруу найргийн наадам, “Утгын чимэг”

богино өгүүллэгийн наадам, “Алтан өд” оны шилдэг бүтээл шалгаруулах ёслолуудыг зохион байгуулдаг.

Хэвлэлийн статистик

Хэвлэлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 600 гаруй байгууллага байдаг ба идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 100 байгууллага байна. Үүний 57 аж ахуйн нэгж нь “Монголын хэвлэх үйлдвэрүүдийн холбоо”-д бүртгэлтэй байдаг.

Монгол Улсад хэвлэгдэж буй нийт бүтээгдэхүүнүүдийг нэр төрлөөр нь ангилан авч үзвэл хамгийн их буюу 60%-г ном, сурах бичиг, сонин сэтгүүлийн хэвлэл эзэлж байна. Хэвлэлийн үйлдвэрлэлд ном хэвлэл хамгийн их хувь эзэлдэг болохыг харж болно.

Бүтээгдэхүүний нэр төрөл/хувиар/



Эх үүсвэр: ХХААХҮЯ, салбарын мэргэжлийн холбоо, 2019 он

Цахим ном

2018 оноос үйл ажиллагаагаа явуулж байгаа M+ аппликейшн нь Монгол хэл дээрх цахим ном, аудио ном болон подкастын цогц платформ юм. Цахим санд 800 гаруй бүтээлийг хэрэглэгчдэдээ хил хязгаар хамаарахгүй хүргэдэг ба дэлхийн өнцөг булан бүрээс Монгол хэл дээр Монголын болон дэлхийн бэстсэллэрүүдийг унших, сонсох боломжтой.

**Бүтээгдэхүүн:**

- ✓ Цахим ном
- ✓ Аудио ном
- ✓ Подкаст

Статистик:

- ✓ 240,000+ хэрэглэгч
- ✓ 800+ нийтлэгч
- ✓ 4000+ оюуны бүтээл

Төлбөр:

- ✓ Суурь хураамж 50,000-200,000 төгрөг
- ✓ Гэрээний шимтгэл 30%

ix. Монгол Улсын утга зохиолын салбарт тулгамдаж буй асуудал бэрхшээл

Монгол Улсын утга зохиолын салбарт тулгамдсан асуудлуудыг хүний нөөц, эко орчин, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон маркетинг, борлуулалт гэсэн таван чиглэлийн хүрээнд тодрууллаа.

ХҮНИЙ НӨӨЦ

- Ном зүйч, номын шүүмжлэгч, хүүхдийн зохиолч, хүүхдийн дуу зохиогч, хэвлэлийн эх бэлтгэгч, редактор, номын дизайнер дутагдалтай.
- Мэргэжлийн бус хүмүүс ажилладаг.
- Редакторын хяналт муу.

Шигтгээ 12: Номын санчаар суралцаж буй оюутнууд

"Утга уран зохиолын салбарт ном зүйч, номын шүүмжлэгч, хүүхдийн зохиолч, хүүхдийн дуу зохиогч, хэвлэлийн эх бэлтгэгч, редактор, номын дизайнер мэргэжлүүд дутагдалтай байна. Монгол Улс дахь номын сангийн үйл ажиллагаа дэлхийн жишигт нийцдэггүй. Соёлын сургууль дээр мэргэжлийн номын санч бэлддэг боловч Монгол хэл дээр нэгдсэн цөм хөтөлбөр гэж байдаггүй. Дээрээс нь номын санчаар бэлтгэгдэж байгаа оюутнууд суурь муутай байдаг."

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас**Шигтгээ 13: Мэргэжлийн хүүхдийн зохиолч хомс**

"Мэргэжлийн хүүхдийн зохиолч бага байна. Утга зохиолын ангийг хүүхдийн зохиолч мэргэжлээр төгсдөг ч хүүхдийн зохиол бичихэд хангалттай сайн бэлтгэгдээгүй байдаг."

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

Редактор хүмүүс цөөн байдаг учраас найрлага сайтай, чанартай ном гардаггүй. Хүмүүс номоо мэргэжлийн редактор хүмүүсээр хянуулдаггүй. Хяналт маш муу байдаг.

ЭКО СИСТЕМ

- Номын агуулгын стандарт бага.
- Номын сангууд нэгдсэн бодлогогүй.
- Хэвлэн нийтлэлийн бодлого байхгүй.
- Ном бүтээгчдээс татвар авдаг.
- ISBN статистик гаргах боломжтой ч гаргаж өгдөггүй, ашиглах боломжгүй.
- Ном бүтээлийн шүүмж орхигдсон.
- Уралдаан тэмцээнүүд эмх замбараагүй.

**Шигтгээ 14: Утга зохиолын салбарын эко системийн асуудлууд**

"Утга зохиолын салбарын эко системийн хувьд номын агуулгын стандарт бага бөгөөд номын сангийн нэгдсэн бодлогогүй. Өнгөрсөн зууны системээр ажилладаг. Ардчилал гарснаас хойш шинэчлэлт огтхон ч хийгдээгүй. Мөн хадгалалт хамгаалалтын мэргэжлийн хичээл үзээд ирэхээр манайх хадгалалт хамгаалалтын хамгийн энгийн шаардлагыг ч ерөөсөө хангахгүй байгаа нь тодорхой байдаг."

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

Хэвлэн нийтлэлийн нэгдсэн бодлого байдаггүйгээс гадна ном бүтээгчдээс их хэмжээний татвар авдаг. Номын дэлгүүр нь нийт 33 хувийн ашгийг авдаг. Ном болгоноос 10 хувийн татвар авдаг. Гэхдээ зарагдаагүй ном байсан ч татвар авдаг. Энэ систем нь зохиолчдыг номоо олон нийтэд худалдахад саад болж байна.

ISBN нь олон улсын стандарчлалын байгууллагаас гаргадаг 13 орон бүхий тухайн ном, бүтээлийг бусад бүтээлээс ялгах олон улсын стандарт дугаар юм. Монгол Улсад ISBN статистик гаргах боломжтой ч гаргаж өгдөггүй учраас уран бүтээлчид ашиглах боломжгүй байдаг.

Ном бүтээлийн шүүмж орхигдож байна. Зөвхөн номын өмнөх үгээр, маркетинг хэлбэрээр бичигдэх болсон. Уралдаан тэмцээнүүд эмх замбараагүй байгаа тул тэмцээнүүдийн шалгуур нэмэгдүүлэх шаардлагатай.

ДЭД БҮТЭЦ

- Салбар хоорондын уялдаа холбоо сул.
- Гадаад улсын уран бүтээлчидтэй хамтарч ажилладаггүй.

Утга зохиолын салбарын дэд бүтцийн хувьд бусад салбартай уялдаа холбоо сул байдаг ба гадаадын зохиолчидтой хамтарч ажилладаггүй. Зөвхөн дотоодын уран бүтээлчидтэйгээ хамтарч ажилладаг.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Судалгаа, мэдээлэл байхгүй.

Салбарт зориулагдан төсөв батлагддаг боловч яг юунд, хэдэн төгрөг зарцуулагдаж байгаа нь тодорхойгүй байдаг. Утга зохиолын салбарын нэгдсэн судалгаа, мэдээлэл байдаггүй.

МАРКЕТИНГ, СУРТАЛЧИЛГАА

- Ном унших ач холбогдол, шаардлагыг иргэд ойлгодоггүй.
- Дижитал платформыг иргэдэд таниулах.

Шигтгээ 15: Ном унших дадлыг нэмэгдүүлэх

Ном унших ач холбогдол, шаардлагыг иргэд сайн ойлгодоггүй. Ихэнх хүмүүс номыг хэрэглэдэг бус шүтдэг хүмүүс байна. Номын хэрэглээг хүмүүст таниулах хэрэгтэй. Шүтдэг ч уншдаггүй хүмүүс олширч байна. Номыг хэрэглэдэг хүмүүсийн тоог нэмэгдүүлэх аян явуулах шаардлагатай. Мөн дижитал платформуудыг хүмүүст таниулж, хэрэглээг нь нэмэгдүүлэх.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

х. Процессын зураглал

УТГА ЗОХИОЛ, НОМ ХЭВЛЭЛИЙН САЛБАРЫН ПРОЦЕССЫН ЗУРАГЛАЛ



ЦАХИМ НОМЫН ПРОЦЕССЫН ЗУРАГЛАЛ



5.2.2. Утга зохиол, ном хэвлэлийн салбарын статистик мэдээлэл

Хүснэгт 55: Номын сангийн статистик

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2018	2019	2020
Номын сангийн тоо	364	364	26
Соёлын төвийн номын сангийн танхим			339
Номын сангийн нийт суудлын тоо	10,445	10,592	10,521
Үйлчилгээний нийт тоо		2,460,585	1,264,686
Нийт номын сангийн үйлчилгээ		2,450,077	1,258,301

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2018	2019	2020
Ном олгох үйлчилгээ		2,406,247	1,214,152
Лавлагаа ном зүйн үйлчилгээ / Өгөгдсөн лавлагаа/		33,528	37,407
Номын татгалзал		10,302	6,742
Олгосон номын нийт тоо	2,557,607	2,401,232	1,277,934
Уншлагын танхимаар	1,741,521	1,680,523	708,939
Гэрээр	582,584	507,774	363,766
Зөврөөр	233,502	194,705	150,790
Цахимаар		18,230	54,439
Тусгай бүлгийн		15,510	6,407
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд		10,252	4,300
Бусад үйлчилгээ		10,508	6,385
Нийт үйлчлүүлэгчид	1,620,524	2,376,180	4,008,380
Хүүхэд		1,006,574	472,499
Төлбөргүй		828,917	1,876,243
Гадаад		4,036	16,202
Тусгай бүлгийн		125,915	52,112
Хөгжлийн бэрхшээлтэй		10,322	6,248
Бусад		115,593	45,864
Байнгын уншигч	735,643	388,180	277,061
Шинэ уншигч		158,918	92,797
Ирэгсэд		1,434,926	660,956
Уншлагын танхимаар		1,020,596	384,755
Гэрээр		358,758	230,801
Зөврийн номын сангийн үйлчилгээ		147,292	100,929
Цахимаар		22,529	1,769,668
Лавлагаа номзүйн үйлчилгээ /Өгөгдсөн лавлагаа/		35,909	23,958
Бусад үйлчилгээ		376,766	1,222,068
Сан хөмрөгийн нийт тоо	6,281,774	6,204,592	6,275,591
Үнийн дүнгээр /мян. төг/	12,809,091		
Хэвлэмэл ном		6,146,724	6,208,465
Брайл үсгийн ном		2,834	8,217
Хэвлэмэл бус		7,479	8,072
Тогтмол хэвлэл		34,335	42,456
Цахим сан хөмрөгийн нийт тоо		16,054	16,598
Шинээр нэмэгдсэн цахим ном		3,100	1,863
Сан хөмрөгийн баяжилт	869,302	53,987	44,340
Сан хөмрөгөөс хасагдсан	72,696	34,179	30,685
Баталсан орон тоо	562	501	491
Нийт ажиллагчдын тоо	482	500	509
Эмэгтэй	359	377	383
Мэргэжлийн		313	308
Төр, засгийн шагналтан		119	119
Хөгжлийн бэрхшээлтэй		10	15
Эмэгтэй		7	8

ҮЗҮҮЛЭЛТҮҮД		2018	2019	2020
Албан тушаалын ангиллаар	Захиргаа, аж ахуйн	213	190	198
	Эмэгтэй	127	117	126
	Мэргэжлийн ажиллагчид	269	277	282
	Эмэгтэй	232	242	243
	Үйлчилгээний ажиллагчид		25	24
	Эмэгтэй		16	13
	Түр хугацаагаар ажиллагчид (гэрээт)		8	5
Эмэгтэй		2	1	
Насны бүлгээр	25 хүртэлх	21	27	14
	Эмэгтэй	14	21	12
	25-34	131	107	124
	Эмэгтэй	95	71	85
	35-44	141	138	135
	Эмэгтэй	104	112	109
	45-54	147	172	182
	Эмэгтэй	121	131	141
	55-59	42	49	49
	Эмэгтэй	25	40	36
Боловсролын түвшнээр	60+	-	7	5
	Эмэгтэй	-	2	
	Боловсролгүй		-	
	Эмэгтэй		-	
	Бага	1	1	1
	Эмэгтэй	1	1	1
	Суурь	10	10	8
	Эмэгтэй	5	7	6
	Бүрэн дунд	94	79	85
	Эмэгтэй	47	38	44
	Техникийн болон мэргэжлийн	38	30	32
	Эмэгтэй	18	13	11
	Тусгай мэргэжил дунд	25	22	17
	Эмэгтэй	25	17	14
	Дипломын болон бакалаврын дээд	258	304	306
	Эмэгтэй	217	253	257
Магистр	54	52	58	
Эмэгтэй	44	46	48	
Доктор	2	2	2	
Эмэгтэй	2	2	2	

Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Утга зохиол, ном хэвлэлийн салбарт утга, уран зохиолын бүтээлийг туурвин гаргахаас эхлүүлээд тэдгээрийг эмхэтгэн гаргах, эх бэлтгэх, редакторлах, хэвлэх, худалдан борлуулах, тэдгээрийг уншигчдад төрөл бүрийн хэлбэрээр уншигчдад хүргэх хүртэлх бүхий л үйл ажиллагааг хамруулан авч үзнэ. Энэ утгаараа уг салбарт дараах салбар, үйл ажиллагааг хамруулан авч үзнэ:

- **Ном бүтээгчид** буюу зохиолчид, орчуулагч, зохиогч, уран бүтээлчид болон хэвлэлийн газрууд (паблишн компаниуд);

- **Ном үйлдвэрлэгчид** буюу хэвлэлийн үйлдвэрүүд;
- **Ном түгээгчид** буюу номын сангууд, номын худалдааны компани, дэлгүүрүүд, цахим номын худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй компаниуд.

Утга зохиол, ном хэвлэлийн салбарт давхардсан тоогоор 79 байгууллагад 1,179 хүн ажиллаж байна. Салбарын нийт орлого 2020 оны байдлаар 124.5 тэрбум төгрөг байжээ.

Хүснэгт 56: Утга зохиол, ном хэвлэлийн салбарын аж ахуйн нэгж, ажиллагчдын тоо, салбарын орлого, 2020 оны байдлаар

Дэд салбар, үйл ажиллагаа	Аж ахуйн нэгжийн тоо	Ажиллагчдын тоо	Салбарын орлого, тэрбум төгрөгөөр
Зохиолчид	-	1,133	-
Хэвлэлийн газар	46	345	7.2
Хэвлэлийн үйлдвэр	300	4,000	76.0
Номын сан	365	509	-
Номын дэлгүүр, худалдаа	238	450	41.3
Цахим номын худалдаа	2	20	0.03
Бүгд	951	6,457	124.5

Тайлбар: Холбогдох мэдээллийн эх үүсвэрийг дэд бүлэг тус бүрээс харна уу

i. Ном бүтээгчид

Зохиолчид: Зохиолчдын бүртгэл статистик тоо мэдээлэл ямар нэг байгууллагад одоогоор байхгүй бөгөөд зохиолчдын хамгийн том байгууллага болох Монголын Зохиолчдын эвлэлийн гишүүдийн тоогоор зохиолчдын тоог гаргалаа. Монголын Зохиолчдын эвлэл 2021 оны 6 дугаар сарын байдлаар 1,133 гишүүн зохиолч уран бүтээлчтэй.¹⁹

Шигтгээ 16: Мэргэжлийн холбоод

Монголын зохиолчдын эвлэл, Орчуулагчдын эвлэл, Чөлөөт зохиолчдын эвлэл, Хүүхдийн зохиолчдын холбоо, Хүүхдийн зохиолчид зураачдын холбоо гэх мэт 10 гаруй холбоо байдаг. Монголын Зохиолчдын Эвлэлийн байгууллага 1929 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр шинэ үеийн уран зохиолыг хөгжүүлэх, зохиолчдыг дэмжих зорилгоор байгуулагдсан манай соёл урлагийн ууган байгууллага юм. Байгуулагдсан цагаасаа эхлэн олон төрлийн шинэ уран зохиолыг хөгжүүлэх, зохиолчдын хөдөлмөрийг үнэлэн урамшуулан дэмжих, үндэсний оюуны сан хөмрөгийг шилдэг уран бүтээлээр баяжуулах, уншигч олон, ард түмнийг гэгээрүүлэн оюун санааг хөгжүүлэх, дотоод, гадаадад сурталчлан танилцуулах, шүүмж судлалыг шинэ шатанд гаргах, зохиолчдын эрх ашгийг хамгаалах ажиллагааг тасралтгүй явуулсан олон нийтийн байгууллага.

Монголын Зохиолчдын Эвлэл яруу найргийн “Болор цом”, хүүрнэл зохиолын богино өгүүллэгийн “Утгын чимэг” наадмуудаас гадна оны шилдэг бүтээл шалгаруулах “Алтан өд” ёслолын ажиллагаа зэрэг олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг. “Утга зохиол урлаг”

сонин, “Цог” сэтгүүл зэрэг үндэсний хэмжээний утга зохиол, уран сайхны уламжлалт тогтмол хэвлэлийг эрхлэн гаргадаг. МЗЭ-ийн гишүүдийн 300 гаруй бүтээл жил бүр хэвлэгдэн гарч байна. Утга зохиолын уралдаан наадмуудад 400 гаруй зохиолч, яруу найрагч, орчуулагч, судлаач, шүүмжлэгчид оролцдог

Зураг 21: Монголын Зохиолчдын эвлэлийн үйл ажиллагаа




Эх үүсвэр: Монголын зохиолчдын эвлэл

Нийгмийн даатгалын ерөнхий газрийн нийгмийн даатгалд даатгуулагчдын мэдээллийн сангаас Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 (YAMAT-08)-ын дагуу Зохиолч, холбогдох бусад нийтлэлч (ангиллын код 2641) нарын тоог авч үзэхэд 2020 онд 345 хүн уг ажил мэргэжлээр ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлжээ. Уг ажил мэргэжлээр ажиллагчдын тоо 2016-2020

онд жил дараалан буурч, 2020 онд 2016 онтой харьцуулахад 2.1 дахин буурчээ. Энэ нь тухайн төрлийн ажилтнуудыг аж ахуйн нэгж, байгууллагууд гэрээт ажилтан байдлаар ажиллуулах болсон, зохиолчид хувиараа ажиллах хэлбэрийг илүүд үзэх болсон, түүнчлэн зохиолчид багш, сэтгүүлч, орчуулагч зэрэг бусад ажилтай давхар эрхлэх болсонтой холбоотой.

График 55: Зохиолч нийтлэлч, сэтгүүлч, орчуулагч нарын тоо



Эх үүсвэр: НДЕГ

Цаашид зохиолчдын тооноос гадна орчуулагч, бусад төрлөөр хувиараа ном эрхлэн гаргаж буй уран бүтээлчид, зохиогчдын тоо, тэдний тухайн жилд гаргасан номын тоо зэрэг үзүүлэлтийг тооцож гарган салбарын хөгжлийн түвшнийг хэмжиж байх шаардлагатай.

Хэвлэлийн газар: Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сан, Үндэсний статистикийн хорооны Бизнес регистрийн сан, Татварын ерөнхий газрын ААНБ-ын бүртгэлийн мэдээллийн сан дахь Номын эх бэлтгэх нийтлэх үйл ажиллагаа (ISIC код - 5811), Хэвлэх үйл ажиллагаа (ISIC код - 1811)-ны чиглэл бүхий ААНБ-ын жагсаалт болон ААНБ-ын нэрийн аль нэг хэсэгт “паблишинг”, “паблишинг” гэсэн үг орсон ААНБ-ыг гаргаж, тэдгээрийг номын худалдааны цахим хуудас болон интернэт танилцуулга мэдээлэлтэй тулгаж, ном эрхлэн гаргах үйл ажиллагаа явуулдаг буюу хэвлэлийн газар (паблишинг компани) ААНБ-ын тоог тодорхойллоо. Ийнхүү тодорхойлоход энэ чиглэлийн нийт **46 ААН** байгаагийн **27 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.**

Эдгээр ААНБ-ууд 2019 онд **7.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 118.5 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар** төлжээ. Албан бус мэдээлэлд үндэслэн тооцож үзэхэд хэвлэлийн газруудад **345 орчим хүн ажиллаж байна.**

Хэвлэлийн газруудаас Монсудар паблишн, Нэпко, Анд паблишн зэрэг компани тэргүүлэх байр суурь эзэлж байна.

Цаашид салбарын аж ахуйн нэгжийн тоо, ажиллагчдын тоо зэрэг үзүүлэлтээс гадна эдгээр аж ахуйн нэгжүүдийн эзэмшиж буй номын эрхийн тоо, редакторласан бүтээлийн тоо, хамтран ажиллагч түншүүдийн тоо буюу зохиолч, орчуулагч, уран бүтээлчдийн болон хамтран ажилладаг хэвлэлийн газрын тоо зэрэг үзүүлэлтийг тооцож гарган салбарын хөгжлийн түвшнийг хэмжиж байх шаардлагатай.

ii. Ном үйлдвэрлэл

Хэвлэлийн үйлдвэрүүд: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны мэдээллээр 2019 оны байдлаар **300 гаруй хэвлэлийн үйлдвэрт 4.0 мянган хүн ажиллаж, 110.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 76.0 тэрбум төгрөгийн борлуулалт хийжээ.** Эдгээр хэвлэлийн үйлдвэрийн дүнгээр **50.0 мянган ам.долларын экспортыг** тухайн жилд хийжээ.


Зураг 22: Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарын үзүүлэлтүүд, 2019 оны байдлаар

ХЭВЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, 2019 ОНЫ БАЙДЛААР	
Хэвлэлийн үйлдвэр	300
Ажиллагчид	4000
Үйлдвэрлэл /тэрбум төгрөг/	110.5
Борлуулалт /тэрбум төгрөг/	76.0
Экспорт /мянган ам.доллар/	50.0

Эх үүсвэр: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийгмийн даатгалд даатгуулагчдын мэдээллийн сангаас Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 (YAMAT-08)-ын дагуу Хэвлэгч (ангиллын код 7322) нарын тоог авч үзэхэд 2020 онд 221 хүн уг ажил мэргэжлээр ажиллаж, нийгмийн даатгал төлжээ. Уг ажил мэргэжлээр ажиллагчдын тоо 2016-2020 оны жил дараалан нэмэгдэж, 2020 онд 2016 онтой харьцуулахад 1.9 дахин өсжээ.

График 56: Хэвлэгч нарын тоо



Эх үүсвэр: НДЕГ

iii. Номын сан

Номын сангийн тоо, үйлчилгээний үзүүлэлтүүд: Соёлын яамны соёлын статистик мэдээллээс харахад 2020 оны байдлаар 26 номын сан, Соёлын төвийн номын сангийн 339 танхим үйл ажиллагаа явуулж байна. 2020 онд Соёлын төвийн номын сангийн уншлагын

танхим нэгээр нэмэгдэж нийт 365 номын сантай болсон хэдий ч суудлын тоо 10,521 болж, 2019 оныхоос 70 суудлаар буурчээ. Ковид – 19 өвчний тархалтын улмаас хөл хорио тогтоосон, үйлчилгээний газруудын үйлчилгээг хязгаарласантай холбоотойгоор 2020 онд ном олгох болон бусад үйлчилгээний тоо буурчээ. Харин олгосон номын дотор цахимаар олгосон номын тоо 54.4 мянга болж, 2019 оныхоос 36.1 мянгаар, ном зүйн лавлагаа үйлчилгээ 37.4 мянга болж, 3.9 мянгаар нэмэгджээ.

Зураг 23: Номын сангийн тоо, үйлчилгээний үндсэн үзүүлэлтүүд, 2019, 2020 оны байдлаар



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик мэдээлэл

Номын сангийн үйлчлүүлэгчдийн тоо:

Номын сангийн үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 2020 онд 4.0 сая хүн болж, 2019 оныхоос 1.6 сая хүнээр нэмэгджээ. Үйлчлүүлэгчдийн төрлөөр нь авч үзвэл төлбөргүй болон цахимаар үйлчлүүлэгчдийн тоо 2020 онд 1.9 сая хүн болж, 1.0 сая хүнээр нэмэгдсэн нь нийт үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэхэд голлон нөлөөлжээ. Түүнчлэн хүүхэд болон тусгай бүлгийн үйлчлүүлэгчдийн тоо 2020 онд буурсан бол гадаад үйлчлүүлэгчдийн тоо 16.2 мянга болж, 12.2 мянган үйлчлүүлэгчээр нэмэгджээ.

Ковид – 19 өвчний тархалтын улмаас хөл хорио тогтоосон, үйлчилгээний газруудын үйлчилгээг хязгаарласантай

холбоотойгоор 2020 онд байнгын уншигч, шинэ уншигчдын болон ирэгсэд, түүний дотор уншлагын танхимаар үйлчлүүлэгчдийн тоо буурчээ. Мөн гэрээр болон зөөврийн номын сангаар үйлчлүүлэгчдийн тоо тус бүр 128.0 мянга болон 46.4 мянгаар буурчээ. Харин цахимаар үйлчлүүлэгчдийн тоо 1.8 сая болж, 2019 оныхоос 78.7 дахин, бусад үйлчилгээнд хамрагдагчдын тоо 1.2 сая болж, 3.2 дахин нэмэгджээ. Энэ нь номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, ном олгох болон уншлагын танхимын бусад шинэ төрлийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгааг харуулж байна.

Зураг 24: Номын сангаар үйлчлүүлэгчдийн тоо, 2019, 2020 оны байдлаар





Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик мэдээлэл

Номын сангийн сан хөмрөгийн үзүүлэлтүүд: Номын сангийн сан хөмрөгийн нийт тоо 2020 оны байдлаар 6.3 сая болж, 2019 оныхоос 71.0 мянган нэгжээр нэмэгджээ. Номын сангийн сан хөмрөгт 2020 онд 44.3 мянган нэгжийн баяжилт хийгдсэн бол 30.7 мянган нэгж сан хөмрөгөөс хасагджээ. Хэвлэмэл ном, түүний дотор брайл үсгийн ном, түүнчлэн хэвлэмэл бус ном, тогтмол хэвлэл цахим сан хөмрөгийн тоо бүгд 2019 онтой харьцуулахад нэмэгдсэн дүнтэй байна. Цахимаар уншсан номын тоо болон үйлчлүүлэгчдийн тоо эрчимтэй нэмэгдсэнтэй харьцуулахад цахим сан

хөмрөгийн тоо хэмжээ харьцангуй бага тоогоор нэмэгджээ. Нийт номын сангийн дүнгээр 2019 онд 3.1 мянган цахим ном шинээр нэмэгдсэн бол 2020 онд 1.9 мянган цахим ном шинээр нэмэгдсэн нь цахим номын баяжилт 1.2 мянгаар буурчээ.

Зураг 25: Номын сангийн сан хөмрөгийн үзүүлэлтүүд, 2019, 2020 оны байдлаар



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик мэдээлэл

Номын санд ажиллагчдын тоо: Номын санд ажиллагчдын тоо 2020 онд 509 болж, 2019 оныхоос 9 хүнээр нэмэгджээ. Номын санд ажиллагчдын 75% нь буюу

383 нь эмэгтэйчүүд байгаа бол нийт ажиллагчдын 61% нь буюу 308 ажилтан номын сангийн мэргэжилтэй ажилтан байжээ.

Зураг 26: Номын санд ажиллагчдын тоо, 2019, 2020 оны байдлаар



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик мэдээлэл

iv. Номын худалдаа

Номын дэлгүүр, худалдаа: Үндэсний статистикийн хорооны Бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ын тоо мэдээллээс харахад 2020 оны байдлаар Соёл, амралтын барааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа (ISIC код - 476)-ны 570 ААНБ байсны 349 буюу 61% нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Нийт ААНБ-ын 338 буюу 59% нь үйл ажиллагаа явуулж байна. Сүүлийн 6 жилийн хугацаанд буюу 2015-2020 онд

уг дэд салбарын бүртгэлтэй болон үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо жил дараалан өсжээ. ААНБ-ын тоо 2015 онтой харьцуулахад 264-өөр буюу 86%-аар нэмэгдсэн байна. Гэхдээ энэ тоонд номын жижиглэн худалдаанаас гадна дуу бичлэгийн бараа, тоглоом, спорт, амралт чөлөөт цагт зориулсан барааны төрөлжсөн жижиглэн худалдааны ААНБ-ууд мөн орсон гэдгийг харгалзан үзэх хэрэгтэй.

Хүснэгт 57: Соёл, амралтын барааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдааны ААНБ-ын тоо

Он	Бүртгэлтэй ААНБ-ын тоо - бүгд	Үүнээс: Улаанбаатар хотод	Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо - бүгд	Үүнээс: Улаанбаатар хотод
2015	306	189	176	90
2016	340	207	200	101
2017	362	216	220	109
2018	418	252	248	127
2019	500	301	303	157
2020	570	349	338	179

Эх үүсвэр: ҮСХ-ны Бизнес регистрийн сангийн мэдээлэл.

Татварын ерөнхий газрын мэдээллээр Ном, сонин болон бичиг хэрэгслийн барааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа (ISIC код - 4761)-ны чиглэлээр 2019 онд 238 ААНБ аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан гаргажээ. ААНБ-ууд 2019 онд 41.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 206.7 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлжээ.

Нийслэлийн статистикийн газрын захиргааны статистик мэдээллийн БР-3 маягтаар цуглуулж нэгтгэн гаргадаг “Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний цэгийн судалгаа”-ны мэдээллээс харахад 2020 онд нийслэл Улаанбаатар хотод нийт 24 номын дэлгүүр байсны 16 нь ААНБ-ын, 8 нь хувь хүний номын дэлгүүр байжээ. 2019 онтой харьцуулахад нийслэл дэх номын дэлгүүрийн тоо 11-ээр түүн дотроо, ААНБ-ын номын дэлгүүрийн тоо 14-өөр буурчээ. Нийслэл дэх номын дэлгүүрүүдийн дийлэнх нь Сүхбаатар, Баянгол, Баянзүрх дүүрэгт байрладаг.

График 57: Нийслэл Улаанбаатар хот дахь номын дэлгүүрийн тоо



Эх үүсвэр: Нийслэлийн статистикийн газрын “Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний цэгийн судалгаа”.

Нийслэлийн статистикийн газрын мэдээлэл болон номын томоохон худалдааны компаниудын танилцуулга мэдээллийг ашиглан тооцож үзэхэд улсын хэмжээнд 2020 оны байдлаар нийт 150 орчим номын дэлгүүр ажиллаж байжээ. Албан бус мэдээлэлд үндэслэн тооцож үзэхэд номын худалдаа, номын дэлгүүр 450 орчим хүн ажиллаж байна.

Номын худалдааны салбарт Аз хур, Мир ном зэрэг компаниуд тэргүүлэх байр суурийг эзэлж байна.

Цаашид салбарын аж ахуйн нэгжийн тоо, ажиллагчдын тоо зэрэг үзүүлэлтээс гадна эдгээр аж ахуйн эзэмшиж буй борлуулсан номын тоо, төрлөөр, номын дэлгүүр, худалдааны цэгийн тоо зэрэг үзүүлэлтийг тооцож гарган салбарын хөгжлийн түвшнийг хэмжиж байх шаардлагатай.

Цахим номын худалдаа: Цахим номын худалдааны чиглэлээр М Нэмэх ХХК **M Plus платформоор**, Аз хур **ХХК bookstore.mn сайт**, **azbooks** апп-аар дамжуулан уншигчдад цахим номын худалдааны үйлчилгээг үзүүлж байна.

Цахим номын худалдааны салбарт 20 хүн ажиллаж, жилийн борлуулалтын орлого нь 31.2 сая төгрөг байдаг ажээ.

Эдгээр цахим номын худалдааны компаниуд доор дурдсан үйлчилгээнээс гадна эрхлэн гаргагчдад өөрийн нийтлэгдсэн бүтээл, борлуулалтын тоо, олгогдсон болон олгогдоогүй орлого, хэрэглэгчдийн сэтгэгдлийг ил тод шууд харах боломжтой Хянах самбарыг ажиллуулдаг байна. Цахим номын санд бүтээлийг байршуулж худалдан борлуулах үндсэн гэрээний шимтгэл буюу борлуулагдсан ном бүрийн борлуулалтын орлогын 30%-ийг эрхлэн гаргагчид олгодог.

Зураг 27: Цахим номын худалдаа эрхлэгчид, тэдний санал болгож буй үйлчилгээ

Цахим номын худалдаа	Уншигчдад үзүүлэх үйлчилгээ	Эрхлэн гаргагчдад үзүүлэх үйлчилгээ
 M нэмэх ХХК	Цогц платформ: <ul style="list-style-type: none"> Цахим ном Аудио ном Подкаст 	<ul style="list-style-type: none"> Цахим номын санд бүтээл байршуулах Аудио ном байршуулах Идэвхжүүлэлт, маркетинг: <ul style="list-style-type: none"> Нүүр хэсэгт онцлуулах Хэрэглэгчдэд тусгайлан мэдэгдэл хүргүүлэх Редакторын сонголт – богино хэмжээний нийтлэл
 Аз хур ХХК	<ul style="list-style-type: none"> Цахим ном Аудио ном 	<ul style="list-style-type: none"> Цахим номын санд бүтээл байршуулах Аудио ном байршуулах

Эх үүсвэр: Тухайн компанийн цахим хуудсанд байршуулсан танилцуулга мэдээлэл.²⁰

Цахим номын худалдааны салбарын орлого Монгол Улсад жилдээ 50 орчим сая төгрөг байна. Дашрамд дурдахад цахим номын уншигчдын дэлхийн зах зээлийн хэмжээ 2020 онд ойролцоогоор 30.69 тэрбум ам.доллар байжээ. Зах зээлийн өсөлт жилд дунджаар 3.7% байж, 2026 онд 38.17 тэрбум ам.долларт хүрэх тооцоог судлаачид хийжээ. Дэлхийн зах зээл дээрх гол тоглогчид Bookeen, Kobo, Pocketbook International SA, Wexler flex, Onyx International Inc., Aluratec Inc. болон бусад компаниуд байна.²¹

M Plus-ийн хувьд 240 мянга орчим бүртгэлтэй хэрэглэгчдэд 800 гаруй нийтлэгчийн 4,000 гаруй оюуны бүтээлийг үйлчилгээгээрээ дамжуулан хүргэдэг. 30.0 мянган тогтмол хэрэглэгч өдөр бүр тус апп-ыг нээж ашигладаг, нэг мэдэгдэл илгээхэд 5.0 мянга гаруй хэрэглэгч тус бүтээлийг сонирхож үздэг гэсэн статистик мэдээлэл байна. Нийт хэрэглэгчдийн 20%-ийг 18 хүртэл насны, 70%-ийг 18-50 насны, 10%-ийг 50-аас дээш насны эзэлдэг.²²

M Plus апп бүтээлийг өөрсдийн цахим өргөтгөлд шилжүүлэн номын сандаа байршуулахдаа нэг удаагийн суурь хураамж авдаг ба энэ нь бүтээлийн хэмжээ, ажиллагаанаас шалтгаалан 50,000-200,000 төгрөг байдаг.²³

²⁰ <https://www.mplus.mn/book>, <https://www.bookstore.mn/index.php/home>

²¹ <https://www.globenewswire.com/en/news-release/2021/05/17/2230826/0/en/Global-E-Book-Reader-Market-Size-Share-Will-Reach-USD-38-17-Million-By-2026-Facts-Factors.html>


²² <https://www.mplus.mn/book>

²³ <https://www.mplus.mn/book>

v. Салбарын гадаад худалдааны үзүүлэлтүүд

Утга зохиол, ном хэвлэлийн салбарын бараа бүтээгдэхүүний экспорт, импортын хэмжээг сүүлийн арван жилийн байдлаар дараах графикт харуулж байна.

График 58: Утга зохиол, ном хэвлэлийн салбарын экспорт, импортын хэмжээ, 2010-2020 оны байдлаар, ам.доллар



Гадаад худалдаа, импортын тоо мэдээлэл

1.83%



Утга зохиол, ном хэвлэлийн салбарын нийт импортын дүнд эзлэх хувь, 2020 он

Утга зохиол, ном хэвлэлийн салбарын импортын хэмжээ 2010 онд 591,269 ам.доллар байжээ. Сүүлийн арван жилийн хугацаанд 2019 онд хамгийн өндөр буюу 3,038,487 ам.долларт хүрсэн байна. 2020 оны байдлаар 1,922,185 ам.доллар байх ба нийт соёлын салбарын импортын хэмжээний 1.83 хувийг эзэлж байна.

Зураг 28: Утга зохиол, ном хэвлэлийн салбарын гадаад худалдааны хэмжээ, сая ам.доллар

\$1.9 сая

УТГА ЗОХИОЛ, НОМ ХЭВЛЭЛИЙН САЛБАРЫН ИМПОРТЫН ХЭМЖЭЭ, 2020 оны байдлаар

\$0.019 сая

УТГА ЗОХИОЛ, НОМ ХЭВЛЭЛИЙН САЛБАРЫН ЭКСПОРТЫН ХЭМЖЭЭ, 2020 оны байдлаар

Гадаад худалдаа, экспортын тоо мэдээлэл

5.21%



Утга зохиол, ном хэвлэлийн салбарын нийт СБҮ-ийн экспортын дүнд эзлэх хувь, 2020 он

Утга зохиол, ном хэвлэлийн салбарын экспортын хэмжээ 2010 онд 27,493 ам.доллар байжээ. Сүүлийн арван жилийн хугацаанд тогтвортой байсан бөгөөд 2020

Эх үүсвэр: ГЕГ, "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"


онд 18,858 ам.доллар болж буурсан ба нийт СБҮ-ийн экспортын хэмжээний 5,21 хувийг эзэлж байна.

Гадаад худалдаа, бүтээгдэхүүний төрлөөр

Утга зохиол, ном хэвлэлийн салбарын импорт, экспортыг бүтээгдэхүүний төрлөөр дараах графикуудад харууллаа.


Тус салбарын гадаад худалдааны хэмжээг 2020 оны байдлаар бүтээгдэхүүний төрлөөр задлан харвал номын экспорт, импорт хамгийн өндөр хувиудыг эзэлж байна.

Зураг 29: Гадаад худалдаа, бүтээгдэхүүний төрлөөр, нийт дүнд эзлэх хувиар, 2020 оны байдлаар



□ Ном □ Сонин □ Хэвлэлийн бусад бүтээгдэхүүн

УТГА ЗОХИОЛ, НОМ ХЭВЛЭЛИЙН САЛБАРЫН ИМПОРТ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРЛӨӨР, 2020 оны байдлаар



□ Ном □ Сонин □ Хэвлэлийн бусад бүтээгдэхүүн


УТГА ЗОХИОЛ, НОМ ХЭВЛЭЛИЙН САЛБАРЫН ЭКСПОРТ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРЛӨӨР, 2020 оны байдлаар

Эх үүсвэр: ГЕГ, "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"

vi. Салбарын төгсөгчдийн тоо мэдээлэл

Утга зохиол, ном хэвлэлийн салбарын 2019-2020 оны хичээлийн жилд суралцаж төгссөн оюутны тоо мэдээлэл:

График 59: Утга зохиол, ном хэвлэлийн салбарын төгсөгчдийн нийт СБҮ-ийн төгсөгчдийн тоонд эзлэх хувь




15 их, дээд сургууль
19 ХӨТӨЛБӨР

Утга зохиол, ном хэвлэлийн салбарт 2019-2020 оны хичээлийн жилд 442 оюутан суралцаж төгссөн ба энэ нь нийт соёлын салбарын төгсөгчдийн 11 хувийг бүрдүүлж байна.

Боловсролын зэрэг



График 60: Утга зохиол, ном хэвлэлийн салбарын төгсөгчид, боловсролын зэрэг, хүйсээр, 2019-2020 оны хичээлийн жилд



Эх үүсвэр: БШУЯ, Төгсөгчдийн тоо мэдээлэл

ДҮРСЛЭХ УРЛАГ

Visual Arts



03

03 ДҮРСЛЭХ УРЛАГ

Visual Arts

Салбарт хамаарах чиглэлүүд:

- Уран зураг
- Гэрэл зураг
- Гар урлал

5.3. ДҮРСЛЭХ УРЛАГ

Салбарын талаарх ЮНЕСКО-ийн тодорхойлолт²⁴

Дүрслэх урлаг гэдэг нь уг чанараараа харах үзэх байдлаар бүтээгдсэн уран сайхны бүх хэлбэрийг хэлнэ. Тэдгээр нь харж хүртэхэд зориулагдсан бөгөөд янз бүрийн хэлбэртэй байж болно. Орчин үед дүрслэх урлагийн төрлүүдэд урлаг хоорондын хэлбэрүүд болох “Виртуал урлаг” гэгдэх хэлбэр багтдаг ч эдгээр нь Аудио, дүрс бичлэг болон интерактив мэдээллийн хэрэгсэл салбарт хамаарна.

Дүрслэх урлаг, гар урлалын салбар нь уран зураг, зураасан зураг, уран баримал зэрэг дүрслэх урлаг, гар урлал болон гэрэл зураг зэргийг багтаана. Энэ салбарт урлагийн бүтээлүүдийг дэлгэн үзүүлдэг байр болох арилжааны уран зургийн галерей багтана.

Соёлын статистикийн хүрээнд олон улсын худалдааны төв болон ЮНЕСКО-оос гар урлал эсвэл гараар урлах бүтээгдэхүүний тодорхойлолтыг “гараар буюу гар багажаар, эсвэл механик хэрэгслийн тусламжтай хийсэн гар урлалын зүйлс байх бөгөөд эцсийн бүтээгдэхүүний гол зонхилох хэсэг нь гар аргаар бүтээгдсэн байна” гэжээ. Гар урлалын бүтээгдэхүүн нь соёлтой холбоотой хэрэглээний, гоо зүйн, уран сайхны, бүтээлч зэрэг онцлох шинж чанартай, чимэглэлийн, ямар нэг үйл ажилд хэрэглэх зориулалттай, уламжлалт, шашны буюу нийгмийн бэлгэдлийн шинжтэй зэрэг байна. (ЮНЕСКО, 1997)

Гар урлалын бүтээлийг ЮНЕСКО (ИТС, 1997)-оос бүтээгдэхүүний материалыг үндэслэн 6 хэсэгт хуваасан байна. Үүнд:

1. Сагс /сүлжмэл, ургамлын мяндсан сав/,
2. Арьсан эд зүйлс,
3. Металл эдлэл,
4. Вааран эдлэл,
5. Хөвөн даавуун эд зүйлс,
6. Модон эд зүйлс оржээ.

²⁴ ЮНЕСКО, Соёлын Статистикийн хүрээ, 2009

“

Хүүхэд бүр
уран бүтээлч.
Асуудлын гол
нь том болсон
хойноо хэрхэн
уран бүтээлч
хэвээр үлдэх вэ
гэдэгт л байгаа
юм.

Пабло Пикассо

”

Түүнчлэн тухайн хэсэгт онцгой, ховор тодорхой бүс нутгаас олборлодог эсвэл боловсруулахад бэрх чулуу, шил, зааны яс, яс, хясаа, дун зэрэг гар урлалын эд зүйлсийг багтаасан нэмэлт ангиллуудыг оруулсан байна. Түүнчлэн нэмэлт ангилалд нэгэн зэрэг өөр өөр материал, технологи ашиглан хийдэг чимэглэл, үнэт эдлэл, хөгжмийн зэмсэг, тоглоом болон урлагийн бусад бүтээлүүдийг оруулсан байна. Уран сайхны олон бүтээл үйлдвэрлэлийн аргаар хийгддэг ч ССХ -нд уламжлалт шинж чанартай бүтээгдэхүүнийг (хээ, угалз, технологи, материал) ССХ -ний нэг хэсэг гэж үзнэ. Орчин үеийн уран сайхны урлалыг дүрслэх урлаг болон гар урлал гэсэн ангилалд бус Загвар, бүтээлч үйлчилгээ -ний салбарт оруулсан байна.

5.3.1. Дүрслэх урлагийн салбар

Түүхийн хувьд дүрслэх урлаг нь эртний урлагийн Ашель үеэс гаралтай. Үүнд, Берехат Рамын Сугар гаригийн базальт баримал (МЭӨ 230,000-700,000), Тан-Тан Сугар (МЭӨ 200,000-500,000)-ын кварцит баримал зэрэг протот баримлууд багтана. Түүнчлэн эртний соёл иргэншлүүд Чаувет агуй (МЭӨ 30,000 он), Ласкау, Алтамира, Печ-Мерле, Коскер зэрэг газруудад агуйн

зураг зурагдсан байдаг (Hidayat, 2020). Тэгэхээр, өнөөг хүртэл тасралтгүй хөгжин, олон төрөл болон хуваагдаж буй дүрслэх урлагийн салбар нь та бидний амьдралд нийгмийн болон эдийн засгийн ямар, ямар үр нөлөөг үзүүлэх вэ?

Нийгмийн үр нөлөө

Бидний амьдралд

Ихэнх хүмүүс урлагаар хичээллэж, урлагийн хүн болж амьдрах нь амьдралд ямар ч хэрэггүй. Цагийн гарз гэж үздэг. Гэтэл урлаг, ялангуяа дүрслэх урлаг, бидний амьдралд үнэхээр ямар ч эерэг нөлөө үзүүлдэггүй юу? Хэрвээ эерэг нөлөөлөл, үр өгөөж байдаг бол тэр нь яг ямар нөлөөллүүд вэ? (Swami, 2016)

Урлаг нь стрессийг тайлдаг.

Урлаг танд баяр баясгаланг өгдөг.

Урлаг нь таны бүтээлч чадварыг хөгжүүлдэг.

Урлаг нь танд авьяас чадвараа харуулах боломжийг олгодог.

Урлаг нь бусад хүмүүстэй харилцахад тусалдаг.

Уран зургийн галерей, музей

Одоогийн байдлаар дэлхийн 202 оронд 55000 гаруй музей байдаг. Урлагийн музей нь түүхийг хадгалан үлдээх, хүн төрөлхтний бүтээлч чадварыг харуулах, соёл, танин мэдэхүйн өвөрмөц ойлголтыг өгөх соёлын хамгийн чухал байгууллагуудын нэг боловч бүгд ижил түвшнийх биш байдаг билээ (Artspace Editors, 2019).

Урлагийн музей, галерей нь аялал жуулчлалын салшгүй нэг хэсэг бөгөөд Англи улсад 2019/20 онд судалгаанд оролцогчдын 51% нь сүүлийн 12 сарын хугацаанд музей эсвэл галерей үзсэн гэж мэдээлжээ. Энэ нь 2018/19-той ижил түвшинд байгаа бол 2005/06 онуудаас 9 хувиар өссөн үзүүлэлт юм (Museums - Taking Part Survey 2019/20, 2020).

2020 оны байдлаар дэлхийн хамгийн алдартай, хамгийн олон хүн зорьж очдог музейнүүд бол Musée du Louvre, Tate Modern, Vatican Museums, National Museum of China болон British Museum юм.

Musée du Louvre



National Museum of China



British Museum



2020 оны байдлаар “Musée du Louvre”-ыг 2,700,000 гаруй хүн үзсэн бөгөөд энэ нь 2019 онтой харьцуулахад 72 хувиар бага үзсэн байна. “National Museum of China”-г 2020 онд 1.600.000 гаруй хүн үзсэн ба энэ нь өмнөх 2019 онтой харьцуулахад 78 хувиар буурсан үзүүлэлт юм. Цар тахлын нөлөөгөөр эхний зуун урлагийн музейн үзэгчдийн тоо 2020 онд 77 хувиар буурчээ (List of most-visited art museums, 2020).

Эдийн засгийн үр нөлөө

Америк дахь урлаг, соёлын үйлдвэрлэлийн үнэ цэнэ 2019 онд 919.7 тэрбум доллар байсан нь дотоодын нийт бүтээгдэхүүний 4.3% -ийг эзэлж байна. Урлаг нь барилга, тээвэр, агуулах, аялал жуулчлал, уул уурхай, нийтийн аж ахуй, хөдөө аж ахуйн салбараас илүүтэйгээр үндэсний эдийн засагт илүү их хувь нэмэр оруулдаг.

1998-2019 оны хооронд урлаг, соёлын салбарын ДНБ-д оруулсан хувь нэмэр 76.9% -иар өссөн байна.

Америкт 2017 онд 5.2 сая урлаг, соёлын салбарын ажлын байр байсан нь АНУ-ын нийт ажлын байрны 3.3% -ийг эзэлж байна.

АНУ-д урлаг, соёлын ажил эрхлэлт 2019 онд 1.2% -иар өссөн байна (Facts & Figures on the Creative Economy, 2020).

Америкийн Музейн Холбоо (AAM) -ны мэдээлснээр АНУ-д музейнүүд 2019 онд эдийн засагт 50 тэрбум ам.доллар оруулж, ойролцоогоор 850 сая үзэгч цуглуулжээ (Museums in the U.S. - statistics & facts, 2021).

i. Монгол Улсын дүрслэх урлагийн салбарын давуу тал онцлог, боломж**Дүрслэх урлагийн салбарын мэргэжлийн холбоод**

Монголын урчуудын эвлэл

Монгол Улсад Монголын урчуудын эвлэл, Монголын Дүрслэх Урлагийн Нэгдсэн Холбоо болон Монголын Орчин Үеийн Урлагийг Дэмжих Холбоо гэх



мэт олон дүрслэх урлагийн нэгдсэн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна. Монголын урчуудын эвлэл нь анх 1942 онд “Зураг Урлалын Газар” нэрээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн Монголын дүрслэх урлагийн байгууллагуудын ууган байгууллагуудын нэг юм. Одоогоор 700 гаруй уран бүтээлчид бүртгэлтэй байдаг (Монголын урчуудын эвлэл, n.d.). Монголдоо хамгийн удаан хугацаанд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй холбоо юм.

- ✓ 1942 онд байгуулагдсан.
- ✓ 600 гаруй гишүүдтэй.
- ✓ Аймаг бүрд салбартай.
- ✓ Хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.
- ✓ Гишүүдийнхээ бүтээлийг үнэтөлбөргүй үзэсгэлэн гаргадаг.
- ✓ Уран бүтээлчдээ бага түрээсийн төлбөртэй урлангаар хангадаг.
- ✓ Өөрийн гэсэн үзэсгэлэнгийн танхимтай.

Монголын Орчин Үеийн Урлагийг Дэмжих Холбоо (МОУУДХ) нь орчин үеийн урлагийг дэмжих, хөгжүүлэх, олон улсад таниулах, нийгэм эдийн засаг дахь нөлөөллийг нь дээшлүүлэх зорилготой төрийн бус байгууллага юм. МОУУДХ нь 2015 онд Венецийн 56 дахь Олон Улсын Дүрслэх Урлагийн Биенналь, Ази Номхон Далайн 8 дахь Триеннальд монгол уран бүтээлчдийг анх удаа оролцуулснаар монголын дүрслэх урлагийг олон улсын

тавцанд таниулах түүхэн алхмыг хийсэн (МОУУДХ-ны танилцуулга, 2017).

Дүрслэх урлагийн салбар нь олон улсад Монгол Улсын нэр алдрыг гаргах өндөр потенциалтай салбар бөгөөд тус салбарт дараах боломжууд байна.

1. Олон улсын биенналь, триеннальд оролцож тэргүүлэх

Орчин үеийн contemporary art чиглэлд маш олон залуу уран бүтээлчид хүч сорьж Монголдоо төдийгүй дэлхийд өрсөлдөж олон улсад Монголын өвөрмөц хэв маяг, онцлогийг сурталчилж байна.

2. Монгол Улсад олон улсын дүрслэх урлагийн үзэсгэлэн тогтмол зохион байгуулах



Тогтмол зохион байгуулснаар гадаадын олон чадварлаг уран бүтээлчид хүрэлцэн ирж оролцохоос гадна аялал жуулчлал давхар хөгжиж бусад салбарт эдийн засгийн үр өгөөжийг авчирна. Мөн Монгол Улсад Contemporary art –ийг сонирхох, түүгээр хичээллэх, мөн энэхүү урлагийг ойлгох хүмүүсийн тоо өсөх болно. Олон улсын үзэсгэлэн зохион байгуулахад олон улсын стандартад нийцсэн галерей барих нэн шаардлагатай.

**ii. Монгол Улсын дүрслэх урлагийн салбарт тулгамдаж буй асуудал бэрхшээл**

Монгол Улсын дүрслэх урлагийн салбарт тулгамдсан асуудлуудыг хүний нөөц, эко орчин, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон маркетинг, борлуулалт гэсэн таван чиглэлийн хүрээнд тодрууллаа.

ХҮНИЙ НӨӨЦ

- Багшлах боловсон хүчний ур чадвар хангалтгүй байна.
- Уран бүтээлчдийн маркетинг, менежмент, хууль эрх зүйн мэдлэг дутмаг.
- Бэлтгэгдэн гарч буй оюутнууд чадвар муу.
- Гадаад хэлний мэдлэггүй.
- Уран бүтээлчдийн НДШ, тогтмол орлоготой холбоотой нийгмийн асуудалтай байдаг.

Дүрслэх урлагийн салбарын хувьд багшлах боловсон хүчний ур чадвар хангалтгүй байгаа ба үүний улмаас бэлтгэгдэн гарч буй оюутнууд ур чадвар муутай байдаг. Ур чадвар муутай уран бүтээлчдийн улмаас иргэд уран зургийн галерейн болон уран зургийн талаар боловсролгүй байна. Жишээлбэл, Материал судлалын үндсэн хичээл ордог. Монгол хэл дээр сурах бичиг байхгүй. Ихэвчлэн гадаад, Орос хэл дээр байдаг. Уран бүтээлчид гадаад хэлний мэдлэггүйгээс гадна тогтмол орлогогүйн улмаас НДШ төлдөггүй.

ЭКО СИСТЕМ

- Зохиогчийн эрх, оюуны өмчийг хамгаалах найдвартай тогтолцоо байхгүй
- Гаалийн хяналт шалгалт, татвар хураамж, төвөг чирэгдэл их байдаг.
- Мэргэжлийн холбоод болон төр хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо бага.

Дүрслэх урлагийн салбарт зохиогчийн эрх, оюуны өмчийг хамгаалах, найдвартай тогтолцоо байхгүй. Найдвартай тогтолцоо байдаггүй учраас өөрсдийн бүтээлийг хамгаалж чаддаггүй. Гаалийн хяналт шалгалт, татвар хураамж их байдаг тул төвөг чирэгдэл их байдаг. Мэргэжлийн холбоод болон төр хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо бага байдаг. Үүний улмаас дүрслэх урлагийг дэмжихүйц нэгдсэн бодлого байдаггүй.

Шигтгээ 17: Уран бүтээлчид хууль эрх зүйн үйлчилгээ авахад тулгардаг бэрхшээл

Уран бүтээлчдийн хуулийн мэдлэг маш бага, гэрээний драфт байхгүй...Оюуны өмчийн чиглэлээр хуульчтай ажиллахад багадаа 2 сая төгрөг гэх мэт зардалтай байдаг. Олон уран бүтээлчээрээ нэгдээд захиалга өгвөл үнэ нь багасах боломжтой.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас**ДЭД БҮТЭЦ**

- Дүрслэх урлагийн сургуулийн орчин нөхцөл маш тааруу.
- Уран бүтээл хийх орон зай, талбай, орчин хангалтгүй.
- Олон улсын стандартад нийцсэн галерей, үзэсгэлэнгийн талбай хангалтгүй.

Дүрслэх урлагийн сургуулийн орчин, нөхцөл маш муу байдаг. Стандарт нөхцөлд сурч боловсордоггүйн улмаас сайн уран бүтээлч, сайн бүтээл төрөхгүй байна. Уран бүтээл хийх орон зай, талбай орчин хангалтгүй байна. Уран бүтээлчид өөрсдийн хүссэн бүтээлээ, хүссэн хэмжээгээр нь бүтээхэд саад болж байна. Үзэсгэлэн, галерейд ч мөн адил олон улсын стандартад нийцсэн талбай хангалтгүй байдаг.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Дотоод болон гадаадын үзэсгэлэнд оролцоход “Спонсор” олоход хүндрэлтэй, уран бүтээлийн ном, каталогоо хэвлүүлэх хөрөнгө дутмаг.
- Олон улсын нэр хүндтэй уралдаан наадамд оролцох эрх авсан ч санхүүгийн хүндрэлээс болоод хамрагдаж чаддаггүй.
- Шагналын урамшуулал, мөнгөн үнэлгээ маш бага байдаг.
- Сайн бүтээлийг худалдан авах санхүүжилт байдаггүй. Сайн бүтээлээ гадаадад худалдан гаргадаг. Шилдэг бүтээлүүд Монголдоо үлдэхгүй байна.

Уран бүтээлийн каталог, ном хэвлүүлэхэд зардал их гардаг учраас дүрслэх урлагийн уран бүтээлчид болон музейн ажилтнууд хүссэн хэмжээгээр хэвлүүлэн гаргахад хүндрэлтэй байдаг. Хэрвээ каталог, номыг тогтмол хэвлэн иргэд болон жуулчдад худалдаж чадвал эдийн засаг болон музей, галерейн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлнэ. Уран бүтээлчдийн хувьд ОУ-ын уралдаан тэмцээнд санхүүжилтгүйн улмаас оролцож чаддаггүй. Ихэнх уран бүтээлчид бүх зардлаа өөрөөсөө гаргаад тэмцээнд оролцдог. Сайн уран бүтээлийг худалдан авах санхүүжилт байдаггүй учраас сайн бүтээлүүд гаднын улсуудад зарагддаг.

МАРКЕТИНГ, СУРТАЛЧИЛГАА

- Онлайн худалдааны систем сайн хөгжөөгүй.
- Уран бүтээлч нарт худалдан авагч олох, бүтээлээ олонд таниулах, сурталчлах, борлуулах чадвар дутмаг.
- Иргэдийн орлогын түвшин бага, урлагийн мэдлэг дутмаг тул худалдан авалт бага.
- Олон улсад бүтээлээ борлуулах механизмын талаар мэдлэг дутмаг.
- Хууль эрх зүйн мэдлэг дутмаг учраас бизнес эрхлэгч нартай хамтарч ажиллах гэрээ хэлцэл хийж чаддаггүй.

Шигтгээ 18: Хувийн компаниуд урлагийн салбарт хөрөнгө оруулалт хийхэд татвараас чөлөөлөх

Гаднын улсад үзэсгэлэн уран бүтээлийг дэмжсэн байгууллагуудыг татвараас чөлөөлөх, хөнгөлөх гэх мэт дэмжлэг үзүүлдэг. Ингэснээр ихэвчлэн банкнууд үзэсгэлэн гаргаж буй уран бүтээлчдийг ивээн тэтгэдэг, каталогийг нь гаргаж өгдөг.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас


Дүрслэх урлагийн салбарт онлайн худалдааны систем сайн хөгжөөгүйгээс гадна олон улсад бүтээлээ борлуулах механизмын талаар мэдлэг муутай. Уран бүтээлч нарт худалдан авагч олох, бүтээлээ олонд таниулах, сурталчлах, борлуулах чадвар дутмаг байдаг. Ихэнх уран бүтээлчид зөвхөн өөрсдийн уран бүтээлд л анхаардаг. Маркетинг, менежмент хийх чадвар байдаггүй. Нийт иргэдийн орлогын түвшин бага, урлагийн мэдлэг дутмаг тул худалдан авалт бага байдаг. Хууль эрх зүйн мэдлэг муу учраас бизнес эрхлэгч нартай хамтарч ажиллах гэрээ хэлцэл хийж чаддаггүй.

Шигтгээ 19: Маркетингийн мэргэжлийн агентлагаас багц үйлчилгээ авах хэрэгцээ

Бүтээлийн үзэсгэлэн хийхэд маркетинг хийх, үзэсгэлэнг нь зохион байгуулах, бүтээлийг нь байршуулах, каталогийг нь хийж өгөх, зургийг нь авч өгөх гэх мэт үйлчилгээ үзүүлдэг агентлаг байвал зүгээр. Багц үйлчилгээ үзүүлдэг газрууд байвал зүгээр байна.

iii. Процессын зураглал

Дүрслэх урлагийн салбарын үйл ажиллагааны процессын зураглал дараах үндсэн 4 үе шатнаас бүрдэж байна.



5.3.2. Дүрслэх урлагийн салбарын тоо мэдээлэл

Монгол Улсад дүрслэх урлагийн салбарт үйл ажиллагаа явуулдаг 10 орчим мэргэжлийн холбоо байдаг. Үүнээс хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн холбоодыг дурдвал “Монголын Урчуудын эвлэл”, “Монголын орчин үеийн урлагийг дэмжих холбоо”, Контемпорари урлагийн “Хөх нар төв”, “Монголын гэрэл зурагчийн нэгдсэн холбоо” зэрэг мэргэжлийн холбоод багтана. Эдгээр мэргэжлийн холбоодын бүртгэлтэй гишүүд 1000 орчим байдаг

байна. Улаанбаатар хотод дүрслэх урлагийн 20 орчим үзэсгэлэн галерей байх боловч сүүлийн нэгээс хоёр жилд үйл ажиллагаа явуулалгүй хаагдсан, эсвэл үйл ажиллагаа нь түр зогссон галерей олон байна. Хэвийн үйл ажиллагаатай үед үзэсгэлэн галерейд 10-50 үзэсгэлэн гардаг байна. Дунджаар 30 орчим үзэсгэлэн гардаг байна. Сүүлийн жилүүдэд танилцуулагдаж буй үзэсгэлэнгийн хувьд орчин үеийн (контемпорари) уран бүтээлийн төрөл давамгайлж байгаа тухай үзэсгэлэн галерейн үйл ажиллагаа эрхлэгчид дурдаж байв.

г. Салбарын ААНБ -ын мэдээлэл


Дүрслэх урлагийн салбарын ААНБ -ын тоо, 2020 оны байдлаар:



2020 оны байдлаар дүрслэх урлагийн салбарт 1,239 ААНБ бүртгэлтэй байгаагаас 546 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа явуулж буй байгууллагын 91 хувь нь СБУ-ийн, 9 хувь нь ТТДМ-ын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд байна.

График 61: Үйл ажиллагаа явуулж буй байгууллагын СБУ -д хамаарах хэлбэр



Эх үүсвэр: ҮСХ

10 20

МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО (МХ) ҮЗЭСГЭЛЭН, ГАЛЕРЕЙ

Жилд дунджаар

30

ҮЗЭСГЭЛЭН ТАНИЛЦУУЛДАГ

Өдөрт дунджаар

20-40

ҮЗЭГЧИД, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ЗОЧИЛДОГ

2К

МХ -НЫ ГИШҮҮН УРАН БҮТЭЭЛЧИД

Нэг үзэсгэлэнд дунджаар

20-50*

УРАН БҮТЭЭЛ ТАНИЛЦУУЛДАГ

*Уран бүтээлийн онцлогоос хамаарах ба 5, эсвэл 200 -н бүтээл гарах тохиолдол ч байдаг.

Эх үүсвэр: Дүрслэх урлагийн салбарт үйл ажиллагаа явуулж буй уран бүтээлч, мэргэжилтний ярилцлага, асуулга судалгаа


Хүснэгт 58: Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагын салбарын ангилал

	СБУ	ТТДМ	Нийт
3. Дүрслэх урлаг	495	51	546
Бүтээл туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа	129		129
Гоёл чимэглэл болон холбогдох эдлэл үйлдвэрлэл	36		36
Гэрэл зургийн үйл ажиллагаа	113		113
Нийгмийн ухаан, хүмүүнлэгийн судалгаа, шинжилгээ, туршилтын ажил	112		112
Ном, сонин, сэтгүүл болон хэвлэлийн зүйлсээс бусад эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа	105		105
Химийн бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл		51	51

Эх үүсвэр: ҮСХ

Соёлын үйлчилгээний буюу үзвэр үйлчилгээний болон телевизийн хураамж сүүлийн таван жилийн хугацаанд харьцангуй тогтвортой байсан бол бичгийн болон зургийн хэрэгслийн үнэ харьцангуй өндөр өсөлттэй байжээ.

График 62: Соёлын үйлчилгээ, бичгийн болон зургийн хэрэгслийн үнийн өөрчлөлт, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Эх үүсвэр: ҮСХ

ii. Салбарын ажиллагчдын тоо мэдээлэл
Нас, хүйсийн мэдээлэл

Дүрслэх урлагийн салбарт 2020 оны байдлаар нийт 12,538 ажиллагчид бүртгэлтэй байна. Үүний 78 хувийг эрэгтэй, 22 хувийг эмэгтэй ажиллагчид эзэлж байна.

НИЙТ АЖИЛЛАГЧДЫН ТОО

12,538





График 63: Салбарын ажиллагчдын дундаж нас, 2020 оны байдлаар



Эх үүсвэр: УСХ

Дүрслэх урлагийн салбарын ажиллагчдын тоо мэдээллийг ажиллагчдын албан тушаалаар задлан дараах хүснэгтэд харууллаа. Үүнээс "Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн ажиллагч" 50 гаруй хувийг эзэлж байна.

Хүснэгт 59: Ажиллагчдын ангилал


	Хувь
Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн ажиллагч	62%
Цалин хөлстэй түр ажиллагч	13%
Цалин хөлстэй байнгын ажиллагч	14%
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	9%
Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил	2%

Эх үүсвэр: УСХ

iii. Салбарын гадаад худалдааны үзүүлэлтүүд

Дүрслэх урлагийн салбарын бараа бүтээгдэхүүний экспорт, импортын хэмжээг сүүлийн арван жилийн байдлаар дараах графикт харуулж байна. Экспортын хэмжээ 2016 онд импортын хэмжээнээс давж байв. Бусад хугацаанд импортын хэмжээ илүү өндөр байжээ.

График 64: Дүрслэх урлаг болон гар урлалын салбарын экспорт, импортын хэмжээ, 2010-2020 оны байдлаар



Эх үүсвэр: ГЕГ, Гадаад худалдааны мэдээлэл

Гадаад худалдаа, импортын тоо мэдээлэл



Дүрслэх урлагийн салбарын нийт импортын дүнд эзлэх хувь, 2020 он

Дүрслэх урлагийн салбарын импортын хэмжээ 2010 онд 637,895 ам.доллар байжээ. Сүүлийн арван жилийн хугацаанд 2014 онд хамгийн өндөр буюу 7,589,716 ам.долларт хүрсэн байна. 2020 оны байдлаар 3,220,330 ам.доллар байх ба нийт соёлын салбарын импортын хэмжээний 3,07 хувийг эзэлж байна.

Зураг 30: Дүрслэх урлагийн салбарын гадаад худалдааны хэмжээ, сая ам.доллар

\$3.2 сая

ДҮРСЛЭХ УРЛАГИЙН САЛБАРЫН ИМПОРТЫН ХЭМЖЭЭ, 2020 оны байдлаар

\$0.03 сая

ДҮРСЛЭХ УРЛАГИЙН САЛБАРЫН ЭКСПОРТЫН ХЭМЖЭЭ, 2020 оны байдлаар

Эх үүсвэр: ГЕГ, Гадаад худалдааны мэдээлэл

Гадаад худалдаа, экспортын тоо мэдээлэл



Дүрслэх урлагийн салбарын нийт экспортын дүнд эзлэх хувь, 2020 он

Дүрслэх урлагийн салбарын экспортын хэмжээ 2010 онд 53,404 ам.доллар байжээ. Сүүлийн арван жилийн хугацаанд 2016 онд хамгийн өндөр буюу 2,234,483 ам.долларт хүрсэн байна. 2020 оны


байдлаар 31,772 ам.доллар байх ба нийт соёлын салбарын экспортын хэмжээний 8.77 хувийг эзэлж байна.

Гадаад худалдаа, бүтээгдэхүүний төрлөөр

Дүрслэх урлагийн салбарын импорт, экспортыг бүтээгдэхүүний төрлөөр дараах графикуудад харууллаа.


Дүрслэх урлагийн салбарын импортын хэмжээг 2020 оны байдлаар бүтээгдэхүүний төрлөөр задлан харвал гэрэл зураг, үнэт эдлэл хамгийн өндөр хувиудыг эзэлж байна. Харин экспортын хувьд үнэт эдлэл 80 гаруй хувийг эзэлж байна.

Зураг 31: Гадаад худалдаа, бүтээгдэхүүний төрлөөр, нийт дүнд эзлэх хувиар, 2020 оны байдлаар



Гэрэл зураг, Үнэт эдлэл, Визуал урлаг, Гар урлал, Зураг

ДҮРСЛЭХ УРЛАГИЙН САЛБАРЫН ИМПОРТ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРЛӨӨР, 2020 оны байдлаар



Гэрэл зураг, Үнэт эдлэл, Визуал урлаг, Гар урлал, Зураг

ДҮРСЛЭХ УРЛАГИЙН САЛБАРЫН ЭКСПОРТ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРЛӨӨР, 2020 оны байдлаар

Эх үүсвэр: ГЕГ, Гадаад худалдааны мэдээлэл




СОЁЛЫН ЯАМ

iv. Салбарын төгсөгчдийн тоо мэдээлэл

Дүрслэх урлагийн салбарын 2019-2020 оны хичээлийн жилд суралцаж төгссөн оюутны тоо мэдээлэл:

График 66: Дүрслэх урлагийн салбарын төгсөгчдийн нийт СБҮ-ийн төгсөгчдийн тоонд эзлэх хувь



4 их, дээд сургууль


17 ХӨТӨЛБӨР

Дүрслэх урлагийн салбарт 2019-2020 оны хичээлийн жилд 78 оюутан суралцаж төгссөн ба энэ нь нийт СБҮ-ийн төгсөгчдийн 3 хувийг бүрдүүлж байна.

Боловсролын зэрэг



График 65: Дүрслэх урлагийн салбарын төгсөгчид, боловсролын зэрэг, хүйсээр, 2019-2020 оны хичээлийн жилд



Эх үүсвэр: БШУЯ, Их, дээд сургууль, коллежийн төгсөгчдийн тайлан

ДУУ ХӨГЖИМ

Music



04

04 ДУУ ХӨГЖИМ

Music

5.4. ДУУ ХӨГЖИМ

Салбарын талаарх ЮНЕСКО-ийн тодорхойлолт²⁵

ЮНЕСКО-ийн ССХ-д дуу, хөгжмийн салбар нь Урлагийн тоглолт ба баяр наадам гэсэн бүлэгт багтана. Хөгжим нь хэлбэрээс үл хамааран хөгжмийн салбарт бүхлээрээ тодорхойлогдоно. Үүнд, амьд хөгжим, хөгжмийн тоглолтын бичлэг, хөгжмийн зохиол, хөгжмийн бичлэг, дижитал хөгжим (үүнд, хөгжмийн татан авалт болон байршуулалт багтана), хөгжмийн зэмсгүүд хамаарна.

Дуу, хөгжмийн салбарт хамаарах ажил мэргэжлүүд:

- ▶ Хөгжимчид
- ▶ Дуучид
- ▶ Хөгжмийн зохиолчид
- ▶ Хөгжмийн зэмсэг үйлдвэрлэгчид
- ▶ Хөгжим хөглөгчид

5.4.1. Дуу хөгжмийн салбар

АНУ-д жилд нийтдээ 32 сая хүн, хамгийн багадаа нэг удаа, хөгжмийн тоглолт болон фестиваль үзсэн байдаг байна. 2018 онд АНУ-ын дуу хөгжмийн салбар ДНБ-д 170 тэрбум долларыг төвлөрүүлсэн бөгөөд тухайн салбартай холбоотой 2.5 сая орчим ажлын байрыг дэмжин ажилладаг байна (New Report: How Music Powers the American Economy, 2021).

Бид яагаад дуу хөгжмийн салбарыг дэмжин ажиллах шаардлагатай вэ? Энэ нь бидний нийгэмд ямар эерэг нөлөөллийг бий болгох вэ? Дуу хөгжмийн салбарт хөрөнгө оруулалт хийснээр цаашлаад ямар, ямар үр нөлөө, боломж үүсэх талаар авч үзлээ.

²⁵ ЮНЕСКО, Соёлын Статистикийн хүрээ, 2009

“

Хөгжим гэдэг
авьяасаар
төдийгүй
ухаанаар бүтдэг
бүтээл

Ардын жүжигчин,
төрийн хошой соёрхолт,
хөгжмийн зохиолч
Н.Жанцанноров

”

Хөгжмийн фестивалиуд

Жил бүр сая сая үзэгчидтэй хөгжмийн фестивалиуд дэлхийн өнцөг булан бүрт болж байна. Монгол Улсын хувьд хөгжмийн хамгийн том фестивали нь “Playtime” юм. Харин олон улсын хувьд хэд хэдэн тэргүүлэгч фестивалиуд байна. Үүнд:

- Donauinselfest
- Coachella
- Tomorrowland
- Glastonbury
- Maya music festival
- Sunburn music festival

Олон улсыг хамарсан хөгжмийн наадамтай болж чадваас уран

Нийгмийн үр нөлөө

Эрүүл мэнд

Дуу хөгжим нь хүмүүсийн урлагийн мэдрэмжийг хөгжүүлэхээс гадна эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлдэг.

Хүн өөрт таалагдсан хөгжмийг сонсоход тархинаас “Дофамин” хэмээх аз жаргалын гормон ялгардаг. Хөгжим биднийг аз жаргалтай, гунигтай, ууртай нэгэн болгож чаддаг. Зарим хүмүүс хөгжмийг хөдөлгөгч хүч гэж үзэх нь ч бий (Pfizer Medical Team, 2017). Тэгэхээр хөгжим нь бидний эрүүл мэндэд яагаад хэрэгтэй вэ?

Стрессийг багасгадаг.

Ой санамжийг сайжруулдаг.

Өвчин намдаагч.

Хөдөлгөөнтэй байдлыг нэмэгдүүлдэг

Мэдрэхүйг сайжруулдаг.

Дутуу төрсөн хүүхдийг тайвшруулдаг.

бүтээлчдийг идэвхжүүлэх, олон орны уран бүтээлчдээс суралцах, цаашлаад эдийн засагт сайн үр нөлөө үзүүлнэ.

Coachella Valley Music and Arts Festival—

Coachella Valley Music and Arts Festival нь жил бүр Колорадо цөлийн Коачелла хөндийд зохион байгуулагддаг хөгжим, урлагийн наадам юм. 1999 оноос хойш тасралтгүй зохион байгуулагдаж байгаа. Coachella бол АНУ болон дэлхийн хамгийн том, хамгийн алдартай, хамгийн ашигтай хөгжмийн наадам юм. Coachella бүр 2013-2015 оны хооронд нийт ирц, нийт орлогын шинэ дээд амжилтыг тогтоосон юм. 2016 оны наадам 198,000 тасалбар зарж, 94.2 сая долларын ашиг олжээ.

Энэхүү арга хэмжээ нь рок, инди, хип хоп, электрон бүжгийн хөгжим зэрэг хөгжмийн олон төрлөөс бүрддэг. Дан ганц хөгжмийн уран бүтээлчид оролцохоос гадна уран баримал, өрөг урлаг зэрэг урлагийн бүтээлүүд танилцуулагддаг.

Sunburn festival

Азийн хамгийн том хөгжмийн фестивалиудын нэг бөгөөд 2007 оноос хойш тасралтгүй зохион байгуулагдаж байгаа. Жилийн хамгийн сүүлийн долоо хоногт гурван өдрийн турш үргэлжилдэг. Азийн хамгийн том электрон хөгжмийн наадам бөгөөд дэлхийн хамгийн том 3 дахь бүжгийн наадам юм.

Эдийн засгийн үр нөлөө

Олон улсын уран бүтээлчид дан ганц тоглолт хийж, зар сурталчилгаанд тоглож мөнгө олдог байсан бол одоо тэр цаг нэгэнт өнгөрчээ. Тэд оюуны өмчөө бусдад ашиглуулах зөвшөөрөл өгч, өөрсдийн нэрийн бараа бүтээгдэхүүнийг худалдаж, цахим платформд дуугаа худалдаж мөнгө олох болсон.

Цахим платформууд

Spotify:



- Дэлхийн хамгийн том хөгжмийн стриминг үйлчилгээ
- 2006 онд Швед улсад анх ашиглагдаж эхэлсэн.
- 2020 оны байдлаар 79 оронд ашиглах боломжтой.
- 2021 оны 3-р сарын байдлаар сар бүр 356 сая гаруй идэвхтэй хэрэглэгчид, түүний дотор 158 сая төлбөртэй захиалагч хэрэглэгчид байна.

Тухайн уран бүтээл 1000 удаа тоглогдох/стриминг хийх/ тутамд 3-5 долларыг уран бүтээлчдэд төлдөг.

Хамгийн олон удаа тоглогдсон уран бүтээл:

Ed Sheeran "Shape of you".
1.318 тэрбум удаа тоглогдсон.

Хэрвээ манай улсад стриминг үйлчилгээ стандартын дагуу нэвтэрвэл уран бүтээлчид тогтмол орлоготой болохоос гадна уран бүтээлийн чанар сайжирна.



iTunes



SoundCloud



iHeartRadio



Pandora

Эдийн засаг дахь бодит үр өгөөж


Бүгд Найрамдах Солонгос улс

Солонгосын Олон улсын соёлын солилцооны сангийн мэдээлснээр К-Поп, телевизийн жүжиг, тоглоомын "Солонгос давлагаа" нь Солонгосын эдийн засагт 2018 онд 9.5 тэрбум ам.доллар оруулсан. Энэ нь цаашид ч өсөх хандлагатай байгаа. 2019 онд Өмнөд Солонгосын хөгжмийн салбар 6.1 их наяд орчим воны борлуулалтын орлого олжээ (South Korea's music industry - Statistics & Facts, 2021).

Солонгос улсын засгийн газар 1990 оноос эхлэн соёл урлагтаа онцгой анхаарал хандуулан хөрөнгө оруулж эхэлснээр К-Поп урсгал хурдтай хөгжих үндэс суурийг тавьсан.

Солонгост уран бүтээлчид бэлддэг энтертайментууд маш олон байдаг бөгөөд түүнийгээ дагаад өрсөлдөөн их, өрсөлдөөн их учраас уран бүтээл нь чанартай, сайн байж чаддаг.

Сүүлийн жилүүдэд К-поп урсгал дан ганц Азид бус дэлхий дахинд танигдах болсон. Үүний нэгэн тод жишээ бол "BTS" хамтлаг юм.



Солонгосын хамгийн том 4 энтертаймент
Эх үүсвэр: Statista (2018 оны байдлаар)

Америкийн нэгдсэн улс

2018 онд АНУ-ын эдийн засагт хөгжмийн салбар нь 170 тэрбум долларыг төвлөрүүлсэн бөгөөд энэ нь өмнөх 2015 онтой харьцуулахад 14.8 хувиар өссөн байна.

Мөн шууд болон шууд бус байдлаар 2.47 сая ажлын байрыг дэмждэг байна. АНУ-ын хөгжмийн салбарын экспорт 2019 онд 9.08 тэрбум доллартой тэнцсэн. Дуу хөгжмийн салбарт зарцуулсан 1 доллар бүр зах зээлд 50 центээр нэмэгдэж байна. Орлогын үржүүлэгч нь 1.5 (New Report: How Music Powers the American Economy, 2021)

i. Монгол Улсын дуу хөгжмийн салбарын хөгжлийн түвшин, давуу тал онцлог, боломж

Хамтын удирдлагын байгууллага

Монгол Улсад Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэгчдийн нийгэмлэг (MOSCAP) болон Монголын дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төв гэсэн үндсэн хоёр хамтын удирдлагын байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Гол зорилго нь уран бүтээлчид болох дуу зохиогчид болон дуучдын оюуны онцгой эрхийг хамгаалахад оршино. Гэвч эдгээр байгууллагуудын хамтын ажиллагаагаа тодорхойгүй, олон улсын стандартад нийцээгүйгээс гадна ил тод бусаар үйл ажиллагаа явуулдаг учир дутагдалтай байсаар байна.



Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэгчдийн нийгэмлэг (MOSCAP)

- Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэгчдийн нийгэмлэг (MOSCAP) нь хөгжмийн бүтээлийн зохиогчийн онцгой эрхийг хамгаалах зорилготой хамтын удирдлагын байгууллага.
- 2011 онд байгуулагдсан, CIS-AC-ийн түр ажиглагч (Provisional) гишүүнээр 2013 онд элссэн.
- 300 гаруй хөгжмийн зохиолч, яруу найрагч, нийтлэгч гишүүнтэй
- 2016 оны байдлаар 10,000 гаруй үндэсний бүтээл бүртгэлтэй

Монголын дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төв (MCPD)

- Дуу бичлэг үйлдвэрлэгчид, фонограммын эрх эзэмшигчид болон дуучид, уран бүтээлчдийн санаачилгаар 2003 онд байгуулагдсан, гишүүддээ үйлчилдэг хамтын удирдлагын ТББ.

ii. Монгол Улсын дуу хөгжмийн салбарт тулгамдаж буй асуудал бэрхшээл

Монгол Улсын дуу хөгжмийн салбарт тулгамдсан асуудлуудыг хүний нөөц, эко орчин, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон маркетинг, борлуулалт гэсэн таван чиглэлийн хүрээнд тодрууллаа.

ХҮНИЙ НӨӨЦ

- Оюуны өмч, уран бүтээлийг үнэлж, төлбөр төлөх зохицуулалт сул - залуус шантарч байна.
- Уран бүтээлчдийн оюуны өмч, зохиогчийн эрхийн талаарх мэдлэг дутмаг.
- Урлагийн байгууллагын ажиллагчдын цалин, нийгмийн асуудал, ур чадвар.
- Сургалтын хөтөлбөр хуучирсан.
- Music Records & Label чиглэлийн мэргэжилтэн, мэдлэг ур чадвар дутагддаг.

Манай улсад уран бүтээлчид оюуны өмчөө хууль эрх зүйн орчинд хангалттай сайн хамгаалуулж чадахгүй байна. Уран бүтээлээ бусдад хулгайлуулж, зөвшөөрөлгүйгээр өөрийн ч мэдэлгүй ашиглуулж байгаа уран бүтээлчид цаашдаа шинэ зүйлс хийх хүсэл эрмэлзэлгүй болж байна. Хэрвээ уран бүтээлчдийн оюуны өмчийг хамгаалж, тэдэнд чанартай сайн уран бүтээл хийх боломжоор нь хангаад өгөх юм бол энэ нь цаашлаад Монгол Улсын эдийн засагт ч сайнаар нөлөөлнө.

Өөр нэгэн чухал асуудлуудын нэг бол урлагийн салбарын боловсон хүчнийг бэлддэг сургуулиуд болон урлагийн чиглэлийн байгууллагуудын чанарыг сайжруулах явдал юм. Монгол Улсын консерваториас эхлүүлээд стандартад нийцсэн анги танхимыг бий болгож, чадварлаг багш нарыг олноор нь бэлдэж, дэлхийд өрсөлдөхүйц уран бүтээлчдийг бэлдэн гаргадаг сургуулийг бий болгох шаардлагатай байна.

Мэргэжлийн сургуулиудыг төгссөн чадварлаг хөгжимчид сайн ажлын байраар хангагдаж чадахгүй байна. Тийм ч учраас хангалттай хэмжээний тогтмол орлогогүй. Энэхүү шалтгааны улмаас маш олноороо урлагийн салбараас гарч, өөр төрлийн ажил хөдөлмөр эрхэлж байна.

Авьяаслаг уран бүтээлчид олон байгаа хэдий ч санхүүгийн бэрхшээлийн улмаас бусдад уран бүтээлээ хангалттай сайн хүргэж чадахгүй байна. Учир нь уран бүтээлээс орж ирэх орлого байдаггүй. Ганц нэг уран бүтээл хийгээд л залуучууд шантрах болсон.

Шигтгээ 20: Залуу уран бүтээлчдийг дэмжих

Манайд бол урлагаар явдаг маш олон авьяаслаг залуучууд байна. Яг дэмжээд явмаар байна. Тэгэхгүй бол өчнөөн залуучууд гадууражилгүй, төгөлдөр хууравч ч чадахгүй, хөгжимгүй учраас бүтээл хийж чадахгүй байгаа залуучууд зөндөө байгаа шүү дээ. Гол асуудал нь санхүүгийн асуудал байна.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

Music Records & Label чиглэлийн мэргэжилтэн, мэдлэг ур чадвар дутагддаг. Тиймээс энэ чиглэлээрээ залуусыг бэлдэх нь зүйтэй.

ЭКО СИСТЕМ

- Хамтын удирдлагын байгууллагуудын үйл ажиллагаа тодорхойгүй.
- Уран бүтээлчид өөрсдийн бүтээлээс дэлхийн жишгийн дагуу ашиг орлого олж чаддаггүй.
- Оюуны өмч, зохиогчийн эрхийн зохицуулалт байхгүй.

Монгол Улсад дуу зохиогчид болон дуучдын оюуны өмчийг хамгаалдаг, нэгдсэн зохион байгуулалттай газар байхгүй. MOSCAP болон MMCP нь энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ч дотоод үйл ажиллагаа ил тод бишээс гадна уран бүтээлчдийн оюуны өмчийг олон улсын стандартын дагуу хамгаалж чаддаггүй. Оюуны өмчийн тухай хууль

нь хэрэгжилт муутайн улмаас караоке, утасны рингтон үйлчилгээнүүд үргэлж оюуныг өмчийг зөрчдөг.

Хөгжмийн салбарын уран бүтээлчид маш цөөхөн эх үүсвэрээс уран бүтээлийн орлого олж байна. Ихэнх уран бүтээлчид бартерын маягаар хөрөнгө оруулалт босгож, дараа дараагийнхаа уран бүтээлийн санхүүг бүрдүүлдэг. Гэтэл олон улсад дуу хөгжмийн платформуудад дууныхаа тоглогдсон болон худалдагдсан тоогоор уран бүтээлчид нь цалинжиж байна. Жишээлбэл, дэлхий даяар 47.7 сая хэрэглэгчидтэй Спотифа (Spotify) платформд л гэхэд нэг дуу 1000 удаа тоглогдох тутам 3-5 ам.долларыг уран бүтээлчдэд төлдөг байна.

Шигтгээ 21: Оюуны өмчийн хуулийг анхааралдаа авч сайжруулах

Соёлын яам идэвхтэй ажиллаж байгаа тул "Оюуны өмч"-ийн хуулиа л хамгийн түрүүнд маш ойлгомжтой бөгөөд цэгцтэй болгох хэрэгтэй. Хэн дуртай нь дуучдын өмчийг ямарваа нэгэн аппликэйшн дээр дураараа тавимааргүй байна. Үүнийг болиулж цэгцлэх ёстой. Мөн орлогын тайланг шилэн болгох хэрэгтэй.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

ДЭД БҮТЭЦ

- 30 мянгаас дээш тооны үзэгчдийг багтаах тоглолтын заал, стандартад нийцсэн тоног төхөөрөмжгүй.
- Уран бүтээлчдийн уран бүтээлийн нэгдсэн сангуй, түгээлтийн сувгуудын зохицуулалт муу.
- ОУ-ын жишигт нийцсэн дуу бичлэгийн студи ховор.

Монгол Улсад ОУ-ын жишигт нийцсэн дуу бичлэгийн студи байхгүй ба мэргэжлийн Music Records & Label-ийн үйлчилгээ нэвтрээгүй байна. Мөн 30 мянгаас дээш тооны үзэгчдийг багтаах тоглолтын заал, стандартад нийцсэн тоног төхөөрөмжгүйн улмаас эх орондоо гадаадын уран бүтээлчдийг урьж, тоглуулахад хүндрэлтэй байдаг. Уран бүтээлчдийн уран бүтээлийн нэгдсэн сангуйгээс гадна түгээлтийн сувгуудын зохицуулалт одоог хүртэл байхгүй байна.

Шигтгээ 22: Монгол улсын дуу бичлэгийн хөгжил

"Хурд" хамтлагийн уран бүтээлийн 33.3% нь аналог буюу соронзон бичлэгээр, 64.7% нь тоон бичлэгээр бичигдсэн ба тэдгээрийн ихэнх нь гадаадад бичүүлж байсан нь Монголд олон замын дуу бичлэгийн хөгжил хожуу дэлгэрснийг харуулж байна.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Records-ийн тоног төхөөрөмжийн үнэ, гаалийн татвар өндөр.
- Төслийн санхүүжилт, зээлд урлагийн салбарыг хамруулдаггүй.
- Татвар, НДШ-д хамрагддаггүйгээс зээл, санхүүгийн дэмжлэг авах боломжгүй.
- Компаниудын ивээн тэтгэх хандлага буурсан.

Records-ийн тоног төхөөрөмжийн үнэ, гаалийн татвар өндөр байдаг учраас мэргэжлийн тоног төхөөрөмжүүд дутмаг байдаг. Шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг авах зорилгоор банкнуудаар зээл хөөцөлдөхөөр зээл өгдөггүй.

Тоног төхөөрөмжүүд дэлхийн жишигт нийцдэггүй учраас гадаадын алдартай уран бүтээлчдийг Монголд авчрахад хүндрэл үүсдэг. Энэ нь цаашлаад урлагийн салбар дахь ОУ-ын хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Шигтгээ 23: Тоглолтын тоног төхөөрөмж ОУ-ын шаардлага хангахгүй

Beyonce, Coldplay, Weekend гэх мэт дэлхийн томоохон одуудыг Монголд авчирч Плэйтийм фестивалд тоглуулъя гэсэн ч тэдний шаардлагыг хангах 100,000 хүнд дуу хөгжмийг хүргэх хүчин чадалтай, олон улсын томоохон хөгжмийн наадмын "Чанга яригч" цогц тоног төхөөрөмж (Sound System Speakers) Монголд байхгүй учраас Монголд ирдэггүй. ... "Чанга яригч" цогц тоног төхөөрөмж 600.000-800.000 ам.долларын үнэтэй...

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

Үүнээс гадна уран бүтээлчдийг ивээн тэтгэх хандлага буурсан. Компаниуд "Маркетингийн хэлтэс"-тэй болсон ба маркетингийн үйл ажиллагаа нь илүү өргөжиж, өөр түвшинд ажиллах болсон. Үүний үр дүнд олны танил хүмүүсээр сурталчилгаа хийлгэж, тэднийг ивээн тэтгэх нь багассан. Мөн уран бүтээлчид татвар, НДШ-д хамрагддаггүйгээс зээл, санхүүгийн дэмжлэг авах боломжгүй байдаг.

МАРКЕТИНГ, СУРТАЛЧИЛГАА

- Зөвхөн дотооддоо маркетинг хийгддэг учир олон улсад танигдаагүй.
- Хөрөнгө оруулалт бага байдаг учраас ОУ-д урлагаа сурталчилж чаддаггүй.

Зөвхөн дотооддоо маркетинг хийгддэг. Олон улсад танигдаагүй. Олон улсад танигдахад төрөөс хөрөнгө оруулалтыг ихээр оруулах шаардлагатай.

iii. Процессын зурлал



5.4.2. Дуу хөгжмийн салбарын статистик мэдээлэл

Дуу хөгжмийн салбарт 2 хамтын удирдлагын байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Хөгжмийн урлагт 1000 гаруй уран бүтээлчид бүртгэлтэй ажиллаж байна. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 190 ААНБ байгаа ажээ.

2

ХАМТЫН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГА

1К

ХӨГЖМИЙН УРАН БҮТЭЭЛЧИД


190

ИДЭВХТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ААНБ

Эх үүсвэр: YCX

i. Салбарын ААНБ -ын мэдээлэл


Дуу хөгжмийн салбарын ААНБ -ын тоо, 2020 оны байдлаар:



2020 оны байдлаар дуу хөгжмийн салбарт 455 ААНБ бүртгэлтэй байгаагаас 190 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа явуулж буй байгууллагын 92 хувь нь СБҮ-ийн, 8 хувь нь ТТДМ-ын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд байна.

График 67: Үйл ажиллагаа явуулж буй байгууллагын СБҮ-д хамаарах хэлбэр



Эх үүсвэр: YCX

Хүснэгт 60: Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын салбарын ангилал, 2020 оны байдлаар

	СБҮ	ТТДМ	Нийт
4. Дуу, хөгжим	175	16	190
Дуу бичлэг хуулбарлах үйл ажиллагаа		15	15
Дуу бичлэг, хөгжмийн эх бэлтгэх үйл ажиллагаа	83		83
Соёл, амралтын барааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	85		85
Хөгжмийн зэмсэг үйлдвэрлэл	7		7
Хэрэглээний цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл		1	1


Эх үүсвэр: ҮСХ

ii. Салбарын ажиллагчдын тоо мэдээлэл
Нас, хүйсийн мэдээлэл

Дуу хөгжмийн салбарт 2020 оны байдлаар нийт 1182 ажиллагчид бүртгэлтэй байна. Үүний 25 хувийг эрэгтэй, 75 хувийг эмэгтэй ажиллагчид эзэлж байна.

НИЙТ АЖИЛЛАГЧДЫН ТОО

1182



Дуу хөгжмийн салбарын ажиллагчдын тоо мэдээллийг ажиллагчдын албан тушаалаар задлан дараах хүснэгтэд харууллаа. Үүнээс "Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн ажиллагч" 36 хувийг эзэлж байна.


Ажиллагчдын ангилал

Хүснэгт 61: Ажиллагчдын ангилал

	Тоо	Хувь
Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн ажиллагч	425	36%
Цалин хөлстэй түр ажиллагч	381	32%
Цалин хөлстэй байнгын ажиллагч	323	27%
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	53	4%

Эх үүсвэр: ҮСХ

График 68: Салбарын ажиллагчдын дундаж нас, 2020 оны байдлаар




Эх үүсвэр: ҮСХ

iii. Гадаад худалдааны үзүүлэлтүү

Дуу хөгжмийн салбарын бараа бүтээгдэхүүний экспорт, импортын хэмжээг сүүлийн арван жилийн байдлаар дараах графикт харуулж байна. Экспорт болон импортын хэмжээ 2016 онд хамгийн өндөр байжээ.

График 69: Дуу хөгжмийн салбарын экспорт, импортын хэмжээ, 2010-2020 оны байдлаар



Зураг 32: Дуу хөгжмийн салбарын гадаад худалдааны хэмжээ, сая ам.доллар

Гадаад худалдаа, импортын тоо мэдээлэл

20.6%



Дуу хөгжмийн салбарын нийт импортын дүнд эзлэх хувь, 2020 он

Дуу хөгжмийн салбарын импортын хэмжээ 2010 онд 2,687,695 ам.доллар байжээ. Сүүлийн арван жилийн хугацаанд 2016 онд хамгийн өндөр буюу 30,295,100 ам.долларт хүрсэн байна. 2020 оны байдлаар 21,657,088 ам.доллар байх ба нийт соёлын салбарын импортын хэмжээний 20.6 хувийг эзэлж байна.

Эх үүсвэр: ГЕГ, "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"

\$21.6 сая

ДУУ ХӨГЖМИЙН САЛБАРЫН ИМПОРТЫН ХЭМЖЭЭ, 2020 оны байдлаар

\$0.03 сая

ДУУ ХӨГЖМИЙН САЛБАРЫН ЭКСПОРТЫН ХЭМЖЭЭ, 2020 оны байдлаар

Гадаад худалдаа, экспортын тоо мэдээлэл

9.34%



Дуу хөгжмийн салбарын нийт экспортын дүнд эзлэх хувь, 2020 он

Дуу хөгжмийн салбарын экспортын хэмжээ 2010 онд 16,935 ам.доллар байжээ. Сүүлийн арван жилийн хугацаанд 2016 онд хамгийн өндөр буюу 3,445,625 ам.долларт хүрсэн байна. 2020 оны байдлаар 33,819 ам.доллар байх ба нийт соёлын салбарын экспортын хэмжээний 9.34 хувийг эзэлж байна.

Гадаад худалдаа, бүтээгдэхүүний төрлөөр

Дуу хөгжмийн салбарын импорт, экспортыг бүтээгдэхүүний төрлөөр дараах графикуудад харууллаа.

Дуу хөгжмийн салбарын импортын хэмжээг 2020 оны байдлаар бүтээгдэхүүний төрлөөр задлан харвал дуу бичлэгийн хэрэгслүүд хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин экспортын хувьд баяр наадам, хөгжмийн зэмсгүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Зураг 33: Гадаад худалдаа, бүтээгдэхүүний төрлөөр, нийт дүнд эзлэх хувиар, 2020 оны байдлаар



■ Дуу бичлэгийн хэрэгслүүд ■ Хөгжмийн зэмсгүүд
□ Хөгжим □ Баяр ёслол

**ДУУ ХӨГЖМИЙН САЛБАРЫН
ИМПОРТ,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРЛӨӨР,
2020 оны байдлаар**




■ Дуу бичлэгийн хэрэгслүүд ■ Хөгжмийн зэмсгүүд
□ Хөгжим □ Баяр ёслол

**ДУУ ХӨГЖМИЙН САЛБАРЫН
ЭКСПОРТ,
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРЛӨӨР,
2020 оны байдлаар**

iv. Салбарын төгсөгчдийн тоо мэдээлэл

Дуу хөгжмийн салбарын 2019-2020 оны хичээлийн жилд суралцаж төгссөн оюутны тоо мэдээлэл:

График 70: Дуу хөгжмийн салбарын төгсөгчдийн нийт СБУ-ийн төгсөгчдийн тоонд эзлэх хувь



Эх үүсвэр: БШУЯ, "Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн тоо мэдээлэл"

5 их, дээд сургууль


36 ХӨТӨЛБӨР

Дуу хөгжмийн салбарт 2019-2020 оны хичээлийн жилд 185 оюутан суралцаж төгссөн ба энэ нь нийт соёлын салбарын төгсөгчдийн 6 хувийг бүрдүүлж байна.

График 71: Дуу хөгжмийн салбарын төгсөгчид, боловсролын зэрэг, хүйсээр, 2019-2020 оны хичээлийн жилд

Боловсролын зэрэг

Дипломын боловсролыг 0
Бакалаврын боловсролыг 147
Магистрын боловсролыг 40
Докторын боловсролыг 0



Эх үүсвэр: БШУЯ, "Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн тоо мэдээлэл"

**ТАЙЗНЫ
УРЛАГ**

Performing Art



05

ТАЙЗНЫ УРЛАГ

Performing Art

Тайзны урлаг нь СБҮ-ийн соёл урлагийн салбарт хамаарах гол салбар чиглэл бөгөөд энэхүү тайланд театр, бүжиг, жүжиг, концерт, дуурь, балет, хүүхэлдэйн театр зэрэг мэргэжлийн болоод уран сайханчдын үйл ажиллагаа мөн соёлын төвийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг тусгалаа.

Нэр томъёоны тайлбар:

Урлагийн байгууллага: Урлагийн байгууллагад захиргааны бие даасан тамга, тэмдэгтэй, ажиллагчдын дийлэнх хэсэг нь мэргэжлийн жүжигчид, хөгжимчид зэрэг урлагийн ажил эрхэлдэг хүмүүсээс бүрдсэн урлагийн байгууллагыг хамааруулна.

Уран бүтээл: Соёл урлагийн салбарт ажиллаж буй зохиолын төрөл хэлбэрээс үл хамаарсан тодорхой нэг буюу хэсэг хүмүүсийн хийж гүйцэтгэсэн ажил

5.5. ТАЙЗНЫ УРЛАГ

5.5.1. Тайзны урлаг

Тайзны урлагийн нийгмийн үр нөлөө болон эдийн засгийн үр нөлөөг дэлгэрүүлэн авч үзлээ.

Нийгмийн үр нөлөө

Тайзны урлаг эрт дээр үеэс хүн төрөлхтний соёлын нэгээхэн хэсэг байсаар ирсэн. Тайзны урлаг нь хүмүүст өөрсдийн бүтээлч талыг харуулж, өөрийгөө илэрхийлэх боломжийг олгодог. Тэгэхээр, бид яагаад тайзны урлагийг хөгжүүлж, хүмүүст таниулж, энэ урлагт дурлуулах хэрэгтэй вэ?



Нэгт, тайзны урлаг бидэнд өөрийгөө хэрхэн илэрхийлэхийг заадаг. Биднийг хүн гэдгийг илтгэдэг гол бүрэлдэхүүний нэг нь өөрийгөө илэрхийлэх хүсэл юм. Энэ нь бидэнд өөрсдийн маань талаар маш олон зүйлсийг сургадаг. Бид тайзны урлагаар дамжуулан нийгэм хэрхэн ажилладгийг ойлгож, амьдарч буй орчныхоо талаар илүү ихийг мэдэх боломжтой.

“

Таны сурах
хамгийн агуу
зүйл бол бусдыг
хайрлаж, хариуд
нь хайрлуулж
сурах явдал юм.

“Moulin Rouge” Musical

”

Хоёрт, тайзны урлагт жуулчид олноороо татагддаг. Хүмүүс амралтаа авч, өдөр тутмын энгийн амьдралаасаа завсарлага авахдаа сонирхолтой үзэсгэлэн, тоглолтуудыг үзэхийг хүсдэг. Хэрвээ хангалттай сайн урлагийн номеруудтай, уран бүтээлчидтэй байж чадвал олон жуулчдыг татах боломжтой.

Гуравт, тайзны урлаг нь эдийн засгийн хувьд давуу талыг бий болгодог (University of Derby, 2016). Өдөр бүр сая сая хүн тоглолт үзэж, мянга мянган тоглолт олны өмнө нээлтээ хийж байна. 2017 онд л гэхэд АНУ-ын урлаг соёлын салбарт нийт 730 тэрбум долларын өртөгтэй байсан бөгөөд энэ нь тухайн жилийн ДНБ-ий 4.2 хувийг дангаараа эзэлж байв (Arts Facts: Arts and Cultural Production Contribution to GDP (2017), 2017).

Тиймээс, Монгол Улсад тайзны урлагийг хөгжүүлж, таниулах нь зүйтэй билээ.

Эдийн засгийн үр нөлөө

Дээр дурдсанчлан тайзны урлаг нь тухайн улсад эдийн засгийн хувьд давуу талыг бий болгодог. Дэлхийд ДНБ-ээрээ нэгдүгээрт бичигддэг АНУ-д л гэхэд 2017 онд ДНБ-ий 4.2 хувийг урлаг соёлын салбар дангаараа эзэлж байв. Тайзны урлагийн компаниуд болон бие даасан уран бүтээлчид, зохиолчид, жүжигчид 2019 онд АНУ-ын эдийн засагт нийт 60.9 тэрбум доллар нэмсэн (Facts & Figures on the Creative Economy, 2020).

Чөлөөт уран бүтээлчид болон тайзны урлагийн компаниудын дэлхийн зах зээл 2017 онд 252.0 тэрбум доллар үнэлэгдсэн. Үүний 92.6 тэрбум доллар буюу дэлхийн зах зээлийн 36.7 хувийг Хойд Америк эзэлсэн байна (Independent Artists And Performing Art Companies Global Market Report 2018, 2018).

Дэлхийн зах зээл



Канад улсын хувьд тайзны урлагийн үзүүлбэр үзүүлдэг 1400 гаруй байгууллага байдаг. Жилд мэргэжлийн уран бүтээлчдийн 80,000 гаруй тоглолтыг үзүүлдэг бөгөөд 200 сая гаруй долларын уран бүтээлийн шимтгэл төлдөг.

2016 онд Канадын 10 хүн тутмын 7 нь ямар нэгэн урлаг соёлын арга хэмжээнд оролцсон байсан байна. Энэ нь нийт хүн амын 68% юм.

Үзүүлбэр үзүүлэхэд шаардагдах санхүүжилтийн нэг эх үүсвэр бол CAPF/Canada Arts Presentation Fund/. CAPF жил бүр Канадын өнцөг булан бүрд байдаг 250 гаруй хот, орон нутгийн 600 орчим мэргэжлийн урлагийн наадам, урлагийн цуврал тоглолтуудыг

дэмжин ажилладаг. 2013-2014 оноос 2017 он хүртэл жилд дунджаар 38210 тоглолтод дэмжлэг үзүүлсэн. 2019-2020 онд буцалтгүй тусламж, хандивын хэмжээ 32.5 сая долларт хүрсэн байна. Канадын эдийн засаг тус хөтөлбөрөөс хөрөнгө оруулалт хийсэн 1 доллар тутмаас дунджаар 8.50 долларын өгөөж хүртдэг (Performing Arts Statistics, 2014).

i. Монгол Улсын тайзны урлагийн давуу тал онцлог, боломж

Тайзны урлагт тайзан дээр тоглогддог дуу, хөгжим, бүжиг, жүжиг тэдгээрийн хосолсон болон нэгдмэл бүх төрлийн урлаг багтдаг. Монголд тайзны урлагийн бүх төрлүүд байдаг. Монгол Улсад Монголын Урлагийн Ажилтны Холбоо (1975 оноос хойш), Монголын мэргэжлийн циркчдийн нэгдсэн холбоо, Монголын циркчдийн холбоо болон Монголын Ардын Урлагийн Нэгдсэн Холбоод үйл ажиллагаагаа явуулдаг ч “Тайзны урлагийн мэргэжлийн нэгдсэн холбоо” одоог хүртэл байгуулагдаагүй байна.

Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх

- БОАЖЯ болон аялал жуулчлалын салбарынхантай хамтран соёлын аялал жуулчлалын хөтөлбөр боловсруулах;
- Соёл урлагийн салбарын тоглолт, үзүүлбэрүүдийг байгаль эх, нүүдэлчин ахуйн гайхамшигтай хослуулж, жуулчдыг татах.

Зураг : “Жуулчны нэг өдрийн жишиг хөтөлбөр”

Цаг	Хөтөлбөр	Байршил
09:30-11:00	Музей үзэх	Үндэсний түүхийн музей
11:30-12:30	Ардын урлагийн тоглолт	Үндэсний соёл амралтын хүрээлэн
12:30-13:30	Өдрийн хоол	Үндэсний соёл амралтын хүрээлэн
14:00-15:30	Ууланд алхах	Богд уулын ам
16:00-17:30	Циркийн үзүүлбэр сурах	Улсын цирк
18:00-19:00	Оройн хоол	Монгол үндэстний ресторан
19:30-21:30	Балет/Контенторари бүжиг	Улсын дуурь бүжгийн эрдмийн театр
22:00-23:00	Одод	Жуулчны бааз

Олон улсын фестивалиудад оролцох

Олон улсын алдартай тайзны урлагийн фестивалд оролцож, Монгол Улс, Монгол соёлоо сурталчлах бүрэн боломжтой.


Олон улсын фестиваль, эвентийг Монголдоо зохион байгуулах

Гаднын уран бүтээлчдийг Монголдоо урьж, олон улсын чанартай эвент, уралдаан тэмцээн, фестиваль зохион байгуулах боломжтой.



Дэлхийн хэмжээний цирк

Монгол Улсын циркчид дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Монголын циркчид дэлхийд гуравт эрэмбэлэгддэг, олон улсын “А” зэрэглэлийн тэмцээнүүдэд үргэлж эхний гурван байрыг эзэлдэг (Б., 2019). Орчинг нь сайн бэлдээд өгөх юм бол дэлхийн алдартай циркүүдтэй эн зэрэгцэх бүрэн боломжтой.



Цогцолбортой болох ба түүний давуу талууд

Циркчдийн ур чадвараараа дэлхийд эхний 3-т ордог Монгол Улс циркийн цогцолбортой болбол дараах давуу талууд бий болох болно.

- Соёлын экспорт нэмэгдэх;
- Аялал жуулчлалыг татах;
- Олон улсын циркийг Монголдоо авчрах;

- Иргэдийн цаг заваа үр бүтээлтэй өнгөрүүлэх боломж нэмэгдэх;
- Циркийн урлаг цаашид тогтвортой хөгжих.

Циркийн цогцолборт байвал зохих зүйлс

Циркийн цогцолборт газар нь иргэд болон жуулчдын цаг заваа үр бүтээлтэй өнгөрөөх газраас гадна циркчдийг бэлтгэлээ хийж, тоглолтоо тавих нөхцөлөөр бүрэн хангагдсан байх хэрэгтэй юм. Тиймээс циркийн цогцолборт дараах зүйлс байвал зохистой. Үүнд:

- Задгай театр
- Оюутны дотуур байр
- Хөдөлгөөнт манеж
- Ресторан, кафе, гудамжны хоол
- Циркийн үзүүлбэрүүд
- Амрах орчин
- Шоу хийх том тайз
- Тоглоомууд
- Циркийн сургууль
- Хийж үзэх боломж
- Бэлтгэл сургуулилтын талбай
- Ногоон байгууламж

ii. Монгол Улсын тайзны урлагт тулгамдаж буй асуудал бэрхшээл

Монголд тайзны урлагт тулгамдсан асуудлуудыг хүний нөөц, эко орчин, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон маркетинг, борлуулалт гэсэн таван чиглэлийн хүрээнд тодрууллаа.

ХҮНИЙ НӨӨЦ

- Сургалтын хөтөлбөр шаардлага хангахгүй.
- Үнэлгээний стандарт байхгүй.
- Хамтын ажиллагаа муу.

Сургалтын хөтөлбөрүүд шаардлага хангахгүй байна. Чанарын шаардлага хангахгүй сургалтын хөтөлбөрийн улмаас ажил олгогчдын шаардлагад нийцдэггүй.

Шигтгээ 24: Мэргэжлийн найруулагчийг их сургуульд бэлтгэх

Монголд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн найруулагчийн сургууль байхгүй. СУИС бол мэргэжлийн найруулагч бэлддэггүй. Зүгээр жүжигчнээр төгссөн хүмүүс нэг хоёр жил магистр хамгаалахдаа “найруулахуй ухаан” зэрэг мэргэжлээр суралцаж тэрүүгээр найруулагч болж байна. Тиймээс мэргэжлийн найруулагч байхгүй.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

Уран бүтээлчдэд зориулсан үнэлгээний стандарт гэж байдаггүй учир үнэлгээ бага байдаг. Тийм ч учраас хангалттай хэмжээний орлоготой байж чаддаггүй тул гадаадад чадварлаг уран бүтээлчдээ алдаж, зарим нь Хятадын жуулчны баазуудад зундаа ажиллаж байна.

Гадаад хэлний хангалттай мэдлэг болон олон улсын хамтын ажиллагаа муу учраас дэлхийн тайзны урлагтай хөл нийлүүлэн алхаж, дэлхийн хурдаар хувьсан өөрчлөгдөж чадахгүй байна.

Салбарт дутагдалтай байгаа мэргэжлүүд:

- Театрын ерөнхий найруулагч
- Удирдаач
- Хөгжмийн зохиолч
- Зураач
- Хөгжмийн найруулагч
- Концерт мастер

**ЭКО СИСТЕМ**

- Төрийн байгууллагууд менежмент муутай.
- Жуулчны баазууд мэргэжлийн бус тоглолт, үзүүлбэр бэлддэг.
- Олон улсын уран бүтээлчдээс авдаг татвар өндөр.
- Чанар чансааг ялгах боломжгүй.

Судалгаанд оролцогчид тайзны урлагийн бодлого, төлөвлөлт, менежменттэй холбоотой дараах асуудлуудыг хамгийн ихээр хөндөж байна. Үүнд:

- Төрийн байгууллагууд менежмент муутай байдаг. Жишээлбэл, маркетинг хариуцсан хэлтэсгүй. Хэлтэстэй байсан ч удирдлагуудаас хангалттай хэмжээгээр төсөв тавьж өгдөггүй учир тоглолтуудаа олон хүнд хүргэж чаддаггүй. Тоглолтын тасалбарууд хангалттай борлуулагддаггүй тул ажилчдадаа тасалбар тарааж, худалдахыг шаарддаг. Зарим тоглолтуудаа үнэ төлбөргүй тавьдаг.
- Жуулчны баазууд жуулчдад Монгол ахуйгаа таниулах зорилгоор жижиг арга хэмжээнүүд зохион байгуулдаг. Гэхдээ мэргэжлийн бус хүмүүс жуулчдад үзүүлбэр үзүүлдэг.

Шигтгээ 25: Жуулчны баазууд болон Соёлын өвийн мэргэжлийн уран бүтээлчдийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх

Аялал жуулчлалын баазууд жуулчдадаа зориулж жижигхэн арга хэмжээнүүдийг хийж байна. Наадам, эсвэл жижиг ёслол ч юм уу. Монгол ахуйгаа л жуулчдадаа үзүүлэх гэж хичээж байна. Гэтэл ихэвчлэн мэргэжлийн бус хүмүүс ажиллаж байдаг. Тэд Соёлын өвийн уран бүтээлчид, мэргэжлийн хүмүүстэй хамтарч, харилцан холбоотой ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

- Монгол Улсын хувьд 20%-ийн татвар нь өндөр хэмжээ юм. Татварын хэмжээ өндөр учраас гадаадын уран бүтээлчид Монголд ирдэггүй. Үүний улмаас Монголын уран бүтээлчид бусад орны хөгжлөөс суралцаж, хөл нийлүүлэн алхахад хүндрэлтэй байна.
- Уран бүтээл, уран бүтээлчдийн чанар чансааг ялгах боломжгүй байдаг.

Шигтгээ 26: Өрсөлдөөнөөр драмын театрын хөгжлийг нэмэгдүүлэх

Өнөөдөр Драмын театр өрсөлдөгчгүй байгаа. Тэгээд сайн юм хийж байсан ч, муу юм хийж байсан ч өрсөлдөгчгүй явсаар байгаа. Хотын театртэй болоод ядаж хоёр театр хоорондоо өрсөлдөх юм бол хот эрчимтэй хөгжинө.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас**ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУД МЕНЕЖМЕНТ МУУТАЙ**

- Маркетинг хариуцсан хэлтэсгүй.
- Маркетингийн төсөв тавьдаггүй.
- Ажилчдаараа тасалбарын шахаа хийлгэдэг.
- Үнэгүй тоглодог.

ЖУУЛЧНЫ БААЗУУД МЭРГЭЖЛИЙН БУС ТОГЛОЛТ, ҮЗҮҮЛБЭР БЭЛДДЭГ

- Шаардлага хангахгүй.
- Зохицуулалт, хяналт байхгүй.

**ОЛОН УЛСЫН УРАН БҮТЭЭЛЧДЭЭС АВДАГ ТАТВАР ӨНДӨР**

- Татварын хэмжээ 20%.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Тогтмол орлогын эх үүсвэргүй.
- Хөрөнгө оруулалт эдийн засгийн үр өгөөжгүй.

Уран бүтээлчид тогтмол орлогын эх үүсвэргүй байна. Улирлын чанартай ажил хөдөлмөр эрхэлж байна. Ардын урлагийнхны хувьд гэхэд зуны улиралд Монголд жуулчид ихээр ирэх үед үзүүлбэрээ үзүүлж, тоглолтоо тавьдаг. Техник, тоног төхөөрөмжүүд хуучирсан. Дэлхийн жишигт нийцсэн тайлан, тоглолт тавихад хүндрэлтэй. Театрын хөрөнгө оруулалт хийгддэггүй.

Шигтгээ 27: Соёлын салбарын хөгжил орхигдсоноос төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сул

Монгол Улс сүүлийн 30 гаруй жил соёлын салбараа орхиж, хөрөнгө оруулалтууд маш бага хийгдсэн. Үүнийг дагаад салбарын яам болон төр хувийн хэвшлийн түншлэл хоорондын хамаарал, хамтын ажиллагаа сул байгаа.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

Тайзны урлагт уран бүтээлчдийг дэмжсэн бодитой хөрөнгө оруулалт байдаггүй. Хуучин соёл урлагийг хөгжүүлэх сангаас зарладаг байсан төслийн уралдаан нь хүртээмжгүй, шударга бус зохион байгуулагддаг. Эдийн засгийн өр өгөөжтэй байдлыг олж хардаггүй.

ТОГТМОЛ ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРГҮЙ

- Улирлын чанартай.
- Техник, тоног төхөөрөмж хуучирсан.
- Театруудад нэмэлт хөрөнгө оруулалт хийгддэггүй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖГҮЙ

- Уран бүтээлчдийг дэмжсэн бодитой хөрөнгө оруулалт байхгүй, шалгаруулалт шударга бус.
- Хүртээмжтэй бус, эдийн засгийн үр өгөөжтэй байдлыг хардаггүй.
- Улсын театруудын уран бүтээл чанаргүй.
- Орон нутагт театрыг авч явахад хэцүү.

ДЭД БҮТЭЦ

- Энэ тэнд тархсан. Нэгдсэн бүртгэлгүй.
- Улсын театрууд түрээс өндөртэй.

Уран бүтээлчдийн нэгдсэн бүртгэлийн сан гэж байдаггүй. Энд тэнд тархан суурьшсан байдаг. Тогтвор суурьшилтай уран бүтээл хийе ч гэсэн хангалттай хэмжээний ажиллах орон зай, ажил байдаггүй.


Хувийн хэвшлийн уран бүтээлчид тоглолт, үзүүлбэрүүдээ улсын театруудад бэлдэж, тавихад түрээс маш өндөр байдаг.

Маркетинг, борлуулалт**МАРКЕТИНГ, БОРЛУУЛАЛТ**

- Сайн чанартай уран бүтээл, уран бүтээлчийг ялгаж үнэлэх боломжгүй.
- Уран бүтээлээ эргэлтэд оруулж чадахгүй байна.

Соёл урлагийн салбар бүхэлдээ соёлын менежмент, маркетингаар мэргэшсэн боловсон хүчин дутмаг. Ихэнхдээ уран бүтээлчид өөрсдөө маркетингийн ажлаа бие даан хийдэг. Түүнээсээ болж гол уран бүтээлдээ бүрэн анхаарлаа хандуулж чаддаггүй ба энэ нь уран бүтээлийн гүйцэтгэлд мөн нөлөөлж байна. Мөн төрийн соёл урлагийн үйлчилгээний байгууллагуудад чадварлаг мэргэжлийн продюсерууд, менежментийн хүмүүс ажилладаггүй. Үүнээс болж өөрсдийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулж чадахгүй байна.

iii. Процессын зураглал



5.5.2. Тайзны урлагийн статистик тоон мэдээлэл

Хүснэгт 62: Урлагийн байгууллагын нэгдсэн статистик

Үзүүлэлтүүд		МД	2018	2019	2020	
А		Б	1	2	3	
Урлагийн байгууллагын нийт тоо		1	35	34	34	
Урлагийн байгууллагын нийт суудлын тоо		2	15,365	13,686	14,104	
Үзвэр үйлчилгээний нийт тоо		3	4,094	6,073	2,370	
Урлагийн төрлөөр	Урлагийн тоглолтын үйлчилгээ	Концерт	4	1,920	2,693	1,032
		Циркийн тоглолт	5	33	18	
		Жүжиг	6	731	1,000	430
Бусад		7	1,410	2,362	908	
Үйлчилгээний зориулалтаар	Хүүхдэд зориулсан	Жуулчдад	8	822	1,347	649
		Дохионы хэлний орчуулагчтай	9		202	60
		Төлбөргүй	10		-	1
Үйлчилгээний хэлбэрээр	Үзвэрийн танхимын үйлчилгээ	Аялан тоглолт /Нүүдлийн үйлчилгээ/	11		1,502	963
		Аялан тоглолт /Нүүдлийн үйлчилгээ/	12	2,548	4,581	1,601
		Аялан тоглолт /Нүүдлийн үйлчилгээ/	13	1,506	1,492	769
Нийт үйлчлүүлэгчид	Аялан тоглолт /Нүүдлийн үйлчилгээ/	Дотоодод	14		1,344	768
		Гадаадад	15		148	1
		Нийт үйлчлүүлэгчид	16	1,919,800	4,219,021	2,925,997
Хүүхэд		17	302,991	343,334	220,706	
Төлбөргүй		18	645,194	579,618		
Гадаад		19	425,691	235,680		
Тусгай бүлгийн		20		51,133	13,150	
Хөгжлийн бэрхшээлтэй		21		8,973	10,355	

Үзүүлэлтүүд		МД	2018	2019	2020	
Бусад		22		42,160	2,795	
Урлагийн төрлөөр	Урлагийн тоглолтын төрлөөр	Концерт	23		3,356,601	2,567,137
		Циркийн тоглолт	24		11,857	
		Жүжиг	25		312,086	135,729
Соёл, олон нийтийн арга хэмжээ		26		538,477	223,131	
Үйлчилгээний хэлбэрээр	Үзвэрийн танхимын үйлчилгээ	Аялан тоглолт /Нүүдлийн үйлчилгээ/	27	761,311	905,461	984,775
		Аялан тоглолт /Нүүдлийн үйлчилгээ/	28	1,158,489	2,775,083	1,718,091
		Дотоодод	29		2,378,578	1,718,091
Гадаадад		30		396,505		
Урын сангийн нийт тоо		31	8,159	12,191	13,514	
Найруулгын төрлөөр	Шинээр туурвисан	Шинээр туурвисан	32	295	373	443
		Үнийн дүнгээр /мян.төг/	33	911,810		
		Шинэчлэн найруулсан	34		96	487
Урлагийн төрлөөр	Сэргээн тавьсан	Концерт	35		500	242
		Циркийн	36		8	8
		Жүжиг	37		1,624	1,743
Баталсан орон тоо		38		2,855	2,731	
Нийт ажиллагчдын тоо		39	2,566	2,701	2,678	
Эмэгтэй		40	1,199	1,261	1,254	
Мэргэжлийн		41		1,901	1,875	
Төр, засгийн шагналтан		42		880	911	
Хөгжлийн бэрхшээлтэй		43		30	35	
Эмэгтэй		44		11	14	
Албан тушаалын ангиллаар	Захиргаа, аж ахуйн	Эмэгтэй	45	597	537	533
		Уран бүтээлийн удирдлага	46		220	217
		Эмэгтэй	47	335	320	328
		Уран бүтээлчид	48		73	71
		Эмэгтэй	49		73	71
		Мэргэжлийн ажиллагчид	50	1,681	1,614	1,579
		Эмэгтэй	51	776	749	729
		Түр хугацаагаар ажиллагчид (гэрээт)	52	288	293	294
		Эмэгтэй	53	88	101	109
		Эмэгтэй	54		37	55
Насны бүлгээр	25 хүртэлх	Эмэгтэй	55		18	17
		Эмэгтэй	56	413	364	358
		Эмэгтэй	57	182	162	165
		25-34	58	1,008	865	838
		Эмэгтэй	59	456	412	397
		35-44	60	625	793	798
		Эмэгтэй	61	320	365	358
		45-54	62	361	446	482
		Эмэгтэй	63	190	234	253
		55-59	64	102	152	132
Эмэгтэй	65	29	62	56		
60+	66	57	81	70		
Эмэгтэй	67	22	26	25		
Нийт ажиллагчдын тоо		68		2,701	-	
Эмэгтэй		69		1,261	-	

Үзүүлэлтүүд		МД	2018	2019	2020
Боловсролын түвшнээр	Боловсролгүй	70		1	1
	Эмэгтэй	71		-	-
	Бага	72	2	1	1
	Эмэгтэй	73	1	-	-
	Суурь	74	20	18	13
	Эмэгтэй	75	9	8	4
	Бүрэн дунд	76	381	422	397
	Эмэгтэй	77	171	203	203
	Техникийн болон мэргэжлийн	78	356	150	186
	Эмэгтэй	79	151	61	73
	Тусгай мэргэжилийн дунд	80	297	337	335
	Эмэгтэй	81	127	163	138
	Дипломын болон бакалаврын дээд	82	1,350	1,607	1,576
	Эмэгтэй	83	661	744	750
	Магистр	84	158	161	165
	Эмэгтэй	85	79	81	85
Доктор	86	2	4	4	
Эмэгтэй	87		1	1	

Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик мэдээлэл

5.5.3. Соёлын төвийн статистик тоон мэдээлэл

Хүснэгт 63: Соёлын төвийн статистик

Үзүүлэлтүүд		МД	2018	2019	2020
А		Б	1	2	3
Соёлын төв /ордон/-ийн нийт тоо		1	345	345	346
Соёлын төв /ордон/-ийн нийт суудлын тоо		2	88,007	89,317	90,538
Үзвэр, үйлчилгээний нийт тоо		3	39,948	38,116	15,855
Урлагийн төрлөөр	Урлагийн тоглолтын үйлчилгээ	Концерт	4	9,927	3,978
		Циркийн тоглолт	5		110
		Жүжиг	6		647
	Бусад	7		27,432	
Үйлчилгээний зориулалтаар	Хүүхдэд зориулсан	8		8,600	
	Жуулчдад	9		317	
	Дохионы хэлний орчуулагчтай	10		4	
Үйлчилгээний хэлбэрээр	Төлбөргүй	11		13,118	
	Үзвэрийн танхимын үйлчилгээ	12		32,126	
	Аялан тоглолт /Нүүдлийн үйлчилгээ/	13		5,982	
	Гадаадад	14		8	
Нийт үйлчлүүлэгчид		15	4,821,708	4,823,798	2,228,359
Хүүхэд		16	1,205,252	1,091,001	444,840
Насанд хүрэгчид		17	3,575,311	3,732,797	1,783,519
Төлбөргүй		18		1,379,119	1,099,313
Гадаад		19	13,175	13,445	1,201
Тусгай бүлгийн		20		188,824	49,283
Хөгжлийн бэрхшээлтэй		21		22,727	6,555
Бусад		22		166,097	42,728
Урлагийн төрлөөр	Урлагийн тоглолтын төрлөөр	Концерт	23	2,236,047	1,028,512
		Циркийн тоглолт	24		68,712
		Жүжиг	25		394,627
	Бусад үйлчилгээ	26		2,124,412	
Үйлчилгээний хэлбэрээр	Үзвэрийн танхимын үйлчилгээ	27		2,216,073	
	Аялан тоглолт /Нүүдлийн үйлчилгээ/	28		480,921	
	Гадаадад	29		2,392	
Урын сангийн нийт тоо		30		5,535	


Үзүүлэлтүүд		МД	2018	2019	2020
Найруулгын төрлөөр	Шинээр туурвисан	31		1,470	788
	Шинэчлэн найруулсан	32		644	238
	Сэргээн тавьсан	33		509	264
Урлагийн төрлөөр	Концерт	34		5,214	3,964
	Циркийн тоглолт	35		37	6
	Жүжиг	36		284	125
Баталсан орон тоо		37	2,525	2,639	2,715
Нийт ажиллагчдын тоо		38	2,385	2,603	2,611
Эмэгтэй		39	1,425	1,520	1,539
Мэргэжлийн		40		992	1,122
Төр, засгийн шагналтан		41		384	395
Хөгжлийн бэрхшээлтэй		42		105	74
Эмэгтэй		43		84	59
Албан тушаалын ангиллаар	Захиргаа, аж ахуйн	44	1,085	973	956
	Эмэгтэй	45	634	548	550
	Мэргэжлийн ажиллагчид	46	1,300	1,239	1,225
	Эмэгтэй	47	791	753	746
	Үйлчилгээний ажиллагчид	48		233	309
	Эмэгтэй	49		169	217
	Түр хугацаагаар ажиллагчид (гэрээт)	50		158	121
	Эмэгтэй	51		50	26
	25 хүртэлх	52	164	203	183
	Эмэгтэй	53	111	100	98
Насны бүлгээр	25-34	54	722	748	751
	Эмэгтэй	55	414	421	427
	35-44	56	692	761	727
	Эмэгтэй	57	452	497	475
	45-54	58	660	707	745
	Эмэгтэй	59	403	425	460
	55-59	60	128	154	168
	Эмэгтэй	61	41	71	69
	60+	62	15	30	37
	Эмэгтэй	63	4	6	10
Боловсролын түвшнээр	Боловсролгүй	64	2	7	8
	Эмэгтэй	65	1	4	4
	Бага	66	14	11	18
	Эмэгтэй	67	5	2	4
	Суурь	68	124	100	119
	Эмэгтэй	69	49	41	56
	Бүрэн дунд	70	733	775	722
	Эмэгтэй	71	401	424	388
	Техникийн болон мэргэжлийн	72	244	174	162
	Эмэгтэй	73	132	66	64
	Тусгай мэргэжилийн дунд	74	322	249	251
	Эмэгтэй	75	189	144	137
	Дипломын болон бакалаврын дээд	76	871	1,225	1,246
	Эмэгтэй	77	595	789	819
	Магистр	78	68	60	80
	Эмэгтэй	79	51	49	63
	Доктор	80	7	2	5
Эмэгтэй	81	2	1	4	

Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик мэдээлэл

i. Урлагийн байгууллагын ажиллагчдын тоо мэдээлэл

Урлагийн байгууллагын ажиллагчдын батлагдсан орон тоонд эзлэх хувь, 2020 оны байдлаар:

График 72: Урлагийн байгууллагын ажиллагчдын батлагдсан орон тоонд эзлэх хувь, 2020 оны байдлаар



Монгол Улсын хэмжээнд Урлагийн байгууллагад 2020 оны байдлаар 2678 ажиллагчид тус салбарт ажиллаж байна. Энэ нь СБҮ-ийн салбарын ажиллагчдын 8 хувийг бүрдүүлж байна.

График 73: Урлагийн байгууллагын ажиллагчдын тоо, ажиллагчдын тоо, 2019-2020 оны байдлаар:




Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик мэдээлэл

График 74: Урлагийн байгууллагын ажиллагчдын албан тушаал, нийт дүнд эзлэх хувь, 2020 оны байдлаар



График 75: Урлагийн байгууллагын ажиллагчдын дундаж нас, сүүлийн гурван жилийн байдлаар



Урлагийн байгууллагын ажиллагчдын хүйсийн харьцааг харахад нийт ажиллагчдын 46 хувийг эмэгтэй ажиллагчид бүрдүүлж байна.


График 76: Урлагийн байгууллагын ажиллагчид, боловсролын түвшнээр, 2020 оны байдлаар

Боловсролын түвшнээр:


Суурь болон бүрэн дунд



Техникийн болон тусгай мэргэжлийн дунд



Дипломын болон дээд боловсролын



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик мэдээлэл

Хүснэгт 64: Урлагийн байгууллагын ажиллагчид, албан тушаал, насны бүлэг, боловсролын түвшин, хүйсээр:

Ажиллагчдын үзүүлэлтээр	Улаанбаатар хотод			Улсын хэмжээнд		
	2018 он	2019 он	2020 он	2018 он	2019 он	2020 он
Баталсан орон тоо	1344	1226	1194	2855	2732	2731
Нийт ажиллагчдын тоо	1223	1223	1199	2566	2701	2678
Үүнээс: Эмэгтэй	543	539	538	1199	1261	1254
Мэргэжлийн		922	867		1901	1875
Төр, засгийн шагналтан		316	293		880	911
Хөгжлийн бэрхшээлтэй		12	14		30	35
Үүнээс: Эмэгтэй		4	5		11	14
АЛБАН ТУШААЛААР						
Захиргаа, аж ахуйн	253	186	186	597	537	533
Үүнээс: Эмэгтэй	148	106	119	335	320	328
Уран бүтээлийн удирдлага		83	91		220	217
Үүнээс: Эмэгтэй		25	29		73	71
Уран бүтээлчид	841	807	757	1681	1614	1579
Үүнээс: Эмэгтэй	358	347	320	776	749	729
Мэргэжлийн ажиллагчид	129	125	121	288	293	294
Үүнээс: Эмэгтэй	37	49	55	88	101	109
Түр хугацаагаар ажиллагчид (гэрээт)		22	44		37	55
Үүнээс: Эмэгтэй		12	15		18	17
НАСНЫ БҮЛГЭЭР						
25 хүртэлх	279	239	189	413	364	358
Үүнээс: Эмэгтэй	125	102	90	182	162	165
25-34	412	355	348	1008	865	838
Үүнээс: Эмэгтэй	151	158	151	456	412	397
35-44	316	328	364	625	793	798
Үүнээс: Эмэгтэй	163	133	146	320	365	358
45-54	156	202	217	361	446	482
Үүнээс: Эмэгтэй	83	110	117	190	234	253
55-59	32	60	48	102	152	132
Үүнээс: Эмэгтэй	12	24	21	29	62	56
60+	28	39	33	57	81	70
Үүнээс: Эмэгтэй	9	12	13	22	26	25
БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР						
Боловсролгүй		1	1		1	1



СОЁЛЫН ЯАМ


Ажиллагчдын үзүүлэлтээр	Улаанбаатар хотод			Улсын хэмжээнд		
	2018 он	2019 он	2020 он	2018 он	2019 он	2020 он
Үүнээс: Эмэгтэй		0	0		0	0
Бага	0	0	0	2	1	1
Үүнээс: Эмэгтэй	0	0	0	1	0	0
Суурь	9	2	0	20	18	13
Үүнээс: Эмэгтэй	3	1	0	9	8	4
Бүрэн дунд	58	75	89	381	422	397
Үүнээс: Эмэгтэй	23	35	44	171	203	203
Техникийн болон мэргэжлийн	165	30	36	356	150	186
Үүнээс: Эмэгтэй	67	13	23	151	61	73
Тусгай мэргэжлийн дунд	173	212	215	297	337	335
Үүнээс: Эмэгтэй	69	103	79	127	163	138
Дипломын болон бакалаврын дээд	699	787	743	1350	1607	1576
Үүнээс: Эмэгтэй	326	334	339	661	744	750
Магистр	117	112	111	158	161	165
Үүнээс: Эмэгтэй	55	52	52	79	81	85
Доктор	2	4	4	2	4	4
Үүнээс: Эмэгтэй		1	1		1	1

Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик мэдээлэл

ii. Салбарын төгсөгчдийн тоо мэдээлэл

Тайзны урлагийн салбарын 2019-2020 оны хичээлийн жилд суралцаж төгссөн оюутны тоо мэдээлэл:

График 77: Тайзны урлагийн салбарын төгсөгчдийн нийт СБҮ-ийн төгсөгчдийн тоонд эзлэх хувь




5 их, дээд сургууль

31 ХӨТӨЛБӨР


Тайзны урлагийн салбарт 2019-2020 оны хичээлийн жилд 274 оюутан суралцаж төгссөн ба энэ нь нийт соёлын салбарын төгсөгчдийн 7 хувийг бүрдүүлж байна.

График 78: Тайзны урлагийн салбарын төгсөгчид, боловсролын зэрэг, хүйсээр, 2019-2020 оны хичээлийн жилд

Боловсролын зэрэг



Хүйс



Эх үүсвэр: БШУЯ

КИНО, ДУУ ДҮРСНИЙ УРЛАГ

Film/Audiovisual



06

06

КИНО, ДУУ ДҮРСНИЙ УРЛАГ

Film/Audiovisual

5.6. КИНО, ДУУ ДҮРСНИЙ УРЛАГ

Нэр томъёоны тайлбар:

КИНО: Хөдөлгөөнт дүрс, үзэгдлийг камер болон өөр бусад тоног төхөөрөмжийн тусламжтайгаар хүн үзэх боломжтой бүтээлийг бүтээн туурвиж кино театр болон телевизээр толилуулдаг урлагийн төрөл;

УРАН САЙХНЫ КИНО: Киноны найруулагч, зураглаач болон жүжигчний уран бүтээл, мөн хөгжмийн зохиолч ба зураачийн уран бүтээлийн тусламжтайгаар драмын бүтээлийн үндсэн дээр бүтээгдсэн кино бүтээл;

БАРИМТАТ КИНО: Болсон үйл явдлыг бодитойгоор үзүүлсэн кино бүтээл;

ХҮҮХДИЙН КИНО: Ерөнхий боловсролын бага, дунд анги буюу 6-12 насныханд зориулан тэдний сонирхолд нийцсэн сэдэв, агуулга бүхий киноны төрөл;

КИНО ЦЭГ: Улсын хэмжээнд кино үзвэрийн үйлчилгээг явуулын болон суурин хэлбэрээр үзэгчдэд үйлчилгээ үзүүлсэн кино театр, суурин кино цэг ба нүүдлийн кино цэгийн нийлбэр;

СУУРИН КИНО ЦЭГ: Иж бүрэн кино аппараттай, үзэгчдийн суудлыг байнга байхаар угсарсан кино заалтай газар;

КИНО ТЕАТР: Киноны зориулалтын барилга байгууламжид 3-аас дээш үзвэрийн танхим, 1000-аас дээш суудлын тоо бүхий олон улсын шаардлагад нийцэх кино үйлчилгээний байгууллага;

КИНО ҮЗЭГЧИД: Тухайн жил кино театр, суурин кино цэг, нүүдлийн кино цэгийн зааланд ирж кино үзсэн хүний тоогоор тодорхойлно;

ҮЙЛДВЭРЛЭСЭН КИНО: Тухайн жилд үйлдвэрлэсэн киноны тоогоор тодорхойлогдоно;

ГАДААДААС АВСАН КИНО: Тухайн жилд гадаадаас худалдаж авсан болон солилцоогоор авсан киноны нийт тоогоор тодорхойлогдоно. Гадаадаас авсан кино нь чухам ямар төрлийн кино болохыг уран сайхны, хүүхдийн баримтат, сургалт сурталчилгааны гэж ялгаж тусгана. Мөн улс тус бүрээр ялгаж бүртгэнэ;

ОРЧУУЛСАН КИНО: Гадаадаас авсан киноноос орчуулсан киноны тоог улс тус бүрээр ялгаж бүртгэнэ. Орчуулсан кино нь ямар төрлийн кино болохыг уран сайхны, хүүхдийн, баримтат, сургалт сурталчилгааны гэж ялгаж тусгана. Мөн улс тус бүрээр нь ялгаж харуулна.

5.6.1. Кино урлагийн салбар

Өнөөгийн бидний мэддэг кино урлагийн салбар 19-р зууны эхэн үеэс эхлэн гэрэл зургийн бүтээл туурвих, бие даасан хөдөлгөөнгүй дүрсийг нэгтгэн хөдөлгөөний хуурмаг байдлыг олж илрүүлэх, хүн, амьтны хөдөлгөөнийг судлах зэрэг технологийн хэд хэдэн хөгжлийн үр дүнд бий болсон юм (The History of Movies, n.d.).

Хамгийн анхны кино театр бол 1905 оны 6-р сарын 19-нд Пеннийн Питтсбург хотод нээгдсэн "Nickelodeon" кино театр юм. Энэхүү театр нь Харри Дэвис, Жон П. Харрис нарын бүтээл бөгөөд 96 суудлыг Смитфилд гудамжны 433-435 тоот дахь хоосон дэлгүүрт шилжүүлснээр дэлхийн хамгийн анхны кино театр үүд хаалгаа нээсэн байна (Infoplease Staff, 2017).

2019 онд дэлхийн хэмжээнд "Box office" нь 42.2 тэрбум доллар үнэлэгдсэн байна. "Box office" болон "Home entertainment" орлогыг хамруулан тооцоход дэлхийн кино урлагийн салбар 2018 онд 136 тэрбум доллар үнэлэгдсэн байна (Film industry, 2019).

Нийгмийн үр нөлөө

Давуу тал

Кино үзэх нь маш олон давуу талтай. Кино үзэх нь найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ цагийг сайхан өнгөрүүлэхэд туслахаас гадна тохиромжтой кино үзэх нь эрүүл мэндэд ч эерэг нөлөөтэй үзүүлдэг (BREO BOX, 2020).

Хэцүү нөхцөл байдлыг даван туулахад бидэнд тусалдаг.

Биеийн эсэргүүцлийг дэмждэг, дархлааг сайжруулдаг.

Стрессийг даван туулахад тусалдаг.

Гэр бүл болон хосуудыг нэгтгэдэг.

Илүү сайн хүн болох урам зоригийг өгдөг.

Илүү сайн хүн болох урам зоригийг өгдөг.

Кино театр

АНУ-д 11,874 кино театр үйл ажиллагаа явуулдаг ба насанд хүрэгчид жилд дунджаар 5 кино кино театрт үздэг байна. 2019 оны 6-р сард явуулсан судалгаагаар АНУ-ын насанд хүрэгчдийн ердөө 14 хувь нь кино театрт сард нэг ба түүнээс олон удаа очдог болох нь тогтоогдсон боловч 46 хувь нь нэг жилд нэг эсвэл түүнээс бага удаа кино үзэх гэж кино театрт очдог байна (Stoll, 2021).

Дэлхийн томоохон кино театрууд

"Le Grand Rex" нь зөвхөн кино театр, концертын танхимаас гадна нийслэлийн хамгийн нэр хүндтэй соёлын байгууллагуудын нэг юм. Долоон дэлгэц байдаг бөгөөд хамгийн том нь 2400 үзэгчийг багтаах боломжтой. "Хичкокийн Шувууд"-аас "Оддын дайн" хүртэлх бүх Францын нээлтийн үзвэрүүд энд нээж байсан байна (Time Out editors, 2021).

Сан Францискогийн түүхэн театр болох Испанийн колоничлолын үзэсгэлэнт фасадаар олонд танигдсан "Castro Theatre in San Francisco". Энэхүү том танхим нь 1400 хүний суудалтай бөгөөд ихэвчлэн сонгодог кинонуудыг үзүүлдэг (Phillips, 2016).

Цахим орчин

Хүмүүс дан ганц телевиз болон кино театрт очин кино үзэхээ больсон. Цахим орчин хөгжсөнөөр ухаалаг гар утас болон түүнтэй төстэй төхөөрөмжүүдээр кино үзэх болсон. Цар тахлын улмаас үзвэр үйлчилгээний газруудын үйл ажиллагаа зогссоноор интернэт ашиглан кино үзэх нь улам бүр нэмэгдээд байгаа билээ. Дэлхий даяар маш олон онлайн-аар кино үзэх сувгууд бий болж байна. Эдгээрээс хамгийн их хүмүүсийн ашигладаг аппликейшнууд бол "Netflix", "Amazon Prime Video" болон "HBO go" юм.

NETFLIX HBO GO prime video

**Эдийн засгийн үр нөлөө**

Кино болон телевизийн салбар нь АНУ-ын эдийн засгийг маш олон талаас нь дэмждэг. Кино техникчээс эхлүүлээд кино зохиолч хүртэл 2.5 сая хүнийг ажлын байраар энэхүү салбар хангаж байна. Энэ нь жилд 188 тэрбум гаруй долларын цалинг эргэлдүүлж байна.

Кино, телевизийн нэвтрүүлэг нь сонгогдсон байршил дээрээ зураг авалт хийхдээ ажлын байр, орлого, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтыг бий болгож, орон нутгийн эдийн засагт шууд нөлөө үзүүлдэг. Энэхүү салбар жил бүр улс орон даяар хот, жижиг суурин газрын 320 гаруй мянган аж ахуйн нэгжид 44 тэрбум долларыг төлдөг. Алдартай кино, телевизийн шоу нэвтрүүлэг аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

Жишээлбэл, Marvel-ын "Black Panther" нь Жоржиа муж дахь 3100 гаруй орон нутгийн ажилчдыг татан оролцуулж, 26.5 сая гаруй долларын төлсөн бол 20th Century Fox телевизийн алдарт "This

Is Us" олон ангит кино Калифорнийн эдийн засагт 61.5 сая гаруй долларын хөрөнгө оруулсан байна. Нью-Йоркт Оскарын шагналд нэр дэвшсэн «Шуудан», «Хамгийн агуу шоучин» кинонууд мужийн орон нутгийн эдийн засагт 108 сая гаруй доллар оруулсан байдаг (DRIVING ECONOMIC, 2019).

i. Монгол Улсын кино урлагийн салбарын давуу тал онцлог, боломж

Монгол Улсад 1935 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Ардын сайд нарын зөвлөлийн 32 дугаар тогтоолоор улсын Кино зургийн хороог байгуулж улмаар уг хорооны харьяа кино үйлдвэрийн газрыг байгуулжээ. Монголын хамгийн анхны кино "Монгол хүү" юм. Хамгийн анхны монгол кино үзэгчдэд хүрснээс хойш 85 жил өнгөрсөн байна.

Кино урлагийн салбарын холбоод

Кино урлагийн салбарт мэргэжлийн холбоод 30 орчим байдаг боловч идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй цөөхөн байгууллага байна.

ii. Монгол Улсын кино урлагт тулгамдаж буй асуудал бэрхшээл

Монгол Улсын кино урлагийн салбарт тулгамдсан асуудлуудыг хүний нөөц, эко орчин, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон маркетинг, борлуулалт гэсэн таван чиглэлийн хүрээнд тодрууллаа.

ХҮНИЙ НӨӨЦ

- Чадварлаг боловсон хүчний нөөц хомс байдаг.
- Олон улсын стандартад нийцсэн кино бүтээх ур чадвар дутмаг.
- Уран бүтээлчдийн маркетинг, менежмент, хууль эрх зүйн мэдлэг дутмаг.
- Гадаадад сурч боловсорсон уран бүтээлчид эх орондоо удаан ажиллаж чаддаггүй.
- Дотоодын кино төслийг хэрэгжүүлэх явцад уран бүтээлчдийг даатгуулах, эрсдэлд орсон тохиолдолд нөхөн төлбөр өгөх нь дутмаг, нэгдсэн даатгалын бодлого байдаггүй.

Монголын кино урлагийн салбарт чадварлаг боловсон хүчний нөөц хомс байдаг. Тийм ч учраас уран бүтээлчид өөрсдийн ажлыг л дагнан ажиллахаас илүүтэй өөрийн мэргэжилд хамааралгүй олон төрлийн ажлыг давхар хийдэг. Үүнээс гадна уран бүтээлчдийн маркетинг, менежмент, хууль эрх зүйн мэдлэг муутай байна. Үйлдвэрлэл хийх хүний нөөц байдаггүй. Үүнд, эвлүүлэгч, дууны найруулагч, график дизайнер гэх мэт мэргэжлүүд багтдаг. Эдгээр мэргэжлүүдээр гадаадад суралцаж, эх орондоо ирсэн хүмүүс байдаг ч ажиллах таатай нөхцөл байхгүйн улмаас ихэнх нь гадаад руу буцдаг. Дотоодын кино төслийг хэрэгжүүлэх явцад уран бүтээлчдийг даатгуулах, эрсдэлд орсон тохиолдолд нөхөн төлбөр өгөх нь дутмаг, нэгдсэн даатгалын бодлого байдаггүй.

**Шигтгээ 28: Кино уран бүтээлчид өөрсдийн хариуцсан чиглэлээ дагнан ажиллах**

Кино урлагийн салбар хөгжиж байгааг яаж мэдэж болох вэ? Гэхээр кино урлагийн салбарт байгаа үе шат болгон дээр өөр өөрсдийн чиглэлийн мэргэжлийн хүмүүс ажиллаж байвал түүнийг хөгжиж байна гэж үзнэ. Түүнээс биш найруулагч нь дууны оператораа ч хийгээд продюсероо ч хийгээд бүх юмыг хийгээд яваад байгаа нь старт-ап байгууллага шиг байна. Кино урлагийн салбарт найруулагч нь найруулагчаа, зураачийн баг нь зургаа, оператор нь оператораа хийгээд явах ёстой.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас**ЭКО СИСТЕМ**

- Мэргэжлийн холбоод хоорондын хамтарч ажиллах, уялдаа холбоо бага, нэгдэж чаддаггүй.
- Кино түгээлтийн суваг болох IPTV –ийн орлогод хяналт тавих боломжгүй тул хичнээн кино үзсэн гэдгийг бодитоор тооцоолж чаддаггүй.
- Олон улсын кино продакшнтай хамтарч ажиллахад татварын хөнгөлөлт байхгүй
- Оюуны өмчийг хамгаалах тухай хууль, түүний хэрэгжилт хангалтгүй.
- Киноны албан ёсны нэгдсэн бүртгэл, статистик тоо баримт дутмаг.

Кино урлагийг цаашид тогтвортой хөгжүүлэх, хэрэгжихүйц нэгдсэн бодлого байдаггүй. Кино түгээлтийн суваг болох IPTV-ийн орлогод хяналт тавих боломжгүй тул хэчнээн удаа кино үзсэн болохыг бодитоор тооцоолж чаддаггүй. Олон улсын хамтын ажиллагааг дэмжин ажиллаж татварын хөнгөлөлт үзүүлдэггүй. Оюуны өмчийг хамгаалах хууль байдаг ч хангалттай сайн хэрэгжиж чадахгүйн улмаас уран бүтээлчид өөрсдийн оюуны өмчийг бусдад зөвшөөрөлгүй ашиглуулсаар байна. Киноны албан ёсны нэгдсэн бүртгэл, статистик тоо баримт дутмаг байдаг.

ДЭД БҮТЭЦ

- Монголын кино үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмж хуучирч, үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй.
- Тоног төхөөрөмжийн гаалийн татвар, НӨАТ –ын татвар маш өндөр зардалтай.
- Хөдөө орон нутгийн соёлын төвүүд, кино театрыг ашиглахгүй байна.

Хот суурин газруудын кино театрууд идэвхтэй ажилладаг ч хөдөө орон нутаг, суурин газраас алслагдсан газруудын соёлын төвүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй. Үүний улмаас хөдөө орон нутгийн хүмүүс орчин үеийн шинэ кинонуудыг цаг тухайд нь үзэж чадахгүй байна. Монголын кино үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмж хуучирсан тул дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй. Мөн тоног төхөөрөмжийн гаалийн татвар, НӨАТ маш өндөр зардалтай.

Шигтгээ 29: Аймгийн театр, сумын соёлын төвийн суудлыг эргэлтэд оруулах

Кино театр байхгүй аймгуудад кино театрын нэмэлт тоног төхөөрөмжөөр тоноглоод аймгийн театрууд дээр байгаа нөөц, суудлыг ашиглах хэрэгтэй. Мөн 330 суманд дор хаяж 200, 300 хүний суудалтай соёлын төвүүд байна. Эдгээр сумын аймгийн театр, соёлын төвүүдийн суудлыг эргэлтэд оруулж кино үйлдвэрлэгчдийн киног 21 аймаг, 330 суманд гаргах боломж байна.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Art house кино хийгдэх зардал өндөр, орлого ашиг бага байдаг.
- Арилжааны кино хийхэд санхүүгийн дэмжлэг, хөрөнгө оруулалт бага тул хурдацтай хөгжиж чадахгүй байдаг.
- Олон улсын кино наадамд оролцоход зардал их.
- Дотоодын кино наадмыг олон улсын хэмжээнд зохион байгуулахад төсөв санхүү дутмаг.
- Залуу уран бүтээлчдэд дэмжлэг байхгүй.

Art house кино нь олон нийтийг соён гэгээрүүлэх, түүх соёлоо хадгалж баримтжуулах гэх мэт олон ач холбогдолтой боловч хийгдэх зардал өндөр, ашиг орлого нь бага байдаг. Арилжааны кино хийхэд санхүүгийн дэмжлэг, хөрөнгө оруулалт бага тул хурдацтай хөгжиж чадахгүй байдаг. Олон улсын наадамд оролцоход зардал их байдаг. Дотоодын кино наадмыг олон улсын хэмжээнд зохион байгуулах нь олон улсын хамтын ажиллагаа болон кино үйлдвэрлэлийн чанарыг сайжруулах ч төсөв санхүү дутмаг байна. Шинэ залуу уран бүтээлчдэд дэмжлэг байхгүй.


МАРКЕТИНГ, СУРТАЛЧИЛГАА

- Гадаад зах зээл дээр бараа бүтээгдэхүүнээ гаргаж чаддаггүй.
- Бизнес эрхлэгчид бараа бүтээгдэхүүний онцлог, Монгол хэв маягийг дэлхийд таниулах, сурталчлахад зардал их, хүний нөөцийн чадавх хүрэлцэхгүй.

Киноны санаа, төсөл байгаа ч маркетинг, менежментийн үйл ажиллагаа муу дээрээс нь хөрөнгө оруулалт босгож чадахгүй байгаа учраас төслүүд хэрэгжихгүй байна. Кино урлагийн салбарт судалгаа, эдийн засгийн тооцоо муу байдаг. Ихэнх кино уран бүтээлчид өөрсдөө маркетинг менежментээ хийдэг. Цогцоор нь хийж чадах энэ тал дээр мэргэшсэн хүмүүс цөөхөн байдаг. ОУ-ын уралдаан наадамд оролцдоггүй тул олон улсын уран бүтээлчидтэй хамтран ажиллаж, маркетинг хийж чаддаггүй.

iii. Процессын зураглал

Кино урлагийн салбарын үйл ажиллагааны процессын зураглал дараах үндсэн 5 үе шатнаас бүрдэж байна.



5.6.2. Кино үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын статистик мэдээлэл

Тус бүлэгт Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа кино үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын тоо, кино театрын тоо, кино цэгийн тоо, танхимын тоо, дэлгэцийн тоо, суудлын тоо, үйлчилгээний нийт тоог бүс, аймаг, нийслэлээр задлан харуулна.

Хүснэгт 65: Кино үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын тоон мэдээлэл

	Үзүүлэлт	МД	2018	2019	2020
			А	Б	1
К-1. КИНО ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ, кино байгууллагаар					
Кино театрын нийт тоо					
			2		16
Дэлгэцийн төрлөөр	Дижитал дэлгэцтэй кино театрын тоо		3		25
	Нэг дэлгэцтэй кино театрын тоо		4		9
	2-7 дэлгэцтэй кино театрын тоо		5		16
	8 буюу түүнээс дээш дэлгэцтэй кино театрын тоо		6		
Танхимын нийт тоо					
			7		223
Дэлгэцийн нийт тоо					
			8		223
Суудлын нийт тоо					
			9	31,133	9,293
Кино цэгийн нийт тоо					
			10	113	174
К-2. КИНО ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ, үйлчилгээгээр					
Үйлчилгээний нийт тоо					
			11	3,916	1,481
Кино үзүүлэх үйлчилгээний нийт тоо					
			12	16,029	3,898
Бүтэц, хэлбэрээр	Уран сайханы		13	3,876	1,458
	Баримтат		14		22
Технологийн төрөл	2D		15	3,715	1,401
	3D		16	183	61




Үзүүлэлт		МД	2018	2019	2020
А		Б	1	2	3
Гаргасан киноны ангиллаар	Монгол	17		3,106	756
	Хамтарсан	18		177	3
	Гадаадын	19		615	703
	Түүхэн	20		110	25
	Хүүхэлдэйн	21		159	253
	Баримтат	22		48	4
	Хүүхдийн	23		471	94
	Бусад	24		3,110	1,086
Бусад үйлчилгээгээр	Бусад үйлчилгээ	25		18	19
	Кино наадам, өдөрлөг	26			18
К-3. КИНО ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ, үйлчлүүлэгчээр					
Нийт үйлчлүүлэгчид		28		1,879,703	1,284,199
Кино үзвэрийн үйлчлүүлэгчид		29		1,877,077	1,278,966
Үзэгчдийн төрлөөр	Хүүхэд	30	1,329,445	394,605	316,938
	Төлбөргүй	31		15,716	318
	Гадаад	32		22,444	84,532
	Тусгай бүлгийн	33		125,756	
	Хөгжлийн бэрхшээлтэй	34		1,515	
	Бусад	35		124,241	
Төрлөөр	Түүхэн	36		22,881	31,347
	Хүүхэлдэйн	37		250,336	161,982
	Баримтат	38		13,573	2,315
	Хүүхдийн	39		267,830	140,100
	Бусад	40		1,322,457	943,222
Бүтцээр	Уран сайхны	41		1,857,611	1,276,651
	Баримтат	42		19,466	2,315
Ангиллаар	Монгол	43		1,085,869	626,672
	Хамтарсан	44		2,119	1,601
	Гадаадын	45		789,089	650,693
	Бусад үйлчилгээгээр үйлчлүүлэгчид	46		2,626	5,233
К-4. КИНО ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ, урын сангаар					
Нийт урын санд байгаа кино бүтээл		47		1,307	1,493
Төрлөөр	Түүхэн	48		226	211
	Хүүхэлдэйн	49		23	53
	Баримтат	50		901	926
	Хүүхдийн	51		25	17
	Бусад	52		132	286
Бүтэц хэлбэрээр	Бүрэн хэмжээний	53		156	326
	Баримтат	54		9	26
	Хүүхдэд зориулсан	55		42	33
	Олон ангит	56		204	207
	Богино хэмжээний	57		896	901
Ангиллаар	Монгол	58		376	445
	Хамтарсан	59		842	846
	Гадаад кино	60		89	202
Технологийн төрлөөр	2D	61		1,306	1,447
	3D	62		1	46
Шинээр нэмэгдсэн кино /тайлант оны/		63		35	141
Ангиллаар	Монгол	64		18	63
	Хамтарсан	65		1	3
	Гадаад кино	66		16	75
К-5. КИНО ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ, киноны төрлөөр					
Нийт урын санд байгаа кино бүтээл		67		1,122	1,148
Үйлдвэрлэгдсэн нийт киноны тоо /тайлант оны/		68	12	49	23



Үзүүлэлт		МД	2018	2019	2020	
А		Б	1	2	3	
Төрлөөр	Монгол кино	69	12	45	23	
	Түүхэн	70		1		
	Хүүхэлдэйн	71	12			
	Баримтат	72		21	19	
	Хүүхдийн	73		18		
	Бусад	74		5	4	
	Хамтарсан кино	Хамтарсан кино	75		4	
Түүхэн		76				
Хүүхэлдэйн		77				
Баримтат		78		1		
Хүүхдийн		79				
Хугацаагаар	Олон ангит кино	81		3		
	Бүрэн хэмжээний	82		19	4	
	Богино хэмжээний	83	12	27	19	
Технологийн төрлөөр	Дижитал системээр хийгдсэн	84		34	23	
	Аналоги системээр хийгдсэн / хальсаар хийгдсэн /	85		15		
Киноны хэлний төрөл	Монгол	86	12	49	23	
	Бусад	87				
Санхүүжилтийн эх үүсвэрээр	100% дотоодын хөрөнгөөр хийгдсэн	88	12	21	19	
	50-аас дээш хувийг дотоодын хөрөнгөөр хийсэн	89		6	2	
	50 хувийг дотоодын хөрөнгөөр бүтээсэн	90		22		
	50-аас бага хувийг дотоодын хөрөнгөөр бүтээсэн	91			2	
К-6. КИНО ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ, киноны түгээлтээр						
Үйлдвэрлэгдсэн нийт киноны тоо /тайлант оны/		92		49	23	
Киноны түгээлтээр	Нээлт хийлгэхээс түдгэлзүүлсэн шинэ киноны тоо	93		1		
	Олон улсын уралдаанд оролцсон киноны тоо	94				
	Олон улсын уралдаанаас хүртсэн шагналын тоо	95		7		
	Кино театраар цацагдсан киноны тоо	96		21	2	
	Үндэсний олон нийтийн телевизээр цацагдсан киноны тоо	97		21		
	Арилжааны телевизээр цацагдсан киноны тоо	98		30	2	
	IPTV-ээр цацагдсан киноны тоо	99		74	15	
	OTT болон бусад сувгаар цацагдсан киноны тоо	100		1	2	
	Цацагдаагүй киноны тоо	101			3	
	Уран сайхны киноны тоо	102		24	4	
	Баримтат киноны тоо	103		10	19	
	К-7. КИНО ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН МЭДЭЭ, албан тушаал, насны бүлгээр					
	Баталсан орон тоо		104		669	654
Нийт ажиллагчдын тоо		105	888	666	646	
Үүнээс: Эмэгтэй		107	547	464	346	
Ажиллагчдын төрлөөр	Мэргэжлийн	108		206	239	
	Төр, засгийн шагналтан	109		51	16	
	Хөгжлийн бэрхшээлтэй	110		51	2	
	Эмэгтэй	111		29		

Үзүүлэлт		МД	2018	2019	2020
А		Б	1	2	3
Албан тушаалын ангиллаар	Захиргаа, аж ахуйн	112	581	295	222
	Эмэгтэй	113	416	194	134
	Мэргэжлийн ажиллагчид	114	307	49	85
	Эмэгтэй	115	131	3	3
	Уран бүтээлчид	116		32	32
	Эмэгтэй	117		3	3
	Үйлчилгээний ажиллагчид	118		289	306
	Эмэгтэй	119		264	206
	Түр хугацаагаар ажиллагчид (гэрээт)	120		1	1
Эмэгтэй	121				
Насны бүлгээр	25 хүртэлх	122	30	318	118
	Эмэгтэй	123	26	288	79
	25-34	124	113	193	263
	Эмэгтэй	125	85	110	146
	35-44	126	373	88	180
	Эмэгтэй	127	170	38	83
	45-54	128	270	55	75
	Эмэгтэй	129	211	20	33
	55-59	130	91	7	3
	Эмэгтэй	131	48	6	3
60+	132	11	5	7	
Эмэгтэй	133	7	2	2	
К-8. КИНО ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГЧДЫН МЭДЭЭ, боловсролын түвшнээр					
Нийт ажиллагчдын тоо		134	888	613	-
Үүнээс: Эмэгтэй		135	547	430	-
Боловсролын түвшнээр	Боловсролгүй	136			
	Эмэгтэй	137			
	Бага	138	22		
	Эмэгтэй	139	9		
	Суурь	140	34	1	3
	Эмэгтэй	141	25	1	2
	Бүрэн дунд	142	60	222	149
	Эмэгтэй	143	45	201	95
	Техникийн болон мэргэжлийн	144	162	21	41
	Эмэгтэй	145	129	4	7
	Тусгай мэргэжлийн дунд	146	248	31	14
	Эмэгтэй	147	124	8	3
	Дипломын болон бакалаврын дээд	148	308	379	433
	Эмэгтэй	149	190	245	236
	Магистр	150	50	11	5
Эмэгтэй	151	23	5	3	
Доктор	152	2	1	1	
Эмэгтэй	153	2			
К-9. КИНО ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН БОРЛУУЛАЛТЫН МЭДЭЭ, нийт борлуулалтын орлого					
Кино үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын борлуулалтын орлого, тэрбум төгрөг		154			852.5

Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик мэдээлэл


i. Кино үзүүлэх үйлчилгээний тоо


Кино цэгүүдэд кино үзүүлсэн тоогоор кино үзүүлэх үйлчилгээний тоог тодорхойлно. 2019-2020 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд кино үзүүлсэн үйлчилгээний тоог дараах графикт дүрсэлж байна.

2019 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд 3,898 кино үзүүлэх үйлчилгээ үзүүлсэн бол 2020 онд 1.462 болж 2,7 дахин буурсан байна.

Байршлын хувьд орон нутагт кино үзүүлэх үйлчилгээний тоо Улаанбаатар хоттой харьцуулахад 3-4 дахин өндөр байна.

График 79: Кино үзүүлэх үйлчилгээний тоо, бүс, нийслэлээр


Кино театрын тоо


Киноны зориулалтын барилга байгууламжид 3-аас дээш үзвэрийн танхим, 1000 -аас дээш суудлын тоо бүхий олон улсын шаардлагад нийцэх кино үйлчилгээний байгууллагыг кино театр гэж тодорхойлно. Кино театрын тоог тооцох арга зүйн хувьд тухайн жилд үйл ажиллагаа явуулсан кино театруудын тоогоор тодорхойлно.

Дараах хүснэгтэд кино театрын тоог 2019-2020 оны байдлаар харуулав. Улсын хэмжээнд 2019 онд 16, 2020 онд 15 кино театр үйл ажиллагаа явуулжээ.



Хүснэгт б6: Кино театрын тоо, бүс, аймаг, нийслэлээр

Бүс, аймаг, нийслэл	2019	2020
Баруун бүс		
Хангайн бүс	4	3
Төвийн бүс	1	1
Зүүн бүс		
Улаанбаатар	11	11
Улсын дүн	16	15

Кино театрын суудлын тоо


Нийт кино театрын суудлын тоо Монгол Улсын хэмжээнд 2019 онд 9,293 байсан бол 2020 онд 9,368 болж өссөн байна. Бүсээр нарийвчлан харвал Улаанбаатар хотод өсөлттэй боловч орон нутагт кино театрын суудлын тоо буурсан байна.


График 80: Кино театрын суудал, нийт дүнд эзлэх хувь, байршлаар


ii. Кино үзвэрийн үйлчлүүлэгчдийн тоо


Тухайн жилд кино театр, суурин кино цэг, нүүдлийн кино цэгийн зааланд ирж кино үзсэн хүний тоогоор кино үзвэрийн үйлчлүүлэгчдийн тоог илэрхийлнэ.

Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар 1.9 сая орчим үйлчлүүлэгч кино үзвэр үзсэн бол 2020 оны байдлаар 1.3 сая орчим болж 500 мянган үзэгчээр буурсан байна.

График 81: Кино үзвэрийн үйлчлүүлэгчид, нийт дүнд эзлэх хувь, байршлаар



Улаанбаатар хотын үзэгчид 2019 онд нийт үзэгчдийн 83 хувийг, 2020 онд 94 хувийг эзэлж байна.

Үзэгчдийн төрлөөр


Хүснэгт 67: Кино үзэгчдийн тоо, төрлөөр

Үзэгчдийн төрөл	2019		2020	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хүүхэд	394,605	21%	316,938	25%
Төлбөргүй	15,716	1%	318	0%
Гадаад	22,444	1%	84,532	7%
Тусгай бүлгийн	125,756	7%		
Хөгжлийн бэрхшээлтэй	1,515	0%		
Бусад	124,241	7%		

Кино үзвэрийн үйлчлүүлэгчдийг хүүхэд, төлбөргүй үзэгч, гадаадын, тусгай бүлгийн, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг ангиллаар дараах хүснэгтэд харуулав. Хүүхэд 2019 оны байдлаар нийт үзэгчдийн 21 хувийг, 2020 онд 25 хувийг эзэлж байв. Тусгай бүлгийн үзэгчид 2019 онд 7 нийт үзэгчдийн 7 хувийг эзэлж байжээ. 2020 онд гадаадын үзэгчдийн нийт үзэгчдийн тоонд эзлэх хувь 6 хувиар өссөн байна.

Киноны төрлөөр


График 82: Кино үзвэрийн үйлчлүүлэгчдийн тоо, киноны төрлөөр



Кино үзвэрийн үйлчлүүлэгчдийн 24-30 орчим хувь хүүхдийн болон хүүхэддэйн кино, 1-2 хувь баримтат болон түүхэн кино, үлдсэн 70 гаруй хувь бусад төрлийн кино үзэж байна.

Киноны бүтцээр


График 83: Кино үзвэрийн үйлчлүүлэгчдийн тоо, киноны бүтцээр



Кино үзвэрийн үйлчлүүлэгчдийн тоог киноны бүтцээр авч үзвэл улсын хэмжээнд уран сайхны кино үзэх хандлага 100 хувь орчим байна. Кино театрт баримтат кино үзэх байдал 1 хүрэхгүй хувийг эзэлж байна.

Киноны ангиллаар

График 84: Кино үзвэрийн үйлчлүүлэгчдийн тоо, киноны ангиллаар



Кино ангиллаар кино үзэгчдийн тоог задлан харвал нийт Монгол киног үзэх байдал 2019 онд 60 орчим хувь, гадаадын киног үзэх байдал 42 хувь байсан бол 2020 онд гадаадын киног үзэх хувь нэмэгдэж, Монгол кино үзэх хувь буурсан байна. Хамтарсан киног үзэх байдал сүүлийн хоёр жил дараалан 0,1 хувь орчим байна.


iii. Урын санд байгаа кино бүтээлийн тоо



Монгол Улсын урын санд байгаа кино бүтээлийн тоо 2019 онд 1,307, 2020 онд 1,493 тус тус бүртгэгджээ.

Урын санд байгаа кино бүтээлийн тоо, киноны төрлөөр

График 85: Урын санд байгаа кино бүтээлийн тоо, киноны төрлөөр




Урын санд байгаа кино бүтээлийн тоог киноны төрлөөр задлан харвал сүүлийн хоёр жилд нийт киноны 60-70 орчим хувийг баримтат кино, 14-17 хувийг түүхэн кино, 4-5 хувийг хүүхэддэйн болон хүүхдийн кино, үлдсэн хувийг бусад төрлийн кино эзэлж байна.

Урын санд байгаа кино бүтээлийн тоо, киноны бүтэц хэлбэрээр

Урын санд байгаа кино бүтээлийг бүтэц хэлбэрээр нь дараах 3 үзүүлэлтээр авч үзнэ. Үүнд, богино хэмжээний, бүрэн хэмжээний, олон ангит зэрэг хэлбэрүүд багтаж байна.


График 86: Урын санд байгаа кино бүтээлийн тоо, киноны бүтэц хэлбэрээр



Урын санд байгаа кино бүтээлийн тоог киноны бүтэц хэлбэрийн хувьд богино хэмжээний, бүрэн хэмжээний, олон ангит, хүүхдэд зориулсан, баримтат гэж ангилж үздэг байна. Тус ангиллын хүрээнд богино хэмжээний киноны нийт урын санд эзлэх хувь хамгийн өндөр буюу 60-70 орчим хувь байна.

Урын санд байгаа кино бүтээлийн тоо, киноны ангиллаар

График 87: Урын санд байгаа кино бүтээлийн тоо, киноны ангиллаар




Монгол Улсын хэмжээнд нийт урын санд байгаа кино бүтээлийн 30 орчим хувийг Монгол кино, 60 орчим хувийг гадаадын кино, 7-14 хувийг хамтарсан кино эзэлж байна. 2020 оны байдлаар хамтарсан киноны эзлэх хувь хоёр дахин өсжээ.

Урын санд байгаа кино бүтээлийн тоо, технологийн төрлөөр

Урын санд байгаа кино бүтээлийг технологийн төрлөөр нь 2D, 3D гэж ангилж үзнэ.

График 88: Урын санд байгаа кино бүтээлийн тоо, технологийн төрлөөр




Урын санд байгаа кино бүтээлийн дийлэнх хэсгийг 2D технологийн кино эзэлж байгаа бөгөөд 2020 онд 3D киноны эзлэх хэмжээ 3 хувьд хүрч өсжээ.

Шинээр нэмэгдсэн киноны тоо, киноны ангиллаар



Тайлант онд урын санд шинээр нэмэгдсэн киноны тоог авч үзвэл 2019 онд 35 кино, 2020 онд 141 кино шинээр нэмэгдсэн байна.

График 89: Шинээр нэмэгдсэн киноны тоо, киноны ангиллаар




Киноны ангиллаар нарийвчлан харвал гадаад киноны эзлэх хувь 2020 онд 7 хувиар нэмэгджээ.

iv. Үйлдвэрлэгдсэн киноны тоо

Үйлдвэрлэсэн киноны тоог тодорхойлохдоо тухайн жилд шинээр үйлдвэрлэсэн уран сайхны кино, хүүхдийн кино, баримтат кино, сургалт сурталчилгааны киноны нийт дүнгээр тодорхойлно.

Үйлдвэрлэсэн кино=Уран сайхны+Хүүхдийн+Баримтат+Сургалт, сурталчилгааны кино



Монгол Улсын хэмжээнд шинээр үйлдвэрлэсэн киноны тоо 2019 онд 49, 2020 онд 23 байжээ.

Киноны төрлөөр

Кино төрлүүдэд монгол кино, баримтат кино, хүүхдийн кино, түүхэн кино, хүүхэлдэйн кино, бусад төрлийн кино багтана.

График 90: Үйлдвэрлэсэн киноны тоо, киноны төрлөөр




Сүүлийн хоёр жилийн хугацаанд шинээр үйлдвэрлэсэн киноны төрлийг дээрх графикт дүрсэллээ. 2019 онд нийт үйлдвэрлэсэн 49 киноноос 45 нь Монгол кино байсан бөгөөд үүний тал орчим нь баримтат кино байжээ. 2020 онд нийт үйлдвэрлэсэн кино бүгд Монгол кино байв. Дээрх хугацаанд хүүхэлдэйн кино үйлдвэрлэгдээгүй боловч 2019 онд 18 хүүхдийн кино үйлдвэрлэгджээ. Мөн тус онд түүхэн кино нэгийг үйлдвэрлэсэн байна.

Киноны бүтэц хэлбэрээр

Үйлдвэрлэсэн кинонуудыг киноны бүтэц хэлбэрээр богино хэмжээний, бүрэн хэмжээний, олон ангит гэж ангилдаг.

График 91: Үйлдвэрлэсэн киноны тоо, киноны бүтэц хэлбэрээр




Шинээр үйлдвэрлэсэн киноны бүтэц хэлбэрээр ангилан харвал 2019 онд богино хэмжээний кино 55 хувийг эзэлж байсан бол 2020 онд 83 хувийг эзэлж байна. Бүрэн хэмжээний кино 2019 онд 39 хувийг эзэлж байсан бол 2020 онд 17 хувийг эзэлж байна. Олон ангит кино 2019 онд 6 хувийг эзэлж байсан ба 2020 онд тус төрлийн кино хийгдээгүй ажээ.

Технологийн төрлөөр

Үйлдвэрлэсэн киног технологийн төрлөөр ангилахдаа дижитал системээр хийгдсэн, аналог системээр хийгдсэн /хальсаар хийгдсэн/ гэж хоёр ангилдаг.

График 92: Үйлдвэрлэсэн киноны тоо, технологийн төрлөөр



Үйлдвэрлэсэн киноны технологийн төрлийг харвал 2019 онд голчлон аналог системээр кино хийдэг байсан бол 2020 онд хийгдсэн 23 кино бүгд дижитал системээр хийгдсэн байна.

Киноны хэлний төрлөөр

Киноны хэлний төрлийн хувьд 2019-2020 онд үйлдвэрлэсэн кинонууд бүгд Монгол хэлээр үйлдвэрлэгдсэн байна.


100%

Үйлдвэрлэсэн киноны хэлний төрөл

Санхүүжилтийн эх үүсвэрээр

Үйлдвэрлэсэн кинонуудыг санхүүжилтийн эх үүсвэрээр 100% дотоодын хөрөнгөөр хийгдсэн, 50-аас дээш хувийг дотоодын хөрөнгөөр хийсэн, 50 хувийг дотоодын хөрөнгөөр бүтээсэн, 50-аас бага хувийг дотоодын хөрөнгөөр бүтээсэн гэж ангилна.

График 93: Үйлдвэрлэсэн киноны тоо, санхүүжилтийн эх үүсвэрээр



Үйлдвэрлэсэн киноны тоог санхүүжилтийн эх үүсвэрээр ангилбал 2019 оны байдлаар 43 хувь нь 100% дотоодын хөрөнгөөр санхүүжиж байсан бол 2020 оны байдлаар тус үзүүлэлт 83 хувь болж өсжээ. Киноны санхүүжилтийн 50 хувийг дотоодын хөрөнгөөр санхүүжүүлэх байдал 2019 онд 45 хувь байсан бол 2020 онд 9 хүртэл буурчээ.

Нээлт хийлгэхээс түдгэлзүүлсэн киноны тоо

Шинээр үйлдвэрлэсэн кинонуудаас 2019 онд нэг киног нээлт хийлгэхээс түдгэлзүүлж байжээ.

1 КИНО

2019 онд нээлт хийлгэхээс түдгэлзүүлсэн

Монгол Улсад шинээр үйлдвэрлэсэн кинонуудаас сүүлийн хоёр жилд олон улсын уралдаан наадмаас шагнал хүртсэн тооны хувьд 2019 онд 7 шагнал хүртэж байв.




Олон улсын уралдаан наадмаас шагнал хүртсэн тоо

Киноны цацалтын тоо, түгээлтийн сувгийн төрлөөр

Шинээр үйлдвэрлэсэн киноны түгээлтийн сувгийг кино театр, үндэсний олон нийтийн телевиз, арилжааны телевиз, IPTV, OTT гэж авч үзнэ.

График 94: Киноны тоо, кино түгээлтийн сувгийн төрлөөр



Дотоодын үйлдвэрлэгдсэн киноноос кино түгээлтийн сувгуудаар цацагдсан байдлыг сүүлийн хоёр жилийн байдлаар дээрх графикт харууллаа.

Үйлдвэрлэгдсэн кинонуудаас IPTV-ээр цацагдсан байдал бусад түгээлтийн сувагтай харьцуулахад сүүлийн хоёр жилд хамгийн өндөр байна. Кино театраар цацагдсан байдлыг харвал 2019 онд 21 кино, 2020 онд 2 кино цацагдсан байна.

Үйлдвэрлэгдсэн киноны тоо, киноны бүтцээр

Үйлдвэрлэгдсэн киноны тоог киноны бүтцээр нь уран сайхны кино, баримтат кино гэж авч үзнэ.

График 95: Үйлдвэрлэсэн киноны тоо, киноны бүтцээр



2019 онд нийт 24 уран сайхны кино, 10 баримтат кино үйлдвэрлэгдсэн байна. 2020 оны байдлаар 4 уран сайхны кино, 19 баримтат кино үйлдвэрлэгджээ.

v. Кино үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын ажиллагчдын тоо мэдээлэл

Кино үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын ажиллагчдын тоо мэдээллийг сүүлийн хоёр жилээр энэ бүлэгт танилцуулж байна.

Нийт ажиллагчдын тоо:




Кино үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын ажиллагчдын баталсан орон тоо 2019 онд 669 байснаас 666 ажиллагчид бүртгэгдсэн байна. 2020 оны байдлаар баталсан орон тоо 654 байснаас 646 ажиллагчид бүртгэгджээ.

Кино үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад ажиллагчдын мэргэжлийн, төр засгийн шагналтан, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг үзүүлэлтээр харуулав. Нийт ажиллагчдын 30 гаруй хувь мэргэжлийн ажиллагчид байх ба 2020 онд төр засгийн шагналтан, хөгжлийн

бэрхшээлтэй ажиллагчдын эзлэх хувь буурчээ.

График 96: Мэргэжлийн болон захиргааны ажилчдын тоо, нас, хүйсээр



2019 онд нийт ажиллагчдын 70 хувийг эмэгтэй ажиллагчид эзэлж байв.



2020 онд нийт ажиллагчдын 54 хувийг эмэгтэй ажиллагчид эзэлж байв.



Хүснэгт 68: Кино үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын ажиллагчдын тоо


Үзүүлэлт	2019	2020
Баталсан орон тоо	669	654
Нийт ажиллагчдын тоо	666	646
Үүнээс: Эмэгтэй	464	346
Мэргэжлийн	206	239
Төр, засгийн шагналтан	51	16
Хөгжлийн бэрхшээлтэй	51	2
Үүнээс: Эмэгтэй	29	-

Үзүүлэлт	2019	2020
Албан тушаалын түвшнээр		
Захиргаа, аж ахуйн	295	222
Үүнээс: Эмэгтэй	194	134
Мэргэжлийн ажиллагчид	49	85
Үүнээс: Эмэгтэй	3	3
Уран бүтээлчид	32	32
Үүнээс: Эмэгтэй	3	3
Үйлчилгээний ажиллагчид	289	306
Үүнээс: Эмэгтэй	264	206
Түр хугацаагаар ажиллагчид (гэрээт)	1	1
Үүнээс: Эмэгтэй	-	-
Насны ангиллаар		
25 хүртэлх	318	118
Үүнээс: Эмэгтэй	288	79
25-34 нас	193	263
Үүнээс: Эмэгтэй	110	146
35-44 нас	88	180
Үүнээс: Эмэгтэй	38	83
45-54 нас	55	75
Үүнээс: Эмэгтэй	20	33
55-59 нас	7	3
Үүнээс: Эмэгтэй	6	3
60+ нас	5	7
Үүнээс: Эмэгтэй	2	2
Боловсролын түвшнээр		
Боловсролгүй	-	-
Үүнээс: Эмэгтэй	-	-
Бага	-	-
Үүнээс: Эмэгтэй	-	-
Суурь	1	3
Үүнээс: Эмэгтэй	1	2
Бүрэн дунд	222	149
Үүнээс: Эмэгтэй	201	95
Техникийн болон мэргэжлийн	21	41
Үүнээс: Эмэгтэй	4	7
Тусгай мэргэжлийн дунд	31	14
Үүнээс: Эмэгтэй	8	3
Дипломын болон бакалаврын дээд	379	433
Үүнээс: Эмэгтэй	245	236
Магистр	11	5
Үүнээс: Эмэгтэй	5	3
Доктор	1	1
Үүнээс: Эмэгтэй	-	-


Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик

Боловсролын түвшнээр, 2020 оны байдлаар:


Суурь болон бүрэн дунд



Техникийн болон тусгай мэргэжлийн дунд



Дипломын болон дээд боловсролын



Эх үүсвэр: Соёлын яам, Соёлын статистик




СОЁЛЫН ЯАМ

vi. Салбарын төгсөгчдийн тоо мэдээлэл

Кино урлагийн салбарын 2019-2020 оны хичээлийн жилд суралцаж төгссөн оюутны тоо мэдээлэл:

График 97: Кино урлагийн салбарын төгсөгчдийн нийт СБУ-ийн төгсөгчдийн тоонд эзлэх хувь



5 их, дээд сургууль 21 ХӨТӨЛБӨР


Кино урлагийн салбарт 2019-2020 оны хичээлийн жилд 32 оюутан суралцаж төгссөн ба энэ нь нийт соёлын салбарын төгсөгчдийн 1 хувийг бүрдүүлж байна.

График 98: Кино урлагийн салбарын төгсөгчид, боловсролын зэрэг, хүйсээр, 2019-2020 оны хичээлийн жилд

Боловсролын зэрэг



Хүйс



Эх үүсвэр: БШУЯ, "Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн тоо мэдээлэл"

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Media





Телевиз бол
гурав дахь эцэг
ЭХ ЮМ.

Америкийн архитектор
Р.Букминстер Фуллер



Эдийн засгийн үр өгөөж

Хялбар аргаар боловсрол олгодог.	Гэр бүлтэйгээ ойр дотно харилцаатай байна.	
Цаг үеийн мэдээллээс хоцрохгүй.	Стресс тайлна.	Шинэ хэл сурахад тусална.
Соёлын талаар мэдлэгтэй болно.		

2019 онд орон нутгийн арилжааны телевиз, радио үйлдвэрлэл нь 1.17 их наяд долларыг Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ), 2.47 сая ажлын байрыг Америкийн эдийн засагт шууд болон шууд бус замаар бий болгосон байна.

Судалгаагаар орон нутгийн телевиз, радио, зар сурталчилгаа, нэвтрүүлгийн ажлын байрыг багтаасан орон нутгийн арилжааны өргөн нэвтрүүлгийн шууд ажил эрхлэлт нь 318,000 гаруй ажлын байртай бөгөөд жил бүр 53 тэрбум гаруй долларын эдийн засгийн үр ашиг авчирдаг болохыг тогтоожээ. Өргөн нэвтрүүлгийн телевиз нь эдгээр ажлын байрны 188,000 гаруй нь ба ДНБ-ий 31 тэрбум гаруй долларыг дангаараа бүрдүүлдэг. Радио нь 130,000 гаруй хүнийг ажлын байраар хангадаг бөгөөд ДНБ -ий 21 тэрбум долларыг бүрдүүлдэг (Study Finds Local TV And Radio Industry Creates \$1.17 Trillion In Economic Activity Annually, 2019).

5.7. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

5.7.1. Хэвлэл мэдээллийн салбар

1895 онд Гуглиемо Маркони хэмээх Итали залуу эцэг эхийнхээ дээврийн хөндийд туршилт хийж байхдаа “утасгүй цахилгаан утас” гэх нэгэн зүйлийг нээсэн нь өнөөгийн бидний мэдэх радио салбарын эхлэл байв. Харин анхны телевиз 1927 онд танилцуулагдаж байжээ. Телевизийг 14 нас хүртлээ ямар цахилгаангүй амьдарч байсан 21 настай зохион бүтээгч Фило Тейлор Фарнсворт зохион бүтээсэн байна (Pruitt, 2021).

Өдөр бүр дэлхийн сая сая хүмүүс радио сонсож, телевиз үзэж байна. Тэгвэл энэ нь эдийн засаг болон нийгэмд ямар үр нөлөөтэй вэ?

Нийгмийн үр өгөөж

Давуу талууд

Америк хүн өдөр бүр 4 цагаас илүү телевиз үздэг (эсвэл долоо хоногт 28 цаг, эсвэл жилд 2 сар тасралтгүй ТВ үздэг). Харин Канад хүмүүс долоо хоногт дунджаар 30 цаг зурагт үздэг байна. Тэгэхээр, телевиз үзэхэд ямар нэгэн давуу тал бий юу? (Gill-in, 2019)



i. Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбарын давуу тал онцлог, боломж.

- **Хэвлэл мэдээллийн салбарын хамрах хүрээ**

Монгол Улсад телевизийн салбар үүсэж хөгжөөд 54 жил, радио үүсэж хөгжөөд хэдийнээ 87 жил өнгөрсөн байна 2020 оны байдлаар 140 телевизийн суваг, 51 ФМ, радио, 84 сонин, 73 сэтгүүл болон 154 цахим хуудас үйл ажиллагаа явуулж байна.



- **Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбарын зохицуулалт**

Монголын хэвлэл мэдээлэл, телевиз, радио салбарт дараах газрууд зохицуулалт хийдэг.

Соёлын яам: Нийгмийг соён гэгээрүүлэх, мэдлэг мэдээллийг түгээх, үндэсний контентыг бүтээх, сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлж байгаа эсэх, СБҮ-ийн хувьд уялдаа холбоог хангах, Монгол контентыг бүтээх сангийн зохицуулалтыг хийх.

Хууль зүй, дотоод хэргийн яам: Хууль журмын дагуу ажиллаж байгаа эсэх, хууль журмын зохицуулалт гаргах, хэрэгжилтэд хяналт тавих.



Харилцаа холбооны зохицуулах хороо: Тусгай зөвшөөрөл олгох; Харилцаа холбооны журам, зохицуулалтын дагуу нэвтрүүлэг, мэдээ мэдээлэл түгээгдэж байгаа эсэхэд хяналт тавих.



Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газар: Харилцаа холбоо, мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавих.

Оюуны өмчийн газар: Оюуны өмч, зохиогчийн эрхийг хүндэлж буй эсэхэд хяналт тавих.

- **Хэвлэл мэдээллийн мэргэжлийн холбоод**

Монголын хэвлэл мэдээлэл, телевиз, радио салбарт Монголын телевизүүдийн холбоо, хэвлэлийн хүрээлэн, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл гэсэн хэвлэл мэдээллийн мэргэжлийн холбоод үйл ажиллагаа явуулж байна.



Монголын телевизүүдийн холбоо нь 2005 онд байгуулагдсан бөгөөд өргөн дэлгэцийн 18 сувагтай хамтарч ажилладаг. Телевиз бүртээ байгуулсан гэрээний дагуу хэрэглэгчийн төлбөрийг хуваарилдаг. Мөн оюуны өмчийн зөвлөл дэргэдээ ажиллуулдаг. Тус холбоо жил бүр “Алтан шонхор” теле наадмыг зохион байгуулдаг.



Хэвлэлийн Хүрээлэн нь Монгол Улсад хараат бус бие даасан хэвлэл мэдээллийг дэмжин хөгжүүлэх зорилго бүхий “Чөлөөт хэвлэл” төслийн хүрээнд 1996 онд анх байгуулагдсан юм. Эл төслийг Монгол, Данийн засгийн газрын хэлэлцээрийн дагуу Данийн Олон Улсын Хөгжлийн Агентлагийн буцалтгүй тусламжаар санхүүжүүлсэн байна (Бидний тухай, 2021).



МОНГОЛЫН СЭТГҮҮЛЧДИЙН
НЭГДСЭН ЭВЛЭЛ

Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл нь 1951 онд байгуулагдсан ба сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн холбоодын сайн дураараа эвлэлдэн нэгдсэн гишүүнчлэл бүхий төрийн бус, үндэсний хэмжээний мэргэжлийн төв байгууллага юм. 4000 гишүүнтэй 21 аймаг, 2 хотод нийт 23 салбар зөвлөлтэй (Түүхэн замнал, 2019).

• **Монголын радио, телевиз**



Монголын үндэсний олон нийтийн радио телевиз нь 1967 онд байгуулагдаж байсан монголын ууган телевизийн суваг юм. МҮОНРТ нь радиогийн 3 суваг, телевизийн 5 суваг болон 1 цахим хуудастай/mnb.mn/.

Монгол Улсын түүхийн сүүлийн 50 жилийг хамтдаа бичилцсэн МҮОНРТ нь ард түмнийхээ нийтлэг эрх ашгийг дээдэлж, “Олон нийтийн радио, телевизийн тухай” хуулийн дагуу улс төр, эдийн засаг, Соёлын өв, зан заншил, урлаг соёл, цэнгээнт, танин мэдэхүйн өргөн хүрээтэй хөтөлбөрийн бодлого явуулдаг. Үндэсний Телевиз өдөрт 17 цаг, 7 хоногт 119 цагийн хөтөлбөрийг бэлтгэн хүргэж байна (ҮНДЭСНИЙ ТЕЛЕВИЗ).

• **Бусад телевизийн суваг, сонин**



Монгол Улсад өргөн нэвтрүүлгийн нийт 18 телевиз байдаг.

• **Хэвлэл мэдээллийн салбарын ковид-19-ийн эерэг нөлөө**

Зайнаас ажиллах болсон: Өртөг, цаг хэмнэж ярилцлагуудыг зайнаас хийх болж, хурд нэмэгдсэн.

Дижитал медиа илүү хөгжсөн: Илүү хурдан дижитал шилжилт хийгдсэн, Вэбсайт болон сошиал илүү хөгжиж байна.

Албан ёсны мэдээллийн эх сурвалжийг ашиглаж эхэлсэн: Иргэд албан ёсны мэдээ мэдээллийг авах ёстой гэдгээ ойлгож эхэлсэн.

ii. **Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбарт тулгамдаж буй асуудал бэрхшээл**

Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбарт тулгамдсан асуудлуудыг хүний нөөц, эко орчин, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон маркетинг, борлуулалт гэсэн таван чиглэлийн хүрээнд тодрууллаа.

Монголын хэвлэл мэдээллийн салбарын хүний нөөцөд хэд хэдэн томоохон асуудлууд тулгамдаж байна. Сэтгүүл зүйн сургуулийг жил бүр маш олон оюутнууд төгсөж, сэтгүүлч мэргэжлийг эзэмшиж байна. Гэвч ихэнх төгсөгчид гадаад хэлний мэдлэггүй, тогтвор суурьшилтай ажилладаггүй учраас чанарын шаардлага хангаж чадахгүй байна. Хэвлэл, мэдээллийн салбарт ажиллагсдын цалин бага, ажлын нөхцөл хүнд байдаг. Редактор мэргэжилтэй хүмүүс маш цөөхөн байгаагаас гадна редакцын хяналт бага байдаг. Продюсер, телевизийн найруулагч, редактор, зураглаач гэх мэт мэргэжилтэй хүмүүс хэвлэл, мэдээллийн салбарт дутагдаж байна.

ХҮНИЙ НӨӨЦ

- Сэтгүүлч тоо их, чанар бага.
- Редакторууд маш цөөхөн, редакцын хяналт бага байдаг.
- Продюсер, телевизийн найруулагч, редактор, зураглаач гэх мэт мэргэжил хомс.

Шигтгээ 30: Сэтгүүл зүйн сургалтыг сайжруулах

Сэтгүүл зүйн их дээд сургуулиуд хэвлэл мэдээллийн байгууллагуудын шаардлагыг хангах хэмжээний боловсон хүчнийг бэлтгэж чадахгүй байна. Яагаад гэхээр, онол болон практик нь онол дээр суурилсан учраас практик мэдлэг чадварыг бол өгөхгүй. Дээрээс нь орчин үеийн мэдлэг чадварыг өгөхгүй байгаад байна. Орчин үед хэвлэл мэдээллийн салбар чинь их өөр болчихсон.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

ЭКО СИСТЕМ

- Монголын хэвлэл мэдээллийн салбар нэр хүнд муутай байдаг.
- Оюуны өмчийн асуудал
- Нэгдсэн бодлого зохицуулалт муу.
- Соён гэгээрүүлэх үндсэн үүрэг алдагдсан.

Монгол Улсад хэвлэл мэдээллийн салбар нэр хүнд муутай байдаг. Иргэд ихэнх хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хараат бус байж чаддаггүй гэж үздэг. Оюуны өмчийн аюулгүй байдал бүрэн хангагдаагүй байдаг. Хэвлэл, мэдээллийн нэгдсэн бодлого зохицуулалт байдаггүй. Телевизүүдийн үндсэн үүргийн нэг болох соён гэгээрүүлэх үүрэг алдагдсан. Мөн бусад салбаруудтай уялдаа холбоо багатай, редакцын хяналт муутай байдаг.

ДЭД БҮТЭЦ

- Орон нутгийн телевиз, радио оршин тогтнох эсэх аюулд орсон.

Өргөн дэлгэцийн томоохон телевизүүд үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж, олон үзэгчидтэй болж байгаа хэдий ч орон нутгийн телевиз, радио оршин тогтнох эсэх аюулд ороод байна.

Шигтгээ 31: Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага оршин тогтноход хэцүү

Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл Монголын нөхцөлд өөрөө бие даан оршин тогтнох ямар ч чадвар байхгүй. Хүн амын тал хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн 90 орчим хувь нь Улаанбаатарт байршиж ажиллаж байгаа. Арав орчим хувь нь орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл байдаг. Өөрөөр хэлбэл, аймагтаа ажиллаж байгаа сонин, радио, телевиз, орон нутгийн сайт юм уу тэнд ажилладаг мэдээллийн сайт гэж бараг л байхгүй байгаа.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Хөрөнгө оруулалт ил тод биш.
- Хувийн мэдээллийн хэрэгсэл хяналтгүй байдаг.
- Зар сурталчилгааны орлого багассан.


Хэвлэл мэдээллийн салбарын ковид-19-ийн сөрөг нөлөө

Үйл ажиллагаа багассан: Хөл хориотой холбоотойгоор эвэнт, хэвлэл мэдээллийн салбарын ковид-19 нөлөөт арга хэмжээ, үйл ажиллагаанууд хумигдсан.

Хуурамч мэдээлэл ихэссэн: Хуурамч мэдээ ихээр тархсан.

Сайн контент бэлдэх боломжгүй: Олон хүн цуглахыг хориглосноор сайн контент бүтээх боломж хомс болсон, үндэсний контент багассан.

iii. Процессын зураглал



5.7.2. Хэвлэл мэдээллийн статистик

Монголын хэвлэл мэдээллийн салбарын тухай сүүлийн үеийн мэдээлэл бүхий “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр” эмхэтгэлийг Хэвлэлийн хүрээлэнгээс 1999 оноос хойш Англи, Монгол хэлээр хэвлэн гаргаж байгаа бөгөөд уг тайланг үндсэн эх сурвалж болгон ашиглалаа.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо:

Монгол Улсад 2020 оны байдлаар 513 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байжээ. 2020 онд өмнөх он (2019)-той сонин, сэтгүүл, телевизийн тоо буурч, радиогийн тоо өөрчлөлтгүй, мэдээллийн сайтын тоо нэмэгджээ.

Хүснэгт 69: Монгол Улсад тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо

	2015	2016	2017	2018	2019	2020
Сонин	101	89	88	92	84	78
Сэтгүүл / эмхэтгэл	86	80	71	78	73	69
Радио	69	56	48	50	51	51
Телевиз	131	125	127	128	140	137
Мэдээллийн сайт	98	96	100	109	154	178
Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийт тоо	485	446	434	457	502	513


Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл – Өнөөдөр”

Монгол Улс дахь хэвлэл мэдээллийн байгууллагын 72% нь хувийн аж ахуйн нэгжийн, 17% нь ТББ-ын, 6.5% нь төрийн байгууллагын, 4% нь улс төрийн нам, эвслийн харьяаллынх байсан бол 0.5% нь олон нийтийн байгууллагынх байжээ. Телевизийн салбарт хувийн аж ахуйн нэгжийн мэдээллийн хэрэгсэл давамгайлж байгаа бол сэтгүүлийн салбарт ТББ-аас эрхлэн гаргадаг мэдээллийн хэрэгсэл хамгийн олон байгаагаараа онцлогтой байна.

Хэвлэл мэдээллийн салбарт ажиллагчид: Хэвлэл мэдээллийн салбарт 2020 оны байдлаар 4,730 хүн ажиллаж байгаагийн 49% нь сэтгүүлч, сурвалжлагч, редактор, найруулагч зэрэг сэтгүүл зүйн бүтээлч ажилтнууд эзэлж байна.

Медиа хэрэглээ: Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК-ийн Үндэсний медиа судалгааны үр дүнгээс харахад уламжлалт болон дижитал медиа хэрэглээ 2020 онд өмнөх оноосоо өсжээ. 2016 оноос хойш буурч байсан уламжлалт медиа хэрэглээнээс телевиз болон ФМ радиогийн хэрэглээ нэмэгджээ. Ухаалаг гар утасны хэрэглээ 6%-аар өсөж, интернэт болон социал медиа хэрэглээ 10%-аар өсжээ.


График 99: Медиа хэрэгслүүдийн хэрэглээний түвшин, хувиар



Эх үүсвэр: Эм Эм Си Жи ХХК, “Үндэсний медиа судалгааны тайлан” 2021 он

Иргэд ажлын өдөр 392 минутыг, амралтын өдөр 578 минутыг медиа хэрэгсэлд зарцуулж байна. Иргэдийн дийлэнх нь интернэт, социал медиа болон телевиз үзэхэд нэлээд цагийг зарцуулдаг байна.

График 100: Медиа хэрэгсэлд зарцуулж буй дундаж хугацаа, минутаар




Эх үүсвэр: Эм Эм Си Жи ХХК, “Үндэсний медиа судалгааны тайлан” 2021 он

Монгол Улсын хувьд 2020 оны байдлаар 602'310 сонин уншдаг хүн байна. Үүний 49% нь УБ хотод, үлдсэн 51% нь орон нутагт амьдардаг байна. УБ хотын иргэдийн 32%, Орон нутгийн иргэдийн 28% сонин уншдаг. Сонин уншдаг хүмүүсийн бараг тэн хагас нь букуу 48% нь 7 хоногт 1-4 удаа сонин уншдаг байна. Өдөр бүр сонин уншдаг иргэдийн 53% нь өөрөө захиалж уншдаг байхад, сард 1 болон түүнээс цөөн удаа сонин уншдаг иргэд олдсон сониноо л уншдаг байна.


Сэтгүүл уншигчдын тоо 2020 онд 592'923-д хүрч өмнөх оноос 5%-аар өсжээ. Тэдний 53% нь УБ хотод, үлдсэн 47% нь орон нутагт амьдардаг байна.

График 101: Сонин, сэтгүүл уншигчдын тоо, байршлаар

СОНИН УНШИХ ТҮВШИН /Байршлаар/



СЭТГҮҮЛ УНШИХ ТҮВШИН /Байршлаар/




Эх үүсвэр: Эм Эм Си Жи ХХК, “Үндэсний медиа судалгааны тайлан” 2021 он

Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын 9 дүүрэг, орон нутгийн 17 аймаг, 26 сум суурины 2,500 өрхийн 15-60 насны гишүүдийг хамруулж, Монгол Улсын хэмжээнд телевиз, интернэт, социал медиа, сонин сэтгүүл, ФМ радио, самбарын сурталчилгаа зэрэг 9 төрлийн 300 гаруй хэвлэл, мэдээллийн хэрэгслийн рейтинг болон Монголчуудын амьдралын хэв маягийг гаргадаг ҮНДЭСНИЙ АНХНЫ СИНДИКАТ СУДАЛГАА юм.

Сонин сэтгүүлийн үнэ сүүлийн таван жилийн хугацаанд тогтвортой байжээ. Харин номын үнэ 2016 оны 9 дүгээр сараас 2018 оны 9 дүгээр сар хүртэл буурч, энэ хугацаанаас 2020 оны 10 дугаар сар хүртэл нэмэгдэж, түүнээс хойш тогтмол байдалтай байна.

График 102: Ном болон сонин, сэтгүүлийн үнийн өөрчлөлт, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Эх үүсвэр: ҮСХ

Зураг 34: Хэвлэл мэдээллийн салбарт ажиллагчдын тоо, 2020 оны байдлаар

Хэвлэл мэдээллийн салбарт ажиллагчид 4,730			
		53% - Эмэгтэй	47% - Эрэгтэй
Салбараар	Албан тушаалаар	Сарын дундаж цалин	
Сонин 762	647 Шийдвэр гаргах түвшний ажилтан	925,000 ₮	
Сэтгүүл 395	2,096 Бүтээлч ажилтан	700,000 ₮	
Радио 423	749 Техникийн болон туслах ажилтан	670,000 ₮	
Телевиз 2,441	578 Захиргааны / үйлчилгээний ажилтан	630,000 ₮	
Сайт 709	215 Бусад		
	445 Цагаар / гэрээгээр ажиллагч		
Улаанбаатар хотод 4,252 89%		Орон нутагт 478 11%	

Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл – Өнөөдөр”

Шийдвэр гаргах түвшний ажилтан гэдэгт захирал, ерөнхий эрхлэгч, менежер; Бүтээлч ажилтан гэдэгт сэтгүүлч, сурвалжлагч, редактор, найруулагч; Техникийн болон туслах ажилтан гэдэгт компьютерын мэргэжилтэн, оператор, тайз засагч, зохион байгуулагч, зураач гэх мэт; Захиргааны / үйлчилгээний ажилтан гэдэгт хүний нөөцийн ажилтан, нярав, эдийн засагч, нарийн бичиг, үйлчлэгч, жолооч, манаач гэх мэт; Бусад ажилтан гэдэгт веб сайт болон социал медиа хөгжүүлэгч, борлуулагч, хэвлэлийн үйлдвэрийн ажилтан зэргийг хамруулан авч үзнэ.

Хүснэгт 70: Хэвлэл мэдээллийн салбарын болон олон суваг дамжуулах үйлчилгээний орлого, тэрбум төгрөгөөр

	2018	2019	2020
Сонин	33.4	31.1	27.8
Сэтгүүл / эмхэтгэл	6.2	2.8	2.1
Радио	1.4	1.3	1.5
Телевиз	72.5	52.2	55.8
Мэдээллийн сайт	6.2	8.8	9.2
Олон суваг дамжуулах үйлчилгээ	179.8	128.7	191.5
Хэвлэл мэдээллийн салбарын нийт орлого	299.5	224.9	287.9

Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, "Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр", ХХЗХ, "Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн үндсэн үзүүлэлт"

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын хэрэгжилт: Хэвлэл мэдээллийн зөвлөл нь 2015 оны 4 дүгээр сарын 14-ны өдөр "Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим", "Гомдол санал хүлээж авах журам"-аа баталснаар 4 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн иргэдээс сэтгүүл зүйн бүтээлийн ёс зүйтэй холбоотой гомдлыг өргөдөл бичгийн хэлбэрээр хүлээн авч эхэлсэн. Иргэд үзэгч, сонсогч, уншигчид сонин, сэтгүүл, сайт, радио, телевиз зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтэлж нэвтрүүлсэн ямар нэгэн нийтлэл нэвтрүүлэг, сурвалжлаг гэх мэт сэтгүүл зүйн бүтээлийг "Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим"-ыг зөрчсөн гэж үзвэл Хэвлэл мэдээллийн зөвлөлд гомдол гаргаж болно.²⁶



Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирүүлсэн гомдлын тоо 2015 оноос жил дараалан өсөж иржээ. 2019 онд нийт 106 гомдол хүлээн авсны 84 нь буюу 79% нь Сонин

Түүнчлэн телевиз радиогийн олон суваг дамжуулах үйлчилгээний салбарт 2020 оны байдлаар 875 хүн ажиллаж байна.

Хэвлэл мэдээллийн салбарын орлого: Хэвлэл мэдээллийн салбарын нийт орлого 2020 онд 96.4 тэрбум төгрөг байсны 58%-ийг телевиз, 29%-ийг сонин, 9%-ийг мэдээллийн сайтын, тус бүр 2%-ийг сэтгүүлийн болон радиогийн салбар бүрдүүлж байжээ. Түүнчлэн олон суваг дамжуулах үйлчилгээний салбарын орлого 2020 онд 191.5 тэрбум төгрөг байжээ.

сэтгүүл, сайтын Ёс зүйн хороонд, 22 нь буюу 21% нь Радио, телевизийн Ёс зүйн хороонд хаяглагджээ.

График 103: Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирүүлсэн гомдлын тоо




Эх үүсвэр: Хэвлэл мэдээллийн зөвлөл, "Үйл ажиллагааны тайлан" 2015-2019 он

Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирүүлсэн гомдол 2018-2019 онд илүү үндэслэлтэй болж, урьдчилсан хяналтаар буцаасан гомдлын тоо буурсан бол хэвлэл мэдээллийн байгууллага (ХМБ)-ууд

зөрчлөө өөрсдөө залруулснаа мэдээлэх байдал нэмэгдсэн байна. Түүнчлэн зөрчил гаргасан нь тогтоогдож, ХМБ-ын нэрийг дурдаж зөрчлийг мэдээлсэн тохиолдлын тоо мөн нэмэгджээ.

График 104: Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирүүлсэн гомдлын шийдвэрлэлтийн байдал



Эх үүсвэр: Хэвлэл мэдээллийн зөвлөл, "Үйл ажиллагааны тайлан" 2015-2019 он

Тайлбар: ГХАБЖ – Гомдол хүлээн авах, барагдуулах журам

Хэвлэл мэдээллийн байгууллагууд дараах төрлийн алдааг нийтлэг гаргаж байна. Үүнд:

- ▶ Мэдээллийг нягталж шалгадаггүй;
- ▶ Олон эх сурвалжаар баталгаажуулдаггүй;
- ▶ Гарчиг, зураг, ишлэл нь агуулгыг буруугаар ойлгуулах;
- ▶ Хувийн мэдээлэлд хүндэтгэлтэй ханддаггүй;
- ▶ Буруутгагдсан этгээдэд тайлбар хийх боломж олгодоггүй;
- ▶ Таамаг цуу яриаг нийтэлж, нэвтрүүлдэг;
- ▶ Шүүх гэм буруутайг нотлоогүй байхад гүтгэн доромжлох;
- ▶ Мэдээлэх, эс мэдээлэхийн тулд авлига авах.

i. Сонин

Иохан Каролус 1605 онд хэвлэсэн «The Relation aller Furnemmen und gedenck-wurdigen Historien» сонин нь сэтгүүл зүйн түүхэнд хамгийн анхны сонин гэж тооцогддог. Анхны Английн өдөр тутмын сонин болох Daily Courant 1702-1735 онд хэвлэн нийтлэгдэж байжээ.²⁷

"Шинэ толь хэмээх бичиг" сонин нь 1913 оны 3 дугаар сарын 06-нд анхны дугаараа төрөлх Монгол хэлээр, Монголчууд өөрсдөдөө зориулж гаргасан тул Монголын анхны сонин гэж тооцож, энэ өдрийг Монголын үндэсний сэтгүүл зүйн өдөр гэж тэмдэглэдэг.

Сонины тоо: Сүүлийн 10 жилийн хугацаанд сонинуудын тоо буурч, 2010 онд 130 сонин хэвлэгдэн гарч байсан бол 2020 онд 78 болжээ. Түүнчлэн сонины борлуулалтын хэмжээ 2010 онд 19.8 сая ширхэг байсан бол 2020 онд 10.8 сая ширхэг болж 1.8 дахин буурчээ.

График 105: Монгол Улс дахь сонины тоо, тэдгээрийн борлуулалтын хэмжээ, сая ширхгээр



Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Монгол Улсад хэвлэгдэн гарч байгаа сонинуудын 58% нь хувийн байгууллагын, 27% нь ТББ-ын, 12% нь төрийн байгууллагын, 3% нь улс төрийн нам, эвслийн харьяаллын сонин байна.

Гадаад хэлээр хэвлэгдэн гардаг 7 сонин байна. Сонинуудын 59% нь нийт орон даяар, 29% нь орон нутгийн хэмжээнд, 9% болон 3% нь салбарын болон бүсийн хэмжээнд түгээгддэг байна.

Сонинуудыг давтамжаар нь авч үзвэл 9 нь өдөр тутмын, 4 нь 3-4 хоног тутмын сонин байна.

Хүснэгт 71: Сонины тоо, давтамжаар

	2015	2016	2017	2018	2019	2020
Өдөр тутмын	11	11	9	10	9	8
3-4 хоног тутмын	5	4	3	4	4	4
7 хоног тутмын	29	25	23	23	22	20
10-14 хоног тутмын	36	33	39	37	29	29
Сар тутмын	17	14	11	13	15	14
Бусад	3	2	3	5	5	3
Сонин нийт	101	89	88	92	84	78

Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл-Өнөөдөр”

Зураг 35: Сонины салбарт ажиллагчдын тоо



Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр”

Зураг 36: Сонины борлуулалт



Сонины борлуулалт: Борлуулагдсан сонины 82%-ийг өдөр тутмын сонин эзэлдэг бол нийт борлуулалтын 93%-ийг захиалгаар, 7%-ийг үүргийн худалдаагаар борлуулжээ.

Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Сонины үнэ: Өдөр тутмын сонины улирлын захиалгын үнэ 23,380 төгрөг байгаа бол нэг дугаарын борлуулалтын дундаж үнэ 775 төгрөг байна.

Хүснэгт 72: Захиалгын болон үүргийн худалдааны дундаж үнэ

Давтамж, төрөл	Улирлын захиалгын үнэ, төгрөг			Нэг дугаарын борлуулалтын үнэ, төгрөг		
	2018 он	2019 он	2020 он	2018 он	2019 он	2020 он
Өдөр тутмын	20,200	20,600	23,380	660	630	775
7 хоног тутмын	9,960	5,450	5,880	945	1,375	1,470
10-14 хоног тутмын	8,000	6,260	5,300	1,310	1,256	1,575
Орон нутгийн сонин	5,520	4,964	5,330	725	1,211	1,330

Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Салбарын орлого: Сонины салбарын орлого 2020 оны байдлаар 27.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 11%-аар буюу 3.3 тэрбум төгрөгөөр буурчээ. Сонины салбарын нийт орлогын 65% нь буюу 18.1 тэрбум төгрөг нь зар сурталчилгааны орлого, 35% буюу 9.7 тэрбум төгрөг нь сонины борлуулалтын орлого байжээ.

График 106: Сонины салбарын орлого, тэрбум төгрөгөөр




Эх үүсвэр: Сонинуудын борлуулалтын тоо, нэг дугаарын борлуулалтын үнэ, зар сурталчилгааны дундаж үнэ зэрэгт үндэслэн тооцов.

ii. Сэтгүүл

Сэтгүүлийн тоо: Сүүлийн 10 жилийн хугацаанд сэтгүүлүүдийн тоо буурч, 2010 онд 102 сэтгүүл хэвлэгдэн гарч байсан бол 2020 онд 69 болжээ. Түүнчлэн сэтгүүлийн борлуулалтын хэмжээ 2012 онд 5.4 сая ширхэг байсан бол 2020 онд 462.2 мянган ширхэг болж 11.7 дахин буурчээ.

График 107: Монгол Улс дахь сэтгүүлийн тоо, тэдгээрийн борлуулалтын хэмжээ, сая ширхэгээр



Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Монгол Улсад хэвлэгдэн гарч байгаа сэтгүүлүүдийн 51% нь хувийн байгууллагын, 30% нь ТББ-ын, 19% нь төрийн байгууллагын харьяаллын сэтгүүл байна.

Сэтгүүлүүдийн 68% нь нийт орон даяар, 25% нь салбарын хэмжээнд, 6% болон 1% нь бүсийн болон орон нутгийн хэмжээнд түгээгддэг байна.

Сэтгүүлүүдийг давтамжаар нь авч үзвэл 26 нь улирал тутмын, 24 нь сар тутмын сэтгүүл байна.

Хүснэгт 73: Сэтгүүлийн тоо, давтамжаар

	2015	2016	2017	2018	2019	2020
7 хоног тутмын	6	5	5	2	2	2
14 хоног тутмын	4	4	3	4	4	2
Сар тутмын	30	25	25	28	27	24
2 сар тутмын	4	5	6	6	5	6
Улирал тутмын	32	34	27	34	31	26
Бусад	10	7	5	4	4	9
Сэтгүүл нийт	86	80	71	78	73	69

Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Сэтгүүлийн салбарт ажиллагчид: Сэтгүүлийн салбарт 2020 оны байдлаар 395 хүн ажиллаж байгаагийн 33% нь буюу 132 сэтгүүлч, сурвалжлагч, редактор, найруулагч зэрэг сэтгүүл зүйн бүтээлч ажилтнууд эзэлж байна. Түүнчлэн сэтгүүлийн салбарт цагаар буюу гэрээгээр ажиллагчид 45 байгаа нь нийт ажиллагчдын 11%-ийг эзэлж байна.

Зураг 37: Сэтгүүлийн салбарт ажиллагчдын тоо



Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Сэтгүүлийн борлуулалт: Борлуулагдсан сэтгүүлийн талаас илүү хувийг буюу 52%-ийг сар тутмын, 20%-ийг 2 сар тутмын сэтгүүл эзэлж байжээ. Хэвлэгдэн гарсан сэтгүүлийн 23%-ийг үнэгүй тарааж, 77%-ийг худалдан борлуулжээ. Нийт борлуулалтын 46%-ийг үүргийн худалдаагаар, 54%-ийг захиалгаар борлуулжээ.

Зураг 38: Сэтгүүлийн борлуулалт



Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Сонины үнэ: Борлуулалтад хамгийн их хувийг эзэлдэг сар тутмын сэтгүүлийн улирлын захиалгын үнэ 18,000 төгрөг байгаа бол нэг дугаарын борлуулалтын дундаж үнэ 5,000 төгрөг байжээ.


Хүснэгт 74: Захиалгын болон үүргийн худалдааны дундаж үнэ

Давтамж, төрөл	Улирлын захиалгын үнэ, төгрөг			Нэг дугаарын борлуулалтын үнэ, төгрөг		
	2018 он	2019 он	2020 он	2018 он	2019 он	2020 он
7 хоног тутмын	23,500	22,250	15,000	2,625	2,750	2,500
10-14 хоног тутмын	21,500	15,300	14,000	3,000	2,800	2,800
Сар тутмын	16,110	11,020	18,000	5,800	4,960	5,000
2 сар тутмын	8,770	7,500	8,000	5,580	4,000	4,200
Улирал тутмын	7,355	6,548	9,000	7,355	5,514	5,500

Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Салбарын орлого: Сэтгүүлийн салбарын орлого 2020 оны байдлаар 2.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 669.0 сая төгрөгөөр буюу 24%-аар буурчээ.

График 108: Сэтгүүлийн салбарын орлого, тэрбум төгрөгөөр



Эх үүсвэр: Сэтгүүлүүдийн борлуулалтын тоо, нэг дугаарын борлуулалтын үнэ зэрэгт үндэслэн тооцов.

iii. Радио


Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл: Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ дараах төрөлтэй байна:

1. радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ;
2. олон суваг дамжуулах үйлчилгээ;
3. олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ;
4. арилжааны радио, телевизийн үйлчилгээ;
5. өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ;
6. төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ.

Энэ бүлэгт дээрх жагсаалтын 5 дугаарт дурдагдсан өргөн нэвтрүүлгийн радиогийн үйлчилгээний талаар авч үзлээ.

Радиогийн тоо: Сүүлийн 10 жилийн хугацаанд радиогийн тоо буурч, 2010 онд 72 радио үйл ажиллагаа явуулж байсан бол 2020 онд 51 болжээ.

График 109: Монгол Улс дахь радиогийн тоо



Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа радионуудын 35 нь хувийн байгууллагын, 9 нь ТББ-ын, 7 нь төрийн / олон нийтийн радио байна. Тэдний 24 нь Улаанбаатар хотод, 17 нь орон нутагт, 6 нь бүсийн хэмжээнд, 3 нь үндэсний хэмжээнд, нэг нь хилийн чанадад нэвтрүүлгээ цацдаг радио байна.

12 радиогийн нэвтрүүлгийг цахим хэлбэрээр, 10 радиогийн нэвтрүүлгийг ухаалаг утасны апп-аар сонсох боломжтой.

Зураг 39: Монгол Улс дахь радиогийн тоон үзүүлэлтүүд

Радио-бүгд: 51		Нэвтрүүлгийн цаг / 7 хоногт	
Улаанбаатар хотод	25	2018	2019
Орон нутагт	16	Улаанбаатар хотод	308 343
Бүсийн хэмжээнд	6	Орон нутагт	1,391 1,628
Үндэсний хэмжээнд	3	Бүсийн хэмжээнд	2,667 3,722
Хилийн чанадад	1	Үндэсний хэмжээнд	308 343
Төрийн / олон нийтийн	7	Цахим хэлбэрээр сонсох	13
ТББ-ын	9	Ухаалаг утасны апп-аар	9
Хувийн	35		

Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Эдгээр радио 2020 оны байдлаар долоо хоногт нийтдээ 6,037 цагийн, жилдээ 313.9 мянган цагийн нэвтрүүлгийг цацжээ.

Радиогийн салбарт ажиллагчид: Радиогийн салбарт 2020 оны байдлаар 423 хүн ажиллаж байсны 60% нь буюу 252 нь сэтгүүлч, сурвалжлагч, редактор, найруулагч зэрэг сэтгүүл зүйн бүтээлч ажилтнууд эзэлж байжээ.

Зураг 40: Радиогийн салбарт ажиллагчдын тоо

Радиогийн салбарт ажиллагчид, 2020			
Ажиллагчид - 423			
53% - Эмэгтэй		47% - Эрэгтэй	
Албан тушаалаар			
63	Шийдвэр гаргах түвшний ажилтан	28	Захиргааны / үйлчилгээний ажилтан
252	Бүтээлч ажилтан	3	Бусад
68	Техникийн болон туслах ажилтан	9	Цагаар / гэрээгээр ажиллагч
Улаанбаатар хотод - 374		Орон нутагт - 49	

Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Радиогийн сурталчилгааны үнэ: Радиогийн үйлчилгээний талаарх сүүлийн үеийн нэгтгэсэн судалгаа байхгүй байгаа бөгөөд хамгийн сүүлд хийгдсэн судалгааны мэдээллийг доор харуулав.


Хүснэгт 75: Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа ФМ радионуудын сурталчилгааны дундаж үнэ, төгрөгөөр

Үйлчилгээний нэр төрөл	Хэмжих нэгж	Үндсэн үнэ	Хөнгөлөлттэй үнэ
Реклам цацах	1 удаа /30-45 секунд/	3,500	1,000
Эх бэлтгэл	1 ширхэг	80,000	50,000
Захиалгат нэвтрүүлэг	1 минут	2,500	2,000

Эх үүсвэр: ХХЗХ, Metro Lounge FM 91.7, 2016 оны 3 сарын 29

Салбарын орлого: Радиогийн салбарын орлого 2020 онд байдлаар 1.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 0.2 тэрбум төгрөгөөр буюу 21%-аар өсжээ.

График 110: Радиогийн салбарын орлого, тэрбум төгрөгөөр



Эх үүсвэр: ХХЗХ, "Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн үндсэн үзүүлэлт"

Хэт богино долгионы (FM) радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрийн нөхцөл шаардлагын биелэлт: Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан "Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл"-ийг үндэслэж, Харилцаа холбооны зохицуулах хороо 2011 онд "Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага"-ыг баталж өргөн нэвтрүүлгийн хяналтыг 2011 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү ерөнхий нөхцөл шаардлагад Монгол Улсын тодорхой хуулиудад заасан радио, телевизийн талаарх зохицуулалт, хязгаарлалтуудыг түүвэрлэн оруулахаас гадна радио, телевизийн хөтөлбөрийн бодлого, нэвтрүүлгийн агуулгад тавигдах шаардлага, нэг цагт дамжуулах зар сурталчилгааны хугацаа, чат, мессеж ашигласан нэвтрүүлэгт тавигдах шаардлага зэрэг зохицуулалтын тодорхой нөхцөлүүдийг онцгойлон тусгасан байдаг.²⁸ Улаанбаатар хотод хэт богино долгионы (FM) радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрийн нөхцөл шаардлагын биелэлтэд 2020 оны 12-р сард хийсэн мониторингд хамрагдсан 10 радио бүгд Монгол бүтээлийн эзлэх хувь 50%-аас багагүй байх шаардлагыг хангасан бол тэдний зөвхөн нэг нь л соён гэгээрүүлэх танин мэдүүлэх, хүүхэд боловсролын нэвтрүүлгийн хувь хэмжээ 15%-аас багагүй байх шаардлагыг хангажээ. Өргөн нэвтрүүлгийн радионуудын дунджаар нийт нэвтрүүлгийн 86.5% нь Монгол бүтээл байгаа бол 8.6% нь соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх, хүүхдийн боловсролын нэвтрүүлэг байжээ.

График 111: Улаанбаатар хот дахь радиогийн тоо, нийт нэвтрүүлэг дэх Монгол бүтээлийн эзлэх хувиар





График 112: Улаанбаатар хот дахь радиогийн тоо, нийт нэвтрүүлэг дэх соён гэгээрүүлэх танин мэдүүлэх, хүүхдийн боловсролын нэвтрүүлгийн эзлэх хувиар



Эх үүсвэр: ХХЗХ, 2020 оны 12 дугаар сарын мониторингийн тайлан

²⁸ <https://crc.gov.mn/k/1s/1j>

iv. Телевиз

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл: Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ дараах төрөлтэй байна:

1. радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ;
2. олон суваг дамжуулах үйлчилгээ;
3. олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ;
4. арилжааны радио, телевизийн үйлчилгээ;
5. өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ;
6. төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ.


Энэ бүлэгт дээрх жагсаалтын 3-6 дугаарт дурдагдсан телевизийн үйлчилгээний талаар авч үзлээ.

Шигтгээ 32: Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиас

- 4.1.1. "өргөн нэвтрүүлэг" гэж радио, телевизийн хөтөлбөр бэлтгэж, нэгтгэн харилцаа холбооны сүлжээ, төхөөрөмжөөр нэг цэгээс олон нийтэд нэгэн зэрэг хүргэхийг;
- 4.1.2. "өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ" гэж энэ хуулийн 4.1.3, 4.1.4, 4.1.5-д заасан үйлчилгээг;
- 4.1.3. "радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ" гэж радио давтамж ашиглан сүлжээ байгуулж, хэрэглэгч хүлээн авах төхөөрөмж ашиглан радио, телевизийн үйлчилгээг тодорхой хүрээнд үнэ төлбөргүй хүлээн авах боломжоор хангах үйлчилгээг;
- 4.1.4. "олон суваг дамжуулах үйлчилгээ" гэж утастай, утасгүй, хиймэл дагуулын сүлжээгээр радио, телевизийн олон сувгийг хэрэглэгчид гэрээний үндсэн дээр дамжуулан хүргэхийг;
- 4.1.5. "радио, телевизийн үйлчилгээ" гэж өөрийн редакцад хөтөлбөр бэлтгэн харилцаа холбооны сүлжээнд холбогдож, олон нийтэд түгээх үйлчилгээг;
- 4.1.6. "олон нийтийн радио, телевиз" гэж Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд заасан зөвхөн олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, ашгийн төлөө бус радио, телевизийн үйлчилгээг;
- 4.1.7. "арилжааны радио, телевиз" гэж хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай, ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэх радио, телевизийн үйлчилгээг;
- 4.1.8. "контент" гэж харилцаа холбооны сүлжээгээр дамжиж байгаа үг, дуу, тэмдэг, дохио, текст, зураг, график, хөдөлгөөнт дүрсбүхий бүх төрлийн мэдээ, мэдээллийг электрон хэлбэрт хувиргасныг;
- 4.1.9. "хөтөлбөр" гэж бүх төрлийн нэвтрүүлгийг радио, телевизээр дамжуулах хуваарьт оруулсан багцыг;
- 4.1.10. "нэвтрүүлэг" гэж радио, телевизээр дамжуулах зориулалтаар бэлтгэсэн бүх төрлийн контентыг;
- 4.1.11. "үндэсний бүтээл" гэж Монгол Улсын иргэн, эсхүл тухайн бүтээлийн уран бүтээлчдийн багийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн бүтээсэн бүтээлийг;
- 4.1.12. "мэдээ" гэж Монгол Улсын болон олон улсын цаг үеийн үйл явдлын талаарх өдөр бүрийн тогтмол мэдээллийн нэвтрүүлгийг;
- 4.1.13. "захиалгат нэвтрүүлэг" гэж радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид нэвтрүүлгийг бэлтгэх, дамжуулахаар хандсан хүсэлтийн дагуу бэлтгэсэн нэвтрүүлгийг;
- 4.1.14. "суваг" гэж радио, телевизийн хөтөлбөрийг дамжуулах сүлжээний багтаамжийн нэгжийг;
- 4.1.15. "ивээн тэтгэгч" гэж нэвтрүүлгийг бэлтгэхэд санхүүгийн болон бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлж байгаа этгээдийг;
- 4.1.16. "хадмал тайлбар" гэж телевизийн нэвтрүүлгээр гарч байгаа дүрслэлийн дуу, чимээ, авиа, яриаг тухайн агшинд нь дэлгэц дээр бичгэн хэлбэрээр илэрхийлэхийг;
- 4.1.17. "нэгдмэл сонирхолтой этгээд" гэж хувь хүн, хуулийн этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийг;
- 4.1.18. "ашгийн төлөө үйл ажиллагаа" гэж компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг;
- 4.1.19. "үндсэн багц" гэж хэрэглэгч олон суваг дамжуулах үйлчилгээнээс худалдан авч болох анхдагч, хамгийн бага багцыг;
- 4.1.20. "бүтээл" гэж зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааны бодит үр дүнг;
- 4.1.21. "өргөн нэвтрүүлгийн радио, телевиз" гэж олон талт хөтөлбөртэй, энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан үйлчилгээний сүлжээгээр заавал дамжих арилжааны радио, телевизийн үйлчилгээг;
- 4.1.22. "төлбөртэй радио, телевиз" гэж хэрэглэгч тухайн сувгийг сонгон, олон суваг дамжуулах үйлчилгээгээр дамжуулан төлбөр төлснөөр идэвхжих радио, телевизийн үйлчилгээг.

Телевизийн тоо: Сүүлийн 10 жилийн хугацаанд телевизийн тоо нэмэгдэж, 2010 онд 95 телевиз үйл ажиллагаа явуулж байсан бол 2020 онд 137 болжээ.

График 113: Монгол Улс дахь телевизийн тоо



Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа телевизүүдийн 125 нь хувийн байгууллагын, 8 нь ТББ-ын, 4 нь төрийн / олон нийтийн телевиз байна. Тэдний 63 нь орон нутагт, 54 нь Улаанбаатар хотод нэвтрүүлгээ цацдаг телевизүүд байгаа бол 20 нь үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг өргөн нэвтрүүлгийн телевиз байна.

20 телевиз өөрийн танилцуулга бүхий цахим хуудастай, 115 телевиз өөрийн албан Фейсбүүк хуудсаар мэдээллээ түгээж байна. Өөрийн цахим хуудас болон сошиал хаягтай телевизүүдийн 72% нь интернэтээр шууд дамжуулалт хийдэг бөгөөд тэдний 60 гаруй хувь нь өдөрт нэг ба түүнээс дээш удаа шууд нэвтрүүлэг цацаж байжээ.

21 телевизийн нэвтрүүлгийг албан ёсны веб сайтаар нь дамжуулан үзэх боломжтой байна. Түүнчлэн www.looktv.mn-ээр дамжуулан 31 сувгийг, MOTV ухаалаг утасны апп ашиглан 61 сувгийн нэвтрүүлгийг хүлээн авах боломжтой.

Зураг 41: Монгол Улс дахь телевизүүдийн тоон үзүүлэлтүүд



Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Эдгээр телевиз 2020 оны байдлаар долоо хоногт нийтдээ 14,434 цагийн, жилдээ 750.6 мянган цагийн нэвтрүүлгийг цацжээ.

Телевизийн салбарт ажиллагчид: Телевизийн салбарт 2020 оны байдлаар 2,441 хүн ажиллаж байсны 44% нь буюу 1,086 нь сэтгүүлч, сурвалжлагч, редактор, найруулагч зэрэг сэтгүүл зүйн бүтээлч ажилтнууд байжээ.

Зураг 42: Телевизийн салбарт ажиллагчдын тоо



Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Телевизийн сурталчилгааны үнэ: Телевизийн сурталчилгааны үйлчилгээний үнийн талаарх сүүлийн үеийн нэгтгэсэн судалгаа байхгүй байгаа бөгөөд хамгийн сүүлд хийгдсэн судалгааны мэдээллийг доор харуулав.


Хүснэгт 76: Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа телевизүүдийн сурталчилгааны дундаж үнэ, төгрөгөөр

Үйлчилгээний нэр төрөл	Хэмжих нэгж	Үндсэн үнэ	Хөнгөлөлттэй үнэ
Бэлэн реклам цацах /18-24 цагт/	1 секунд	5,500	3,800
Захиалгат мэдээ	1 минут	300,000	250,000
Захиалгат нэвтрүүлэг	1 минут	70,000	60,000

Эх үүсвэр: ХХЗХ, Metro Lounge FM 91.7, 2016 оны 3 сарын 29

Телевизийн салбарын орлого: Телевизийн салбарын орлого 2020 онд 55.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 3.5 тэрбум төгрөгөөр буюу 7%-аар нэмэгджээ. Телевизийн салбарын орлогын 65%-ийг өргөн нэвтрүүлгийн телевиз бүрдүүлж байна.

График 114: Телевизийн салбарын орлого, тэрбум төгрөгөөр




Эх үүсвэр: ХХЗХ, “Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн үндсэн үзүүлэлт”

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлага: Монгол Улсад телевизийн үйлчилгээ эрхлэхэд Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Аж ахуйн тусгай зөвшөөрлийн тухай хууль болон телевизийн үйлчилгээ эрхлэхтэй холбоотой ХХЗХ-ноос батлан гаргасан дараах зохицуулалт журмыг мөрдөн ажиллана. Үүнд:

- “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, 2021 оны 01 дүгээр тогтоол;
- “Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлага”, 2021 оны 02 дугаар тогтоол;
- “Олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам”, 2020 оны 62 дугаар тогтоол;
- “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалт”, 2020 оны 89 дүгээр тогтоол.

Телевизийн бүтээл, нэвтрүүлгийн хувь хэмжээнд тавигдах шаардлагыг доорх зургаар харуулав.

Зураг 43: Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага, төрөл, хамрах хүрээгээр



Эх үүсвэр: ХХЗХ, “Зөвлөмж: Телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд. Өргөн нэвтрүүлгийн хуульд заасан нөхцөл шаардлага, журмын тайлбар”

Мониторингийн 2021 оны 5 дугаар сарын тайлангаас өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн нэвтрүүлэг дэх Монгол бүтээлийн болон соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн нэвтрүүлгийн эзлэх хувь, хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн тоо, цаг болон төрөлжсөн телевизүүдийн төрөлжсөн нэвтрүүлгийн эзлэх хувь, хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн тоо, цаг гэсэн шаардлагын гүйцэтгэлийг энд нэгтгэн харуулав.

Өргөн нэвтрүүлгийн телевизийн шаардлага: 2021 оны 5 дугаар сарын мониторингд хамрагдсан өргөн нэвтрүүлгийн 20 телевизийн 18 нь Монгол бүтээлийн эзлэх хувь 50%-аас багагүй байх шаардлагыг хангасан бол 6 телевиз соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн нэвтрүүлгийн эзлэх хувь 20%-аас багагүй байх шаардлагыг хангажээ. Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн дунджаар нийт нэвтрүүлгийн 75.5% нь Монгол бүтээл байгаа бол 17.6% нь соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн нэвтрүүлэг байжээ.

График 115: Өргөн нэвтрүүлгийн телевизийн тоо, нийт нэвтрүүлэг дэх Монгол бүтээлийн эзлэх хувиар





График 116: Өргөн нэвтрүүлгийн телевизийн тоо, нийт нэвтрүүлэг дэх соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн нэвтрүүлгийн эзлэх хувиар



Эх үүсвэр: ХХЗХ, “Мониторингийн тайлан”, 2021 оны 5 дугаар сар

2021 оны 5 дугаар сарын мониторингд хамрагдсан өргөн нэвтрүүлгийн 20 телевизийн дүнгээр тухайн сард хүүхдэд зориулсан 60 цаг 53 минутын 141 нэвтрүүлгийг цацжээ. 2021 оны 5 дугаар сард 9 телевиз хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг гаргаагүй бол 11 телевиз нь 1-29 хүртэлх тооны хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг гаргажээ.

Төрөлжсөн телевизийн шаардлага: 2021 оны 5 дугаар сарын мониторингд хамрагдсан төрөлжсөн 40 телевизийн 29 нь Монгол бүтээлийн эзлэх хувь 50%-аас багагүй байх шаардлагыг хангасан бол 17 телевиз төрөлжсөн нэвтрүүлгийн эзлэх хувь 80%-аас багагүй байх шаардлагыг хангажээ. Төрөлжсөн телевизүүдийн дунджаар нийт нэвтрүүлгийн 65.3% нь Монгол бүтээл байгаа бол 63.7% нь төрөлжсөн нэвтрүүлэг байжээ.

График 117: Төрөлжсөн телевизийн тоо, нийт нэвтрүүлэг дэх Монгол бүтээлийн эзлэх хувиар





График 118: Төрөлжсөн телевизийн тоо, нийт нэвтрүүлэг дэх төрөлжсөн нэвтрүүлгийн эзлэх хувиар




Эх үүсвэр: ХХЗХ, “Мониторингийн тайлан”, 2021 оны 5 дугаар сар

2021 оны 5 дугаар сарын мониторингд хамрагдсан төрөлжсөн 20 телевизийн дүнгээр тухайн сард хүүхдэд зориулсан 224 цаг 15 минутын 948 нэвтрүүлгийг цацжээ. 2021 оны 5 дугаар сард 26 телевиз хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг гаргаагүй бол 14 телевиз нь 1-729 хүртэлх тооны хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг гаргажээ. Мөрөөдлийн суваг ТББ-ын DREAM TV суваг 101 цаг 24 минутын 729 хүүхдэд зориулсан нэвтрүүлгийг цацсан хэдий ч тухайн телевизийн цацсан нийт бүтээлийн 20.5% нь Монгол бүтээл байжээ.

v. Мэдээллийн сайт

Мэдээллийн сайтын тоо: Сүүлийн 10 жилийн хугацаанд мэдээллийн сайтуудын тоо нэмэгдэж, 2011 онд 30 мэдээллийн сайт үйл ажиллагаа явуулж байсан бол 2020 онд 178 болжээ.

График 119: Мэдээллийн сайтын тоо




Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа мэдээллийн сайтуудын 160 нь хувийн байгууллагын, 11 нь ТББ-ын, 4 нь хүйн байгууллагын, 3 нь төрийн байгууллагын мэдээллийн сайт байна.

Нийт мэдээллийн сайтын 65% нь бүх нийтлэл мэдээллээ өөрсдөө бэлтгэж нийтэлдэг бол 32% нь нийтлэл, мэдээллийн тодорхой хувийг өөрсдөө бэлтгэж байна. Сайтуудын мэдээ, мэдээллээ шинэчлэх давтамж нэмэгдэж, сайтуудын 62% нь цаг тутамд эсвэл цагт хэд хэдэн удаа мэдээллээ шинэчилж байна. Түүнчлэн таван сайт тутмын хоёр нь үйл явдлыг газар дээрээс нь шууд дамжуулж байна.

Зураг 44: Монгол Улс дахь мэдээллийн сайтуудын тоон үзүүлэлтүүд



Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Шигтгээ 33: Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Хэл, соёл, зан заншил, шашин, тодорхой нэг нутаг дэвсгэрт оршин суудаг гэх мэт өөр хоорондоо ямар нэг байдлаар хүйн холбоотой хүмүүсийн нийтлэг ашиг сонирхолд үйлчилж, тэдгээр иргэдийн оролцоотойгоор үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг ОЛОН НИЙТИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ (Community media) гэнэ.

Эх үүсвэр: <https://en.unesco.org/community-media-sustainability/policy-series/defining>

Мэдээллийн сайтад ажиллагчид: Мэдээллийн сайтуудад 2020 оны байдлаар 709 хүн ажиллаж байсны 47% нь буюу 336 нь сэтгүүлч, сурвалжлагч, редактор, найруулагч зэрэг сэтгүүл зүйн бүтээлч ажилтнууд байжээ.


Зураг 45: Мэдээллийн сайтад ажиллагчдын тоо



Эх үүсвэр: Хэвлэлийн хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”

Мэдээллийн сайтуудын орлого: Мэдээллийн сайтуудын орлого 2020 онд 9.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 0.4 тэрбум төгрөгөөр буюу 7%-аар өсжээ.

График 120: Мэдээллийн сайтуудын орлого, тэрбум төгрөгөөр



Эх үүсвэр: Сэтгүүлчдийн борлуулалтын тоо, нэг дугаарын борлуулалтын үнэ зэрэгт үндэслэн тооцов.

vi. Радио, телевизийн нэвтрүүлэг дамжуулах үйлчилгээ

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 зааснаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгодог бөгөөд тус байгууллагаас хагас жил тутам гаргадаг Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн үндсэн үзүүлэлтийн тайланг энд эх сурвалж болгон ашиглалаа.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний төрөл: Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ дараах төрөлтэй байна:

1. радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ;
2. олон суваг дамжуулах үйлчилгээ;
3. олон нийтийн радио, телевизийн үйлчилгээ;
4. арилжааны радио, телевизийн үйлчилгээ;
5. өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ;
6. төлбөртэй радио, телевизийн үйлчилгээ.

Энэ бүлэгт дээрх жагсаалтын 1, 2 дугаарт дурдагдсан радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ олон суваг дамжуулах үйлчилгээний талаар авч үзлээ.



Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ: Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д заасны дагуу радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ гэдэгт радио давтамж ашиглан сүлжээ байгуулж, хэрэглэгч хүлээн авах төхөөрөмж ашиглан радио, телевизийн үйлчилгээг тодорхой хүрээнд үнэ төлбөргүй хүлээн авах боломжоор хангах үйлчилгээг ойлгоно. Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээг Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ эрхлэн явуулж байна. Тус байгууллага нь Радио нэвтрүүлэх төв станц, Телевизийн төв станц болон Баян-Өлгий, Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Хөвсгөл аймгууд дахь Радио телевизийн станцууд, Телевизийн дахин дамжуулах сүлжээний 20 Вт-аас 5000 Вт хүртэлх хүчин чадалтай нийт 365 станцын ашиглалт үйлчилгээг хариуцан Монгол Улсын засаг захиргааны бүх нэгж болох баг, сум, суурин газар, хот, тосгон, улсын чанартай амралт, сувиллуудад Монголын Үндэсний Радио, Телевиз болон арилжааны телевизүүдийн нэвтрүүлгийг дахин дамжуулж төрөөс ард иргэдэд радио болон телевизийн олон сувгийн станцаар өргөн нэвтрүүлгийг үнэ төлбөргүй хүргэх үүргийг ханган ажиллаж байна.²⁹

²⁹ <https://rtbn.gov.mn/about/>

Олон суваг дамжуулах үйлчилгээ:

Телевиз, радиогийн олон сувгийг дамжуулах үйлчилгээ гэдэг нь утастай, утасгүй, хиймэл дагуулын сүлжээгээр телевиз, радиогийн олон суваг болон бусад нэмэлт агуулгыг хэрэглэгчдэд дамжуулан хүргэх үйлчилгээ юм. Олон суваг дамжуулах үйлчилгээнд:

- Телевизийн олон сувгийг кабелиар дамжуулах үйлчилгээ (КаТВ)
- Телевиз, радиогийн олон сувгийг интернэт протокол ашиглан дамжуулах үйлчилгээ (АйПиТВ)
- Телевиз, радиогийн олон сувгийг мобайл сүлжээгээр дамжуулах үйлчилгээ (МобайлТВ)
- Телевиз, радиогийн олон сувгийг сансрын хиймэл дагуул ашиглан дамжуулах үйлчилгээний төрлүүд хамаарна.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид нь телевиз, кабелийн сувгуудтай адил нэвтрүүлэг, контент бэлтгэдэггүй, харин тэдгээрийг өөрсдийн байгуулсан сүлжээгээр хэрэглэгчдэд тодорхой төлбөртэйгөөр хүргэдэг бизнес эрхэлдгээрээ ялгаатай.

Олон суваг дамжуулах үйлчилгээ үзүүлэгчдийн тоо:

Телевизийн олон сувгийг кабелиар дамжуулах үйлчилгээ (КаТВ) үзүүлэгч 31 аж ахуйн нэгж; телевиз, радиогийн олон сувгийг интернэт протокол ашиглан дамжуулах үйлчилгээ (АйПиТВ) үзүүлэгч 2 аж ахуйн нэгж; телевиз, радиогийн олон сувгийг сансрын хиймэл дагуул ашиглан дамжуулах үйлчилгээ үзүүлэгч 2 аж ахуйн нэгж 2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байна.


Зураг 46: Олон суваг дамжуулах үйлчилгээ үзүүлэгчдийн тоо, 2021 оны байдлаар



Эх үүсвэр: ХХЗХ

Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчдийн тоо: Олон суваг дамжуулах үйлчилгээний бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо сүүлийн 11 жилийн хугацаанд тасралтгүй эрчимтэй нэмэгдэж, 2020 онд 1.2 саяд хүрч, 2010 онтой харьцуулахад 5.5 дахин нэмэгджээ.

График 121: Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний бүртгэлтэй болон идэвхтэй* хэрэглэгчдийн тоо



Эх үүсвэр: ХХЗХ

Тайлбар: * - ХХЗХ нь Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчдийн тоог 2018 оноос эхлэн идэвхтэй хэрэглэгчдийн тоогоор гаргаж эхэлсэн.

Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчдийн 336.8 мянга нь буюу 45% нь хиймэл дагуулын, 260.9 мянга нь буюу 35% нь АйПиТВ-ийн хэрэглэгч байна.

Хүснэгт 77: Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчдийн тоо, 2020 оны байдлаар, технологи болон байршлаар


Технологи	Улаанбаатарт	Орон нутагт	Тоо - бүгд	Дүнд эзлэх хувь
КаТВ	30,090	4,741	34,831	4.7%
MMDS	83,807	31,425	115,232	15.4%
Хиймэл дагуул	138,582	198,262	336,844	45.0%
АйПиТВ	190,597	70,293	260,890	34.9%
Бүгд	443,076	304,721	747,797	100.0%

Эх үүсвэр: ХХЗХ

ҮСХ-ны мэдээллээр 2020 онд 908.7 мянган өрх байсан, телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчид бүгд өрхийн хэрэглэгчид гэж үзвэл нийт өрхийн 82% нь телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчид байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээний салбарын ажиллагчдын тоо: Олон суваг дамжуулах үйлчилгээний салбарт 2020 оны байдлаар 875 хүн ажиллаж байна.

График 122: Олон суваг дамжуулах үйлчилгээний салбарын ажиллагчдын тоо




Эх үүсвэр: ХХЗХ



СОЁЛЫН ЯАМ

Олон суваг дамжуулах үйлчилгээний салбарын орлого: Олон суваг дамжуулах үйлчилгээний салбарын орлого 2020 онд 191.5 тэрбум төгрөгт хүрчээ.

График 123: Олон суваг дамжуулах үйлчилгээний салбарын орлого, тэрбум төгрөгөөр




Эх үүсвэр: ХХЗХ

vii. Салбарын төгсөгчдийн тоо мэдээлэл

Хэвлэл мэдээллийн салбарын 2019-2020 оны хичээлийн жилд суралцаж төгссөн оюутны тоо мэдээлэл:

График 124: Хэвлэл мэдээллийн салбарын төгсөгчдийн нийт СБҮ-ийн төгсөгчдийн тоонд эзлэх хувь



Эх үүсвэр: БШУЯ, "Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн тоо мэдээлэл"

9 их, дээд сургууль


24 ХӨТӨЛБӨР

Хэвлэл мэдээллийн салбарт 2019-2020 оны хичээлийн жилд 15 оюутан суралцаж төгссөн ба энэ нь нийт соёлын салбарын төгсөгчдийн 0,5 хувийг бүрдүүлж байна.

График 125: Хэвлэл мэдээллийн салбарын төгсөгчид, боловсролын зэрэг, хүйсээр, 2019-2020 оны хичээлийн жилд

Боловсролын зэрэг

- Дипломын боловсролыг 0
- Бакалаврын боловсролыг 15
- Магистрын боловсролыг 0
- Докторын боловсролыг 0



Хүйс

Эх үүсвэр: БШУЯ



ХУВЦАС ЗАГВАР

Fashion Design

08

ХУВЦАС ЗАГВАР

Fashion design

5.8. ХУВЦАС ЗАГВАР

Салбарын талаарх ЮНЕСКО-ийн тодорхойлолт³⁰

ЮНЕСКО -гийн ССХ -нд Загвар ба бүтээлч үйлчилгээ салбарт Хувцас загварын салбар тусгагдсан байдаг.

Салбарт хамаарах ажил мэргэжлүүд:

- ▶ Хувцасны загвар зохион бүтээгч
- ▶ Нэхмэлчин, элдүүрчин (адил төстэй материалаар эд зүйлс үйлдвэрлэгчид)
- ▶ Эрэгтэй, эмэгтэй хувцасны оёдолчин, элдүүрчин, малгайчид
- ▶ Малгай хийгч, арьс элдэгч, хувцасны эсгүүрчид
- ▶ Оёдолчин, хатгамалч болон тэдгээртэй төстэй мэргэжлүүд
- ▶ Элдүүрчин, арьс шүүлэгч, арьс үсний мэргэжилтнүүд
- ▶ Гуталчин, түүнтэй төстэй мэргэжлүүд

Жич: Нэхмэлчин, элдүүрчин (адил төстэй материалаар эд зүйлс үйлдвэрлэгчид), эрэгтэй, эмэгтэй хувцасны оёдолчин, элдүүрчин, малгайчид, Малгай хийгч, арьс элдэгч, хувцасны эсгүүрчид, Оёдолчин, хатгамалч болон тэдгээртэй төстэй мэргэжлүүд, Элдүүрчин, арьс шүүлэгч, арьс үсний мэргэжилтнүүд, Гуталчин, түүнтэй төстэй мэргэжлүүд ажил мэргэжлүүд Дүрслэх урлаг ба гар урлалын салбарт ЮНЕСКО-ийн ССХ -нд хамааруулсан байдаг. Харин бид эдгээр ажил мэргэжлийг хувцас загварын салбарт хамааруулж бүртгэлээ.

5.8.1. Хувцас загварын салбар

Хувцас загварын салбар анх хүн үүсэн бий болсон цагтай зэрэгцэн бий болсон гэхэд буруудахгүй. Оюун ухаан хөгжиж, он цаг өнгөрөхийн хэрээр хувцас загварын салбар өөрийн гэсэн онцгой өнгө төрхтэй болж, хэрэглээнээсээ шалтгаалан олон төрөл болон салаалан хөгжиж байна.

Дан ганц хүний хэрэглээ ч бус тухайн улс орны эдийн засагт нөлөөлөгч томоохон хүчин зүйлсийн нэг юм. АНУ-ын хувцасны зах зээл л гэхэд 2019 оны байдлаар ойролцоогоор 368 тэрбум ам.доллар үнэлэгдсэн байна. Энэ нь цаашид ч мөн өсөх хандлагатай байгаа юм (M. Shahban-deh, 2021).

³⁰ ЮНЕСКО, Соёлын Статистикийн хүрээ, 2009

“

Та ганц жижиг хар даашинзтай байхад хэзээ ч илүү гоёхгүй, бас дутуу гоёхгүй.

К.Лагерфелд

”

Монголчууд “Хувцсаар нь угтаж, ухаанаар нь үднэ” гэж ярьцгаадаг билээ. Тэгэхээр хувцас загварын салбарын нийгмийн болон эдийн засгийн үр өгөөжүүд нь яг юу болох талаар дэлгэрүүлэн авч үзье.

Нийгмийн үр өгөөж

Хувцас загвар хүнд өөрөө өөрийгөө илэрхийлэх боломжийг олгодог. Цагдаа хүн бол цагдаагийн дүрэмт хувцсаа өмсөнө. Эмч хүн бол эмчийн цагаан халаадаа өмсөнө. Хурим хийж байгаа эмэгтэй хүн цагаан даашинз өмсөнө. Учир нь “Цагаан өнгө” нь цэвэр ариун байдал болон ариун журмыг бэлгэддэг. Хувцас нь зүгээр ч нэг хэрэглээ бус оёдол, өнгө, чимэглэл бүрээрээ өөрийн гэсэн онцгой утга санааг илэрхийлж байдаг.

Үндэсний хувцаснууд

Үндэсний хувцас нь тухайн улсын угсаа гарал болон түүхийн салшгүй нэг хэсэг юм. Цаг үеийн байдал болон ямар аж ахуй эрхэлж, яаж амьдардаг байсныг ч мөн илэрхийлдэг. Бүр цаашлаад тухайн орны цаг агаар, уур амьсгалыг үндэсний хувцсаар нь тодорхойлж болно.

Монгол “Дээл” Япон “Кимоно” Шотланд “Килт”



Хувцас загварын давуу талууд

Хувцас загварын давуу талуудаас дурдвал (Pucker and Pout, 2019):

Орчин үетэйгээ хөл нийлүүлэн алхахад тусалдаг.

Элдэв янзын гадны хүчин зүйлсээс хамгаалдаг.

Анхны эерэг сэтгэгдлийг бий болгодог.

Хувцас загвар нь тухайн хүний илэрхийлэмж юм.

Өөртөө итгэлтэй болоход тусалдаг.

Загварын шоу, долоо хоног

Дэлхий даяар янз бүрийн загварын шоу зохион байгуулагддаг бөгөөд хүмүүс хувцас загвар, сүүлийн үеийн чиг хандлагад автсаар байгаа тул улам бүр алдартай болж байна. Нью-Йоркийн загварын долоо хоногос Коко Шанелийн загварын арга хэмжээ хүртэл олон сая хүмүүсийг хамарсан гайхалтай, өвөрмөц загварын шоуунууд жил бүр дэлхийн өнцөг булан бүрд болдог.

New York Fashion Week



1943 оноос хойш зохион байгуулагдаж байгаа ба жилд хоёр удаа хоёр болон есдүгээр сард АНУ-ын Нью-Йорк хотод болдог загварын арга хэмжээ юм. Дэлхийн хамгийн алдартай, авьяаслаг, шилдэг загвар зохион бүтээгчид өөрсдийн загваруудыг танилцуулдаг. "New York" загварын долоо хоногийн "Big 4" -ийн нэг бөгөөд дэлхийн хамгийн том загварын арга хэмжээний нэгд тооцогддог. Долоо хоног нь ойролцоогоор 7-9 хоног үргэлжилдэг (The 10 Best Fashion Shows in the World, 2018).

Paris Fashion Week



"Big 4" загварын шоуны нэг бол Парисын загварын долоо хоног юм, гэхдээ бусад загварын долоо хоногуудтайгаа адил алдартай биш боловч дэлхийн олон олон гайхалтай загвар зохион бүтээгчид болон загвар өмсөгчид энэхүү шоунд оролцдог байна. "Big 4" арга хэмжээ нь Лондоны загварын долоо хоногоос эхэлж, Парисаар дуусдаг. Анхны албан ёсны Парисын загварын долоо хоногийн арга хэмжээг 1973 онд Haute Couture, Men's Fashion хамтран зохион байгуулжээ. Энэхүү арга хэмжээ нь үнэндээ Версалын ордныг сэргээн босгох хандивын аян байсан бөгөөд 60 сая долларыг босгох зорилготой байжээ (The 10 Best Fashion Shows in the World, 2018).

Эдийн засгийн үр өгөөж

Загварын салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө асар их юм. Загварын компаниуд хэдэн зуун тэрбум долларын энэхүү салбараар дамжуулан эргэлдүүлж байна. Хувцас загварын салбарын бий болгож буй ажлын байрны тоо, бий болгож буй мөнгөний хэмжээ зэргээс шалтгаалан эдийн засагт асар их нөлөө үзүүлдэг.

Хувцас загвар нь дэлхийн зах зээлд 2.5 их наяд доллар үнэлэгдэж байна. Зөвхөн АНУ -д л гэхэд хэрэглэгчид 2017 онд хувцас, гуталд бараг 380 тэрбум доллар зарцуулсан байна. Нэхмэл эдлэл, хувцасны брэндээс бөөний худалдаа, импортлогч, жижиглэн худалдаачдыг багтаасан энэ салбарт АНУ -д 1.8 сая гаруй хүн ажилладаг (The Economic Impact of the Fashion Industry, 2019).

"Fast fashion" нь хүмүүсийн анхаарлыг илүү ихээр татах болсон. Энэ нь эдийн засагт асар их нөлөө үзүүлдэг. Энэ нь оёдлын үйлдвэрлэлийн одоогийн болон ирээдүйн өсөлтийг хариуцдаг гэж хэлж болно. 2017 онд энэхүү зах зээлийг 5.91 хувиар өсөж, 2020 онд 1,652.73 тэрбум долларт хүрнэ хэмээн таамаглаж байсан ч цар тахал нь энэхүү таамаглалд нөлөөлсөн юм.

Хэдийгээр "Fast fashion" нь байгаль орчинд ээлтэй биш ч гэсэн 2022 онд 713 тэрбум долларт хүрнэ гэж салбарынхан үзэж байна (Swatski, 2020).

Цар тахлын нөлөө

Маш олон хүмүүс гэрээсээ ажиллаж, ихэнх цагаа гэртээ өнгөрөөдөг болсон тул хувцаслах тийм ч их ач холбогдлоо өгөхөө больсон. Хурим, баяр наадам, амралт гэх мэт арга хэмжээ цуцлагдаж, зохион байгуулахыг хориглосон тул эрэлт хэрэгцээ багассан. Үүний үр дүнд хувцас, тансаг зэрэглэлийн барааны зах зээлийн дундаж үнэлгээ 2020 оны 1-р сараас 3-р сарын 24-ний хооронд бараг 40% буурсан байна.

Гэвч хөл хорио нь хувцас загварын салбарын өөр нэгэн өсөлтийг бий болгосон нь онлайн худалдаа юм. Цахим худалдааны өсөлтүүдээс дурдвал:

- H&M -ийн мэдээлснээр 2020 оны 3-р сараас 5-р сарын хооронд онлайн борлуулалт 36% -иар өссөн.
- Онлайн жижиглэн худалдааны ASOS группийн олон улсын борлуулалт 17%-иар тус тус өссөн байна (Ozdil, 2020).

i. Монгол Улсын хувцас загварын салбарын давуу тал онцлог, боломж

Хувцас загварын салбарын мэргэжлийн холбоод

Хувцас загварын салбарт мэргэжлийн холбоо 30-40 орчим байдаг. Тэдгээр байгууллагууд дундаас хамгийн идэвхтэй ажиллаж буй холбоо нь "Монголын мэргэжлийн загвар бүтээгчдийн холбоо" байна.



Монголын мэргэжлийн загвар зохион бүтээгчдийн холбоо нь Монголын загварын салбарын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлж, амжилтын төлөө хамтдаа ажиллах зорилготой төрийн бус байгууллага юм. Анх 2017 онд шинэ үеийн төлөөлөл болсон дизайнеруудын бүрэлдэхүүнтэй үүсгэн байгуулагдсан тус холбоо нь өнөөдрийг хүртэл идэвхтэй ажиллаж байна. Тус холбооны ерөнхийлөгчөөр BURO. олон улсын дижитал сэтгүүлийн Монгол дахь салбарын үүсгэн байгуулагч Ө.Содгэрэл ажилладаг.

ii. Монгол Улсын хувцас загварын салбарт тулгамдаж буй асуудал бэрхшээл

Монгол Улсын хувцас загварын салбарт тулгамдсан асуудлуудыг хүний нөөц, эко орчин, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон маркетинг, борлуулалт гэсэн таван чиглэлийн хүрээнд тодрууллаа.

ХҮНИЙ НӨӨЦ

- Нарийн мэргэжлийн хүний нөөц дутмаг.
- Чанаргүй олон сургууль, дизайнерууд байна.
- Маркетинг, менежмент, санхүү, хууль эрх зүйн мэдлэг дутмаг.

Хувцас загварын салбарт бэлтгэгдсэн боловсон хүчнээ эх орондоо байлгаж чадахгүй байна. Ихэнх чадварлаг хүмүүс нь Өвөр Монгол болон бусад орнуудад ажиллаж, амьдарч байна. Учир бусад улсууд амьдрахад илүү таатай орчин, нөхцөлөөр хангадаг. Мөн маш олон дизайнерууд байгаа ч оёдолчин, эсгүүрчид буюу үйлдвэрлэлийн ажил эрхэлдэг хүмүүс хангалтгүй байна. Хувцас загварын маш олон сургуулиуд байгаа ч багш болон сургалтын чанар, орчин муутай учраас ур чадвар муутай, мэргэшсэн мэргэжилтнүүд төгсдөггүй. Маркетинг, менежмент, санхүү, хууль эрх зүйн мэдлэг дутмаг.

ЭКО СИСТЕМ

- Спонсор, хөрөнгө оруулагч бага.
- ЖДҮ –ийн зээл авахад хүнд.
- Материал, түүхий эдийн гаалийн татвар өндөр.
- Шинээр үйл ажиллагаа эхлүүлж буй Start-up компаниудад татвар, НДШ –ийн татвар маш их дарамт учруулдаг.

Хувцас загварын салбарт спонсор, хөрөнгө оруулагчид байдаггүй. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас зээл өгдөггүй. Ихэнх загвар зохион бүтээгчид материал, түүхий эдээ импортлох авдаг. Гаалийн татвар үнэтэй байдаг. Шинээр үйл ажиллагаа эхлүүлж буй Start-up компаниудад татвар, НДШ-ийн татвар маш их дарамт учруулдаг. Тийм учраас загвар зохион бүтээгчид шинээр үйлдвэрлэл эрхэлж чадахгүй байна.

ДЭД БҮТЭЦ

- Бараа бүтээгдэхүүнээ экспорт хийх боломж бага.
- Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулахад зардал их, гэрээний хугацаа тогтвортой бус, гэнэт гэрээ цуцлах асуудал гардаг.
- Тоног төхөөрөмж их хэрэгтэй байдаг боловч өндөр үнэтэй байдаг. Мөн гаалийн татвар өндөр.
- Материалын судалгаа хийх газар цөөхөн төдийгүй өндөр үнэтэй байдаг.
- Хувцас загварын шоу зохион байгуулах талбай, танхим цөөн, төлбөр их.

Хувцас загварын салбарт бараа бүтээгдэхүүнээ экспорт хийх боломж бага байдгаас гадна түрээсийн байранд ихэнх загварын салбарынхан үйл ажиллагаа явуулдаг. Түрээсийн талбайд үйл ажиллагаа явуулахад зардал их, гэрээний хугацаа тогтвортой бус, гэнэт гэрээ цуцлах асуудлууд их тохиолддог байна. Хувцас үйлдвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжүүд өндөр үнэтэй байдаг. Мөн гаалийн татварын үнэ нэмэгддэг. Материалын судалгаа хийх газар цөөн төдийгүй өндөр үнэтэй байдаг. Ойролцоогоор 30 сая төгрөг. Хувцас загварын шоу зохион байгуулах талбай, танхим, заал цөөхнөөс гадна өндөр төлбөртэй байдаг.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Олон улсад суралцахад тэтгэлэг олгодоггүй.
- Гадаадын нэр хүндтэй загварын шоунд Монгол Улсаа төлөөлж оролцоход санхүүгийн хүндрэл тулгардаг.
- Монгол Улсдаа олон улсын үзэсгэлэн шоу арга хэмжээ зохион байгуулахад зардал их.

Оюутан, сурагчдад олон улсад хувцас загварын чиглэлээр суралцахад тэтгэлэг олгодоггүй. Гадаадын нэр хүндтэй загварын шоунд Монгол Улсаа төлөөлж оролцоход санхүүгийн хүндрэл тулгардаг. Үүнээс шалтгаалан хувцас загварын салбарын хамтын Олон улс дахь ажиллагаа өргөждөггүй. Монгол Улсдаа олон улсын үзэсгэлэн шоу арга хэмжээ зохион байгуулахад зардал их гардаг.

МАРКЕТИНГ, СУРТАЛЧИЛГАА

- Гадаад зах зээл дээр бараа бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж чаддаггүй.
- Эх орондоо байнгын хэрэглэгч бага. Эх орондоо бага танигдсан.
- ОУ-д эх орныхоо бренд барааг сурталчилсан сурталчилгаа бага.

Хямд зардлаар олон тоогоор үйлдвэрлэж чаддаггүй учраас олон хүмүүст өөрсдийн бараа бүтээгдэхүүнийг хүргэж чаддаггүй. Учир нь иргэд өөрсдийн эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн өндөр дүнтэй бараа бүтээгдэхүүнийг хэрэглэдэггүй. ОУ-д эх орныхоо бренд барааг сурталчилсан сурталчилгаа явуулдаггүй. Гадаад зах зээл дээр бараа бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж чаддаггүй.

Шигтгээ 34: Дотоодын зах зээлд туршлагажиж гаднын зах зээлд гарах


Монголдоо хийх гээд зорьж байгаа хүмүүсийг дэмжиж чадвал дотоодод боломж их байна. Бид өнөөдөр гаднын зах зээл дээр гарна гэж том том ярьж болох ч гэсэн дотоодынхоо зах зээл дээр брэндутгаараа хүлээн зөвшөөрөгдөж, тодорхой хэмжээний эргэлт борлуулалт хийсэн туршлагатай байж гаднын зах зээл дээр зөвшөөрөгдөнө.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

Ковид-19-ийн нөлөө Монголын загварын салбарт

- Худалдан авалт, борлуулалт огцом буурч эргэлтийн хөрөнгөгүй болсон.
- Гадаадаас түүхий эдийн татан авалт хийж чадахгүй байгаа.
- Үзэсгэлэн, загварын шоу зохион байгуулах боломжгүй байна.
- Цалингаа тавьж чадахгүйн улмаас хүний нөөцөө алдаж байна.
- Ажлын байрны түрээсийн төлбөрөө төлөхөд хүндрэлтэй болсон.
- 3 хувийн зээлд хамрагдах гэхэд орлого, барьцаа хөрөнгө хүрэхгүй, татварын өртэй зэрэг асуудал нөлөөлж зээлд хамрагдаж чадахгүй байна.

iii. Процессын зураглал



Хувцас загварын салбарын үйл ажиллагааны процессын зураглал дараах үндсэн 5 үе шатнаас бүрдэж байна.

5.8.2. Хувцас загварын салбарын статистик

Монгол Улсад хувцас загварын салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ийн тоо 2020 онд 902 байна. Харин хувцасны дизайнер, загвар зохион бүтээгч 201 бүртгэгджээ.

902 ХУВЦАС ЗАГВАРЫН САЛБАРТ ИДЭВХТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ААНБ, 2020 ОНД

201 ХУВЦАСНЫ ЗАГВАР ЗОХИОН БҮТЭЭГЧИД, 2020 ОНД

Эх үүсвэр: Уран бүтээлч, үзэсгэлэн галерейн асуулга судалгаа болон ҮСХ

i. Салбарын ААНБ -ын мэдээлэл

Хувцас загварын салбарын ААНБ -ын тоо, 2020 оны байдлаар:



2020 оны байдлаар хувцас загварын салбарт 1841 ААНБ бүртгэлтэй байгаагаас 902 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 78: Үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын салбарын ангилал, 2020 оны байдлаар

8. Хувцас загвар	902
Үслэг, арьсан эдлэл үйлдвэрлэл	37
Гутал үйлдвэрлэл	112
Нэхмэл болон сүлжмэл хувцас үйлдвэрлэл	191
Үслэг, арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл	562

ii. Салбарын ажиллагчдын тоон мэдээлэл

Нас, хүйсийн мэдээлэл

Хувцас загварын салбарт 2020 оны байдлаар нийт 20,484 ажиллагчид бүртгэлтэй байна. Үүний 18 хувийг эрэгтэй, 82 хувийг эмэгтэй ажиллагчид эзэлж байна.

НИЙТ АЖИЛЛАГЧДЫН ТОО




График 126: Салбарын ажиллагчдын дундаж нас, 2020 оны байдлаар



Ажиллагчдын ангилал

"Хувцас загварын салбарын ажиллагчдын тоон мэдээллийг ажиллагчдын албан тушаалаар задлан дараах хүснэгтэд харууллаа. Үүнээс "Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн ажиллагч" 64 хувийг эзэлж байна.

Хүснэгт 79: Ажиллагчдын ангилал


	Хувь
Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн ажиллагч	64%
Цалин хөлстэй байнгын ажиллагч	21%
Цалин хөлстэй түр ажиллагч	13%
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	2%
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	0%

Эх үүсвэр: ҮСХ, Ажиллах хүчний судалгаа

iii. Салбарын төгсөгчдийн тоо мэдээлэл

Хувцас загварын салбарын 2019-2020 оны хичээлийн жилд суралцаж төгссөн оюутны тоо мэдээлэл:

График 127: Хувцас загварын салбарын төгсөгчдийн нийт СБҮ-ийн төгсөгчдийн тоонд эзлэх хувь



6 их, дээд сургууль

19 ХӨТӨЛБӨР


Хувцас загварын салбарт 2019-2020 оны хичээлийн жилд 148 оюутан суралцаж төгссөн ба энэ нь нийт соёлын салбарын төгсөгчдийн 5 хувийг бүрдүүлж байна.

График 128: Хувцас загварын салбарын төгсөгчид, боловсролын зэрэг, хүйсээр, 2019-2020 оны хичээлийн жилд

Боловсролын зэрэг



Хүйс



Эх үүсвэр: БШУЯ, "Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн тоо мэдээлэл"



АРХИТЕКТУР

Architecture



Архитектур нь соёл иргэншилд бус соёлд хамаардаг.

Финлянд архитектор
Альвар Аалто



5.9. АРХИТЕКТУР

5.9.1. Архитектурын салбар

Архитектур нь бидний өвөг дээдэс гадаад орчноос хамгаалах байр барьсан цагаас эхэлсэн гэж хэлж болно. Бидний эргэн тойронд байгаа байшин барилга бүр өөр өөрийн гэсэн зориулалт, хэрэглээтэй байдаг. Жишээлбэл, цэцэрлэгийн барилга хоёроос илүү давхартай байж болохгүй гэсэн стандарт бий. Учир нь ямар нэгэн саад бэрхшээл, гамшиг тохиолдоход бага насны хүүхдүүд аль болох богино хугацаанд барилгаас гарах шаардлагатай байдаг байна.

Эртний Архитектурын тухай бодоход бид гайхамшигтай пирамид, Колизейн болон Стоунхенжийн талаар боддог билээ. Стоунхенж нь 5000 жилийн өмнө баригдсан бөгөөд тэр цагаас хойш архитектурын салбар тасралтгүй хөгжиж байна.

Нийгмийн үр өгөөж

Архитектурын салбарын нийгмийн үр өгөөжөөс дурдвал:

- Олон нийтийн сэтгэл зүйд эергээр нөлөөлнө: үйлчлүүлэгчдийг татах, ажиллагчдын бүтээмжийг нэмэгдүүлдэг.
- Хувь хүний биеэ авч явах байдал, хүмүүжилд шууд нөлөөлдөг.
- Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх гол хэрэглүүр.

2019 оны байдлаар АНУ-д архитектор мэргэжилтэй 129900 хүн байна. Энэхүү мэргэжил нь гоо зүйн мэдрэмж болон шинжлэх ухааны мэдлэгийг хослуулсан мэргэжил юм. Тэгвэл архитектор мэргэжлийн давуу талууд юу вэ? (Wonderful Benefits of a Career in Architecture, 2020)

Төсөөллөө бодит байдал дээр буулгана.

Дэлхийд өөрийн ул мөрийг үлдээнэ.

Олон төрлийн ажил, салбар луу хөрвөх боломжтой.

Олон оронд ажиллах бүрэн боломжтой.

Эдийн засгийн үр өгөөж

Барилга бол улс орны эдийн засгийн өсөлтөд ихээхэн хувь нэмэр оруулдаг чухал салбар юм. Барилгын салбар бол хөрөнгө оруулалт хийдэг салбар бөгөөд засгийн газартай хамгийн нягт нарийн холбоотой байх ёстой салбаруудын нэг юм. Засгийн газар барилгын салбартай эрүүл мэнд, тээвэр, боловсролын салбартай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэхээр хамтран ажилладаг.

АНУ -д архитекторуудын жилийн дундаж цалин одоогоор 89,560 доллар байна. Жилээс жилд архитекторуудын дундаж цалин улсын хэмжээнд тогтвортой өсөж байна. 2017 онд жилийн дундаж цалин архитекторуудын хувьд 87,500 доллар байсан бол 2018 онд 88,860 доллар, 2019 оны байдлаар 89,560 доллар байжээ (DePietro, 2020). Дизайн салбарын орлогын нэмэлт 1 доллар тус бүр ДНБ -д 1.55 доллар оруулдаг байна (Alisa Zevin, 2021).

i. Монгол Улсын архитектурын салбарын давуу тал онцлог, боломж

Хамтын удирдлагын байгууллага



Монголын архитекторуудын эвлэл 1956 онд байгуулагдсан. Олон улсын архитекторуудын эвлэл (UIA), Азийн архитекторуудын бүсийн зөвлөл (ARCA-SIA)-ийн гишүүн. Залуу, дунд үеийнхэн нь ажилдаа анхаарлаа хандуулаад эвлэлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдоггүй бол ахмадууд нь эвлэлийн үйл ажиллагаандаа идэвхтэй оролцдог.

Архитектурын салбарт байгаа боломж


Барилга угсралт, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж байгаа ба сайн хийц загвартай, чанартай барилга барьж чадвал цаашдын орж ирэх хөрөнгө оруулалтуудын нэмэгдүүлэх бүрэн боломжтой.

Аялал жуулчлалын объектуудыг олноор нь байгуулж, олон орны жуулчдыг татах боломжтой. Дотоодын аялагчдыг ч мөн идэвхжүүлж болно.

Салбар дахь ковид-19-ийн нөлөө, дижитал тренд

- Бүтээлдээ төвлөрөх цагтай болсон.
- Өөрөөр сэтгэх шаардлагатай болсон.
- Хөрөнгө оруулалтын хэмжээ буурч, ажлын олдоц буурах.


Дижитал тренд



3D принтер



AR & VR технологи



Мэдээллийн сан, программ хангамжийн хөгжил

ii. Монгол Улсын архитектурын салбарт тулгамдаж буй асуудал бэрхшээл

ХҮНИЙ НӨӨЦ

- Сургууль шаардлага хангахгүй.
- Архитектур бол барилгын зураг төсөл хийх гэсэн хэвшмэл буруу ойлголт тогтсон.
- Архитектурын шийдэл гаргадаг мэргэжилтэн хомс

Монгол Улсын архитектурын салбарт тулгамдсан асуудлуудыг хүний нөөц, эко орчин, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон маркетинг, борлуулалт гэсэн таван чиглэлийн хүрээнд тодрууллаа.

Архитектурын сургуулийн тоо, төгсөгчдийн тоогоор олон улсад дээгүүр ордог хэдий ч сургуулиудад чанарын шаардлага хангадаггүй. Сургалтын орчин, нөхцөл бололцоо дутмаг. Шинжлэх ухаан талаас нь заадаг хэдий ч урлагийн мэдлэг болон ур чадварыг орхигдуулдаг. Мөн дадлага хийх боломж багатай. Инженерийн бусад салбаруудтайгаа уялддаггүй. Архитектур бол барилгын зураг төсөл хийх гэсэн хэвшмэл буруу ойлголт тогтсон. Архитектурын шийдэл гаргадаг мэргэжилтэн хомс байдаг.

ЭКО СИСТЕМ

- Соёлын өвийг тодорхойлох, хамгаалах, сэргээн засварлах, эдийн засгийн эргэлтэд оруулах зохицуулалт хангалтгүй.
- Архитектурын шийдэл, оюуны бүтээл гарахгүй, гарсан ч оюуны өмч болж, хамгаалагдахгүй байна.
- ТЭЗҮ, хөгжлийн төлөвлөгөө дэх архитектур төлөвлөлт дутагдаж байна.
- Өртөг төсөв багатай зураг төслийг дэмжих хандлагатай.
- Улс төрийн болон ашиг сонирхлын зөрчил.

Архитектурын салбарт урт хугацааны төлөвлөлт, бодлогогүй. Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах, эдийн засгийн эргэлтэд оруулах зохицуулалт хангалтгүй байдаг. Архитекторууд архитектурын шийдэл, бүтээл гаргадаггүй. Гаргасан тохиолдолд оюуны өмчөөр хамгаалагддаггүй. Ихэнх төслүүд өртөг багатай зураг төслийг дэмжих хандлагатай байна. Улс төрийн болон ашиг сонирхлын зөрчил энэ салбарт үргэлж бий болдог.

ДЭД БҮТЭЦ

- Мэдээллийн сангийн дэд бүтэц – “санах ой” байхгүй.

Архитектурын мэдээллийн сан байдаггүй.

ДЭД БҮТЭЦ

- Бага төсөв, өртөгтэй төслүүдийг илүүд үздэг.

Төсвийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад бага төсөв, өртгийг илүүд үздэг. Аль болох бага төсөв шаардагдах төслийг дэмжин ажилладаг.

МАРКЕТИНГ, СУРТАЛЧИЛГАА

- Орчны төлөвлөлт, архитектурын талаарх ойлголт бага байдаг.
- Хандлага, үнэлэмж муу байгаагаас хөрөнгө оруулалтын үнэ цэн буурч байна.

Нийт иргэд орчны төлөвлөлт, архитектурын талаарх ойлголт бага, хандлага, үнэлэмж муу байгаагаас хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурч байна.

iii. Процессын зураглал





5.9.2. Архитектурын салбарын статистик

“Газар дээр хүний оюун ухаан, гараар гүйцэтгэж болох бүтээмж / бүтцүүдийг нийцүүлэн найруулж зохиомжлох мэргэжлийн ур чадвар, үйл ажиллагаа”-г архитектур гэж тодорхойлж болно. Архитектурын салбарт дараах үйл ажиллагааг хамруулж авч үзнэ.

- **Хот төлөвлөлт** – Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах;
- **Ландшафт архитектур** - Орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилтийн зураг төсөл боловсруулах;
- **Барилга архитектур** – Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл боловсруулах;
- **Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах үйл ажиллагаа** – Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалтын зураг төсөл боловсруулах (ЗТ-4.8), Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалт, угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил (БА-4.8).

Барилга хот байгуулалтын яамны мэдээллээр 2021 оны 5 сарын байдлаар зураг төслийн тусгай зөвшөөрөлтэй нийт 831 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагийн дотор давхардсан тоогоор:

- **Хот төлөвлөлтийн** чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 42 ААНБ,
- **Ландшафт архитектурын** буюу орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилтийн зураг төсөл боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 138 ААНБ,
- **Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл боловсруулах** чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 523 ААНБ,
- **Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалтын зураг төсөл боловсруулах** чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 11 ААНБ.

Түүнчлэн Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалт, угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 22 ААНБ тус тус байна.

Архитектурын салбарт давхардсан тоогоор 736 ААНБ-д 1,763 хүн ажиллаж байна. Салбарын нийт орлого 2019 оны байдлаар 122.1 тэрбум төгрөг байжээ.

Хүснэгт 80: Архитектурын салбарын аж ахуйн нэгж, ажиллагчдын тоо, салбарын орлого, 2020 оны байдлаар

Дэд салбар, үйл ажиллагаа	Аж ахуйн нэгжийн тоо	Ажиллагчдын тоо	Салбарын орлого, тэрбум төгрөгөөр
Хот төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах	42	220	6.0
Орчны төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах	138	281	10.1
Барилга архитектурын зураг төсөл боловсруулах	523	1,262	104.5
Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалтын зураг төсөл боловсруулах	11	-	-
Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалт, угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил	22	-	1.5
Бүгд	736	1,763	122.1

Тайлбар: Холбогдох мэдээллийн эх үүсвэрийг дэд бүлэг тус бүрээс харна уу


i. Хот төлөвлөлт

Барилгын хөгжлийн төвийн мэдээллээр 2021 оны 7 дугаар сарын байдлаар хот төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй 42 ААНБ байна.

Эдгээр ААНБ-ууд 2019 онд үндсэн үйл ажиллагаанаас 6.0 тэрбум төгрөгийн орлого олж, 638.8 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 91.2 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлжээ. Орчны ерөнхий төлөвлөлт, архитектур, барилга бүтээцийн зураг төсөл боловсруулах үйл ажиллагааг давхар эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг хасаж, давхардлын арилгаж тооцсон.

Барилгын хөгжлийн төвд бүртгэлтэй хот төлөвлөлтийн 124 мэргэжилтэн байна. Тэдний 76 нь буюу 61% нь эрэгтэй мэргэжилтнүүд байгаа бол дундаж нас нь 43 байна.

График 129: Хот төлөвлөлтийн мэргэжилтнүүдийн нас, хүйсийн бүтэц



Эх үүсвэр: Барилгын хөгжлийн төв

Эдгээр мэргэжилтнүүдийн 93 нь архитектор, 17 нь хот төлөвлөлтийн архитектор, эдийн засагч, 10 нь эдийн засагч, бизнесийн удирдлага, маркетингийн мэргэжилтэй байгаа бол 4 нь ландшафтын архитектор байна.

Тэднийг мэргэшлийн зэргээр нь авч үзвэл 23 нь хот төлөвлөлтийн зөвлөх архитектор, 82 нь мэргэшсэн архитектор, 18 нь хот төлөвлөлтийн эдийн засагч, 1 нь хот төлөвлөлтийн зөвлөх эдийн засагч байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийгмийн даатгалд даатгуулагчдын мэдээллийн сангаас Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 (YAMAT-08)-ын дагуу Хот байгуулалт, тээврийн хөдөлгөөн төлөвлөгч (ангиллын код 2164) нарын тоог авч үзэхэд 2020 онд 220 хүн уг ажил мэргэжлээр ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлжээ. Уг ажил мэргэжлээр ажиллагчдын тоо 2016-2020 онд жил дараалан өсөж, 2020 онд 2016 онтой харьцуулахад 2.7 дахин өсжээ. Энэ нь тухайн төрлийн мэргэжилтний эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгааг харуулж байна. Үүнийг дагаад тухайн төрлийн мэргэжилтнүүдийн цалингийн хэмжээ нэмэгдэж, 2020 онд сарын дундаж цалин 2,930.0 мянган төгрөгт хүрсэн нь 2016 онтой харьцуулахад 23%-аар өсжээ.

График 130: Хот байгуулалт, тээврийн хөдөлгөөн төлөвлөгч нарын тоо, сарын дундаж цалин, мян.төгрөгөөр



Эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Барилгын хөгжлийн төвийн мэдээллээр хот байгуулалтын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-ууд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө 32, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 34, ерөнхий төлөвлөгөө 53, техник эдийн засгийн үндэслэл 10, нийт 129 хот байгуулалтын баримт бичгийг боловсруулжээ.


Хүснэгт 81: Хот байгуулалтын боловсруулсан баримт бичгийн тоо, төрлөөр

ДД	Баримт бичгийн төрөл	Тоо
1	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	32
2	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	34
3	Ерөнхий төлөвлөгөө	53
4	Техник эдийн засгийн үндэслэл	10
Нийт		129

Эх үүсвэр: Барилгын хөгжлийн төв

Монгол Улсын төсвийн 2019 оны төсвийн тухай хуульд Аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий болон хилийн боомтуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах /Архангай, Дорноговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий, Сүхбаатар/ ажлыг 2019 онд 1.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр, 2020 оны төсвийн тухай хуульд Сумын төвийн дахин төлөвлөлтийн зураг төсөв /Архангай, Ихтамир сум/, Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Архангай, Өлзийт, Батцэнгэл, Эрдэнэмандал, Хашаат сум болон Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/-ний ажлыг 547.0 сая төгрөгөөр, 2021 оны төсвийн тухай хуульд Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/-ний ажлыг 145.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус заажээ.

График 131: Төсвийн тухай хуульд тусгагдсан хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний тухайн онд санхүүжих дүн, сая төгрөгөөр



Эх үүсвэр: Монгол Улсын 2019, 2020, 2021 оны төсвийн тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем - <https://www.legalinfo.mn/law/details/15726>

ii. Орчны ерөнхий төлөвлөлт

Барилгын хөгжлийн төвийн мэдээллээр 2021 оны 7 дугаар сарын байдлаар орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилтийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй 138 ААНБ байна. Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн жагсаалтад ААНБ-ууд давхардаж орсныг хасаж тооцов.

Эдгээр ААНБ-ууд 2019 онд үндсэн үйл ажиллагаанаас 10.1 тэрбум төгрөгийн орлого олж, 1.8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, 211.7 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлжээ. Хот төлөвлөлт, архитектур, барилга бүтээцийн зураг төсөл боловсруулах үйл ажиллагаа болон барилга, уул уурхай, худалдааны салбарын үйл ажиллагааг давхар эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг хасаж, давхардлыг арилгаж тооцсон.

Барилгын хөгжлийн төвд бүртгэлтэй ландшафт, орчны төлөвлөлтийн 77 мэргэжилтэн байна. Тэдний 48 нь буюу 62% нь эрэгтэй мэргэжилтнүүд байгаа бол дундаж нас нь 32 байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийгмийн даатгалд даатгуулагчдын мэдээллийн сангаас Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 (YAMAT-08)-ын дагуу Газар тохижуулалтын архитектор (ангиллын код 2162) нарын тоог авч үзэхэд 2020 онд 281 хүн уг ажил мэргэжлээр ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлжээ. Уг ажил мэргэжлээр ажиллагчдын тоо 2020 онд 2016 онтой харьцуулахад 9%-аар өсжээ. Тухайн төрлийн мэргэжилтнүүдийн сарын дундаж цалингийн хэмжээ 2020 онд 971.2 мянган төгрөгт хүрсэн нь 2016 онтой харьцуулахад 29%-аар нэмэгджээ.


График 132: Газар тохижуулалтын архитектор нарын тоо, сарын дундаж цалин, мян.төгрөгөөр



Эх үүсвэр: НДЕГ

Барилгын хөгжлийн төвийн мэдээллээр хот байгуулалтын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-ууд 2016 онд 750 орчны төлөвлөлтийн зураг төсөл боловсруулж байсан бол 2020 онд 2,336 орчны төлөвлөлтийн зураг төсөл боловсруулсан нь 1,586 зураг төслөөр буюу 3.1 дахин нэмэгджээ.

График 133: Боловсруулсан орчны төлөвлөлтийн зураг төслийн тоо



Эх үүсвэр: Барилгын хөгжлийн төв

iii. Барилга архитектур

Барилгын хөгжлийн төвийн мэдээллээр 2021 оны 7 дугаар сарын байдлаар Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй 523 ААНБ байна.

График 134: Барилгын архитектор нарын тоо, сарын дундаж цалин, мян.төгрөгөөр



Эх үүсвэр: НДЕГ

Барилга, хот байгуулалтын яамны мэдээллээр барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй ААНБ-ууд 2016 онд нийт 881 зураг төсөл боловсруулж байсан бол 2020 онд 2,009 зураг төсөл боловсруулсан нь 1,128 зураг төслөөр буюу 2.3 дахин нэмэгджээ. Эдгээр аж ахуйн нэгж, байгууллагын 2020 онд боловсруулсан зураг төслийн 806 нь буюу 40% нь орон сууцны бус барилгын, 663 нь буюу 33% нь инженерийн байгууламжийн, 269 болон 271 нь буюу 13% нь харгалзан орон сууцны барилгын болон их засварын ажлын зураг төсөл байжээ.

Эдгээр ААНБ-ууд 2019 онд үндсэн үйл ажиллагаанаас 104.5 тэрбум төгрөгийн орлого олж, 2.5 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, 963.3 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлжээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийгмийн даатгалд даатгуулагчдын мэдээллийн сангаас Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 (YAMAT-08)-ын дагуу Барилгын архитектор (ангиллын код 2161) нарын тоог авч үзэхэд 2020 онд 1,262 хүн уг ажил мэргэжлээр ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлжээ. Уг ажил мэргэжлээр ажиллагчдын тоо 2020 онд 2016 онтой харьцуулахад 15%-аар өсжээ. Тухайн төрлийн мэргэжилтнүүдийн сарын дундаж цалингийн хэмжээ 2020 онд 1,246.2 мянган төгрөгт хүрсэн нь 2016 онтой харьцуулахад 14%-аар нэмэгджээ.

Хүснэгт 82: Барилга байгууламжийн зураг төслийн тоо


ДД	Ажлын үндсэн төрөл	2016	2017	2018	2019	2020
1	Орон сууцны барилга	142	142	211	255	269
2	Орон сууцны бус барилга	369	445	738	928	806
3	Инженерийн байгууламж	328	345	507	626	663
4	Их засварын ажил	42	96	209	282	271
	Нийт	2,897	3,045	3,683	4,110	4,029

Эх үүсвэр: Барилга, хот байгуулалтын яам

iv. Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалт

Барилга хот байгуулалтын яамны бүртгэл мэдээллээр Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалтын зураг төсөл боловсруулах (ЗТ-4.8) тусгай зөвшөөрөлтэй 11 аж ахуйн нэгж, Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалт, угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил (БА-4.8)-ын тусгай зөвшөөрөлтэй 22 аж ахуйн нэгж байна. Монгол Улсын төсвийн 2020 оны төсвийн тухай хуульд Гандантэгчилэн хийдийн түүх соёл, шашны дурсгалт зүйлийг сэргээн тохижуулах барилгын ажил, Эрдэнэзуу хийдийн барилгын их засварын ажлыг 2020 онд 700 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр, 2021 оны төсвийн тухай хуульд дээрх ажлууд болон соёлын өвийг сэргээн засварлах /Архангай, Батцэнгэл сум, Авга дугана, Архангай, Өлзийт сум, Өөлд Бээсийн хийд/ ажлыг 1,450.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус заажээ.

График 135: Төсвийн тухай хуульд Соёлын сайдын багцад тусгагдсан түүх соёлын өвийг сэргээн засварлах ажлын тухайн онд санхүүжих дүн, сая төгрөгөөр




Эх үүсвэр: Монгол Улсын 2019, 2020, 2021 оны төсвийн тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем - <https://www.legalinfo.mn/law/details/15726>

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогоор 86,157 үл хөдлөх дурсгалыг тоолж бүртгэсний 2,820 нь барилга, архитектурын дурсгал байсан бөгөөд нийт дурсгалын гурван хувийг эзэлж байна. Улсын хамгаалалтад байгаа 185 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг судалж үзэхэд 54 дурсгал нь, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх 607 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 111 дурсгал нь Барилга, архитектурын дурсгал байна. Судалгааны хүрээнд сум, дүүргээс нийт 3,739 дурсгалын мэдээ, бүртгэл ирснээс, сум болон дүүргийн хамгаалалтад давхардсан байдлаар барилга, архитектурын 189 дурсгал хамрагдсан байна. Нийт дүнгээр улсын хэмжээнд 354 барилга, архитектурын дурсгал улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтад байх жагсаалтад орсон байна.³¹

v. Салбарын гадаад худалдааны үзүүлэлтүүд

Архитектурын салбарын бараа бүтээгдэхүүний экспорт, импортын хэмжээг сүүлийн арван жилийн байдлаар дараах графикт харуулж байна.

График 136: Архитектурын салбарын импортын хэмжээ, 2010-2020 оны байдлаар



³¹ "Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл – Зөвлөх үйлчилгээний төгсгөлийн тайлан", Барилга хот байгуулалтын яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА), 2021 оны 4 сар.

График 137: Архитектурын салбарын экспортын хэмжээ, 2010-2020 оны байдлаар



Гадаад худалдаа, импортын тоо мэдээлэл

0.01%



Архитектурын салбарын нийт импортын дүнд эзлэх хувь, 2020 он

Архитектурын салбарын импортын хэмжээ 2010 онд 7,369 ам.доллар байжээ. Сүүлийн арван жилийн хугацаанд 2018 онд хамгийн өндөр буюу 3,539,493 ам.долларт хүрсэн байна. 2020 онд 12,073 ам.доллар байсан ба нийт соёлын салбарын импортын хэмжээний 0,01 хувийг эзэлж байна.

Зураг 47: Архитектурын салбарын гадаад худалдааны хэмжээ, мянган ам.доллар

\$ 12.1 мянга

Архитектурын салбарын импортын хэмжээ, 2020 оны байдлаар

Гадаад худалдаа, экспортын тоо мэдээлэл

0.00%



Архитектурын салбарын нийт экспортын дүнд эзлэх хувь, 2020 он

Архитектурын салбарын экспортын хэмжээ 2014 онд 52 ам.доллар байжээ. 2015, 2016 онд тус салбарын экспортын хэмжээ буурч 10, 7 ам.долларт хүрсэн байна. Бүтээгдэхүүний төрөл зүйлээр харвал импортын бараа бүтээгдэхүүнийг зураг төсөл, экспортын бараа бүтээгдэхүүнийг баримт бичиг дийлэнх хувийг бүрдүүлж байна.

\$ 0


Архитектурын салбарын экспортын хэмжээ, 2020 оны байдлаар

Эх үүсвэр: ГЕГ, гадаад худалдааны бараа бүтээгдэхүүний хэмжээ

vi. Салбарын төгсөгчдийн тоо мэдээлэл

Архитектурын салбарын 2019-2020 оны хичээлийн жилд суралцаж төгссөн оюутны тоо мэдээлэл:

График 138: Архитектурын салбарын төгсөгчдийн нийт СБҮ-ийн төгсөгчдийн тоонд эзлэх хувь




**7 их, дээд сургууль
21 ХӨТӨЛБӨР**

Архитектурын салбарт 2019-2020 оны хичээлийн жилд 273 оюутан суралцаж төгссөн ба энэ нь нийт соёлын салбарын төгсөгчдийн 9 хувийг бүрдүүлж байна.

График 139: Архитектурын салбарын төгсөгчид, боловсролын зэрэг, хүйсээр, 2019-2020 оны хичээлийн жилд

Боловсролын зэрэг

Дипломын боловсролыг	5
Бакалаврын боловсролыг	256
Магистрын боловсролыг	12
Докторын боловсролыг	0



Хүйс

Эх үүсвэр: БШУЯ, "Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн тоо мэдээлэл"

ДИЗАЙН

Design



10



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
СОЁЛЫН ЯАМ

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
СУУРЬ СУДАЛГАА | 2021

5.10. ДИЗАЙН

5.10.1. Дизайны салбар

Дизайн бол орчин үеийн ертөнцийн хамгийн чухал зүйлсийн нэг бөгөөд үүнгүйгээр амьдралыг төсөөлөхөд бэрх болсон билээ. Дизайны гол зорилго нь хүний хэрэглээний чанарыг сайжруулахад оршино.

Нийгмийн үр өгөөж

Бид эргэн тойронд байгаа бүхий л зүйлсээсээ дизайн олж харах боломжтой. Үзэг л гэхэд том гартай хүнд зориулсан, дөнгөж бичиж сурч байгаа хүүхдэд зориулсан гээд л бүх зүйлс өөр өөрсдийн гэсэн дизайнтай.



iMac суурин компьютерын жишээг авч үзье. 1998 онд компьютерын загвар өргөн зузаан, 18 кг жинтэй байв. Мэдээж, байрыг нь өөрчлөхөд нэлээн их хүчин чармайлт гарах нь ойлгомжтой. Харин өнөөдөр iMac суурин компьютер нимгэхэн, илүү том дэлгэцтэй, ердөө л 4.5 кг жинтэй болсон байна. Хэрэглэхэд илүү амархан, авсаархан, хүний хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн болсон байгаа юм. Энэ мэтчилэн загвар, дизайн бидний амьдралд үр өгөөжөө үзүүлдэг байх нь ээ.

“

Дизайн
бол нүдэнд
харагдахуйц
оюун ухаан юм.

Зохиолч Алина Уилер

”

Эдийн засгийн үр өгөөж

АНУ-д дизайнераар ажиллаж буй хүмүүсийн тоо 0.00687%-иар өсөж, 2016 онд 786.017 хүн байсан бол 2017 онд 786.071 хүн болж өсжээ. Мэргэшсэн дизайны үйлчилгээнд дизайнеруудын хамгийн их хувийг 20.1% эзэлдэг бол архитектур, инженерчлэл, холбогдох үйлчилгээний салбарт 7.99%, жижиглэн худалдаачид 4.87%-ийг эзэлдэг.

2017 онд Дизайнерууд дунджаар 55,731 доллар олсон нь улсын дундаж цалин 55,524 доллароос 207 доллар илүү байна (Designers, 2017).

i. Монгол Улсын дизайны салбарын хөгжлийн түвшин, давуу тал онцлог, боломж

Хамтын удирдлагын байгууллага

Монголын дизайны салбарт нэгдсэн мэргэжлийн холбоо байдаггүй. Гэхдээ дизайны салбар нь судалгаа, сургалтын байгууллагад түшиглэн график дизайн болон интерьер дизайн салбартай хамтран мэргэжлийн холбоо байгуулах бүрэн боломжтой. Дараах холбоодтой хамтарч ажиллах боломжтой.



МОНГОЛЫН
УРЧУУДЫН ЭВЛЭЛ



МОНГОЛЫН
АРХИТЕКТОРУУДЫН
ЭВЛЭЛ



МОНГОЛЫН
УРЛАГИЙН
ЗӨВЛӨЛ

Дизайны салбарт байгаа боломж

Монгол Улсын дизайнерууд олон улсын чадварлаг дизайнеруудтай хамтран өөрсдийн ур чадварыг сайжруулах боломжтой. Хэрвээ мэргэжлийн ур чадварыг нь хангалттай сайн хөгжүүлэх нөхцөлөөр хангаж чадвал Соёлын өвийн баялаг, авьяас, хүний нөөц хангалттай бий. Жуулчдад зориулсан бэлэг дурсгал, гар урлалын үйлдвэрлэлийг дэмжин ажиллаж, цаашид хөгжих боломжтой. Арьс шир, ноос зэрэг малын гаралтай түүхий эдээр илүү үнэ цэн шингэсэн цөөн тоотой брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, олон улсын тавцанд таниулах боломж бий.

Дизайны салбарын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөж

Нийгмийн үр өгөөж:

- Дангааршил - ондоошил
- Монгол Соёлын өвыг залуу үед хүргэх агуулга
- Хэрэглээгээр дамжуулж гоо зүй, урлагийн мэдрэмжийг хэрэглэгчдэд хүргэх
- Бүтээлч үндэстэн – дизайн сэтгэлгээ, стартап, энтерпрайнор сэтгэлгээг бий болгох
- ЖДҮ, орон нутаг дахь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх
- Дэлхийн трендэд Монгол Улсын хувь нэмрийг оруулах

Эдийн засгийн үр өгөөж:

- Илүү цэнэ шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ – үндэсний үйлдвэрлэлийг дэмжигч
- Нөөцийн хэмнэлттэй, тогтвортой үйлдвэрлэл - хэрэглээ
- Аж үйлдвэрийн 4-р хувьсгал дахь бидний оролцоо

Материал судлалын лабораториуд



Салбар дахь ковидын үр нөлөө, дижитал тренд


Эерэг үр нөлөө:

- Бүтээлдээ төвлөрөх цагтай болсон.
- Зургийн ажлаа гэртээ онлайнар хийх, бүтээлдээ төвлөрөх.

Сөрөг үр нөлөө:

- Материалын үнийн өсөлт, хомсдол.
- Гүйцэтгэлийн ажлууд зогссон.


Дижитал тренд



3D принтер



Бүтээгдэхүүний дизайны программ хангамж



AR & VR технологи

ii. Монгол Улсын дизайны салбарт тулгамдаж буй асуудал бэрхшээл

Монгол Улсын дизайны салбарт тулгамдсан асуудлуудыг хүний нөөц, эко орчин, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон маркетинг, борлуулалт гэсэн таван чиглэлийн хүрээнд тодрууллаа.

ХҮНИЙ НӨӨЦ

- Үйлдвэрийн газар цөөн - ажлын байр хомс байдаг.
- Оюутнуудад тэтгэлэг олгодоггүй.

Монголын дизайны салбарт үйлдвэрийн газар цөөн, ажлын байр хомс байдаг. Тийм ч учраас төгсөгчид мэргэжлээрээ ажиллах боломж багатай. Судалгаа туршилт хийх, бүтээгдэхүүн хөгжүүлэх боломж хомс байдаг. Оюутнуудад тэтгэлэг олгодоггүй.

Шигтгээ 35: График дизайнерыг сургалтын тэтгэлгийг нэмэгдүүлэх

Манай салбарт сургалтын тэтгэлэг олоход хэцүү. Анимэйшн салбарт дотоодод болон гадаадад цөөхөн хүмүүс сурдаг. Өнөөдрийн хэмжээнд 3D анимэйшн хийх боломж бага байна. Богино хэмжээний кино хийх боломжийг нээгээд өгмөөр байна.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

ЭКО СИСТЕМ

- Салбарын бодлого, зохицуулалт тодорхойгүй.
- СБҮ-ийн бусад салбар болон ЖДҮ-тэй уялдаагүй явж ирсэн.
- Интерьер дизайны шийдэл оюуны өмч, зохиогчийн эрхээр баталгааждаггүй..

Салбарын бодлого, зохицуулалт тодорхойгүй ажилладаг. СБҮ-ийн бусад салбар болон ЖДҮ-тэй уялдаагүй явж ирсэн. Интерьер дизайны шийдэл оюуны өмч, зохиогчийн эрхээр баталгааждаггүй.

ДЭД БҮТЭЦ

- Судалгаа, туршилтын лабораторийн үйл ажиллагаа хязгаарлагдмал.
- Шинжлэх ухаан, технологи, инновацийн үйл ажиллагаанд дизайны асуудлыг орхигдуулдаг.
- Орон нутгийн ЖДҮ-ийн болон гар урлалын бүтээгдэхүүн дизайн гологддог.
- Зөвхөн интерьер дизайны шийдэл гаргаж өгдөг дизайнер, компаниудын хувьд материал, технологийн дутагдалтай байдлаас шалтгаалж бодит ажил болдоггүй.

Судалгаа, туршилтын лабораторийн үйл ажиллагаа хязгаарлагдмал байдаг ба шинжлэх ухаан, технологи инновацийн үйл ажиллагаанд дизайны асуудлыг орхигдуулдаг. Орон нутгийн ЖДҮ-ийн болон гар урлалын бүтээгдэхүүн дизайн гологддог. Дизайн, загвар муутай байдаг. Зөвхөн интерьер дизайны шийдэл гаргаж өгдөг дизайнер, компаниудын хувьд материал, технологийн дутагдалтай байдлаас шалтгаалж бодит ажил болдоггүй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Үйлдвэрлэгчид болон ЖДҮ нарт хөрөнгө оруулдаггүй.
- Интерьерийн зургийн төсвийг оруулдаггүй.
- ЖДҮ нарт татвар, НДШ маш хүнд тусдаг.

Үйлдвэрлэгчид болон ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан бүтээгдэхүүний брэндиг дизайн хөрөнгө оруулалт хийж чаддаггүй. Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга, байгууламжийн зураг төслийн зардалд интерьерийн зургийн төсвийг оруулдаггүй. ЖДҮ нарт татвар, НДШ маш их дарамт болдог.

Шигтгээ 36: Start-Up компаниудад татварын таатай нөхцөл бүрдүүлэх

Татварын орчин маш хүнд байна. Дөнгөж өсөж яваа шинэ бизнес эрхлэгч нарт татвар маш их дарамт болдог. Бид бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн төлөө, салбартаа хөрөнгө оруулахын төлөө ажиллаж байна. Гэтэл цалин тавихад НДШ маш өндөр төлдөг. Гаднаас бараа оруулж ирэх, наймаа хийх нь дээр ч юм уу гэсэн бодолд хүрч байна.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

МАРКЕТИНГ, СУРТАЛЧИЛГАА

- Иргэд дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн муу гэсэн ойлголттой.
- Монголын Урлагийн түүхийн судалгаа, бүтээл байдаггүй.
- Үндэсний интерьер дизайнеруудын шийдлийн талаарх мэдээлэл хомс.


Дизайн, интерьерийн салбарын маркетинг, борлуулалтын хувьд дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний брэндиг, дизайн муу гэсэн олон ойлголт, хандлага хэрэглэгчдийн дунд байдаг. Монгол Улсад Монголын Урлагийн түүхийн судалгаа, бүтээл байдаггүй. Үндэсний интерьер дизайнеруудын шийдлийн талаарх мэдээлэл хомс байдаг.

iii. Процессын зураглал

Дизайны салбарын процессын ерөнхий зураглал



Интерьер дизайны процессын зураглал



5.10.2. Дизайны салбарын статистик

Дизайны салбарт хүний хэрэглээний эд зүйл, орон сууц, худалдаа, үйлчилгээ, ажлын байрны орчны дизайныг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх бүхий л үйл ажиллагааг хамруулан авч үзнэ. Энэ утгаараа уг салбарт дараах салбар, үйл ажиллагааг хамруулан авч үзнэ:

- **Үйлдвэрлэлийн дизайн** буюу хөнгөн үйлдвэрлэлийн салбарын аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчид, тэдгээрийн загвар дизайныг зохион бүтээгчид;
- **Интерьер дизайн** буюу интерьерийн зураг төсөл боловсруулах болон интерьерийн гүйцэтгэлийн ажил гүйцэтгэгчид болон тэдгээртэй холбогдох үйлдвэрлэл, худалдаа;

Дизайны салбарт давхардсан тоогоор 2,889 ААНБ-д 9,787 хүн ажиллаж байна. Салбарын нийт орлого 2020 оны байдлаар 507.6 тэрбум төгрөг байжээ.

Хүснэгт 83: Дизайны салбарын аж ахуйн нэгж, ажиллагчдын тоо, салбарын орлого, 2020 оны байдлаар

Дэд салбар, үйл ажиллагаа	Аж ахуйн нэгжийн тоо	Ажиллагчдын тоо*	Салбарын орлого, тэрбум төгрөгөөр
Үйлдвэрлэлийн дизайн	2,827	8,710	490.0**
Интерьер дизайн	62	1,077	17.6
Бүгд	2,889	9,787	507.6

Тайлбар: Холбогдох мэдээллийн эх үүсвэрийг дэд бүлэг тус бүрээс харна уу.

Тайлбар: * - Тухайн салбарт хамаарах дизайнер зэрэг бүтээлч ажилтны тоогоор тооцов.

** - Хөнгөн үйлдвэрийн салбарын нийт борлуулалтын орлогын 18%-аар тооцов.

i. Үйлдвэрлэлийн дизайн

Хөнгөн үйлдвэрийн салбарын үзүүлэлтүүд: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны мэдээллээр 2019 оны байдлаар 2,827 үйлдвэрт 49.1 мянган хүн ажиллаж, 2.8 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2.2 их наяд төгрөгийн борлуулалт хийжээ. Эдгээр үйлдвэрийн дүнгээр 472.3 сая ам.долларын экспортыг тухайн жилд хийжээ.

Зураг 48: Хөнгөн үйлдвэрийн салбарын үзүүлэлтүүд, 2019 оны байдлаар

Салбар	Үйлдвэр	Ажиллах хүчин	Үйлдвэрлэл /Тэрбум төг/	Борлуулалт /Тэрбум төг/	Экспорт /Сая ам.доллар/
Ноос, ноолуур	670	21700	1,380.0	1,300.0	434.6
Арьс шир	150	4225	20.8	20.1	14.1
Оёдол	300	2000	516.4	43.2	21.3
Модон эдлэл, тавилга	450	6000	288.4	232.1	0.604
Барилгын материал	850	7000	248.3	261.2	-
Хэвлэл	300	4000	110.5	76.0	0.05
Сая баглаа боодол	50	2000	160.0	200.0	-
Дахин боловсруулах	27	2000	31.5	34.7	1.2
Гоо сайхан, ахуйн хими	30	200	8.0	4.0	0.5
Нийт	2827	49125	2763.9	2171.3	472.3

Эх үүсвэр: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Дизайны салбарт ажиллагчдын тоо: Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийгмийн даатгалд даатгуулагчдын мэдээллийн сангаас Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 (YAMAT-08)-ын дагуу салбарт хамаарах мэргэжилтэн, ажиллагчдын тоог авч үзэхэд 2020 онд 8,710 хүн эдгээр ажил мэргэжлээр ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлжээ. Үүнийг дээр дурдсан ХХААХҮЯ-ны хөнгөн үйлдвэрийн салбарын нийт ажиллагчдын тоонд харьцуулбал 18% болж байна.

Хөнгөн үйлдвэрийн салбарын нийт орлогод дизайны буюу бүтээлч үйл ажиллагааны эзлэх хувийг нийт ажиллагчдын тоон дахь бүтээлч ажиллагчдын эзлэх хувийг ашиглан тооцвол

Хүснэгт 84: Хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах мэргэжилтэн, ажиллагчдын тоо, YAMAT-08 ангиллаар


Анги нэршил	2016	2017	2018	2019	2020
Бүтээгдэхүүн, хувцасны дизайнер	50	139	167	179	205
Хөгжмийн зэмсэг хийгч, хөглөгч	15	23	30	34	45
Эрдэнийн чулуу, үнэт металлын ажилтан	409	16	16	41	40
Ваар, шавар эдлэлийн ажилтан	-	1	-	1	4
Шилэн эдлэл хийгч, зүсэгч, зүлгэгч, өнгөлөгч	-	-	1	4	6
Хаяг, зарлал, гоёл чимэглэлийн зураач, будагч, сийлбэрч, зураг хээ гаргагч	4	13	12	13	18
Модоор гар урлалын зүйл, сагс зэргийг хийгч	8	12	21	21	28
Нэхмэл, даавуу, арьс, бусад материалаар гар урлалын зүйлс хийгч	59	100	101	146	177
Энэ ангилалд ороогүй гар урлалын зүйл хийгч	26	50	49	56	59
Хэвлэгч	119	149	188	274	221
Оёдолчин, загварчин, үслэг эдлэл, малгай хийгч	1,013	897	770	757	592
Хувцас болон бусад төрлийн зүйлд үлгэр гаргагч, хувилагч, эсгүүрчин	133	246	318	350	364
Оёдолчин, хатгамалчин, бусад ажилтан	3,262	4,525	5,637	6,714	6,440
Тавилгын бүрээс хийгч, бусад холбогдох ажилтан	10	44	60	27	37
Ангийн үс, арьс шир боловсруулагч	149	194	236	207	167
Гуталчин, холбогдох бусад ажилтан	128	180	272	274	307
Дүн	5,385	6,589	7,878	9,098	8,710

Эх үүсвэр: НДЕГ

* Тайлбар: Тухайн онд нэг даатгуулагч олон ажил мэргэжил дээр бүртгэгдсэн бол ажил мэргэжил тус бүрд тоологдсон болно.

Сүүлийн 5 жилийн хугацаанд буюу 2016-2020 оны хооронд Бүтээгдэхүүн, хувцасны дизайнер нарын тоо жил бүр нэмэгдэж, 2020 онд 205 болжээ.

График 140: Бүтээгдэхүүн, хувцасны дизайнер нарын тоо



Эх үүсвэр: НДЕГ

Бүтээгдэхүүний загвар: Тухайн улс орны үйлдвэрлэл, дизайны хөгжил, иргэдийн бүтээлч байдлын түвшнийг илэрхийлэх үзүүлэлт нь тухайн улсад болон олон улсад гаргасан бүтээгдэхүүний загвар (industrial design)-ын мэдүүлэг, тэдгээрт олгосон патентын тоо байж болно.

Шигтгээ 37: Оюуны өмчийн тухай хууль

5.1. Оюуны өмчийн дараах эрхийг хамгаална:

5.1.1. зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх;

5.1.2. аж үйлдвэрийн өмчийн эрх.

7.1. Аж үйлдвэрийн өмчийн эрхэд дараах зүйл хамаарна:

7.1.1. шинэ бүтээл;

7.1.2. ашигтай загвар;

7.1.3. бүтээгдэхүүний загвар;

7.1.4. барааны тэмдэг;

7.1.5. газар зүйн заалт.

7.3. Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохих журмын дагуу энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3-т заасан зүйлийг бүртгэж патент, 7.1.4, 7.1.5-д заасан зүйлийг бүртгэж гэрчилгээ тус тус олгоно.

Шигтгээ 38: Патентын тухай хууль

3.1.2. "бүтээгдэхүүний загвар" гэж бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг;

3.1.4. "патент" гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг;

3.1.6. "зохиогч" гэж оюуны бүтээлч үйл ажиллагаагаар шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиосон хувь хүнийг;

Оюуны өмчийн газар (ОӨГ) 2020 онд 293 бүтээгдэхүүний загварын мэдүүлэг хүлээн авсан нь 2019 онтой харьцуулахад 7 мэдүүлгээр буюу 2.3%-аар буурчээ. 2020 онд 225 бүтээгдэхүүний загварын патент олгосон нь өмнөх оныхоос 10 патентаар буюу 4.7%-аар өсжээ. Патентын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д зааснаар бүтээгдэхүүний загварын патент 10 жил хүчинтэй байдаг бөгөөд 2020 оны байдлаар 2,643 бүтээгдэхүүний загварын патент хүчинтэй байна.

Хүснэгт 85: Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг, олгосон патент болон хүчинтэй байгаа патентын тоо


	2018	2019	2020
Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг - бүгд	269	300	293
Дотоодын мэдүүлэг	140	180	167
Иргэн	65	88	82
Хуулийн этгээд	75	92	85
Гадаадын мэдүүлэг	38	3	4
Иргэн	-	1	1
Хуулийн этгээд	38	2	3
Гаалийн хэлэлцээрийн дагуу мэдүүлсэн олон улсын мэдүүлэг	91	117	122
Иргэн	-	4	6
Хуулийн этгээд	91	113	116
Олгосон бүтээгдэхүүний загварын патент - бүгд	271	215	225
Дотоодын мэдүүлэг	143	95	102
Гадаадын мэдүүлэг	40	3	1
Гаалийн хэлэлцээрийн дагуу мэдүүлсэн олон улсын мэдүүлэг	88	117	122
Хүчинтэй байгаа бүтээгдэхүүний загварын патент	3,742	3,279	2,643

Эх үүсвэр: Оюуны өмчийн газар

Дэлхийн оюуны өмчийн байгууллага (ДОӨБ)-ын “Дэлхийн оюуны өмчийн үзүүлэлтүүд-2020” тайланд дурдсанаар дэлхийн хэмжээнд 154 оюуны өмчийн байгууллагаар дамжуулан 2019 онд 1.4 сая бүтээгдэхүүний загварын 1.0 сая мэдүүлэг хүлээн авсан нь 2018 оноос бүтээгдэхүүний загварын тоо 1.3%-аар, мэдүүлгийн тоо 1.7%-аар нэмэгджээ. Нийт бүтээгдэхүүний загварын мэдүүлгийн тоогоор Хятад, Европын холбоо, БНСУ, АНУ, Турк зэрэг улсууд тэргүүлж байна.

Нэг сая (1,000,000) хүнд ногдох бүтээгдэхүүний загварын мэдүүлгийн тоогоор БНСУ тэргүүлж байгаа бөгөөд уг үзүүлэлт тус улсын хувьд 2019 онд 1,187 байжээ. Энэ үзүүлэлт Украинд 105, АНУ-д 70, ОХУ-д 31, Бразилд 20, Энэтхэгт 7 байжээ. Монгол Улсын хувьд 2019 оны байдлаар 1,000,000 хүнд ногдох бүтээгдэхүүний загварын мэдүүлгийн тоо 91 байжээ.

График 141: Нэг сая (1,000,000) хүнд ногдох бүтээгдэхүүний загварын мэдүүлгийн тоо, 2019 оны байдлаар



Эх үүсвэр: WIPO, “World Intellectual Property Indicators 2020”

Барааны тэмдэг: Дизайны салбарын бүтээгдэхүүн нь барааны тэмдэг (trademark) буюу иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийлэл байж болно.

Шигтгээ 39: Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль

3.1.1. “барааны тэмдэг” гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг;
4.1. Барааны тэмдэг нь үг, дүрс, үсэг, тоо, гурван хэмжээст дүрс, өнгө, дуу авиа, үнэр, эсхүл тэдгээрийг хосолсон байдлаар илэрхийлэгдэж болно.

Оюуны өмчийн газар 2020 онд 4,193 барааны тэмдгийн мэдүүлэг хүлээн авсан нь 2019 онтой харьцуулахад 413 мэдүүлгээр буюу 9%-аар буурчээ. 2020 онд 4,028 барааны тэмдэгт эрхийн хамгаалалтын гэрчилгээ олгосон нь өмнөх оныхоос 101 барааны тэмдгээр буюу 2.6%-аар өсжээ. Бараа тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д зааснаар барааны тэмдгийн гэрчилгээ 10 жил хүчинтэй байдаг бөгөөд 2020 оны байдлаар 50,809 барааны тэмдгийн гэрчилгээ хүчинтэй байна. Хүчинтэй барааны тэмдгийн тоо сүүлийн гурван жилийн хугацаанд жил дараалан 5%-5.9%-аар нэмэгджээ.

Хүснэгт 86: Барааны тэмдгийн мэдүүлэг, олгосон патент болон хүчинтэй байгаа патентын тоо

	2018	2019	2020
Барааны тэмдгийн мэдүүлгийн нийт тоо	4,374	4,603	4,190
Дотоодын мэдүүлэг	1,431	1,581	1,663
Иргэн	354	480	529
Хуулийн этгээд	1,077	1,101	1,134
Гадаадын мэдүүлэг	576	619	529
Иргэн	5	20	7
Хуулийн этгээд	571	599	522
Мадридын хэлэлцээр болон Протоколын дагуу мэдүүлсэн олон улсын мэдүүлэг	2,367	2,403	1,998
Иргэн	10	58	52
Хуулийн этгээд	2,357	2,345	1,946
Эрхийн хамгаалалт олгосон барааны тэмдгийн нийт тоо	3,505	3,927	4,028
Хүчинтэй байгаа барааны тэмдэг	45,696	47,983	50,809

Эх үүсвэр: Оюуны өмчийн газар

Дэлхийн оюуны өмчийн байгууллага (ДОӨБ)-ын “Дэлхийн оюуны өмчийн үзүүлэлтүүд-2020” тайланд дурдсанаар дэлхийн хэмжээнд 168 оюуны өмчийн байгууллагаар дамжуулан 2019 онд 15.3 сая барааны тэмдгийн 11.5 сая мэдүүлэг хүлээн авсан нь 2018 оноос барааны тэмдгийн тоо 5.9%-аар, мэдүүлгийн тоо 5.8%-аар нэмэгджээ. Дэлхийн хэмжээнд 2019 оны байдлаар 58.2 сая барааны тэмдгийн гэрчилгээ хүчинтэй байжээ. Нийт хүлээн авсан барааны тэмдгийн мэдүүлгийн тоогоор Хятад, АНУ, Япон, Иран, Европын холбоо зэрэг улс, бүсийн оюун өмчийн байгууллагууд тэргүүлж байна.

Нэг сая (1,000,000) хүнд ногдох барааны тэмдгийн мэдүүлгийн тоогоор Хятад улс


тэргүүлж байгаа бөгөөд уг үзүүлэлт тус улсын хувьд 2019 онд 5,425 байжээ. Энэ үзүүлэлт Англид 2,619, Сингапурт 1,950, АНУ-д 1,402, Арменийн 1,323, Бразилд 1,037, Энэтхэгт 236 байжээ. Монгол Улсын хувьд 2019 оны байдлаар 1,000,000 хүнд ногдох барааны тэмдгийн тэмдгийн тоо 1,191 байжээ.

Цаашид салбарын буюу үйлдвэрлэлийн дизайны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо, ажиллагчдын тоо зэргийг нарийвчлан тодорхойлж гаргахаас гадна эдгээр аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэсэн дизайны төсөл, гүйцэтгэлийн ажлын тоо, гэрээний үнийн дүн зэрэг үзүүлэлтийг тооцож гарган салбарын хөгжлийн түвшнийг хэмжиж байх шаардлагатай.

ii. Интерьер дизайн

Бизнес мэдээллийн дэлхийн хамгийн том портал сайт болох <https://www.statista.com/>-ийн мэдээллээр интерьер дизайны салбарын дэлхийн зах зээлийн хэмжээ 2020 онд 114.9 тэрбум ам.доллар байсан бол 2021 онд 121.1 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. 2013-2020 оны хооронд салбарын орлогын жилийн өсөлт жилд дунджаар 6%-тай байжээ.

График 142: Интерьер дизайны дэлхийн зах зээлийн орлого, 2013-2020 оноор, ам.доллар



Эх үүсвэр: <https://www.statista.com/>

Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сан, Үндэсний статистикийн хорооны Бизнес регистрийн сан, Татварын ерөнхий газрын ААНБ-ын бүртгэлийн мэдээллийн сан дахь Барилгыг дуусгах шатны ажил (ISIC код - 4330), Мэргэжлийн дизайны үйл ажиллагаа (ISIC код - 7410)-ны чиглэл бүхий ААНБ-ын жагсаалт болон ААНБ-ын нэрийн аль нэг хэсэгт "интерьер", "декор" гэсэн үг орсон ААНБ-ыг гаргаж, тэдгээрийг тухайн компанийн цахим хуудас болон интернэт танилцуулга мэдээлэлтэй тулгаж, интерьер дизайны үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ын тоог тодорхойллоо. Ийнхүү тодорхойлоход энэ чиглэлийн нийт 62 ААН байгаагийн 33 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр ААНБ-ууд 2019 онд үндсэн үйл ажиллагаанаас 17.6 тэрбум төгрөгийн орлого олж, 30.4 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлжээ.

Интерьер дизайны салбарт интерьерийн зураг төсөл боловсруулах болон интерьерийн гүйцэтгэлийн ажлаас гадна дараах холбогдох үйл ажиллагааг хамруулан авч үздэг байна. Үүнд:

- Барилга архитектурын зураг төсөл боловсруулах;
- Тавилгын худалдаа, үйлдвэрлэл;


- Хивс, шал, ханын цаас, гэрэл, хөшиг, цахилгаан сантехникийн тоноглол, гэр ахуйн тоноглол, чимэглэл зэргийн худалдаа, үйлдвэрлэл;

- Үл хөдлөх хөрөнгийн төсөл хэрэгжүүлэгч.³²

Интерьер дизайны салбарын нийт эрэлтийг ашиглалтад орсон орон сууцны тоо, талбайн хэмжээ болон оффис, худалдаа, үйлчилгээний барилгын талбайн хэмжээ зэрэг үзүүлэлтээр тооцож болно.

Үндэсний статистикийн хороо, Монголбанкны мэдээллээр 2010-2019 оны хооронд нийтдээ 164.8 мянган айлын 8.4 сая м.кв талбай бүхий орон сууц ашиглалтад оржээ. Шинээр ашиглалтад орсон орон сууцны интерьер дизайныг төлөвлөх, түүнчлэн гал тогооны тавилгыг тухайн орон сууцны нөхцөл байдалд нийцүүлэн төлөвлөж үйлдвэрлэх, нийлүүлэх зэрэг интерьер дизайн эрэлт хэрэгцээ гардаг.

График 143: Ашиглалтад оруулсан орон сууц, айлын тоогоор болон сууцны талбайн хэмжээгээр




Эх үүсвэр: ҮСХ, Монголбанк

Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи (ММСГ) ХХК-ийн судалгаанаас харахад 2021 оны байдлаар захиалгат тавилга үйлдвэрлэлийн 163 ААН үйл ажиллагаа явуулж байгаа бол 2020 онд 1,684 ААН, иргэн 31.5 сая ам.долларын тавилга импортолжээ.

Түүнчлэн Эм Эм Си Жи ХХК-ийн мэдээллээр 2010-2019 онд нийт 3,825 төслийн 10.5 сая м.кв ашигтай талбай бүхий худалдаа үйлчилгээний талбай ашиглалтад оржээ.

График 144: Нийслэл Улаанбаатар хот дахь худалдаа үйлчилгээний талбайн нийт нийлүүлэлт



Эх үүсвэр: Эм Эм Си Жи ХХК-ийн судалгаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалд даатгуулагчдын мэдээллийн сангаас Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 (YAMAT-08)-ын дагуу Дотоод засал чимэглэлийн дизайнер, чимэглэгч (ангиллын код 3432) нарын тоог авч үзэхэд 2020 онд 38 хүн уг ажил мэргэжлээр ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлжээ. Тухайн төрлийн мэргэжилтнүүдийн сарын дундаж цалингийн хэмжээ 2020 онд 1,067.2 мянган төгрөгт хүрсэн нь 2016 онтой харьцуулахад 21%-аар өсжээ.

График 145: Дотоод засал чимэглэлийн дизайнер, чимэглэгч нарын тоо, сарын дундаж цалин, мян.төгрөгөөр



Эх үүсвэр: НДЕГ

Үндэсний статистикийн хорооны Ажиллах хүчний судалгааны мэдээллээс Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 (YAMAT-08)-ын дагуу Дотоод засал чимэглэлийн дизайнер, чимэглэгч (ангиллын код 3432) нарын тоог авч үзэхэд 2020 онд 1,077 хүн уг ажил мэргэжлээр ажиллажээ. Тэдний 939 нь буюу 87% нь эрэгтэйчүүд байгаагийн дотор 35-39 насны эрэгтэйчүүд голлох хувийг эзэлж байна. Энэ ажил мэргэжлээр ажиллагчдын 420 нь цалин хөлстэй байнгын ажиллагч, 335 нь цалин хөлстэй түр ажиллагч байгаа бол 323 нь цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна.

Хүснэгт 87: Дотоод засал чимэглэлийн дизайнер, чимэглэгч нарын тоо, 2020 оны байдлаар, насны бүлэг, хүйсээр болон хөдөлмөр эрхлэлтийн байдлаар

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Насны бүлгээр			
20 - 24 насны	167	167	-
25 - 29 насны	218	201	17
30 - 34 насны	167	167	-
35 - 39 насны	402	402	-
40 - 44 насны	121	-	121
Хөдөлмөр эрхлэлтийн байдлаар			
Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч	323	201	121
Цалин хөлстэй байнгын ажиллагч	420	402	17
Цалин хөлстэй түр ажиллагч	335	335	-
Бүгд	1077	939	139

Эх үүсвэр: ҮСХ, "Ажиллах хүчний судалгаа"

Цаашид салбарын аж ахуйн нэгжийн тоо, ажиллагчдын тоо зэргийг нарийвчлан тодорхойлж гаргахаас гадна эдгээр аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэсэн интерьер дизайн зураг төсөл, гүйцэтгэлийн ажлын тоо, гэрээний үнийн дүн зэрэг үзүүлэлтийг тооцож гарган салбарын хөгжлийн түвшнийг хэмжиж байх шаардлагатай.

iii. Салбарын төгсөгчдийн тоо мэдээлэл

Дизайны салбарын 2019-2020 оны хичээлийн жилд суралцаж төгссөн оюутны тоо мэдээлэл:

График 146: Дизайны салбарын төгсөгчдийн нийт СБУ-ийн төгсөгчдийн тоонд эзлэх хувь





График 147: Дизайны салбарын төгсөгчид, боловсролын зэрэг, хүйсээр, 2019-2020 оны хичээлийн жилд



ДИЖИТАЛ ИННОВАЦИ, КОНТЕНТ

Digital Innovation, Content

“

Дижитал
өөрчлөлтийн
хамгийн том
хэсэг бол
бидний сэтгэхүй
өөрчлөгдөж
байгаа явдал юм.

Симеон Престон, BUPA

”

5.11. ДИЖИТАЛ ИННОВАЦИ, КОНТЕНТ

5.11.1. Дижитал инноваци, контент салбар

ДИЖИТАЛ Инноваци, КОНТЕНТ - тодорхой зорилгоор нийгмийн бүлэгт тодорхой мессежийг хүргэх зорилгоор дүрслэлт харилцааг төлөвлөх үйл ажиллагааг агуулсан урлагийн, мэргэжлийн болон шинжлэх ухааны нэг салбар

График дизайн нь МЭӨ 15000 жилийн өмнөөс үүсэлтэй бөгөөд дараах хэсэгт График дизайны салбарын нийгэм болон эдийн засгийн үр өгөөжийг авч үзэв (A Brief History Of Graphic Design, n.d.).

Нийгмийн үр өгөөж

Бизнесийн давуу тал

График дизайн нь дан ганц гадаад үзэмж биш бөгөөд ямар нэг зүйлийг сайхан харагдуулахаас илүү олон давуу талтай билээ. Ихэнх хүмүүс ач холбогдлыг нь сайн мэддэггүй боловч сайн дизайн нь бизнесийн олон чухал ашиг тусыг авчирдаг. Үүнд:

Мэргэжлийн, ур чадвартай мэт сэтгэгдэл төрүүлдэг.

График дизайн нь компанийн эрхэм зорилго, үнэ цэнийг тусгадаг.

Борлуулалт ба зах зээлийн байр сууриа нэмэгдүүлдэг.

Сайн график брэндийг үнэ цэнтэй болгодог.

Мэргэжлийн давуу тал

2016 оны байдлаар АНУ -д ойролцоогоор 266,300 график дизайнер байдаг гэсэн тооцоо байдаг. Ирэх 10 жилийн турш график дизайнерайн мэргэжил нэмэгдэх хандлагатай байгаа. График дизайнерайн мэргэжил нь дараах давуу талуудтай (Elrick, 2017).

Маш олон салбарт ажилд орох боломжтой.

Хувиараа бизнес эрхлэх бүрэн боломжтой.

Өөрийгөө илэрхийлэх боломжтой.

График дизайнер болохын тулд заавал их сургууль төгсөх шаардлагагүй.

Эдийн засгийн үр өгөөж

График дизайнерайн ажлын зах зээл 2016-2026 оны хооронд 4.2% -иар өсөх төлөвтэй байна (The job market for graphic designers in the United States, 2016).

2021 оны байдлаар АНУ-д График дизайнер дунджаар цагт ам.доллар 18.41-оор цалинжиж байна (How much does a Graphic Designer make in the United States?, 2021).

i. Монгол Улсын дижитал инновацийн салбарын хөгжлийн түвшин, давуу тал онцлог, боломж

Мэргэжлийн холбоод

Монголд дижитал инновацийн салбарын мэргэжлийн холбоо байдаггүй. Тиймээс мэргэжлийн холбоог байгуулах шаардлагатай байна. Учир нь мэргэжлийн холбоо нь харилцан туршлага, мэдээлэл солилцох, тулгамдсан асуудлыг хамтран шийдвэрлэх, төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, салбарын хөгжлийн бодлогыг хамтран тодорхойлох эерэг нөлөө үзүүлнэ.

Мэргэжлийн холбоо нь Design Hub, ШУТИС зэрэг их сургууль, судалгааны байгууллага дээр тулгуурлан байгуулагдсан нь зүйтэй.

Дизайны салбарын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөж

Нийгмийн үр өгөөж:

- ✓ Харагдаж байгаа бүх зүйлс, гадаад, дотоод орчныг таатай болгох.
- ✓ Хүний сэтгэхүй, бодол санаа, зан төлөвийг өөрчлөх.
- ✓ Хаана ч мэдэрч болохоор хүнд ойр байдаг хэрэглээний урлаг.
- ✓ Бүтээлч шинэ залуу үеийг бий болгох.

Эдийн засгийн үр өгөөж:

- ✓ Бүтээмжийг нэмэгдүүлж, цаг хугацаа, зардлыг хэмнэх.
- ✓ Брэндинг, маркетингийн хүчирхэг хэрэгсэл.
- ✓ Жинхэнэ авьяасыг олж, ур чадварыг нь хөгжүүлж чадвал хөрөнгө оруулалтын өгөөж өндөртэй.

Дижитал инноваци, контентын салбарт байгаа боломж

Гар утасны тоглоом хөгжүүлэгчдийн дэмжих

- Дэлхийн зах зээлд гарах тэгш боломжтой.

Экспортын орлогыг нэмэгдүүлэх

- Онлайн орчинд ажилладаг учраас гаднаас үйлчилгээний захиалга авах боломжтой.

Дотоодын зах зээлийн потенциалыг өсгөх

- Хэрэглэгчдийн ойлголт, хандлагыг өөрчилж, үнэлгээг нэмэгдүүлж чадвал боломжтой.

СБҮ –ийн бусад салбарыг дэмжих

- Бусад салбарын хэрэглэгч болон дэмжих бүтэц байдлаар ажиллаж салбарыг хөгжүүлэх боломжтой.

Дижитал инноваци, контентын салбарт дахь ковид-19-ийн нөлөө, дижитал тренд

Эерэг үр нөлөө:

- Захиалагчтай хийх уулзалт зэргийг онлайнгаар хийж цаг хэмнэх болсон.

Сөрөг үр нөлөө:

- Захиалга багассаныг эс тооцвол байхгүй.

ii. Монгол Улсын дижитал инновацийн салбарт тулгамдаж буй асуудал бэрхшээл

Монгол Улсын дижитал инновацийн салбарт тулгамдсан асуудлуудыг хүний нөөц, эко орчин, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон маркетинг, борлуулалт гэсэн таван чиглэлийн хүрээнд тодрууллаа.

ХҮНИЙ НӨӨЦ

- Их дээд сургуульд шаардлагатай мэдлэг, чадварыг олгодоггүй.
- Ажилтнаа сургаж бэлтгэж авахад хугацаа их ордог, ажлаасаа гардаг.
- Гарааны компанийн цалинг голдог, ажлаас шантардаг.
- Хууль эрх зүй, татвар, санхүүгийн орчны мэдлэг дутагддаг.

Дижитал инноваци, контентын салбарын хувьд их дээд сургуулиуд шаардлагатай мэдлэг, чадварыг олгодоггүй ба төгссөн оюутнуудыг сургаж авахад хугацаа их шаарддаг байна. Тийм ч учраас ихэнх оюутнууд шантарч, ажлаасаа гардаг. Мөн гарааны компаниудын цалинг голдог. Ихэнх Дижитал инноваци, контентын салбарын ажилчид хууль эрх зүй, татвар, санхүүгийн орчны мэдлэг дутмаг байдаг.

ЭКО СИСТЕМ

- Эвлэлдэж нэгдэж эрх ашгаа хамгаалах байдал сул.
- СБҮ-ийн бусад салбартай уялдаагүй явж ирсэн.

Эвлэлдэн нэгдэж эрх ашгаа хамгаалах байдал сул байдгаас гадна СБҮ-ийн бусад салбаруудтай хамтраач ажилладаггүй. Мөн нэгдсэн зохион байгуулалттай, хамтын удирдлагын газар байдаггүй.

ДЭД БҮТЭЦ

- Оффисын түрээс өндөр байдаг.
- Мэдээлэлийн нэгдсэн бүртгэлгүй.

Ихэнх байгууллагууд оффисын түрээс зэрэг зардлаа нөхөж чадахгүйгээс эхний 2-3 жилдээ үйл ажиллагаагаа зогсоох хандлагатай байдаг. СБҮ-ийн бусад салбарын бүтээл, урын сангийн мэдээлэл дутмаг. Салбарт ажиллаж байгаа аж ахуйн нэгж, уран бүтээлчдийн талаарх бүртгэл мэдээлэл байдаггүй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Гарааны компаниудад хөрөнгө оруулалт дутагддаг.
- Барьцаа хөрөнгөгүйгээс зээл авч чаддаггүй.
- НӨАТ, НДШ салбарын компаниудад дарамт болдог.
- Салбарыг олон нийтэд таниулах нийгмийн шинжтэй төслүүдэд дэмжлэг бага.

Гарааны компаниудад хөрөнгө оруулалт дутагддаг. Зээл авч бизнесээ эхлүүлж гэсэн ч барьцаа хөрөнгөгүй тул зээл авч чаддаггүй. НӨАТ, НДШ нь компаниудад маш их дарамт болдог. Уг салбарыг олон нийтэд таниулах нийгмийн шинжтэй төслүүдэд дэмжлэг бага байдаг.

Шигтгээ 40: Санхүү, хөрөнгө оруулалтын орчин нөхцөлийг бүрдүүлэх

Улсаас хууль эрх зүй гэхээс илүү санхүүгээр тусламж, дэмжлэг, хөрөнгө оруулалтын орчин нөхцөлийг бүрдүүлээд өгвөл маш дэмжлэг болно. ЖДҮ – д хамрагдах гэхээр зарим барьцаа хөрөнгө гэх мэт нөхцөлийг нь хангаж чадахгүйн улмаас хамрагдаж чаддаггүй. Энэ тал дээр дэмжээд өгвөл бидэнд маш их боломж байгаа.

Судалгаанд оролцогчийн ярилцлагаас

МАРКЕТИНГ, СУРТАЛЧИЛГАА

- Онлайн орчин дахь Монголын талаарх мэдээлэл дутмаг.
- Дижитал инноваци, контентын талаарх захиалагчид, хүүхэд залуус, олон нийтийн мэдлэг дутмаг.

Онлайн орчинд Монголын талаарх мэдээлэл дутмаг байна. Дижитал инноваци, контентын талаарх захиалагчид, хүүхэд залуус, олон нийтийн мэдлэг муу байдаг.

iii. Процессын зураглал

Дижитал инноваци, контентын салбарын процессын ерөнхий зураглал



Тоглоом хөгжүүлэлтийн процессын зураглал



UX/UI дизайны процессын зураглал



Хүүхэлдэйн киноны процессын зураглал



5.11.2. Дижитал инноваци, контентын салбарын статистик

Дижитал инноваци гэдэг нь одоогийн бизнес процесс, ажиллах хүчний үр ашгийг сайжруулах, хэрэглэгчийн мэдрэмжийг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн болон бизнес загварыг нэвтрүүлэхэд дижитал технологи, хэрэгслийг ашиглах үйл ажиллагаа юм.³³

Дижитал контент гэдэг нь дижитал өгөгдлийн хэлбэртэй аливаа хэлбэрийн контент юм. Дижитал медиа хэрэгслийн хувьд дижитал контент нь тусгай форматаар дижитал болон аналогитөхөөрөмжид хадгалагддаг. Дижитал контентын төрөл хэлбэрт дижитал хэлбэрээр цацагддаг, нийлүүлэгддэг болон компьютерын файлд агуулагдаж буй мэдээлэл ордог.³⁴

Өөрөөр хэлбэл, аливаа үйл ажиллагааг сайжруулах зорилгоор дижитал технологийг ашиглахтай холбоотой боловсруулалт, хөгжүүлэлтийг хийж байгаа үйл ажиллагааг дижитал инноваци гэж үзнэ. Уг үйл ажиллагаа нь мэдээллийн технологийн салбар болон СБҮ-ийн бусад салбарын тухайлбал, утга зохиол, ном хэвлэлийн салбарын цахим ном, аудио номын худалдаа, дуу хөгжмийн салбарын стриминг үйлчилгээ, кино, дуу дүрсний урлагийн салбарын кино сан, видео сангийн үйл ажиллагаатай

давхцаж байна. Тиймээс захиалагч, хариулагч байгууллага, хэрэглэгчийн захиалгаар дижитал инновацийг хөгжүүлж, нийлүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх бүтээлч үйл ажиллагааг дижитал инновацийн үйл ажиллагаа гэж тодорхойлно. Үүнтэй адилаар дижитал контент гэдэгт олон төрөл хэлбэрийн контентыг хамруулах боловч энэ хэсэгт зөвхөн цахим тоглоом хөгжүүлэлт, AR, VR контент хөгжүүлэлтийн үйл ажиллагааг хамруулна. Иймээс дижитал инноваци, контентын салбарт дараах салбар, үйл ажиллагааг хамруулан авч үзнэ:

- **Дижитал инноваци** буюу программ хангамж, веб, апп дизайн, тэдгээртэй холбоотой хэрэглэгчийн мэдрэмжийн болон интерфейс дизайн (UX / UI Design), өгөгдөл/мэдээлэл боловсруулах, байршуулах, ашиглах, хэрэглэгчдэд хүргэхтэй холбоотой бүтээлч үйл ажиллагаа, хиймэл оюун ухаан (AI) хөгжүүлэлт.
- **Дижитал контент** буюу цахим тоглоом хөгжүүлэлт (Game Developers) болон AR, VR контент хөгжүүлэлт.

Дижитал инноваци, контентын салбарт давхардсан тоогоор 2,336 ААНБ-д 1,039 хүн ажиллаж байна. Салбарын нийт орлого 2020 оны байдлаар 139.5 тэрбум төгрөг байжээ.

³³ <https://www.mendix.com/digital-innovation/>
³⁴ https://en.wikipedia.org/wiki/Digital_content

Хүснэгт 88: Дижитал инноваци, контентын салбарын аж ахуйн нэгж, ажиллагчдын тоо, салбарын орлого, 2020 оны байдлаар

Дэд салбар, үйл ажиллагаа	Аж ахуйн нэгжийн тоо	Ажиллагчдын тоо	Салбарын орлого, тэрбум төгрөгөөр
Дижитал инноваци	2,322	1,039	139.1
Дижитал контент	14		0.4
Бүгд	2,336	1,039	139.5

Тайлбар: Холбогдох мэдээллийн эх үүсвэрийг дэд бүлэг тус бүрээс харна уу.

1. Дижитал инноваци

Веб дизайн: Веб хуудас (цахим хуудас) гэдэг нь html тэмдэглэгээт хэл (скрипт хэл) ашиглан үүсгэгдсэн, текст, зураг болон бусад график, видео дүрс, дуу авиа агуулсан баримт юм. Харин тодорхой нэг домэйн нэр, интернэтэд байршсан хост, сэдэв, дизайн загвар, мэдээллийн сан болон холбоосоор (линк) өөр хоорондоо холбогдсон веб хуудаснуудын нэгдлийг веб сайт (Website) гэх ба үндсэн хуудсыг нь нүүр хуудас гэнэ. Монгол Улсад олгогдсон домэйн нэрийн тоог гаргаж, жилд хийгдсэн веб сайтыг тоог гаргах боломжтой. Одоогоор Монгол Улсад хэдэн домэйн нэр бүртгэлтэй байгаа талаарх статистик мэдээлэл гараагүй байна. Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдээллээр домэйн нэрийн бүртгэгч тусгай зөвшөөрөлтэй 7 байгууллага байна.

Шигтгээ 41: Монгол Улс дахь домэйн нэрийн тоо

Домэйн нэрийн олголт, зохицуулалтыг Олон улсын интернэтийн нэр, хаягийн байгууллага /ICANN/ хариуцдаг. Монгол Улсын хувьд .MN домэйн нэрийг олгох эрхийг Датаком ХХК эзэмшдэг бөгөөд 1996 оноос эхлэн одоог хүртэл олгож байна. Мөн боловсролын байгууллагуудад зориулсан EDU. MN домэйн нэрийг Эрдэмнэт, төрийн байгууллагын GOV.MN домэйн нэр олгох үйлчилгээг Үндэсний Дата төв тус тус олгож байна. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо нь "Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журам"-ыг баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2020 оны 07 дүгээр сарын 06-ны өдөр бүртгүүлсэн.

Эх үүсвэр: Харилцаа холбооны зохицуулах хороо - <https://crc.gov.mn/k/39E/9T>


Internet Live Stats сайтын мэдээллээр 2021 оны 8 дугаар сарын байдлаар дэлхий дээр 1 тэрбум 883.8 сая веб сайт бүртгэгджээ.³⁵ Секунд тутамд нэг веб сайт шинээр бүртгэгдэж байна.

Программ хангамж хөгжүүлэлт: Монгол Улсад жилдээ хэдэн төгрөгийн өртөг бүхий хэдэн программ хангамжийн хөгжүүлэлт хийгддэг гэх зэрэг мэдээлэл судалгаа одоогоор байхгүй байна.

Апп хөгжүүлэлт: Монголын программ хангамж хөгжүүлэгчдийн холбооны мэдээллээр 250 апп хөгжүүлэгч хувь хүн, байгууллага байдаг. Үүнээс өөрөөр апп хөгжүүлэлтийн талаарх мэдээлэл судалгаа одоогоор байхгүй байна.

Бизнес мэдээллийн дэлхийн хамгийн том портал сайт болох <https://www.statista.com/>-ийн мэдээллээр 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар голлох апп-ын дэлгүүр (app store) дээрх нийт апп-ын тоо 6.8 сая байсны 3.5 сая нь буюу 51% нь Google Play, 2.2 сая нь буюу 33% нь Apple App Store, 669.0 мянга нь буюу 10% нь Windows Store (2016 оны 3 дугаар сарын байдлаар), 460.6 мянга нь буюу 7% нь Amazon Appstore дээр тус тус байжээ.

График 148: Голлох аппликейшны дэлгүүр дэх аппликейшны тоо



Эх үүсвэр: <https://www.statista.com/>

Statista сайтын мэдээллээр мобайл апп татан авалтын тоо 2016 онд 140.7 тэрбум байсан бол 2020 онд 218 тэрбум болж, 77.3 тэрбумаар буюу 55%-аар нэмэгджээ.³⁶ Түүнчлэн мобайл апп хөгжүүлэлтийн салбарын орлого 2016 онд 218.2 тэрбум ам.доллар байсан бол 2020 онд 581.9 тэрбум ам.долларт хүрч, 2.7 дахин нэмэгджээ. Цаашид мобайл апп хөгжүүлэлтийн орлого 2021 онд 693.0, 2022 онд 808.7, 2023 онд тэрбум ам.доллар 935.2 ам.долларт хүрэх таамаглалыг хийжээ.³⁷

Салбарын ААНБ-ын тоо, орлого: Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын мэдээллээр харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын компаниудын үйл ажиллагааны талаарх статистик мэдээлэл судалгааг бий болгох зорилгоор 2021 онд ҮСХ-той салбарын статистик мэдээллийн маягтыг шинэчлэн боловсруулж, шинэчилсэн маягтын дагуу бэлтгэсэн асуулгыг салбарын 4,000 гаруй компани байгаагаас 800 компани руу явуулсан боловч 55 компаниас хариу ирүүлжээ.

Үндэсний статистикийн хорооны Бизнес регистрийн санд 2020 оны жилийн эцсийн байдлаар Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC)-ын дагуу Компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа (ISIC 620)-ны чиглэлээр 2,033 ААНБ, Өгөгдөл/мэдээлэл боловсруулах, байршуулах, түүнтэй холбоотой үйл ажиллагаа; веб гарцын үйл ажиллагаа (ISIC 631)-ны чиглэлээр 286 ААНБ, нийт 2,322 ААНБ бүртгэлтэй байжээ. Нийт ААНБ-ын 812 нь буюу 35% нь л үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 89: Мэдээллийн технологийн холбогдох чиглэлээр бүртгэлтэй болон үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо

	Компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа (620)		Өгөгдөл/мэдээлэл боловсруулах, байршуулах, түүнтэй холбоотой үйл ажиллагаа; веб гарц (631)		Бүгд	
	Нийт ААНБ-ын тоо	Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо	Нийт ААНБ-ын тоо	Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо	Нийт ААНБ-ын тоо	Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо
2013	906	423	74	35	980	458
2014	1 006	439	91	45	1 097	484
2015	1 066	428	120	51	1 186	479
2016	1 168	505	148	61	1 316	566
2017	1 300	567	171	76	1 471	643
2018	1 499	685	214	103	1 713	788
2019	1 757	662	225	93	1 982	755
2020	2 033	704	289	108	2 322	812

Эх үүсвэр: УСХ

Компьютер программчлалын үйл ажиллагаа (ISIC 620)-ны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ууд 2019 онд үндсэн үйл ажиллагаанаас 129.2 тэрбум төгрөгийн орлого олж, 4.2 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, 1.4 тэрбум төгрөгийн ААНОАТ төлжээ.

Өгөгдөл/мэдээлэл боловсруулах, байршуулах, түүнтэй холбоотой үйл ажиллагаа; веб гарцын үйл ажиллагаа эрхэлж байгаа ААНБ-ууд 10.0 тэрбум төгрөгийн орлого олж, 1.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, 40.2 сая төгрөгийн ААНОАТ төлжээ.

Салбарын дүнгээр 139.1 тэрбум төгрөгийн орлого олж, 2.9 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, 1.5 тэрбум төгрөгийн ААНОАТ төлжээ.

Хүснэгт 90: Мэдээллийн технологийн холбогдох чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-уудын үндсэн үйл ажиллагааны орлого, ашиг, ногдуулсан ААНОАТ-ын хэмжээ, 2019 оны байдлаар, сая төгрөгөөр

Үйл ажиллагааны чиглэл	Үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого	Үйл ажиллагааны ашиг	Ногдуулсан ААНОАТ
Компьютер программчлалын үйл ажиллагаа	129,167.7	4,164.8	1,438.3
Өгөгдөл/мэдээлэл боловсруулах, байршуулах, түүнтэй холбоотой үйл ажиллагаа; веб гарцын үйл ажиллагаа	9,959.6	(1,311.0)	40.3
Дүн	139,127.2	2,853.8	1,478.6


Эх үүсвэр: Татварын ерөнхий газар

Цаашид салбарын буюу дижитал инновацийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо, ажиллагчдын тоо зэргийг нарийвчлан тодорхойлж гаргахаас гадна эдгээр аж ахуйн нэгжүүдийн хөгжүүлсэн веб, программ хангамж, апп-ын тоо, гэрээний үнийн дүн зэрэг үзүүлэлтийг тооцож гарган салбарын хөгжлийн түвшнийг хэмжиж байх шаардлагатай.

ii. Дижитал контент

Цахим тоглоом хөгжүүлэлт: Тоглоомын зах зээлийн судалгаа, зөвлөх үйлчилгээний Newzoo компанийн 2021 оны 4 дүгээр сард гаргасан “Дэлхийн тоглоомын зах зээлийн тайлан”-д дурдсанаар дэлхийн тоглоомын зах зээлийн нийт орлого 2020 онд 177.8 тэрбум ам.доллар байсан бол 2021 онд 175.8 тэрбум ам.доллар болж 1.1%-аар буюу 2.0 тэрбум ам.доллар буурах төлөвтэй байна. Гэсэн хэдий ч нийт орлого 2023 онд 204.6 тэрбум долларт хүрч, 2019-2023 оны жилийн дундаж өсөлт 7.2%-тай байхаар урьдчилсан тооцоог тэд хийжээ.

График 149: Дэлхийн тоглоомын зах зээлийн хэмжээ



Эх үүсвэр: Newzoo, Global Games Market Report, April 2021

Мобайл тоглоомын орлого 90.7 тэрбум ам.долларт хүрч, 4.4%-аар өсөж, нийт тоглоомын орлогод талаас илүү буюу 52%-ийг эзлэх төлөвтэй байна. Харин консол (Console) тоглоомын орлого 28% буюу 49.2 тэрбум ам.доллар болж 8.9%-аар, компьютерын тоглоомын орлого 20% буюу 35.9 тэрбум ам.доллар болж 1.7%-аар тус тус буурахаар байна.

График 150: Дэлхийн тоглоомын зах зээлийн 2021 оны орлогын урьдчилсан тооцоо, тоглоомын төрлөөр




Эх үүсвэр: Newzoo, Global Games Market Report, April 2021

Монгол Улсад цахим тоглоом хөгжүүлэлтээр дагнасан 4-5 компани байгаа бөгөөд эдгээр компаниуд 2019 онд үндсэн үйл ажиллагаанаас 215.6 сая төгрөгийн орлого олж, 237.2 төгрөгийн алдагдалтай ажиллаж, 109.5 мянган төгрөгийн ААНОАТ төлжээ.

Цахим тоглоом хөгжүүлэлтийн салбарт компанийн хэлбэрээр ажиллахаас гадна хувь тоглоом хөгжүүлэгчид, сонирхогчид мөн ажилладаг хэдий ч энэ талаар судалгаа мэдээлэл одоогоор байхгүй.

AR, VR контент хөгжүүлэлт: Бизнес мэдээллийн дэлхийн хамгийн том портал сайт болох <https://www.statista.com/>-ийн мэдээллээр дэлхийн AR, VR контент зах зээлийн хэмжээ 2019 онд 10.6 тэрбум ам.доллар байсан бол 2021 онд 18.8 тэрбум ам.доллар болж, 78%-аар буюу 8.2 тэрбум ам.доллар нэмэгджээ. Цаашид 2021-2023 онд энэ салбарын дэлхийн зах зээлийн хэмжээ эрчимтэй өсөж, 2024 онд 296.9 тэрбум ам.долларт хүрнэ гэсэн урьдчилсан таамгийг тэд хийжээ.

График 151: AR, VR-ийн дэлхийн зах зээлийн хэмжээ, тэрбум ам.доллар



Эх үүсвэр: <https://www.statista.com/>

AR, VR контент хөгжүүлэлтийн чиглэлээр Монгол Улсад гарааны бизнес байдлаар 8-9 компани ажиллаж байна. Эдгээр компаниудад 30 орчим хүн ажиллаж, салбарын орлогын хэмжээ ойролцоогоор 200 орчим сая төгрөг байна. Цаашид энэ мэдээллийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

AR, VR контент хөгжүүлэлтийн үйл ажиллагаа нь СБҮ-ийн бусад салбарууд, түүн дотроо Соёлын өв, түүх соёлын дурсгалт газрууд, музей, үзэсгэлэн галерейг олон нийтэд хүргэх, түүнчлэн аялал жуулчлал, маркетингийн үйл ажиллагаанд чухал үүрэгтэй болж байна. Тухайлбал, энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Гарааны дижитал солюнс компанийн Дижитал Хархорум төсөл, Мифокс анимейшн студи компанийн Зэв дижитал музей зэргийг энд дурдах нь зүйтэй.

Хувиараа энэ салбарт ажиллаж буй хүмүүсийн талаарх мэдээлэл судалгаа байхгүй. Гэхдээ Фейсбүүкт "VR сонирхогчид" группт 2.7 мянган гишүүн нэгдсэн байна.


Цаашид салбарын буюу дижитал контентын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо, ажиллагчдын тоо зэргийг нарийвчлан тодорхойлж гаргахаас гадна эдгээр аж ахуйн нэгжүүдийн хэрэгжүүлсэн төсөл, гэрээний үнийн дүн зэрэг үзүүлэлтийг тооцож гарган салбарын хөгжлийн түвшнийг хэмжиж байх шаардлагатай.

Салбарын ажиллагчдын тоо: Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалд даатгуулагчдын мэдээллийн сангаас Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт-08 (YAMAT-08)-ын дагуу График, мультимедиа зохиомжийн дизайнер (ангиллын код 2166) нарын тоог авч үзэхэд 2020 онд 679 хүн, Веб, мультимедиа зохиогч (ангиллын код 2513) нарын тоог авч үзэхэд 2020 онд 360 хүн, эдгээр ажил мэргэжлээр тус тус ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.

График, мультимедиа зохиомжийн дизайнер нарын тоо 2016 онтой харьцуулахад 3.1 дахин, Веб, мультимедиа зохиогч нарын тоо 8.8 дахин нэмэгджээ.

График, мультимедиа зохиомжийн дизайнер нарын сарын дундаж цалингийн хэмжээ 2020 онд 1,132.6 мянган төгрөг, Веб, мультимедиа зохиогч нарын сарын дундаж цалингийн хэмжээ 2020 онд 1,631.5 мянган төгрөг тус тус байжээ. Эдгээр мэргэжлийн ажилтнуудын эрэлт хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр цалин хэмжээ мөн нэмэгджээ. График, мультимедиа зохиомжийн дизайнер нарын сарын дундаж цалин 2016 онтой харьцуулахад 22%-аар, Веб, мультимедиа зохиогч нарын сарын дундаж цалин 80%-аар өсжээ.

График 152: График, мультимедиа зохиомжийн дизайнер болон Веб, мультимедиа зохиогч нарын тоо




Эх үүсвэр: НДЕГ

iii. Салбарын төгсөгчдийн тоо мэдээлэл

Дижитал инноваци, контентын салбарын 2019-2020 оны хичээлийн жилд суралцаж төгссөн оюутны тоо мэдээлэл:

График 153: Салбарын төгсөгчдийн нийт СБҮ-ийн төгсөгчдийн тоонд эзлэх хувь



21 их, дээд сургууль


54 ХӨТӨЛБӨР

Дижитал инноваци, контентын салбарт 2019-2020 оны хичээлийн жилд 357 оюутан суралцаж төгссөн ба энэ нь нийт соёлын салбарын төгсөгчдийн 11 хувийг бүрдүүлж байна.

График 154: Салбарын төгсөгчид, боловсролын зэрэг, хүйсээр, 2019-2020 оны хичээлийн жилд

Боловсролын зэрэг

Дипломын боловсролыг 3
Бакалаврын боловсролыг 334
Магистрын боловсролыг 20
Докторын боловсролыг 0



Эх үүсвэр: БШУЯ, "Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн тоо мэдээлэл"

МАРКЕТИНГ, ЗАР СУРТАЛЧИЛГАА

*Advertising and
communication*

12

“

*Мөнгө хэмнэхийн
тулд зар
сурталчилгааг
зогсоох нь цаг
хэмнэхийн
тулд цагийг
зогсоохтой адил
юм.*

Хенри Форд

”

5.12. МАРКЕТИНГ, ЗАР СУРТАЛЧИЛГАА

5.12.1. Маркетинг, зар сурталчилгаа салбар

Олон улс дахь маркетинг, зар сурталчилгааны салбарын нийгмийн үр өгөөж болон эдийн засгийн үр өгөөжийг авч үзэв.

Амжилттай маркетингийн стратеги ашигладаг бизнесийн борлуулалт өндөр байдаг ба энэ нь цаашлаад ажлын байрыг нэмэгдүүлэх, засгийн газрын татварын орлогыг нэмэгдэх, улмаар эдийн засгийн өсөлтийг бий болгодог.

Сайн маркетингийн бусад давуу талуудаас дурдвал:

Маркетинг нь зах зээлийг өргөжүүлдэг.

Маркетинг нь нөөцийг оновчтой ашиглахад тусалдаг.

Маркетинг нь бусад үйл ажиллагааг хурдасгадаг.

Маркетинг нь ДНБ-г нэмэгдүүлдэг.

Маркетинг нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

АНУ-д 2019 онд Маркетингийн менежерүүд дунджаар 136,850 долларын цалин авч байжээ. Хамгийн өндөр цалинтай 25 хувь нь тэр жилдээ 185,320 доллар, хамгийн бага цалинтай 25 хувь нь 97,710 доллар байсан байна (How Much Does a Marketing Manager Make?, 2016).

Маркетинг, брэндинг, коммуникацийн салбар – мэргэжлийн холбоод

Маркетинг, зар сурталчилгааны салбарт хоёр томоохон мэргэжлийн холбоо байдаг.



Монголын
маркетингийн
холбоо



Монголын үндэсний
маркетингийн
холбоо

Маркетинг, зар сурталчилгааны салбарын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөж

Нийгмийн үр өгөөж:

- ✓ Хүүхэд залуучуудын хэв маяг, трендийг тодорхойлдог, чиглүүлдэг.
- ✓ Иргэд, олон нийтийн хандлага, зан үйлд хамгийн хүчтэй нөлөөлдөг.

Эдийн засгийн үр өгөөж:

- ✓ Үндэсний брэндүүдийн дэлхийн түвшинд өрсөлдөх чадвар, боломжийг нэмэгдүүлнэ.
- ✓ Олон улсад Монгол Улсыг сурталчилж, контент бүтээж, нэр хүндийг дээшлүүлэн аялал жуулчлалыг татна.

- ✓ Бизнесийн загварт зах зээлийн судалгаа, маркетинг стратеги, брэнд, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, зар сурталчилгаа, борлуулалт, түгээлт зэрэг үйл ажиллагааны хүрээнд оролцож ашиг орлого, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.

Үндэсний соёл уламжлалаа сурталчлан таниулах кампанит ажлууд

“Эсгий туургатны соёл”-ын нэгдсэн арга хэмжээ

- Эсгий туургатны соёлын их наадмыг 2022 онд зохион байгуулах;
- Монгол туургатны хувцас дизайны шоу зохион байгуулах;

СБҮ-ийн нэгдсэн форум

- Соёлын салбарын шилдэг төслүүдийн PITCH DAY - Top 50 компанийн CEO, CMO;
- Соёлын салбарын судалгаа, зохиол бүтээлүүдийн танилцуулга;
- СБҮ-ийн нэгдсэн үзэсгэлэн.

5.12.2. Маркетинг, брэндинг, коммуникаци салбарын статистик

Америкийн маркетингийн ассоциаци (American Marketing Association (AMA)) маркетингийг “хэрэглэгчид, харилцагчид, хамтран ажиллагчид болон нийгэмд үнэ цэнэ өгөх зүйлсийг бүтээх, хүргэх, солилцох, харилцах үйл ажиллагаа, институт болон процессын нийлбэр цогц” гэж тодорхойлсон байдаг.³⁸ Энэ утгаараа маркетинг, брэндинг, коммуникацийн салбарт дараах салбар, үйл ажиллагааг хамруулан авч үзнэ:

- Брэндинг, маркетинг, олон нийттэй харилцах үйл ажиллагаа буюу аж ахуйн нэгж, байгууллага дахь бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, ялгарах шинж чанар, үнэ цэнийг бий болгож хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд хүргэх, таниулах үйл ажиллагаа болон энэ төрлийн үйлчилгээг бусдад гэрээний үндсэн дээр төлбөртэй гүйцэтгэдэг маркетинг, брэндинг, олон нийттэй харилцах (PR and Communication) агентлагууд;

- Зар сурталчилгааны агентлаг буюу бүтээгдэхүүн, үйлчилгээний зар сурталчилгааны санааг гаргах, төлөвлөх, хэрэгжүүлэх бүтээлч үйл ажиллагааг эрхэлдэг агентлагууд;
- Маркетингийн судалгаа буюу маркетингийн боломж, асуудлыг тодорхойлох; маркетингийн үйл ажиллагааг төлөвлөх, сайжруулах, үнэлэх; маркетингийн гүйцэтгэлд хяналт тавих; маркетингийн процессын талаарх ойлголтыг сайжруулах ашиглагдах мэдээллээр дамжуулан хэрэглэгч, үйлчлүүлэгч, олон нийтийг маркетингийн мэргэжилтнүүдтэй холбож өгөх аж ахуйн нэгж, байгууллагын дотоод дахь үйл ажиллагаа³⁹ болон маркетингийн судалгааны агентлагууд;
- Sales house буюу хэвлэл мэдээллийн байгууллагын өмнөөс зар сурталчилгааны цаг, орон зайг төлөвлөж, бусад аж ахуйн нэгж, байгууллагуудад зуучлан борлуулдаг агентлагийн үйл ажиллагаа. Монгол Улсын хувьд энэ төрлийн агентлагийн үйл ажиллагаа төдийлөн хөгжөөгүй байна.

Монгол Улсад маркетингийн болон зар сурталчилгааны агентлагууд тухайн нэг төрлийн үйлчилгээ, үйл ажиллагаагаа дагнаагүй, ихэнхдээ эдгээр үйлчилгээг хамтад нь үзүүлдэг учраас энэхүү тайланд маркетингийн болон зар сурталчилгааны агентлагийн үйл ажиллагааг хамтад нь авч үзлээ.

Маркетингийн салбарт давхардсан тоогоор 1,098 ААНБ-д 4,960 хүн ажиллаж байна. Салбарын нийт орлого 2020 оны байдлаар 38.8 тэрбум төгрөг байжээ.

Хүснэгт 91: Маркетинг, брэндинг, коммуникацийн салбарын аж ахуйн нэгж, ажиллагчдын тоо, салбарын орлого, 2020 оны байдлаар

Дэд салбар, үйл ажиллагаа	Аж ахуйн нэгжийн тоо	Ажиллагчдын тоо	Салбарын орлого, тэрбум төгрөгөөр
Маркетинг зар сурталчилгааны агентлаг	957	4,767	25.4
Маркетингийн судалгааны агентлаг	141	193	13.4
Бүгд	1,098	4,960	38.8

Тайлбар: Холбогдох мэдээллийн эх үүсвэрийг дэд бүлэг тус бүрээс харна уу.

i. Маркетинг, зар сурталчилгааны агентлаг

Салбарын ААНБ-ын тоо, орлого: Үндэсний статистикийн статистикийн хорооны Бизнес регистрийн сан дахь Зар сурталчилгааны ажил (ISIC код - 7310) болон Хурал, цуглаан болон худалдааны үзүүлбэр/шоу зохион байгуулах үйл ажиллагаа (ISIC код - 8230) гэсэн үйл ажиллагааны чиглэл бүхий ААНБ-ын тоогоор тухайн салбарын ААНБ-ын тоог тодорхойллоо. Ийнхүү тодорхойлоход Зар сурталчилгааны ажил чиглэлийн нийт 864 ААНБ байгаагийн 405 нь буюу 47% нь, Хурал, цуглаан болон худалдааны үзүүлбэр/шоу зохион байгуулах үйл ажиллагаа чиглэлийн нийт 141 ААНБ байгаагийн 34 нь буюу 37% нь үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр дэд салбарын дүнгээр авч үзвэл маркетинг зар сурталчилгааны салбарт нийт 957 ААНБ бүртгэлтэй байгаагийн 439 нь буюу 46% нь үйл ажиллагаа явуулж байна.

Нийт бүртгэлтэй ААНБ-ын тоо 2013 оноос жил дараалан өсөж, 2020 онд 2013 онтой харьцуулахад 2.1 дахин буюу 494 ААНБ-аар нэмэгджээ. 2013 онд нийт бүртгэлтэй ААНБ-ын 57% нь үйл ажиллагаа явуулж байсан бол 2020 онд энэ үзүүлэлт 46% болж буурчээ.

Хүснэгт 92: Маркетинг, зар сурталчилгааны ААНБ-ын нийт тоо, үйл ажиллагааны чиглэлээр, үйл ажиллагаа явуулж байгаа эсэх

	Зар, сурталчилгааны ажил (7310)	Үүнээс: үйл ажиллагаа явуулж байгаа	Хурал, цуглаан болон худалдааны үзүүлбэр/шоу зохион байгуулах үйл ажиллагаа (8230)	Үүнээс: үйл ажиллагаа явуулж байгаа	Маркетинг зар сурталчилгааны ААНБ-ын тоо - бүгд	Үүнээс: үйл ажиллагаа явуулж байгаа
2013	451	256	12	6	463	262
2014	511	259	18	9	529	268
2015	576	257	31	16	607	273
2016	648	300	43	23	691	323
2017	692	329	48	23	740	352
2018	765	360	53	26	818	386
2019	821	405	63	29	884	434
2020	864	405	93	34	957	439

Эх үүсвэр: ҮСХ

Зар сурталчилгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ууд 2019 онд үндсэн үйл ажиллагаанаас 23.3 тэрбум төгрөгийн орлого олж, 191.5 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 126.1 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлжээ.

Харин Хурал, цуглаан болон худалдааны үзүүлбэр/шоу зохион байгуулах үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ууд 2019 онд үндсэн үйл ажиллагаанаас 2.1 тэрбум төгрөгийн орлого олж, 15.6 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 3.6 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлжээ.

Салбарын дүнгээр эдгээр ААНБ-ууд 2019 онд үндсэн үйл ажиллагаанаас 25.4 тэрбум төгрөгийн орлого олж, 207.1 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 129.7 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлжээ.

Салбарын ажиллагчдын тоо: Нийгмийн даатгалын ерөнхий газрын нийгмийн даатгалд даатгуулагчдын мэдээллийн сангаас Үндэсний ажил мэргэжлийн ангилал,

³⁸ <https://www.ama.org/the-definition-of-marketing-what-is-marketing/>

³⁹ <https://www.ama.org/the-definition-of-marketing-what-is-marketing/>

тодорхойлолт-08 (YAMAT-08)-ын дагуу Зар сурталчилгаа, олон нийттэй харилцах менежер (ангиллын код 1222)-ээр 2020 онд 314 хүн, Зар сурталчилгаа, маркетингийн мэргэжилтэн (ангиллын код 2431)-ээр 4,453 хүн, нийт 4,767 хүн ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлжээ. Зар сурталчилгаа, олон нийттэй харилцах менежерийн сарын дундаж цалингийн хэмжээ 2020 онд 1,917.3 мянган төгрөг, Зар сурталчилгаа, маркетингийн мэргэжилтний сарын дундаж цалин 1352.4 мянган төгрөг байсан нь 2016 онтой харьцуулахад 37-38%-аар өсжээ.

График 155: Маркетинг, зар сурталчилгааны салбарт ажиллагчдын тоо



Эх үүсвэр: НДЕГ

Салбарын бусад үзүүлэлтүүд: Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК 2018 оноос хойш 2 жил тутам Маркетингийн захирлуудын судалгаа (CMO Survey)-г хийж байна. Уг судалгааг тус компани одоогийн байдлаар 2018, 2020 онд 2 удаа хийгээд байгаа бөгөөд тэргүүлэх 50 компанийн Маркетингийн захирлуудыг уг судалгаанд хамруулдаг.

Маркетингийн захирлуудын 2020 оны судалгааны дүнгээс харахад ТОП 50 компанийн маркетингийн батлагдсан төсөв 2020 онд 99 тэрбум төгрөг байсан нь 2018 онынхоос 24 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Гэсэн хэдий ч Ковид-19 гарснаар маркетингийн батлагдсан төсвөө эдгээр компаниудын 71% бууруулсан бөгөөд батлагдсан нийт төсвөө 34%-аар буюу 29 тэрбум төгрөгөөр бууруулжээ.

ТОП 50 компанийн маркетингийн батлагдсан төсөвт дижитал медиа сурталчилгааны зардал 27%-ийг, уламжлалт медиа сурталчилгаа 22%-ийг, урамшуулалт хөтөлбөр 16%-ийг хувийг бүрдүүлж байна.

График 156: ТОП-50 компанийн 2020 оны маркетингийн төсвийн хуваарилалт



-2018 онтой харьцуулахад өссөн ↑
-2018 онтой харьцуулахад буурсан ↓

Эх үүсвэр: Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК, CMO Survey 2020

ТОП 50 компанийн уламжлалт медиа сурталчилгааны төсөвт телевизийн сурталчилгаа 40%-ийг эзэлж байгаа хэдий ч 2018 онтой харьцуулахад 7 пунктээр буурчээ. Шинэ дижитал медиад зарцуулах төсөвт хамгийн өндөр хувийг буюу 57%-ийг сошиал медиа сурталчилгааны зардал эзэлж байна. Шинэ дижитал медиад зарцуулж буй нийт зардлын 24% нь Инфлюенсер (influencer), хувийн сувгийн контент (channel content) хөгжүүлэгч нараар бүтээгдэхүүнээ сурталчлуулахад зарцуулагдаж байна.


График 157: ТОП-50 компанийн 2020 оны сурталчилгааны төсвийн хуваарилалт



Эх үүсвэр: Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК, CMO Survey 2020

ТОП-50 компанийн Маркетингийн захирлууд 2021 онд дижитал сурталчилгаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн болон маркетингийн судалгааны зардал хамгийн их өснө гэж үзжээ.


График 158: ТОП-50 компанийн Маркетингийн захирлуудын 2021 оны маркетингийн зардлын өөрчлөлтийн талаарх төсөөлөл



Эх үүсвэр: Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК, CMO Survey 2020

ТОП-50 компанийн Маркетингийн захирлууд Influencer, YouTube, контент бүтээгч нартай хамтран хийж буй сурталчилгааны ажлууд нь телевизийн сурталчилгаанаас илүү үр дүнтэй байна гэж үзэж байна.

График 159: ТОП-50 компанийн Маркетингийн захирлуудын үзэж байгаагаар хамгийн үр өгөөжтэй маркетингийн сувгууд




Эх үүсвэр: Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК, CMO Survey 2020

Маркетингийн захирлууд маркетингийн албаны үйл ажиллагаанд тулгамдаж буй гол асуудлуудыг дараах байдлаар тодорхойлжээ:

- Ковид хэр удаан үргэлжлэх, нөхцөл байдал хэзээ хэвийн болох эсэх зэрэг тодорхойгүй байдал нь тулгамдаж буй асуудал болж байна. Зардал танагдсан тул маркетингийн үр өгөөжөө нэмэгдүүлэх, төсвийн хуваарилалтаа илүү ухаалаг зөв зарцуулах нь чухал байна. Үүний тулд зорилтот хэрэглэгчдийнхээ амьдралын хэв маяг, медиа хэрэглээг судалж, ямар контент, аль суваг илүү хүрч байна гэдгээ хэмжсэнээр үр дүнгүй зардлуудаа танаж, өгөөжөө нэмэгдүүлэх боломжтой юм.
- Маркетингийн салбарт нарийн мэргэшсэн хүний нөөц хамгийн тулгамдсан асуудал болж байна. Их дээд сургуулиуд зөвхөн ерөнхий мэдлэг зааж, маркетингийн нарийвчилсан чиглэл буюу дижитал, UX, UI хөгжүүлэлт, судалгаа шинжилгээ зэрэг мэргэшүүлэх сургалтууд хийхгүй байна.
- Дижитал шилжилтийг хийхэд нарийн мэргэжилд хүмүүсээ сургах хэрэгцээ үүсэж байна. Бүтээлч сэтгэлгээ дутагдалтай, үүнийг дэмжсэн процесс алга байна.
- Хэт их контент цацагдаж байгаа учир хэрэглэгчийн анхаарлыг татах, ялгарах нь улам бүр төвөгтэй болж байна.

Дижитал шилжилттэй холбоотой дата шинжээч, UI, UX хөгжүүлэгч, социал платформ дээр ажиллах чадвартай боловсон хүчин шаардлагатай болж байна. Хэрэглэгчээ халамжлах, тогтоон барихад тэдний хэрэгцээг гүнзгий ойлгох аналитик чадвар, дан функциональ гэхээсээ сэтгэл хөдлөлийн болон социал хэрэгцээг нь мэдэрч, бүтээгдэхүүн болон коммуникаци хөгжүүлэлтийг системтэйгээр бүтээлчээр хөгжүүлэх бүтээлч процессын ур чадваруудыг нэмэгдүүлэх нь чухал болж байна.


График 160: Маркетингийн мэргэжилтнүүдэд шаардлагатай ТОП-5 ур чадвар



Эх үүсвэр: Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК, CMO Survey 2020

Маркетингийн захирлуудын үзэж байгаагаар видео студи, маркетингийн судалгааны агентлаг, программ хангамж, веб болон апп хөгжүүлэлтийн агентлагууд хэрэгцээ өндөртэй, үнэлгээ өндөртэй байна. Дийлэнх агентлагийн хувьд баруун дээш чиглэлд шилжилт хийсэн нь маркетингийн зөвлөх үйлчилгээний хэрэгцээ өсөж, гүйцэтгэлийн чанар сайжирсныг харуулж байна.

График 161: Маркетингийн агентлагуудын хэрэгцээ ба үнэлгээ




Эх үүсвэр: Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК, CMO Survey 2020

Цаашид салбарын аж ахуйн нэгжийн тоо, ажиллагчдын тоо зэргийг нарийвчлан тодорхойлж гаргахаас гадна эдгээр аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэсэн төсөл, гүйцэтгэлийн ажлын тоо, гэрээний үнийн дүн зэрэг үзүүлэлтийг тооцож гарган салбарын хөгжлийн түвшнийг хэмжиж байх шаардлагатай.

ii. Маркетингийн судалгааны агентлаг

Салбарын ААНБ-ын тоо, орлого: Үндэсний статистикийн статистикийн хорооны Бизнес регистрийн сан дахь Зах зээлийн судалгаа болон олон нийтийн санал хураах үйл ажиллагаа (ISIC код - 7320) гэсэн үйл ажиллагааны чиглэл бүхий ААНБ-ын тоогоор тухайн салбарын ААНБ-ын тоог тодорхойллоо. Ийнхүү тодорхойлоход энэ чиглэлийн нийт 141 ААНБ байгаагийн 62 нь буюу 44% нь үйл ажиллагаа явуулж байна. Нийт бүртгэлтэй ААНБ-ын тоо 2013 оноос жил дараалан өсөж, 2020 онд 2013 онтой харьцуулахад 4.9 дахин буюу 112 ААНБ-аар нэмэгджээ. 2013 онд нийт бүртгэлтэй ААНБ-ын 55% нь үйл ажиллагаа явуулж байсан бол 2020 онд энэ үзүүлэлт 44% болж буурчээ.

График 162: Зах зээлийн судалгаа болон олон нийтийн санал хураах үйл ажиллагаа (ISIC 7320)-ны чиглэлээр бүртгэлтэй болон үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо




Эх үүсвэр: ҮСХ

Маркетингийн судалгааны компаниудын орлого 2019 онд 17.1 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 13.4 тэрбум төгрөг болж, 3.7 тэрбум төгрөгөөр буюу 22%-аар буурчээ.

Салбарын ажиллагчдын тоо: Маркетингийн судалгааны чиглэлээр судалгааны агентлагуудаас гадна нийт ААНБ-д хэдэн хүн ажиллаж байгаа талаарх тоо мэдээлэл одоогоор байхгүй. Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК-ийн мэдээллээр маркетингийн судалгааны агентлагуудад 2021 оны байдлаар 193 орчим ажилтан ажиллаж байна.

Судалгааны салбарын дэлхийн зах зээлийн төлөв байдал: Маркетингийн судалгааны мэргэжлийн дэлхийн хамгийн том байгууллага болох ЭСОМАР (ESOMAR) байгууллага 1947 онд байгуулагдсан. Одоогийн байдлаар тус байгууллагад дэлхийн 130 гаруй орны 550 орчим судалгааны байгууллага, 6,000 орчим мэргэжилтэн гишүүнээр элсээд байна.⁴⁰ Тус байгууллагаас Дэлхийн маркетингийн судалгааны салбарын тайланг нэгтгэн гаргадаг бөгөөд 2020 онд гаргасан тайланд дурдсанаар дэлхийн судалгааны зах зээлийн орлого 2019 онд 89.9 тэрбум ам.долларт хүрсэн нь 2018 онтой харьцуулахад жилийн цэвэр өсөлт 3.9% байжээ. Үүний 48.3 тэрбум ам.доллар буюу 54% нь Хойд Америкийн, 23.8 тэрбум ам.доллар буюу 26% нь Европын, 13.1 тэрбум ам.доллар буюу 15% Ази, Номхон далайн бүс нутагт ногдож байна.

График 163: Дэлхийн судалгааны салбарын нийт орлого, дүнд эзлэх хувь, бүс нутгаар



Эх үүсвэр: Global Market Research 2020: An ESOMAR Industry Report in cooperation with BDO Accountants and Advisors, ESOMAR, 2021

Уламжлалт судалгааны орлого 2019 онд 42.5 тэрбум ам.доллар байгаа нь нийт судалгааны орлогын 47.3%-ийг эзэлж байгаа бол Технологид суурилсан судалгааны орлого 47.4 тэрбум долларт хүрсэн нь нийт судалгааны орлогод 52.7%-ийг эзэлж байжээ.

Уламжлалт судалгааны орлогын өсөлт 2019 онд 2018 онтой харьцуулахад 4.3% байсан бол Технологид суурилсан судалгааны орлогын өсөлт 11.5% байжээ.

Хүснэгт 93: Дэлхийн маркетингийн судалгааны салбарын орлого, өсөлт, дүнд эзлэх хувь, үйл ажиллагааны чиглэлээр, тэрбум ам.доллар

	2017	2018	2019	2018/2019 өсөлт (%)	Дүнд эзлэх хувь
Уламжлалт судалгаа (Established Research)	39.7	40.7	42.5	4.3%	47.3%
Технологид суурилсан судалгаа (Technology-enabled Research)	38.6	42.5	47.4	11.5%	52.7%
Үүнээс:					
Дижитал дата анализ (Digital Data Analytics)	12.4	13.4	15.5	15.5%	17.2%
Онлайн тайлан, судалгаа (Vertical Reports and Research)	11.0	12.4	13.4	7.7%	14.9%
Зөвлөх компани (Consulting Firms)	9.0	9.6	10.4	8.3%	11.6%
Нийгмийн сүлжээний тандалт (Social Listening and Communities)	4.1	4.6	5.3	15.5%	5.9%
Байгууллагын санал хүсэлтийн менежмент (Enterprise Feedback Management)	1.1	1.3	1.6	23.1%	1.7%
Судалгааны платформ (DIY Research Platforms)	1.0	1.2	1.2	3.7%	1.4%
Нийт дүн	78.3	83.3	89.9	8.0%	100.0%

Эх үүсвэр: Global Market Research 2020: An ESOMAR Industry Report in cooperation with BDO Accountants and Advisors, ESOMAR, 2021

iii. Салбарын төгсөгчдийн тоо мэдээлэл

Маркетинг, брэндинг, коммуникаци салбарын 2019-2020 оны хичээлийн жилд суралцаж төгссөн оюутны тоо мэдээлэл:

График 164: Салбарын төгсөгчдийн нийт СБҮ-ийн төгсөгчдийн тоонд эзлэх хувь





График 165: Салбарын төгсөгчид, боловсролын зэрэг, хүйсээр, 2019-2020 оны хичээлийн жилд

Боловсролын зэрэг

Хүйс


Эх үүсвэр: БШУЯ, "Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн тоо мэдээлэл"

ХАВСРАЛТ

СБҮ-д хамаарах ISIC-04 код

ISIC код -3 оронгоор	ISIC код -4 оронгоор	СБҮ -д хамаарах чиглэл	Хамаарах 6 салбар	Хамаарах 12 салбар	ISIC Тодорхойлолт	Жин
477	4774	СБҮ 12 салбар	А. Соёлын болон байгалийн өв	1. Соёлын өв	Хуучин барааны жижиглэн худалдаа	1
910	9103	СБҮ 12 салбар	А. Соёлын болон байгалийн өв	1. Соёлын өв	Ургамлын болон амьтны хүрээлэн, байгалийн үзэсгэлэнт газар, дархан цаазат газрын үйл ажиллагаа	1
910	9102	СБҮ 12 салбар	А. Соёлын болон байгалийн өв	1. Соёлын өв	Музей, түүхийн дурсгалт газар, байшин, барилга, байгууламж үзүүлэх	1
900	9000	СБҮ 12 салбар	А. Соёлын болон байгалийн өв	1. Соёлын өв	Бүтээл туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа	0.25
900	9000	СБҮ 12 салбар	Г. Утга зохиол, ном хэвлэл	2. Утга зохиол, ном хэвлэл	Бүтээл туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа	0.25
181	1811	ТТДМ	Г. Утга зохиол, ном хэвлэл	2. Утга зохиол, ном хэвлэл	Хэвлэх үйл ажиллагаа	1
581	5819	СБҮ 12 салбар	Г. Утга зохиол, ном хэвлэл	2. Утга зохиол, ном хэвлэл	Дээр дурдсанаас бусад материалын эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа	0.2
910	9101	СБҮ 12 салбар	Г. Утга зохиол, ном хэвлэл	2. Утга зохиол, ном хэвлэл	Номын сан, архивын үйл ажиллагаа	1
464	4649	СБҮ 12 салбар	Г. Утга зохиол, ном хэвлэл	2. Утга зохиол, ном хэвлэл	Гэр ахуйн бусад барааны бөөний худалдаа	1
639	6391	СБҮ 12 салбар	Г. Утга зохиол, ном хэвлэл	2. Утга зохиол, ном хэвлэл	Мэдээллийн агентлагийн үйл ажиллагаа	0.333333
476	4761	СБҮ 12 салбар	Г. Утга зохиол, ном хэвлэл	2. Утга зохиол, ном хэвлэл	Ном, сонин болон бичиг хэрэгслийн барааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	0.25
581	5811	СБҮ 12 салбар	Г. Утга зохиол, ном хэвлэл	2. Утга зохиол, ном хэвлэл	Номын эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа	0.2
282	2829	ТТДМ	Г. Утга зохиол, ном хэвлэл	2. Утга зохиол, ном хэвлэл	Тусгай зориулалтын бусад машин үйлдвэрлэл	0.5
900	9000	СБҮ 12 салбар	В. Дүрслэх урлаг, гар урлал	3. Дүрслэх урлаг	Бүтээл туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа	0.25
581	5819	СБҮ 12 салбар	В. Дүрслэх урлаг, гар урлал	3. Дүрслэх урлаг	Дээр дурдсанаас бусад материалын эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа	0.2
202	2029	ТТДМ	В. Дүрслэх урлаг, гар урлал	3. Дүрслэх урлаг	Химийн бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1
321	3211	СБҮ 12 салбар	В. Дүрслэх урлаг, гар урлал	3. Дүрслэх урлаг	Үнэт эдлэл, гоёл чимэглэлийн зүйлс үйлдвэрлэл	1
722	7220	СБҮ 12 салбар	В. Дүрслэх урлаг, гар урлал	3. Дүрслэх урлаг	Нийгмийн ухаан, эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажил	1
742	7420	СБҮ 12 салбар	В. Дүрслэх урлаг, гар урлал	3. Дүрслэх урлаг	Гэрэл зургийн үйл ажиллагаа	1
202	2022	ТТДМ	В. Дүрслэх урлаг, гар урлал	3. Дүрслэх урлаг	Будаг, лак болон үүнтэй ижил төстэй будаг, хэвлэлийн бэх ба давирхай үйлдвэрлэл	1
267	2670	ТТДМ	В. Дүрслэх урлаг, гар урлал	3. Дүрслэх урлаг	Оптик багаж хэрэгсэл болон гэрэл зургийн төхөөрөмж үйлдвэрлэл	0.5
322	3220	СБҮ 12 салбар	Б. Урлагийн тоглолт, баяр ёслол	4. Дуу, хөгжим	Хөгжмийн зэмсэг үйлдвэрлэл	1
592	5920	СБҮ 12 салбар	Б. Урлагийн тоглолт, баяр ёслол	4. Дуу, хөгжим	Дуу бичлэг, хөгжмийн эх бэлтгэх үйл ажиллагаа	1

ISIC код -3 оронгоор	ISIC код -4 оронгоор	СБҮ -д хамаарах чиглэл	Хамаарах 6 салбар	Хамаарах 12 салбар	ISIC Тодорхойлолт	Жин
182	1820	ТТДМ	Б. Урлагийн тоглолт, баяр ёслол	4. Дуу, хөгжим	Дуу бичлэг хуулбарлах үйл ажиллагаа	1
476	4762	СБҮ 12 салбар	Б. Урлагийн тоглолт, баяр ёслол	4. Дуу, хөгжим	Хөгжим, видео бичлэгийн төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	0.25
264	2640	ТТДМ	Б. Урлагийн тоглолт, баяр ёслол	4. Дуу, хөгжим	Хэрэглээний цахилгаан бараа үйлдвэрлэл	0.5
900	9000	СБҮ 12 салбар	Б. Урлагийн тоглолт, баяр ёслол	5. Тайзны урлаг	Бүтээл туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа	0.25
329	3290	ТТДМ	Б. Урлагийн тоглолт, баяр ёслол	5. Тайзны урлаг	Дээр дурдсан ангид ороогүй боловсруулах үйлдвэрийн бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	0.5
